

**Нягтлан Бодогчдын Ёс Зүйн
Олон Улсын Стандартын Зөвлөл**

**Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн
Олон Улсын Дүрэм (Хараат бус Байдлын Олон
Улсын Стандартыг багтаасан)**

2018 оны хэвлэл

International Federation of Accountants®
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо
529-р Байшин, 5-р өргөн чөлөө,
Нью-Йорк, Нью-Йорк 10017 АНУ

Энэхүү бүтээлийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) (International Federation of Accountants (IFAC®) хэвлэн гаргасан. Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны эрхэм зорилго бол өндөр чанартай, олон улсын стандарт боловсруулах ажлыг дэмжих; эдгээр стандартын нэвтрүүлэлт ба хэрэгжүүлэлтийг сайшаан дэлгэрүүлэх; нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах; нийтийн эрх ашигт хамаарах асуудлаар санал бодлоо илэрхийлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм. Энэ хэвлэлийг Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-ийн www.ethicsboard.org хаягаас үнэ төлбөргүй татаж эсвэл худалдаж авах боломжтой.

Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан), Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг болон НБЁЗОУСЗ-ийн бусад бүтээлийг ДНБХ өөрийн зохиогчийн эрхийн дагуу хэвлэн гаргадаг.

Энэ хэвлэлийн материалыг үндэслэл болгож үйлдэл хийсэн эсвэл үйлдэл хийхээс татгалзсан аливаа этгээдэд хохирол учирсан бөгөөд энэ хохирол нь түүний хайхрамжгүй байдал эсвэл өөр шалтгаантай холбоотой эсэхийг үл харгалзан НБЁЗОУСЗ болон ДНБХ хариуцлага хүлээхгүй.

‘Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (International Ethics Standards Board for Accountants)’, Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан) (International Code of Ethics for Professional Accountants™ (including International Independence Standards™)’, ‘Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо’ (International Federation of Accountants), ‘НБЁЗОУСЗ’ (IESBA), ‘ДНБХ’ (IFAC), НБЁЗОУСЗ (IESBA) гэсэн лого, ДНБХ (IFAC) гэсэн лого нь ДНБХ-ны худалдааны тэмдэг эсвэл АНУ болон бусад улс оронд бүртгэлтэй ДНБХ-ны худалдааны ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2018 оны 7 дугаар сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хуулиар хамгаалагдсан. Зөвхөн хувийн хэрэгцээнд буюу арилжааны бус зорилгоор хадгалахаас бусад тохиолдолд, энэ баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх эсвэл үүнтэй ижил төстэй аргаар ашиглах бол ДНБХ-оос бичгээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Мөн permissions@ifac.org цахим хаягаар холбоо барина уу.

ISBN: 978-1-60815-369-5



ДНБХ-оос хэвлүүлэв

ОРШИЛ

Дэлхийн нягтлан бодогчдын холбоо (IFAC)-ны Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс баталсан *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан)*-ийн 2018 оны хэвлэлийн монгол хэл дээрх орчуулгыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт гүйцэтгэсэн.

Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хороо 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хуралдаж, дараах гишүүдийн саналыг үндэслэн, 11 тоот тогтоолоор уг стандартын монгол хэл дээрх орчуулгыг баталлаа.

Хорооны дарга:

Санжаагийн Мөнгөнчимэг

Сангийн дэд сайд

Нарийн бичгийн дарга:

Будсүрэнгийн Болормаа

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах шинжээч, доктор

Гишүүд:

Чойгүнсэнгийн Чимидсүрэн

Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, доктор

Цэвэгсүрэнгийн Наранчимэг

Үндэсний аудитын газрын САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Дагвадоржийн Төрмөнх

Стандартчилал хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын мэргэжилтэн

Лувсан-Очирын Дондог

Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн, проф, доктор

Лхагвацэрэнгийн Бадамханд

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын стандартын төслийн менежер

Дуламсүрэнгийн Нямаа

МУИС-ийн Бизнесийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн дэд проф, доктор

Гарамдоржийн Гантулга

СЭЗИС-ийн ОУНББСМС-ийн проф, доктор

Дагвын Бүнчинсүрэн

МУИС-ийн Бизнесийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш

Батсүхийн Анхтайван

Делойт-Онч Аудит ХХК-ийн аудитын менежер

Дуламжавын Энхтуяа

“Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн санхүүгийн удирдлагын хяналтын газрын захирлын орлогч

Чинбатын Байгалмаа

“Клин Энержи” ХХК-ийн санхүүгийн менежер

МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧДЫН ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ГАРЫН АВЛАГА (ХАРААТ БУС БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ БАГТААСАН БОЛНО)

2018 ОНЫ ХЭВЛЭЛ

Гарын Авлагыг Эрэмбэлэн Эмхэтгэсэн Байдал:

Гарын авлагын агуулгыг дараах хэсгүүдээр эрэмбэлж цэгцэлсэн болно:

Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Танилцуулга	1
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны Үүрэг	2
Гарын Авлагын Цар Хүрээ	3
2016 оны Хэвлэлээс Ялгарах Агуулгын Шинжтэй Өөрчлөлт	4
Ёс Зүйн Дүрмийн Заавар	6
Агуулга	11
Өмнөх үг	14
Бүлэг 1 – Ёс Зүйн Дүрэм, Суурь Зарчим ба Онолын Үзэл Баримтлалд Нийцүүлэх	16
Бүлэг 2 – Бизнесийн Салбар Дахь Мэргэжлийн Нягтлан Бодогчид	29
Бүлэг 3 – Нийтэд Үйлчилдэг Мэргэжлийн Нягтлан Бодогчид	58
Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт (Бүлэг 4А болон 4Б)	
Бүлэг 4А – Аудит ба Нягтлах Гэрээт Ажлын Хараат Бус Байдал	91
Бүлэг 4Б – Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас Бусад	
Баталгаажуулах Гэрээт Ажлын Хараат Бус Байдал	177
Нэр Томьёоны Тайлбар болон Товчилсон Үгсийн Жагсаалт	208
Хүчин Төгөлдөр Болох Хугацаа	219

Зохиогчийн эрх ба Орчуулга

ДНБХ нь НБЁЗОУСЗ-ийн гарын авлага, стандарт болон бусад хэвлэлийн материалуудыг гаргасан ба эдгээртэй холбоотой зохиогчийн эрхийг эзэмшдэг болно.

Англи хэлээр ярьдаггүй орнуудын санхүүгийн тайлан бэлтгэн гаргагчид, түүнийг хэрэглэгчид, аудиторууд, мэргэжлийн нягтлан бодогчид, зохицуулагчид, үндэсний стандарт тогтоогчид, ДНБХ-ны гишүүн байгууллагууд, хуульчид, их дээд сургууль, оюутнууд болон энэхүү баримт бичгийг сонирхон судлагчид эдгээр стандартыг өөрийн төрөлх хэл дээрээ ашиглах боломжтой байх нь чухал гэдгийг ДНБХ ойлгодог. Иймээс, өөрийн хэвлэсэн бүтээлүүдийг олшруулах, орчуулж хэвлүүлэх ажлыг ДНБХ сайшаан дэмждэг.

ДНБХ-ны бүтээлүүдийг орчуулах, зохиогчийн эрхтэйгээр дахин хэвлүүлэхэд баримтлах бодлогыг *Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооноос Хэвлүүлсэн Стандартуудыг Орчуулах ба Дахин Хэвлүүлэх Бодлого*, мөн *Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны Бүтээлүүдийг Дахин Хэвлүүлэх эсвэл Орчуулаад Дахин Хэвлүүлэх Бодлого*-д тайлбарласан болно. Энэхүү гарын авлагыг дахин хэвлүүлэх, эсвэл орчуулаад дахин хэвлүүлэх хүсэлтэй сонирхогч талууд холбогдох нөхцлүүдийн талаар permissions@ifac.org хаягаар хандаж лавлана уу.

НЯГТЛАН БОДОГЧДЫН ЁС ЗҮЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ) нь олон улсын хэмжээнд тохирохуйц *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартын хамт)* боловсруулан гаргадаг стандарт тогтоогч, хараат бус байгууллага юм.

НБЁЗОУСЗ-ийн ажил үүргийн хуваарьт тодорхойлсны дагуу НБЁЗОУСЗ-ийн зорилго нь мэргэжлийн нягтлан бодогчдод зориулсан дээд зэргийн чанартай ёс зүйн стандартыг тогтоох замаар олон нийтэд үйлчлэх явдал юм. НБЁЗОУСЗ-ийн урт хугацааны зорилго бол мэргэжлийн нягтлан бодогчдын Ёс Зүйн дүрэм стандарт ба аудиторын хараат бус байдлын стандартуудыг зохицуулагчид, үндэсний стандарт тогтоогчдын гаргасан ижил төрлийн баримт бичгүүдтэй нийцүүлэх явдал юм. Нэгдсэн нэг стандарттай болсноор дэлхий даяарх мэргэжлийн нягтлан бодогчдын үзүүлж буй үйлчилгээний чанар ба нийцтэй байдлыг сайжруулах, дэлхийн капиталын зах зээлийн үр өгөөжийг сайжруулах боломж бүрдэх юм.

НБЁЗОУСЗ нь дэлхийн өнцөг булан бүрийн төлөөлөл болсон 18 гишүүнээс бүрдэх бөгөөд эдгээрээс 9-өөс дээшгүй гишүүнийг нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч, 3-аас цөөнгүй гишүүнийг нийтийн эрх ашгийг төлөөлөх хэсэг (нийтийн ашиг сонирхлыг илүү өргөн хүрээнд илэрхийлж чадахуйц хүмүүс)-ээс сонгодог. НБЁЗОУСЗ-ийн гишүүдийг ДНБХ-ны Нэр дэвшүүлэх хорооны саналыг харгалзан, НБЁЗОУСЗ-ийн үйл ажиллагааг хөндлөнгөөс хянадаг Олон нийтийн эрх ашгийг хянах зөвлөл (ОНЭАХЗ)-өөс зөвшөөрсөний дагуу ДНБХ-ны Захирлуудын Зөвлөл томилдог.

НБЁЗОУСЗ-ийн боловсруулдаг стандарт, удирдамжид олон нийтийн эрх ашиг тусгагддаг учир ОНЭАХЗ ба НБЁЗОУСЗ-ийн Зөвлөх Бүлэг (ЗБ)-ийн зүгээс НБЁЗОУСЗ-ийн стандарт тогтоох үйл явцад оролцдог.

НБЁЗОУСЗ нь стандарт боловсруулах үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод байлгахаас гадна ОНЭАХЗ-өөс баталсан албан журмыг мөрдөн сахидаг. Видеоконференци зэрэг Зөвлөлийн хурлыг олон нийтэд нээлттэй зохион байгуулж, хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн цахим хуудаст байршуулдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.ethicsboard.org хаягаар орж авна уу.

ДЭЛХИЙН НЯГТЛАН БОДОГЧДЫН ХОЛБООНЫ ҮҮРЭГ

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) нь хүчирхэг бөгөөд тогтвортой мэргэжлийн байгууллага, зах зээл болон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулснаар олон нийтийн эрх ашигт үйлчилдэг.

Тэрээр санхүүгийн тайлагналын ил тод, хариуцлагатай, зэрэгцүүлэгдэхүйц байдлыг дэмждэг; нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэхэд тусалдаг; дэлхий нийтийн санхүүгийн дэд бүтцэд нягтлан бодогчдын үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгуулан таниулдаг. 1977 онд байгуулагдсан ДНБХ одоогоор 130 гаруй улс, эрхзүйн орчны 175 гаруй гишүүд, холбоодоос бүрддэг бөгөөд тэдгээр нь нийтэд үйлчилдэг нягтлан бодох бүртгэл, боловсрол, засгийн газрын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийн салбарт ажилладаг 3 сая орчим нягтлан бодогчдыг төлөөлдөг.

ДНБХ нь олон нийтийн эрх ашигт үйлчлэх үүрэг хариуцлагынхаа хүрээнд, юуны өмнө НБЁЗОУСЗ-ийн үйл ажиллагааг дэмжин, нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартыг чанарын өндөр түвшинд боловсруулах, нэвтрүүлэх, мөрдүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. ДНБХ нь энэхүү бие даасан стандарт тогтоогч зөвлөлийн хүний нөөц, ажлын байрны удирдлага, харилцаа холбоо, санхүүжилтийг хариуцахаас гадна, уг Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээр сонгох үйл явцад нь дэмжлэг үзүүлдэг.

НБЁЗОУСЗ нь үйл ажиллагааны хөтөлбөрөө өөрөө боловсруулж, баримталбал зохих дүрэм, журамд нийцүүлэн хэвлэн нийтлэх баримт бичгүүдийг ДНБХ-ны оролцоогүйгээр батлан гаргадаг. Түүний үйл ажиллагааны хөтөлбөр болон хэвлэн нийтэлсэн баримт бичгүүдэд ДНБХ нөлөө үзүүлэх эрхгүй болно. ДНБХ зөвхөн гарын авлага, стандарт, бусад хэвлэлүүдийг хэвлэн нийтэлж, зохиогчийн эрхийг эзэмшдэг юм.

НБЁЗОУСЗ-ийн хараат бус байдлыг дараах хэд хэдэн арга замаар баталгаажуулдаг:

- ОНЭАХЗ нь нийтийн эрх ашгийг төлөөлөн, стандарт боловсруулах үйл явцад албан ёсны, хараат бус хяналт тавьдаг бөгөөд олон нийтээр хэлэлцүүлэх зэрэг хатуу чанга журам (дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл www.ipiob.org хаягт хандана уу) үйлчилдэг;
- Олон нийтийн дунд нэр дэвшүүлэх үйл ажиллагаа, сонгох үйл явцад ОНЭАХЗ албан ёсны, хараат бус хяналт тавьдаг;
- Стандарт боловсруулах албан ёсны үйл явц, хэлэлцэх асуудлын материал, хурал зөвлөгөөн ил тод байх, стандарт бүрээр хэвлэн нийтэлсэн эцсийн дүгнэлтийн үндэслэлийг олон нийт үзэх боломжтой байх;
- Стандарт тогтоох үйл явц дахь Зөвлөх Бүлэг ба шинжээчдийн оролцоо;
- НБЁЗОУСЗ-ийн гишүүд болон нэр дэвшүүлэгч/ажил олгогч байгууллагууд нь зөвлөлийн хараат бус болон шударга байдал, олон нийтийн өмнөх хүлээсэн эрхэм зорилгыг биелүүлж ажиллахаа амлах шаардлага.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.ifac.org хаягаар хандана уу.

ГАРЫН АВЛАГЫН ЦАР ХҮРЭЭ

2018 ОНЫ ХЭВЛЭЛ

Энэхүү гарын авлагад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны ерөнхий мэдээлэл болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан *Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаана) (Дүрэм)*-ын албан ёсны эх бичвэрийг хамтад нь багтаасан болно.

2016 ОНЫ ДҮРЭМД ОРСОН АГУУЛГЫН ШИНЖТЭЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дараах баримт бичгүүд гарснаар, 2016 онд шинэчлэн найруулсан ДНБХ-ны гарын авлага, *Мэргэжлийн нягтлан бодогчдын Ёс зүйн Дүрэм*-ийг энэхүү баримт бичиг дэх текст орлох болно. Үүнд:

- NOCLAR (Responding to Non-Compliance with Laws and Regulations)- ХТҮНТ-ын Тунхаглал буюу Хууль тогтоомжтой үл нийцсэн тохиолдолд авах хариу арга хэмжээ;
- *Байнгын баримт бичиг - Аудит эсвэл Баталгаажуулах үйлчилгээний үйлчлүүлэгчтэй удаан хугацаанд холбоотой байсан ажилтнуудын баримтлах Дүрмийн өөрчлөлт*;
- *Байнгын баримт бичиг - Мэдээлэл бэлтгэх ба толилуулах болон Суурь зарчмуудыг зөрчихөд хүргэх дарамт шахалтын талаар тодорхойлсон Дүрмийн Бүлэг В-д орсон өөрчлөлт*.

Өөрчлөлт

Гарын авлагын 2018 оны Хэвлэлийг бүтэц ба төсөл боловсруулах цоо шинэ хэлцлийн дагуу дахин бичиж гаргасан бөгөөд ингэснээр Дүрмээс хайлт хийх, ашиглах, сахиж мөрдөхөд илүү хялбар болсон. *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан)* хэмээн нэрийг нь өөрчилсөн уг Дүрэмд дараах хэд хэдэн чухал нэмэлт заалтыг оруулснаас гадна өмнөх заалтуудыг шинэчлэн найруулсан болно:

- Онолын үзэл баримтлалын ойлголтыг илүү өргөжүүлж, тодотгосон.
- Суурь зарчмын нийцэл ба хараат бус байдалд учрах аюул заналд илүү сайн зохицох хамгалалтын арга хэмжээний талаарх заалт буюу нөхцөлүүдийг илүү тодорхой, хүчтэй болгосон.
- Аудит ба баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй аливаа хувь хүний удаан хугацаанд хамтарч ажиллах асуудлыг хөндсөн заалтуудад хараат бус байх асуудлыг сайжруулсан.
- Бизнесийн салбар дахь мэргэжлийн нягтлан бодогч (БСМНБ)-дод зориулан дараах асуудлаар шинэ бөгөөд шинэчлэн найруулсан хэсгийг оруулсан:
 - мэдээллийг бэлтгэх ба толилуулах;
 - суурь зарчмуудыг зөрчихөд хүргэх дарамт шахалт.
- Дүрмийн Бүлэг 2-т БСМНБ-дод хамаарахаар заасан нөхцөлүүдийг нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч (НҮМНБ)-дод мөн мөрддөг байх талаар тодорхой удирдамж оруулсан.
- БСМНБ болон НҮМНБ-гчдын хувьд, бэлэг, дайллагыг санал болгох эсвэл түүнийг хүлээн авахтай холбоотой заалтыг илүү сайжруулсан.
- Мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх үедээ бодит байдал, нөхцөлийг ойлгохын ач холбогдлыг онцлон дурдсан ашиглах материалыг шинээр оруулсан.
- Суурь зарчимд нийцүүлснээр, аудит эсвэл бусад баталгаажуулах гэрээт ажилд мэргэжлийн үл итгэх үзлээ хэрэгжүүлэхэд хэр тус дэмтэй болохыг тайлбарласан шинэ ашиглах материал.

Хүчин төгөлдөр болох хугацаа

Бүлэг 1-3

- Бүлэг 1, 2, 3-ыг 2019 оны 6-р сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөнө.

Хараат бус байдлын олон улсын стандарт (4А ба 4Б)

- Аудитын болон нягтлах гэрээт ажилд зориулсан хараат бус байдлын талаарх Бүлэг 4А-г 2019 оны 6-р сарын 15 буюу түүнээс хойш эхлэх тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудит ба нягтлах ажилд дагаж мөрдөнө.
- Авч үзэх асуудлыг хамарсан хугацаатай холбоотой баталгаажуулах ажилд баримтлах хараат бус байдлыг тусгасан Бүлэг 4Б-г 2019 оны 6-р сарын 15 буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд; бусад тохиолдолд 2019 оны 6-р сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөх юм.

Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

Урт хугацаанд хамтран ажиллах нөхцөлийн тухай заалт

Өмнөх бүтэц ба төслийн тохиролцооны дагуу 2017 оны 1-р сард НБЁЗОУСЗ-өөс байнгын баримт бичиг болгон гаргасан урт хугацаанд хамтран ажиллахтай холбоотой Дүрмийн заалтын өөрчлөлтийн хүчинтэй мөрдөх хугацаа дараах байдалтай байна. Үүнд:

- (а) Дараах (в)-д дурдсан шилжилтийн нөхцөлийг харгалзан, 2018 оны 12-р сарын 15 ба түүнээс хойш эхлэх тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад 290.148-290.168-р параграфыг мөрдөнө.
- (б) Баталгаажуулалтын ажилд хамрагдсан тайлант үеийн хувьд, 291.137-291.141-р параграф нь 2018 оны 12-р сарын 15 ба түүнээс хойш эхлэх хугацаанд хүчин төгөлдөр болно. Өөрөөр хэлбэл үүнийг 2018 оны 12-р сарын 15-аас эхлэн мөрдөх юм.
- (в) 290.163-р параграфыг зөвхөн 2023 оны 12-р сарын 15-наас өмнө эхэлсэн тайлант үеүдийн санхүүгийн тайлангийн аудитад мөрдөнө. Хууль тогтоох байгууллага эсвэл зохицуулагч байгууллага (эрхтэй байгууллага юм уу, хууль тогтоох эсвэл зохицуулах байгууллагаас хүлээн зөвшөөрсөн этгээд)-ын зүгээс, дараалсан таваас цөөн жилийн түр завсарлах хугацаа зааж өгдөг хууль эрхзүйн орчинд, гэрээт ажлын партнерүүдэд шаардагдах шилжилтийн хугацааг дараалсан таван жил бүхий түр завсарлах хугацаа гэж үзэх боломж олгох юм.

Бүтцийн өөрчлөлт бүхий Дүрмийн хүчинтэй мөрдөх өдрийг Урт хугацааны харилцаа холбоог тусгасан заалт бүхий 290 ба 291-р хэсгийн өөрчлөгдсөн заалтуудыг хүчинтэй мөрдөх хугацаагаар орлуулахгүй байж үл болно.

2018 оны 7-р сараас хойших хугацаанд гарсан Дүрмийн Өөрчлөлт болон Саналын Төсөл

Сүүлийн үед боловсруулж байгаа ажлын тухай мэдээлэл авах болон 2018 оны 7-р сараас хойших хугацаанд гарсан эцсийн хувилбар бүхий тунхаглал, мөн хүлээгдэж байгаа саналын төслийг сонирхож байвал НБЁЗОУСЗ-ийн www.ethicsboard.org цахим хаягаар зочилно уу.

ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ЗААВАР

(Энэхүү Заавар нь Ёс зүйн дүрмийг ашиглах албан ёсны бус нэмэлт мэдээлэл болно.)

Дүрмийн Зорилт

1. *Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын дүрэм* (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан) ("Дүрэм") нь мэргэжлийн хувьд олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хариуцлагыг тусгасан мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн суурь зарчмуудыг тодорхойлсон болно. Эдгээр зарчимд мэргэжлийн нягтлан бодогчоос хүлээж болох зан төлөвийн стандартыг тогтоосон байна. Суурь зарчим нь: шударга байдал, бодитой байдал, мэргэжлийн ур чадвар, хянамгай байдал, нууц хадгалах, мэргэжлийн зан төлөв эдгээр болно.
2. Дүрэм нь суурь зарчмуудыг мөрдөхөд тулгарч буй аюул заналыг тодорхойлох, үнэлэх, шийдвэрлэхдээ мэргэжлийн нягтлан бодогчийн ашиглах онолын үзэл баримтлал болдог. Дүрэм нь тухайн сэдвээр онолын үзэл баримтлалыг ашиглахад нь нягтлан бодогчдод тус болохуйц янз бүрийн сэдвийн хүрээнд тавигдах шаардлага, ашиглах материалыг тодорхойлдог.
3. Аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулах ажлын хувьд, эдгээр ажилтай холбоотойгоор хараат бус байдалд учирч болох аюул заналд онолын үзэл баримтлалыг ашиглах *Хараат бус байдлын олон улсын стандартыг* энэхүү Дүрмээр тогтоосон болно.

Дүрмийн бүтэц ямар болсон талаар

4. Дүрэмд дараах материалыг багтаасан:
 - Бүлэг 1—суурь зарчим, онолын үзэл баримтлалыг тусгасан бөгөөд мэргэжлийн бүх нягтлан бодогчдод хамааралтай Дүрэм, Суурь зарчмууд болон Онолын үзэл баримтлалд нийцүүлэх.
 - Бүлэг 2—Бизнесийн салбар дахь мэргэжлийн нягтлан бодогчид, энд бизнесийн салбарт ажилладаг мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлийн үйлчилгээ гүйцэтгэхдээ ашигладаг нэмэлт материалыг тусгасан. Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч гэдэгт дараах жишээнд дурдсан салбарт гүйцэтгэх болон гүйцэтгэх бус албан тушаал эрхэлж, эсвэл гэрээгээр ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчдыг багтаадаг:
 - Худалдаа арилжаа буюу үйлчилгээ.
 - Улсын сектор.
 - Боловсрол.
 - Ашгийн төлөө бус салбар.
 - Зохицуулах эсвэл мэргэжлийн байгууллага.

Бүлэг 2—ыг мөн нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа тухайн компанитай гэрээлэгч, ажилтан эсвэл өмчлөгчийн аль нэр хэлбэрээр харилцаатай байх хувь хүмүүс мөрддөг.

 - Бүлэг 3—*Нийтэд Үйлчилдэг Мэргэжлийн Нягтлан Бодогчид*-г нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх үедээ мөрддөг нэмэлт материалыг багтаасан болно.
 - *Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт*-д нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан

бодогч нь баталгаажуулах үйлчилгээ үзүүлэх үедээ мөрддөг дараах нэмэлт материалыг багтаадаг:

- o Бүлэг 4А—*Аудит ба нягтлах ажлын хараат бус байдал*-ыг аудит эсвэл нягтлах гэрээт ажил гүйцэтгэж байх үедээ мөрдөнө.
- o Бүлэг 4Б—*Аудит ба нягтлах ажлаас бусад баталгаажуулах ажлын хараат бус байдал*-ыг аудит эсвэл нягтлах ажил биш гэрээт ажлаас бусад баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлэхдээ мөрддөг.

Тодорхой нэр томьёонуудыг агуулсан нэр томьёо (зүйтэй гэж үзсэн тохиолдолд нэмэлт тайлбар оруулсан) болон Дүрмийн тодорхой хэсгүүдэд тодорхой утгаар ашигласан нэр томьёоны тайлбар. Жишээлбэл, Нэр томьёоны тайлбарт дурдсанчлан, Бүлэг 4А-д "аудитын гэрээт ажил" гэсэн нэр томьёог аудит ба нягтлах гэрээт ажлын аль алинд ижил агуулгаар ашиглана. Мөн Нэр томьёоны хэсэгт энэ Дүрэм болон Дүрэмд хамааралтай авч үзэх бусад стандартад ашигладаг товчилсон үгсийн жагсаалтыг оруулсан болно.

5. Дүрэм нь тодорхой сэдвийг хөндсөн хэсгүүдтэй. Зарим хэсэг нь тэдгээр сэдвийн хүрээнд онцолсон асуудалд хамааралтай дэд хэсгүүдээс бүрддэг. Энэ Дүрмийн хэсэг бүрийн бүтэц дараах байдалтай байна. Үүнд:

- Танилцуулга—тухайн хэсэгт авч үзсэн асуудлыг тодруулж, үзэл баримтлалд тусгагдсан шаардлага, ашиглах материалыг танилцуулсан. Танилцуулах материалд Бүлэг болон түүнд хамаарах хэсэг бүрийн агуулгыг ойлгох, ашиглахад ач холбогдол бүхий нэр томьёог тайлбарласан мэдээллийг багтаадаг.
- Шаардлага—тодруулах асуудалтай холбогдуулан хүлээх ерөнхий болон тусгай үүрэг хариуцлагыг тогтоодог.
- Ашиглах материал—харгалзвал зохих орчин нөхцөл, тайлбар, авбал зохих арга хэмжээ болон шаардлагад нийцүүлэхэд тус дэм болох үлгэрчилсэн жишээ, бусад удирдамжаар хангадаг.

Дүрмийг Хэрхэн Ашиглах вэ?

Суурь зарчим, хараат бус байдал ба онолын үзэл баримтлал

6. Дүрэм нь мэргэжлийн нягтлан бодогчид ёс зүйн суурь зарчмуудыг дагаж мөрдөхийг шаарддаг. Суурь зарчмуудад нийцүүлэхэд тулгарч буй аюул заналыг тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын үзэл баримтлалаа мөрдөхийг тэдгээр нягтлан бодогчдоос энэхүү Дүрэм шаарддаг. Онолын үзэл баримтлалыг мөрдөх гэдэг нь мэргэжлийн шүүн тунгаалт хийх, шинэ мэдээлэл болон бодит байдал, орчин нөхцөлийн өөрчлөлтийг соргог тусгах, ул үндэслэлтэй бөгөөд мэдлэгтэй гуравдагч талын тестийг ашиглах шаардлагатай гэсэн үг юм.
7. Онолын үзэл баримтлалын хүрээнд мэргэжлийн, хууль тогтоох, зохицуулах, компани эсвэл ажил олгогч байгууллагаас тогтоосон нөхцөл байдал, бодлого, горим нь аюул заналыг олж тогтооход нөлөөлж болзошгүйг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр нөхцөл байдал, бодлого, горим нь мэргэжлийн нягтлан бодогчийн зүгээс аюул заналыг хүлээн зөвшөөрч болохуйц түвшин байгаа эсэхийг үнэлэхэд хамаарах хүчин зүйлс байж болох юм. Хэрэв аюул заналыг хүлээн зөвшөөрч болохуйц түвшинд биш байна гэж тухайн нягтлан бодогч дүгнэвэл тэдгээр аюул заналыг тодорхойлсон байхыг онолын үзэл баримтлалд шаарддаг. Хамгаалалтын арга хэмжээг дагаж мөрдөх нь аюул заналыг тодорхойлох нэг арга зам мөн юм. Хамгаалалтын арга хэмжээ гэдэг бол тухайн аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл үр дүнтэй бууруулахын тулд нягтлан бодогчийн дангаар нь эсвэл цогц байдлаар авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаа юм.
8. Үүнээс гадна, аудит, нягтлах ажил болон бусад баталгаажуулах гэрээт ажил гүйцэтгэхдээ ямагт хараат бус байхыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг. Хараат бус байдалд учирч болох аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхийн тулд онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхдөө суурь зарчмын нийцэлд учрах аюул заналтай ижил арга замыг хэрэгжүүлнэ.
9. Дүрмийг дагаж мөрдөхийн тулд дараах зүйлийг мэдэх, ойлгох, ашиглах шаардлагатай. Үүнд:
 - Бүлэг 1–ийн хүрээнд, тодорхой хэсгийн бүх холбогдох заалтыг Хэсэг 200, 300, 400, 900–д тусгасан нэмэлт материалуудын хамт.
 - Тухайн хэсгийн холбогдох бүх заалт, тухайлбал "Нийтлэг зүйл", "Аудитын бүх үйлчлүүлэгч" гэсэн дэд гарчиг бүхий заалтууд, үүний дотор "Нийтийн ашиг сонирхлыг үл төлөөлөх аж ахуйн нэгжүүдийн аудитын үйлчлүүлэгч" эсвэл "Нийтийн ашиг сонирхолтой аж ахуйн нэгжүүдийн аудитын үйлчлүүлэгч" гэсэн дэд гарчигтай хэсгүүдэд тодорхойлсон заалтуудын хамт.
 - Тухайн хэсгийн холбогдох бүх заалтыг дэд хэсэгт дурдсан холбогдох нэмэлт заалтуудын хамт.

Шаардлага болон ашиглах материал

10. Шаардлага ба ашиглах материалыг суурь зарчмуудад нийцүүлэх, онолын үзэл баримтлалыг мөрдөх болон аудит, нягтлах ажил ба бусад баталгаажуулах ажлыг хараат бусаар гүйцэтгэх зорилгод нийцүүлэн уншиж, хэрэгжүүлнэ.

Шаардлага

11. Шаардлагыг илэрхийлсэн параграфын дугаарыг "Ш" үсгээр тэмдэглэн тодруулсан бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд "ёстой" гэсэн утгыг илэрхийлнэ. "Ёстой" гэдэг утгаар илэрхийлэгдсэн Дүрмийн заалтуудыг мэргэжлийн нягтлан бодогч эсвэл компани онцгой анхаарч, түүнд нийцүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.
12. Зарим тохиолдолд, шаардлагад онцгойлон үл хамаарах зүйлийг Дүрэмд оруулсан байдаг. Ийм тохиолдолд, "Ш" үсгээр тодруулан тэмдэглэсэн ч гэсэн "болох юм, магадгүй" эсвэл үүнтэй ойролцоо нөхцөлт үйл үг хэрэглэдэг.
13. Дүрэмд "...-ж/ч болох; ...-ж/ч болох юм" гэдэг үгийг хэрэглэхдээ, тодорхой нөхцөл байдал үүсэх үед дүрмийн шаардлагад зааснаас бусад ямар нэг үйлдэл хийхийг зөвшөөрч байгааг илэрхийлсэн. Харин боломжтой гэдэг утгыг энэ үгээр илэрхийлэхгүй.
14. Асуудал үүсэх, үйл явдал тохиолдох эсвэл арга хэмжээ авах боломжтой гэсэн утгыг Дүрэмд илэрхийлэхдээ "-ж болзошгүй; "-х боломжтой" гэдэг үгийг ашигласан. Энэ нэр томъёог аюул заналтай холбогдуулан ашиглаж байвал, боломж эсвэл магадлалын тодорхой түвшнийг илэрхийлдэггүй, учир нь аюул заналын түвшин бол тодорхой асуудал, үйл явдал эсвэл арга хэмжээ авах бодит байдал, орчин нөхцөлөөс шалтгаалдаг.

Ашиглах материал

15. Шаардлагаас гадна, тухайн шаардлагыг зөв зүйтэй ойлгоход дэмжлэг болохуйц ашиглах материалыг Дүрэмд оруулсан байгаа. Тухайлбал, уг ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг тодорхой орчин нөхцөлд хэрхэн мөрдөх, тусгай шаардлагыг ойлгож, түүнд нийцүүлэхэд нь мэргэжлийн нягтлан бодогчид туслах зорилготой юм. Хэдийгээр ашиглах материал нь өөрөө Дүрмийн шаардлага биш боловч Дүрмийн шаардлагуудыг үнэн зөв мөрдөх, үүн дотор, онолын үзэл баримтлалыг мөрдөхөд тухайн материал чухал ач холбогдолтой. Ашиглах

материалыг "А" үсгээр тодруулан тэмдэглэсэн болно.

16. Ашиглах материалд олон жишээ жагсаан дурдсан байвал, бүх нөхцөл байдлыг энэхүү жагсаалтад нэг бүрчлэн илэрхийлсэн хэмээн ойлгож болохгүй юм.

Дүрмийн Зааврын Хавсралт

17. Энэхүү Зааврын Хавсралт нь уг Дүрмийн ерөнхий ойлголтыг агуулсан болно.

Дүрмийн ерөнхий ойлголт

<p>БҮЛЭГ 1</p> <p>ЁС ЗҮЙН ДҮРЭМ, СУУРЬ ЗАРЧИМ БА ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛЭХ НЬ</p> <p>(мэргэжлийн бүх нягтлан бодогч – ХЭСЭГ 100-199)</p>	<p>БҮЛЭГ 3</p> <p>НИЙГЭД ҮЙЛЧИЛДЭГ МЭРГЭЖЛИЙН НИЯГТЛАН БОДОГЧИД</p> <p>(ХЭСЭГ 300-399)</p>
<p>БҮЛЭГ 2</p> <p>БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ</p> <p>МЭРГЭЖЛИЙН НИЯГТЛАН БОДОГЧИД</p> <p>(ХЭСЭГ 200-299)</p> <p>(Бүлэг 2-ыг мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг компанитай холбоотой үйл ажиллагаа явуулдаг нийгэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч мөн мөрддөг)</p>	<p>ХАРААТ БУС БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ</p> <p>(БҮЛЭГ 4А БА 4Б)</p> <p>БҮЛЭГ 4А – АУДИТЫН ХАРААТ БУС БАЙДАЛ БА НИЯГТЛАХ ГЭРЭЭГ АЖИЛ</p> <p>БҮЛЭГ 4Б – АУДИТ БА НИЯГТЛАХ ГЭРЭЭГ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ ГЭРЭЭГ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ</p> <p>(ХЭСЭГ 900-999)</p>
<p>НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР</p> <p>(мэргэжлийн бүх нягтлан бодогч)</p>	

**МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧДЫН ЁС ЗҮЙН ОЛОН УЛСЫН ДҮРМИЙН ГАРЫН
АВЛАГА (ХАРААТ БУС БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ багтаасан)
АГУУЛГА**

	Хуудас
ӨМНӨХ ҮГ	14
БҮЛЭГ 1 – ЁС ЗҮЙН ДҮРЭМ, СУУРЬ ЗАРЧИМ БА ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛЭХ	
100 Ёс Зүйн Дүрмийн Нийцэл	16
110 Суурь Зарчим	18
111 – Шударга Байдал	19
112 – Бодитой Хандлага	19
113 – Мэргэжлийн Ур Чадвар ба Хянамгай Байдал	19
114 – Нууц Хадгалах	20
115 – Мэргэжлийн Зан Төлөв	21
120 Онолын Үзэл Баримтлал	22
БҮЛЭГ 2–БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД	
200 Онолын Үзэл Баримтлал – Бизнесийн Салбар Дахь Мэргэжлийн Нягтлан Бодогчид	29
210 Ашиг Сонирхлын Зөрчил	33
220 Мэдээлэл Бэлтгэх ба Толилуулах.....	35
230 Хангалттай Ур Чадвартай Гүйцэтгэх	39
240 Санхүүгийн Ашиг Сонирхол, Санхүүгийн Тайлагнал ба Шийдвэр Гаргалттай Холбоотой Нөхөн Олговор ба Урамшуулал	40
250 Бэлэг, Дайллага	42
260 Хууль Тогтоомжтой Үл Нийцэх Тохиолдолд Авах Арга Хэмжээ	47
270 Суурь Зарчмыг Зөрчихөд Хүргэх Дарамт Шахалт	54
БҮЛЭГ 3 – НИЙТЭД ҮЙЛЧИЛД МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД	
300 Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх – Нийтэд Үйлчилдэг Мэргэжлийн Нягтлан Бодогчид	58
310 Ашиг Сонирхлын Зөрчил	63
320 Мэргэжлийн Томилгоо	68
321 Хоёрдогч Дүгнэлт	71
330 Хураамж болон Бусад Төрлийн Урамшуулал	72
340 Бэлэг, Дайллага	74
350 Үйлчлүүлэгчийн Хөрөнгийн Хамгаалалт	79
360 Хууль Тогтоомжтой Үл Нийцэх Тохиолдолд Авах Арга Хэмжээ	80
БҮЛЭГ 4А – АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ	
400 Аудит ба Нягтлах Гэрээт Ажлын Хараат бус Байдалд Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх	91
410 Төлбөр, Хураамж	100
411 Нөхөн Олговор ба Үнэлгээний Бодлого	103

420	Бэлэг, Дайллага	104
430	Бодит ба Айлган Сүрдүүлсэн Зарга	105
510	Санхүүгийн Ашиг Сонирхол.....	106
511	Зээл ба Баталгаа	138
520	Бизнесийн Харилцаа Холбоо	140
521	Гэр Бүлийн ба Хувийн Харилцаа Холбоо	142
522	Аудитын Үйлчлүүлэгчид Үзүүлсэн Өнөөгийн Үйлчилгээ	145
523	Аудитын Үйлчлүүлэгчид Захирал эсвэл Ажилтан Байдлаар Үйлчлэх	146
524	Аудитын Үйлчлүүлэгчид Ажил Эрхлэх	147
525	Хувь Хүн Байдлаар Түр Зуур Үүрэг Гүйцэтгэх	150
540	Аудитын Үйлчлүүлэгчтэй Удаан Хугацааны Турш Холбоотой Байх (Партнерийн эргэцийг оруулна)	151
600	Аудитын Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Үйлчилгээ Үзүүлэх	155
601	– Нягтлан Бодох Бүртгэл ба Данс Хөтлөх Үйлчилгээ	158
602	– Захиргааны Үйлчилгээ.....	160
603	– Үнэлгээний Үйлчилгээ.....	161
604	– Татварын Үйлчилгээ	162
605	– Дотоод Аудитын Үйлчилгээ	166
606	– Мэдээллийн Технологийн Системийн Үйлчилгээ	168
607	– Зарга Шийдвэрлэхэд Дэмжлэг Үзүүлэх Үйлчилгээ	170
608	– Хууль Эрх Зүйн Үйлчилгээ	172
609	– Ажилтан Ажилд Авах Үйлчилгээ	173
610	– Корпорацийн Санхүүгийн Үйлчилгээ	173
800	Ашиглах ба Түгээхэд нь Хязгаарлалт Тавьсан Тусгай Зорилготой Санхүүгийн Тайлангийн Талаар Тайлагнах (Аудит Ба Нягтлах Гэрээт Ажил)	175
БҮЛЭГ 4Б – АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ ГЭРЭЭТ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ		
900	Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Гэрээт Ажлын Хараат бус Байдалд Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх	177
905	Төлбөр, Хураамж	184
906	Бэлэг, Дайллага	186
907	Бодит ба Болзошгүй Зарга	187
910	Санхүүгийн Ашиг Сонирхол	188
911	Зээл ба Баталгаа	191
920	Бизнесийн Харилцаа Холбоо.....	193
921	Гэр Бүлийн болон Хувийн Харилцаа Холбоо	194
922	Аудитын Үйлчлүүлэгчид Үзүүлсэн Өнөөгийн Үйлчилгээ	197
923	Аудитын Үйлчлүүлэгчид Захирал эсвэл Ажилтан Байдлаар Үйлчлэх	198
924	Аудитын Үйлчлүүлэгчид Ажил Эрхлэх	199

940	Аудитын Үйлчлүүлэгчтэй Удаан Хугацааны турш Боловсон Хүчний Холбоотой Байх	201
950	Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Үйлчилгээ Үзүүлэх	203
990	Ашиглах ба Түгээхэд нь Хязгаарлалт Тавьсан Тайлан (Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажил)	206
	НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР БА ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	208
	ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА	219

ӨМНӨХ ҮГ

НБЭЗОУСЗ нь стандарт тогтоох өөрийн эрх мэдлийн хүрээнд, Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (*Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан*) (“Дүрэм”)-ыг боловсруулан гаргадаг. Уг Дүрмийг дэлхийн өнцөг булан бүрд ажилладаг мэргэжлийн нягтлан бодогчид ашигладаг. НБЭЗОУСЗ нь уг Дүрмийг олон улсын хэмжээнд мөрдүүлэхээр тогтоосон болно.

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) нь энэхүү Дүрэмтэй холбоотойгоор өөрийн гишүүн байгууллагуудад зориулан тусгай шаардлага тавьдаг.

**БҮЛЭГ 1 – ЁС ЗҮЙН ДҮРЭМ, СУУРЬ ЗАРЧИМ БА ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД
НИЙЦҮҮЛЭХ**

	Хуудас
Хэсэг 100	Ёс зүйн дүрэмд нийцүүлэх нь 16
Хэсэг 110	Суурь зарчим 18
	Дэд хэсэг 111 –Шударга байдал 19
	Дэд хэсэг 112 - Бодитой хандлага 19
	Дэд хэсэг 113 - Мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдал 19
	Дэд хэсэг 114 - Нууцыг хадгалах 20
	Дэд хэсэг 115 - Мэргэжлийн зан төлөв 21
Хэсэг 120	Онолын үзэл баримтлал 22

БҮЛЭГ 1 – ЁС ЗҮЙН ДҮРЭМ, СУУРЬ ЗАРЧИМ БА ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛЭХ

ХЭСЭГ 100

ЁС ЗҮЙН ДҮРЭМД НИЙЦҮҮЛЭХ НЬ

Ерөнхий зүйл

- 100.1 А1 Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн бусдаас ялгарах шинж чанар нь нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлах явдал юм. Мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг нь зөвхөн хэн нэг үйлчлүүлэгч эсвэл ажил эрхэлж байгаа байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах явдал биш юм. Иймээс, энэхүү Дүрэмд нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлах боломжийг мэргэжлийн нягтлан бодогчдод олгохуйц шаардлага дагаж мөрдөх материалыг багтаасан болно.
- 100.2 А1 Энэ Дүрэмд “Ш” үсгээр тэмдэглэсэн зүйлийг албан ёсоор биелүүлэх үүрэг хариуцлага хэмээн ойлговол зохино.
- 100.2 А2 Мөрдөх материалыг “М” үсгээр тэмдэглэж, үүнд харгалзвал зохих үйлдэл эсвэл асуудлыг тайлбарлах, санал болгох байдлаар, мөн Дүрмийг үнэн зөв ойлгоход хамааралтай зурган жишээ, бусад удирдамжийг оруулсан байгаа. Ялангуяа, мөрдөх материалыг тодорхой нөхцөл байдалд онолын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах, тусгай шаардлагыг ойлгох, түүнд нийцүүлэхэд нь мэргэжлийн нягтлан бодогчдод тус дэм болоход чиглэдэг. Дагаж мөрдөх материал нь өөрөө шаардлага биш боловч түүнийг харгалзах нь Дүрмийн шаардлага, мөн онолын үзэл баримтлалыг зөв зүйтэй мөрдөхөд чухал юм.
- Ш100.3** Мэргэжлийн нягтлан бодогч нь энэ Дүрмийг дагаж мөрдөх ёстой. Хууль тогтоомжийн заалт нь энэ Дүрмийн зарим тодорхой хэсэгт нийцүүлэн ажиллахад нягтлан бодогчид саад учруулахаар байж болзошгүй. Ийм тохиолдол гарвал, тэрхүү хууль, тогтоомжийн заалтыг давууд үзэх боловч нягтлан бодогч энэ Дүрмийн бусад хэсгийн шаардлагыг сахин мөрдөх нь зүйтэй.
- 100.3 А1 Мэргэжлийн хүний зан төлөвийн зарчмын дагуу, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллахыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг. Хууль эрх зүйн зарим орчинд энэ Дүрэмд зааснаас ялгаатай эсвэл үүнээс хатуу шаардлага тавьдаг байж болзошгүй. Хууль эрх зүйн ийм орчинд ажилладаг нягтлан бодогч тэдгээр ялгааг сайтар мэдэж, хууль тогтоомжоор хориглоогүй бол тэрхүү хатуу чанга хуулийн заалтуудыг сахин биелүүлэх нь зүйтэй.
- 100.3 А2 Хэрэв энэ Дүрмийн аль нэг тухайлсан шаардлагыг мөрдвөл харилцан уялдаагүй үр дүн эсвэл нийтийн эрх ашигт харшлахуйц үр дүн үүсэх онцгой буюу ер бусын нөхцөл байдалтай мэргэжлийн нягтлан бодогч тулгарч болзошгүй. Энэ тохиолдолд, мэргэжлийн эсвэл зохицуулах байгууллагатай зөвлөлдөхийг нягтлан бодогчид зөвшөөрдөг.

Ёс Зүйн Дүрмийг Зөрчих

- Ш100.4** Ш400.80-Ш400.89 болон Ш900.50-Ш900.55-д *Хараат бус байдлын олон улсын стандартыг* тусгасан байгаа. Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч энэхүү Ёс Зүйн дүрмийн заалтыг зөрчсөн бол энэ зөрчил хэр ноцтой болох, суурь зарчмыг баримтлан ажиллах нягтлан бодогчийн чадавхад хэр нөлөөлөх зэргийг үнэлэх хэрэгтэй. Мөн нягтлан бодогч дараах алхмыг хийх нь зүйтэй:
- (а) Зөрчлийн үр дагаврыг боломжийн хэрээр даруй хангалттай тодорхойлохын тулд хийж болохуйц ямар алхам байна, түүнийг хийх;
 - (б) Холбогдох талуудад зөрчлийн талаар тайлагнах эсэхээ тодорхойлох.
- 100.4A1 Дээрх зөрчлийн талаар мэдэгдэх боломжтой талуудад уг зөрчлийн нөлөө тусаж мэдэх хүмүүс буюу мэргэжлийн эсвэл зохицуулах эсвэл хяналтын эрх мэдэл бүхий байгууллагын ажилтнуудыг багтаадаг.

ХЭСЭГ 110

СУУРЬ ЗАРЧИМ

Ерөнхий зүйл

110.1A1 Мэргэжлийн нягтлан бодогчийн хувьд заавал биелүүлэх таван суурь зарчим байдаг. Үүнд:

- (a) Шударга байдал – мэргэжлийн болоод бизнесийн бүхий л харилцаанд илэн далангүй, үнэнч шударга байхыг хэлнэ.
- (б) Бодитой хандлага – хэт өрөөсгөл бодол, сонирхлын зөрчил, бусдын зохисгүй нөлөөний улмаас мэргэжлийн болоод бизнесийн талаарх шүүн тунгаалтаасаа ухрахгүй байхыг хэлнэ.
- (в) Мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдал – дараах зүйлд:
 - (i) Өнөөгийн техникийн болоод мэргэжлийн стандарт, мөн холбогдох хууль тогтоомжид тулгуурлан, үйлчлүүлэгч ба ажил эрхэлж байгаа байгууллагад мэргэжлийн чадварлаг үйлчилгээ үзүүлэхийн тулд шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшиж, түүнийгээ хадгалдаг байх;
 - (ii) Харгалзвал зохих техникийн болоод мэргэжлийн зохих стандартад нийцүүлэн нямбай ажиллах.
- (г) Нууц хадгалах – мэргэжлийн болон бизнесийн харилцааны үр дүнд олж авсан мэдээллийн нууцыг чандлан сахих.
- (д) Мэргэжлийн зан төлөв- холбогдох хууль тогтоомжийг сахин мөрдөж, мэргэжлийн нэр хүндийг гутааж болох юм гэдгийг мэргэжлийн нягтлан бодогч мэддэг эсвэл мэдсэн байвал зохих аливаа үйлдлээс зайлсхийхийг хэлнэ.

Ш110.2 Мэргэжлийн нягтлан бодогч суурь зарчмыг нэг бүрчлэн сахих ёстой.

110.2 A1 Ёс зүйн суурь зарчмууд нь мэргэжлийн нягтлан бодогчоос хүлээгддэг зан төлөвийн стандартыг тодорхойлдог. Онолын үзэл баримтлалд, эдгээр суурь зарчмыг мөрдөхөд нь нягтлан бодогчдод тус дэм болохуйц арга хандлагыг тогтоож өгсөн байдаг. 111-115-р Дэд хэсэгт суурь зарчим тус бүрд хамаарах шаардлага ба мөрдөх материал оруулж өгсөн болно.

110.2A2 Мэргэжлийн нягтлан бодогчид суурь зарчмуудын нэг эсвэл хэд хэдийг зөрчсөн суурь зармын аль нэгийг зөрчих нөхцөлтэй тулгарч болох юм. Энэ тохиолдолд, нягтлан бодогч шаардлагатай гэж үзвэл, дараах хүмүүстэй нэргүйгээр зөвлөх талаар бодох нь зүйтэй. Үүнд:

- Компани эсвэл ажил эрхэлж байгаа байгууллагын доторх бусад хүмүүс.
- Засаглах эрхтэй хүмүүс.
- Мэргэжлийн байгууллага.
- Зохицуулах хүрээний байгууллага.
- Хуулийн зөвлөх.

Гэхдээ, ийм зөвлөгөө нь тухайн зөрчлийг шийдвэрлэх, эсвэл хэрэв шаардлагатай гэж үзвэл, хуулиар хориглоогүй тохиолдолд зөрчил үүсгэж буй асуудлаас салах талаар мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх хариуцлагаас нягтлан бодогчийг чөлөөлдөггүй.

110.2 A3 Асуудлын гол мөн чанар, хэлэлцсэн асуудлын дэлгэрэнгүй, гаргасан шийдвэр, уг шийдвэрийн үндэслэл зэргийг баримтжуулахад мэргэжлийн нягтлан бодогчийг хөхүүлэн дэмждэг.

ДЭД БҮЛЭГ 111 – ШУДАРГА БАЙДАЛ

- Ш111.1** Мэргэжлийн нягтлан бодогч нь шударга байх зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчим нь мэргэжлийн болоод бизнесийн бүхий л харилцаанд илэн далангүй, шударга байхыг шаарддаг.
- 111.1 A1 Шударга байдал гэдэг нь ажил хэргээ үнэнчээр, зөв шударга явуулахыг хэлнэ.
- Ш111.2** Мэргэжлийн нягтлан бодогч нь мэдээлэл дараах агуулгатай байна гэдэгт итгэлтэй байвал, тэрхүү тайлан, харилцаа, мэдээлэлтэй санамсаргүйгээр холбогдож үл болно. Үүнд:
- (а) Материаллаг хуурамч эсвэл төөрөгдүүлсэн батламж мэдэгдлийг агуулсан;
 - (б) Хайхрамжгүйгээр гоёчилсон батламж мэдэгдэл эсвэл мэдээллийг агуулсан;
 - (в) Оруулах ёстой байсан мэдээллийг орхигдуулсан буюу бүрхэгдүүлсэн бөгөөд ингэснээр төөрөгдөл үүсгэсэн гэж үзэж байгаа бол тухайн тайлан, маягтуудын мэдээлэл, харилцсан зүйлс болон бусад мэдээлэлтэй холбогдох ёсгүй.
- 111.2 A1 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь дээрх тайлан, харилцаа, бусад мэдээллээр өөрчлөн засварласан тайлан ирүүлбэл, түүнийг Ш111.2-р параграфыг зөрчөөгүй гэж үзнэ.
- Ш111.3** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч өөрийгөө дээрх Ш111.2-р параграфт дурдсан мэдээлэлтэй холбоотой гэдгээ мэдвэл, уг мэдээллээс өөрийгөө тусгаарлах арга хэмжээ авах ёстой.

ДЭД БҮЛЭГ 112 – БОДИТОЙ ХАНДЛАГА

- Ш112.1** Мэргэжлийн нягтлан бодогч нь бодитой хандах зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчим нь ерөөсгөл бодол, сонирхлын зөрчил, бусдын зохисгүй нөлөөний улмаас мэргэжлийн болоод бизнесийн талаарх шүүн тунгаалтаасаа ухрахгүй байхыг шаарддаг.
- Ш112.2** Хэрэв нөхцөл байдал болон хэлхээ холбоо нь тухайн үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодогчийн мэргэжлийн шүүн тунгаалтыг гажуудуулах буюу зохисгүй нөлөө үзүүлэхээр байвал тэрээр уг мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх ёсгүй.

ДЭД БҮЛЭГ 113 – МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР БА ХЯНАМГАЙ БАЙДАЛ

- Ш113.1** Мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдлын зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчим нягтлан бодогчдод дараах шаардлагыг тавьдаг. Үүнд:
- (а) Үйлчлүүлэгчид ба ажил олгогчдод мэргэжлийн чадварлаг үйлчилгээ үзүүлэхийн тулд шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байх;
 - (б) Техникийн болоод мэргэжлийн стандартад нийцүүлэн нягт нямбай ажиллах.
- 113.1 A1 Үйлчлүүлэгч болон ажил олгогч байгууллагадаа мэргэжлийн ур чадвар гаргаж үйлчилгээ үзүүлнэ гэдэг нь мэргэжлийн мэдлэг, ур чадварыг мэргэжлийн оновчтой шүүн тунгаалттай хослуулан мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.
- 113.1 A2 Мэргэжлийн ур чадвараа хадгалахын тулд холбогдох техникийн, мэргэжлийн болоод бизнесийн хөгжлийг байнга судалж, ойлгохыг шаарддаг. Мэргэжлийн тасралтгүй хөгжил нь мэргэжлийн орчинд ур чадвартай ажиллах чадавхаа хөгжүүлж, түүнийгээ хадгалах боломжийг мэргэжлийн нягтлан бодогчид олгодог.
- 113.1 A3 Хянамгай байх шаардлагад, даалгасан ажил үүргийг анхааралтай, бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь гүйцэтгэх шаардлагад нийцүүлж ажиллах хариуцлага ордог.
- Ш113.2** Мэргэжлийн нягтлан бодогчийн удирдлага дор, мэргэжлээрээ ажиллаж байгаа хүмүүс нь зохих сургалтад хамрагдан, түүнийг нь хянаж байгаа гэдэгт итгэлтэй байхын тулд ул үндэслэлтэй алхам

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

хэрэгжүүлэх замаар мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдлын зарчимд нийцүүлэх ёстой.

- Ш113.3** Зохих ёсоор шаардаж байгаа үед, мэргэжлийн нягтлан бодогч нь үйлчлүүлэгч, ажил олгогч байгууллага болон түүний мэргэжлийн үйлчилгээ буюу үйл ажиллагааны бусад хэрэглэгчдэд тухайн үйлчилгээ буюу үйл ажиллагааны уламжлалт хязгаарлагдмал байдлын талаар мэдүүлэн таниулах ёстой.

ДЭД БҮЛЭГ 114 – НУУЦ ХАДГАЛАХ

- Ш114.1** Мэргэжлийн нягтлан бодогч нь нууцыг хадгалах зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчим мэргэжлийн болон бизнесийн харилцааны үр дүнд олж авсан нууц мэдээллийг хүндэтгэн үзэхийг нягтлан бодогчдоос шаарддаг. Нягтлан бодогч дараах шаардлагыг биелүүлэх ёстой. Үүнд:

- (а) Нийгмийн орчинд, ялангуяа бизнесийн ойрын хамтрагч эсвэл ам бүл буюу гэр бүлийн ойрын гишүүн зэрэг хүмүүст санаандгүй илчлэх боломжоос сэрэмжлэх;
- (б) Өөрийн компани эсвэл ажил олгогч байгууллагын доторх мэдээллийн нууцыг хадгалах;
- (в) Ирээдүйн болзошгүй үйлчлүүлэгч эсвэл ажил олгогч байгууллагын өөрт нь дэлгэсэн мэдээллийн нууцыг хадгалах;
- (г) ирээдүйн болзошгүй үйлчлүүлэгчид болон ажил олгогчдын өөрт нь дэлгэсэн мэдээллийн нууцыг хадгалах;
- (д) Өөрийн компани эсвэл ажил олгогч байгууллагаас гадуур мэргэжлийн болон бизнесийн харилцааны үр дүнд олж авсан нууц мэдээллийг хуульд заасан мэргэжлийн үүрэг эсвэл эрхийн дагуу мэдээлэхээс бусад тохиолдолд, зохих ёсны бөгөөд тусгайлсан зөвшөөрөл авахгүйгээр илчлэх;
- (е) Мэргэжлийн болон бизнесийн харилцааны үр дүнд олж авсан нууц мэдээллийг өөрийн хувийн эрх ашиг эсвэл, гуравдагч талын эрх ашгийн төлөө ашиглах;
- (ё) Мэргэжлийн нягтлан бодогчийн хяналт дор ажиллаж байгаа ажилтнууд болон нягтлан бодогч өөрөө зөвлөгөө, тусламж авсан хүмүүс нь тухайн нягтлан бодогчийн нууц хадгалах үүргийг нь хүндэтгэн үзэж байгаа эсэхийг бататгах ул үндэслэлтэй алхам хийх.

- 114.1 A1 Мэргэжлийн нягтлан бодогчийн үйлчлүүлэгч эсвэл ажил олгогч байгууллага ба нягтлан бодогчийн хоорондох мэдээллийн урсгал чөлөөтэй байхад түлхэц болдог учраас, гэхдээ гуравдагч этгээдэд мэдээллийг илчлэхгүй байх хүрээнд мэдээллийн нууц нь нийтийн эрх ашигт үйлчилдэг. Гэхдээ, нууц мэдээллийг илчлэхийг мэргэжлийн нягтлан бодогчдоос шаарддаг эсвэл шаардаж магадгүй, эсвэл ийм мэдээллийг илчлэх нь зохистой байж болох дараах нөхцөл бий:

- (а) Мэдээлэл илчлэхийг хуулиар шаардах нөхцөл нь;
 - (i) Хуулийн заргын явцад баримт материал эсвэл бусад нотлох баримт болж байвал;
 - (ii) Хууль зөрчсөн нь илэрхий болсныг холбогдох төрийн байгууллагад мэдээлэх;
- (б) Мэдээлэл гаргаж өгөхийг хуулиар шаардсан бөгөөд үүнийг нь үйлчлүүлэгч эсвэл ажил олгогч байгууллага зөвшөөрсөн;
- (в) Хуулиар хориглоогүй бөгөөд дараах зорилгоор мэдээлэл гаргаж өгөх мэргэжлийн эрх буюу үүрэг байгаа бол:
 - (i) Мэргэжлийн байгууллагын чанарын хяналтад тавьдаг шалгуурт нийцүүлэх;
 - (ii) Мэргэжлийн эсвэл зохицуулах байгууллагын асуулга, судалгаанд хариу өгөх;
 - (iii) Хуулиар шийдэх зарга маргаанд мэргэжлийн нягтлан бодогчийн мэргэжлийн эрх ашгийг хамгаалах;
 - (iv) Техникийн болон мэргэжлийн стандарт, үүнд ёс зүйн шаардлагыг дагаж мөрдөх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- 114.1 A2 Нууц мэдээллийг илчлэх эсэх тухай шийдвэр гаргахдаа нөхцөл байдлаас хамааран харгалзвал зохих хүчин зүйлсэд дараах орно:
- Хэрэв үйлчлүүлэгч эсвэл ажил олгогч нь мэдээллийг илчлэхийг мэргэжлийн нягтлан бодогчид зөвшөөрвөл эрх ашиг нь хөндөгдөж магадгүй аливаа талууд, үүний дотор гуравдагч талуудын эрх ашигт хохирол учрах эсэх.
 - Холбогдох бүх мэдээллийг практик боломжтой хэмжээнд баримтжуулсан эсэх. Мэдээллийг илчлэх шийдвэрт нөлөөлж болох хүчин зүйл нь дараах байна:
 - Баримтаар нотлогдоогүй нөхцөл байдал.
 - Бүрэн гүйцэт бус мэдээлэл.
 - Баримтаар нотлогдоогүй дүгнэлт.
 - Харилцааны төлөвлөж байгаа хэлбэр, мэдээллийг хэнд хаяглах.
 - Харилцаагаар төлөвлөсөн талууд нь зохих ёсны хүлээн авагчид мөн эсэх.

Ш114.2 Нягтлан бодогч ба үйлчлүүлэгч эсвэл ажил олгогч байгууллагын хоорондох харилцаа дуусгавар болсны дараа ч мэргэжлийн нягтлан бодогч нууц хадгалах зарчмыг дагаж мөрдсөн хэвээр байна. Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь ажил эрхлэлтээ өөрчлөх гэж байгаа эсвэл шинэ үйлчлүүлэгчтэй болж байгаа бол өмнөх туршлагаа ашиглах эрхтэй боловч мэргэжлийн болоод бизнесийн харилцааны үр дүнд олж авсан эсвэл хүлээж авсан нууц мэдээллийг ашиглах буюу илчлэх ёсгүй.

ДЭД БҮЛЭГ 115 – МЭРГЭЖЛИЙН ЗАН ТӨЛӨВ

- Ш115.1** Мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн зан төлөвийн зарчмыг баримтлах ёстой бөгөөд энэ зарчим нь холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөх, мэргэжлийн нэр хүндийг гутааж болно гэдгийг мэддэг эсвэл мэдсэн байх ёстой аливаа үйлдлээс зайлсхийхийг мэргэжлийн бүх нягтлан бодогчоос шаарддаг. Шударга байдал, бодитой хандлага, мэргэжлийн өндөр нэр хүндийг гутаадаг эсвэл гутааж болох аливаа бизнес, албан тушаал, үйл ажиллагааг мэдсээр байж эрхлэх, ингэснээр суурь зарчмыг зөрчих нөхцөл үүсгэж болохгүй.
- 115.1 A1 Ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл сайтай гуравдагч тал нь мэргэжлийн өндөр нэр хүндэд сөргөөр нөлөөлөх боломжтой хэмээн дүгнэх магадлалтай үйл ажиллагааг мэргэжлийн нэр хүндийг гутааж болзошгүй үйл ажиллагаа гэж үздэг.
- Ш115.2** Маркетинг буюу сурталчилгааны үйл ажиллагаа явуулахдаа мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн нэр хүндийг сэвтүүлэх ёсгүй. Мэргэжлийн нягтлан бодогч шударга бөгөөд үнэнч байж, дараах үйлдлээс зайлсхийх ёстой:
- (а) Нягтлан бодогчийн санал болгодог үйлчилгээ, түүний мэргэшил ба туршлагыг хэтрүүлэн сурталчлах;
 - (б) Бусдыг басамжлан доромжлох, эсвэл бусдын ажилтай баримт нотолгоогүйгээр харьцуулах.
- 115.2 A1 Хэрэв зар сурталчилгаа буюу маркетингийн хэлбэр тохиромжтой эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогчид эргэлзээ төрж байвал тэрээр холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвлөлдөх нь зүйтэй.

ХЭСЭГ 120

ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Танилцуулга

- 120.1 Мэргэжлийн нягтлан бодогчдын ажиллаж буй нөхцөл байдал нь суурь зарчмуудтай зөрчилдөх аюул заналыг үүсгэж болзошгүй. Бүлэг 120-д суурь зарчимд нийцүүлэх, тэднийг нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хариуцлагаа биелүүлэхэд нь туслах зорилготой шаардлага болон ашиглах материалыг тусгасан болно. Энэхүү үзэл баримтлалд суурь зарчмын нийцэлд аюул занал учруулах мэргэжлийн янз бүрийн үйл ажиллагаа, эрх ашиг ба харилцаа бүхий нөхцөл байдлын олон тохиолдлыг харуулсан шаардлага ба ашиглах материал байгаа юм. Түүнээс гадна, эдгээр шаардлага ашиглах материал нь энэ Дүрмээр тусгайлан хориглоогүй тэр тохиолдолд л зөвхөн зөвшөөрөх боломжтой хэмээн нягтлан бодогч дүгнэхээс сэргийлж чадна.
- 120.2 Онолын үзэл баримтлал нь дараах тохиолдолд мэргэжлийн нягтлан бодогчийн баримтлах арга хандлагыг онцгойлон зааж байгаа юм. Үүнд:
- (а) Суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг олж тогтоох;
 - (б) Олж тогтоосон аюул заналыг үнэлэх;
 - (в) Аюул заналыг арилгах эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах замаар түүнийг шийдвэрлэх.

Шаардлага Ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- Ш120.3** Мэргэжлийн нягтлан бодогч нь Бүлэг 110–д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 120.3A1 Онолын үзэл баримтлалыг мөрдөхөд хамааралтай нэмэлт шаардлага ба ашиглах материалыг дараах хэсэгт тодорхойлсон болно. Үүнд:
- (а) Бүлэг 2 – *Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч*;
 - (б) Бүлэг 3 – *Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч*;
 - (в) *Хараат бус байдлын олон улсын стандарт* буюу:
 - (i) Бүлэг 4А – *Аудит ба нягтлах гэрээт ажлын хараат бус байдал*;
 - (ii) Бүлэг 4Б – *Аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах гэрээт ажлын хараат бус байдал*.
- Ш120.4 Ёс зүйтэй холбоотой асуудлыг авч үзэхдээ мэргэжлийн нягтлан бодогч, тухайн асуудал үүсээд байгаа эсвэл үүсэж болзошгүй орчин нөхцөлийг харгалзах нь зүйтэй. Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь компанитай харилцаа үүсгэсний дараа түүнд гэрээний дагуу, ажилтан эсвэл өмчлөгчийн хувиар мэргэжлийн үйл ажиллагаа гүйцэтгэж байвал; ийм нөхцөлд мөрддөг Бүлэг 2-ын заалтуудад нийцүүлэн ажиллах ёстой.
- Ш120.5 Онолын үзэл баримтлалыг мөрдөхдөө, мэргэжлийн нягтлан бодогч дараах алхмыг хийх ёстой. Үүнд:
- (а) мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх;
 - (б) шинэ мэдээлэл болон бодит байдал, нөхцөлийн өөрчлөлтийг анхааралтай, соргогоор ажигладаг байх;
 - (в) параграф 120.5A4-д тодорхойлсон ухаалаг, боловсролтой гуравдагч талын тестийг ашиглах.

Мэргэжлийн Шүүн Тунгаалтаа Хэрэгжүүлэх

- 120.5 А1 Мэргэжлийн шүүн тунгаалт гэдэг нь холбогдох сургалт, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлагаа бодит байдал, нөхцөлд тохируулан ашиглахыг хэлэх бөгөөд үүнд мэргэжлийн тодорхой үйл ажиллагааны мөн чанар ба далайц, эрх ашиг ба харилцаа багтдаг. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа, боломжтой үйлдлийн талаар мэдлэг бүхий шийдвэр гаргах, мөн энэ шийдвэр нь тухайн нөхцөлд тохиромжтой эсэхийг тодорхойлохын тулд онолын үзэл баримтлалыг ашиглах үед мэргэжлийн шүүн тунгаалт ашиглахыг нягтлан бодогчоос шаарддаг.
- 120.5 А2 Бодит байдал ба нөхцөлийг ойлгох нь онолын үзэл баримтлалыг зөв зүйтэй ашиглахын урьдчилсан нөхцөл юм. Энэ ойлголтыг олж авахад хэрэгтэй үйлдлээ тодорхойлох, мөн тэр нь суурь зарчимтай нийцэж байгаа эсэх дүгнэлт гаргахад мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгтэй болдог.
- 120.5 А3 Энэ ойлголтыг олж авахын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хийж байгаа мэргэжлийн нягтлан бодогч нь дараах асуудлыг бусад асуудлын хамт авч үзэх хэрэгтэй:
- Нягтлан бодогчийн мэддэг болсон бодит байдал ба нөхцөлөөс хамааралтай байх боломжтой мэдээлэл алга болсон байж болзошгүй ямар нэг шалтгаан байгаа эсэх.
 - Мэддэг болсон бодит байдал, нөхцөл ба нягтлан бодогчийн хүлээлтийн хооронд ямар нэг үл тохирол гарсан эсэх.
 - Дүгнэлт гаргахад нягтлан бодогчийн тусгай мэдлэг ба туршлага хангалттай эсэх.
 - Холбогдох тусгай мэдлэг ба туршлага бүхий бусад хүмүүстэй зөвлөлдөх шаардлага бий эсэх.
 - Өгч буй мэдээлэл нь дүгнэлт хийхэд ул үндэслэлтэй байж чадах эсэх.
 - Нягтлан бодогчийн өөрийнх нь итгэл үнэмшил/ зөн совин эсвэл өрөөсгөл хандлага нь түүнийг мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэхэд нөлөөлж болох эсэх.
 - Бэлэн байгаа мэдээлэлд тулгуурлан хүрч болох ул үндэслэлтэй өөр дүгнэлт байж болох эсэх.

Ухаалаг бөгөөд Боловсролтой Гуравдагч Тал

- 120.5 А4 Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч талын тест бол түүнтэй яг ижил дүгнэлтийг өөр нэг тал гаргаж болох магадлалыг мэргэжлийн нягтлан бодогч авч үзэхийг хэлнэ. Үүнийг дүгнэлт хийж байхдаа, нягтлан бодогчийн мэддэг эсвэл мэднэ гэж үндэслэлтэй хүлээж болох холбоотой бүх бодит баримт, нөхцөлийг үнэлж цэгнэдэг ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч талын хэтийн төлөв байдлаас хийдэг. Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч тал нь заавал нягтлан бодогч байх албагүй, гэхдээ ямар нэг алагчлах үзэлгүйгээр хийсэн нягтлан бодогчийн дүгнэлтийн зохистой эсэхийг ойлгож, дүгнэх хэмжээний мэдлэг, туршлагыг эзэмшсэн байх нь зүйтэй.

Аюул Заналыг Олж Тогтоох

- Ш120.6** Суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг мэргэжлийн нягтлан бодогч олж тогтоох ёстой.
- 120.6 А1 Бодит байдал ба нөхцөл, үүнд мэргэжлийн үйл ажиллагаа, эрх ашиг, харилцаа зэрэг суурь зарчмыг алдагдуулж болзошгүй зүйлсийг ойлгох нь дээрх нийцэлд учрах аюул заналыг олж тогтоох мэргэжлийн нягтлан бодогчийн урьдчилсан нөхцөл юм. Тодорхой нөхцөл байдал болон нягтлан бодогчийн ёс зүйтэй үйлдэл хийх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага, хууль тогтоомж, компани буюу ажил олгогч байгууллагаас тогтоосон бодлого, горим нь суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг тодорхойлоход

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

мөн тустай байдаг. 120.8 А2 параграфт эдгээр нөхцөл байдал, бодлого, горимын ерөнхий жишээг харуулсан бөгөөд эдгээр нь аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйл болно.

120.6 А2 Суурь зарчмын нийцэлд учрах аюул занал нь өргөн хүрээний бодит баримт, нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болно. Аюул занал учруулдаг нөхцөл тус бүрийг тодорхойлох боломжгүй. Түүнээс гадна, гэрээт ажил, ажлын үүрэг даалгаврын шинж чанар өөр хоорондоо адилгүй тул тус бүрийн учруулах аюул заналын төрөл ялгаатай байна.

120.6 А3 Суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг доор дурдсан нэг буюу хэд хэдэн категорт хувааж болно:

- (а) Хувийн ашиг сонирхлын аюул занал - санхүүгийн эсвэл өөр ашиг сонирхол нь мэргэжлийн нягтлан бодогчийн шүүн тунгаалт эсвэл зан төлөвт зохисгүй нөлөө үзүүлэх аюул занал;
- (б) Өөрийгөө хянах аюул занал – мэргэжлийн нягтлан бодогч өмнөх үед хийсэн шүүн тунгаалтаа; эсвэл нягтлан бодогчийн өөрийнх нь хийсэн эсвэл компани буюу ажил олгогч байгууллагад ажилладаг өөр хэн нэг хүний гүйцэтгэсэн үйл ажиллагаанд тулгуурлан тухайн нягтлан бодогч одоогийн үйл ажиллагааг шүүн тунгаахдаа тэдгээрийн үр дүнг зохистойгоор үнэлэхгүй байх аюул занал;
- (в) Өмгөөлөх аюул занал – Мэргэжлийн нягтлан бодогч өөрийн үйлчлүүлэгч эсвэл ажил олгогчийн байр суурийг сурталчлахдаа өөрийнх нь бодитой байх хандлагыг алдагдуулахуйц түвшинд хүрэх аюул занал;
- (г) Танилын аюул занал – Үйлчлүүлэгч эсвэл ажил олгогчтой урт удаан, эсвэл ойр дотно харилцаатай байсны улмаас мэргэжлийн нягтлан бодогч нь тэдгээрийн эрх ашигт хэт найр тавих, эсвэл ажилд нь хэт хүлээцтэй хандах аюул занал;
- (д) Айлган сүрдүүлэх аюул занал – Тухайн мэргэжлийн нягтлан бодогчид зохисгүй нөлөө үзүүлэхийг оролдох гэх мэт бодитой буюу илэрхий дарамт шахалтын улмаас мэргэжлийн нягтлан бодогчийг бодитой ажиллахад нь саад учруулах аюул занал.

Аюул Заналыг Үнэлэх

Ш120.7 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг олж тогтоохдоо эдгээр аюул занал нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэхийг үнэлэх ёстой.

Хүлээн Зөвшөөрөгдөх Түвшин

120.7А1 Ухаалаг, боловсролтой гуравдагч талын тестийг ашиглаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч нь уг нягтлан бодогчийг суурь зарчимд нийцүүлэн ажиллаж байгаа хэмээн дүгнэх магадлалын түвшнийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин гэнэ.

120.8А1 Мэргэжлийн нягтлан бодогч нь аюул заналын далайцыг үнэлэхдээ тоо хэмжээ ба чанарын хүчин зүйлийг харгалзах, ингэхдээ хэрэв боломжтой бол олон аюул заналын нэгдмэл үр нөлөөг харгалзах нь зүйтэй.

120.8А2 Параграф 120.6А1-д тодорхойлсон нөхцөл, бодлого, горимтой эсэх нь суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг үнэлэхэд мөн хамааралтай хүчин зүйлс юм. Эдгээр нөхцөл байдал, бодлого, горимын ерөнхий жишээг доор харуулсан болно. Үүнд:

- Корпорацийн засаглалын шаардлага.
- Мэргэжилд шаардагдах боловсрол, сургалт, туршлага.
- Мэргэжлийн нягтлан бодогч болон нийт ард иргэдийн анхаарлыг ёс зүйгүй зан төлөвт хандуулах боломж олгодог нийцлийн үр өгөөжтэй систем.
- Ёс зүйн шаардлагын зөрчлийг тайлагнахыг илэрхий тодорхойлсон үүрэг даалгавар.
- Мэргэжлийн эсвэл зохицуулагч байгууллагын мониторинг ба сахилгын горим.

Шинэ Мэдээлэл Болон Бодит Байдал, Нөхцөлийн Өөрчлөлтийг Харгалзах

- Ш120.9** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч аюул заналыг арилгасан, эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах эсэхэд нөлөөлж болохуйц шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлтийг мэдэж авсан бол тэрхүү аюул заналыг дахин үнэлж, зохих ёсоор тодорхойлох ёстой.
- 120.9 А1 Мэргэжлийн үйл ажиллагааны туршид шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлт гарсан эсэхийг анхааралтай, соргоогоор ажигладаг байх нь мэргэжлийн бодогчид дараах зүйлийг тодорхойлоход нь тус дэм болдог. Үүнд:
- (а) Аюул заналын далайцад нөлөөлөх;
 - (б) Ашигласан хамгаалалтын арга нь олж тогтоосон аюул заналыг тодорхойлоход цаашид тохиромжтой хэвээр байх эсэх талаар хийсэн нягтлан бодогчийн дүгнэлтэд нөлөөлөх.
- 120.9 А2 Хэрэв шинэ мэдээллийн үр дүнд шинэ аюул занал үүссэнийг олж тогтоовол, түүнийг үнэлж, тухайн аюул заналыг тодорхойлохыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг. (Лав: Параграф Ш120.7, Ш120.10).

Шинэ Мэдээлэл Болон Бодит Байдал, Нөхцөлийн Өөрчлөлтийг Харгалзах

- Ш120.9** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч аюул заналыг арилгасан, эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах эсэхэд нөлөөлж болохуйц шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлтийг мэдэж авсан бол тэрхүү аюул заналыг дахин үнэлж, зохих ёсоор тодорхойлох ёстой.
- 120.9А1 Мэргэжлийн үйл ажиллагааны туршид шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлт гарсан эсэхийг анхааралтай, соргоогоор ажигладаг байх нь мэргэжлийн бодогчид дараах зүйлийг тодорхойлоход нь тус дэм болдог. Үүнд:
- (а) Аюул заналын далайцад нөлөөлөх;
 - (б) Ашигласан хамгаалалтын арга нь олж тогтоосон аюул заналыг тодорхойлоход цаашид тохиромжтой хэвээр байх эсэх талаар хийсэн нягтлан бодогчийн дүгнэлтэд нөлөөлөх.
- 120.9 А2 Хэрэв шинэ мэдээллийн үр дүнд шинэ аюул занал үүссэнийг олж тогтоовол, түүнийг үнэлж, тухайн аюул заналыг тодорхойлохыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг. (Лав: Пара. Ш120.7, Ш120.10).

Аюул Заналыг Тодорхойлох

- Ш120.10** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч суурь зарчмын нийцэлд учрах аюул занал нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд биш байгааг тодорхойлсон бол тэрээр аюул заналыг арилгах эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах хамгаалалтыг тодорхойлох ёстой. Үүнийг дараах байдлаар хийнэ. Үүнд:
- (а) Аюул занал үүсгэж байгаа эрх ашиг ба харилцаа гэх мэт нөхцөл байдлыг арилгах;
 - (б) Аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулахын тулд ашиглаж байгаа бэлэн буюу тохиромжтой хамгаалалтыг хэрэглэх;
 - (в) Мэргэжлийн тусгай үйл ажиллагаанаас татгалзах эсвэл дуусгавар болгох.

Аюул Заналыг Арилгах Үйлдлүүд

- 120.10 А1 Бодит баримт ба нөхцөлөөс шалтгаалан, аюул занал үүсгэж байгаа нөхцөлийг арилгах замаар тухайн аюулыг тодорхойлох боломжтой. Гэхдээ, зарим тохиолдолд, аюул заналыг зөвхөн мэргэжлийн тусгай үйл ажиллагаанаас татгалзах эсвэл дуусгавар болгосноор тодорхойлох боломжтой байж болно. Учир нь, аюул занал үүсгэсэн нөхцөлийг арилгах боломжгүй бөгөөд ашиглах гэж байгаа хамгаалалт нь аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулж чадахаргүй байж болно.

Хамгаалалт

- 120.10 А2 Хамгаалалт гэдэг нь суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулахад дангаараа эсвэл нийлмэл байдлаар үр дүнтэй гэж мэргэжлийн нягтлан бодогч үзэн, хэрэгжүүлдэг үйлдэл юм.

Гаргасан Чухал Шүүн Тунгаалт ба Ерөнхий Дүгнэлт

- Ш120.11** Үүссэн аюул заналыг тодорхойлохын тулд нягтлан бодогчийн хэрэгжүүлдэг эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйлдэл нь тэдгээр аюул заналыг арилгах, эсвэл хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогч ерөнхий дүгнэлт гаргах ёстой. Ийм ерөнхий дүгнэлт гаргахдаа, нягтлан бодогч дараах алхмыг хийх нь зүйтэй. Үүнд:

- (а) Гаргасан томоохон шүүн тунгаалт ба дүгнэлтээ нягтлах;
- (б) Ухаалаг, боловсролтой гуравдагч талын тест ашиглах.

Аудит, Нягтлах Ажил, бусад Баталгаажуулах Гэрээт Ажлыг Харгалзаж Үзэх

Хараат бус Байдал

- 120.12 А1 Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулах ажил гүйцэтгэхдээ хараат бус байхыг *Хараат бус байдлын олон улсын стандартаар* шаарддаг. Хараат бус байдал нь бодитой хандлага ба шударга байдлын суурь зарчимтай холбоотой юм. Хараат бус байдал нь дараах зүйлсээс бүрдэнэ:

- (а) Сэтгэл санааны хараат бус байдал –мэргэжлийн шүүн тунгаалтын үнэ цэнийг алдагдуулах нөлөөнд үл автуулах, тэгснээрээ шударга, бодитой, мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандан дүгнэлт илэрхийлэх боломж олгохуйц сэтгэл санааны байдал.
- (б) Гадна төрхийн хараат бус байдал – ухаалаг бөгөөд мэдлэгтэй гуравдагч этгээд нь компанийн эсвэл аудит, эсвэл баталгаажуулах багийн гишүүний шударга ёс, бодитой хандлага, мэргэжлийн үл итгэх үзэл алдагдсан гэж үндэслэлтэйгээр дүгнэж болохуйц бодит баримт, нөхцөл байдлаас зайлсхийх явдал.

- 120.12 А2 *Хараат бус байдлын олон улсын стандартад* аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулах гэрээт ажил гүйцэтгэх явцад хараат бус байдлаа хадгалах онолын үзэл баримтлалыг хэрхэн мөрдөх талаарх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон байдаг. Мэргэжлийн нягтлан бодогчид болон компаниуд дээр дурдсан гэрээт ажлыг хийхдээ хараат бус байхын тулд эдгээр стандартад нийцүүлэх ёстой. Суурь зарчмын нийцэлд учирч болох аюул заналыг тогтоох, үнэлэх, тодорхойлох онолын үзэл баримтлалыг хараат бус байх шаардлагад мөн нийцэхүйц арга замаар хэрэгжүүлэх нь зүйтэй. 120.6А3-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учрах аюул заналын ангилал бол мөн хараат бус байх шаардлагын нийцэлд учрах аюул заналын ангилал юм.

Мэргэжлийн Үл Итгэх Үзэл

- 120.13 А1 Аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулалтын стандарт болон АБОУСЗ-өөс гаргасан бусад баримт бичигт шаардсаны дагуу, нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулах гэрээт ажлыг төлөвлөн гүйцэтгэхдээ мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлах ёстой. Хэсэг 110-д тодорхойлсон мэргэжлийн үл итгэх үзэл ба суурь зарчим бол хоорондоо харилцан уялдаатай ухагдахуун/ ойлголт юм.

- 120.13 А2 Санхүүгийн тайлангийн аудитад, суурь зарчимд дангаараа эсвэл хамтаараа нийцсэн байх нь мэргэжлийн үл итгэх үзлээ хэрэгжүүлэхэд тус дэм болдог бөгөөд үүнийг дараах жишээнд

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

харуулав:

- Шударга байдал нь мэргэжлийн нягтлан бодогчийг шулуун шударга бөгөөд үнэнч байхыг шаарддаг зарчим юм. Шударга байх зарчимд нийцүүлэхийн тулд нягтлан бодогч дараах алхмыг хийх ёстой:
 - а) Үйлчлүүлэгчийн байр суурийн талаар асуудал үүсвэл энэ тухай шулуун шударга бөгөөд үнэнч байх;
 - б) Материаллаг хэмжээний худал эсвэл төөрөгдүүлсэн байж болох тайлангийн асуудлыг тодруулахдаа тухайн нөхцөлд хийвэл зохих үйл явцын талаар оновчтой шийдвэр гаргахын тулд тохирохгүй байгаа мэдээллээр асуулга явуулж, дараагийн аудитын нотлох баримт эрж хайх.

Ингэхдээ, нягтлан бодогч нь мэргэжлийн үл итгэх үзлээ хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц аудитын нотлох баримтыг онцлон үнэлснээ үзүүлэх хэрэгтэй.

- Бодитой хандлага нь мэргэжлийн нягтлан бодогчдыг хувийн үзэл бодол, сонирхлын зөрчил, бусдын зохисгүй нөлөөний улмаас мэргэжлийн эсвэл бизнесийн шүүн тунгаалтаасаа гажихгүй байхыг шаарддаг зарчим юм. Жишээлбэл, дараах алхмыг хийх нь нягтлан бодогчийг бодит байх хандлагын зарчимд нийцсэн байхыг илтгэдэг. Үүнд:
 - (а) Нягтлан бодогчийг мэргэжлийн эсвэл бизнесийн шүүн тунгаалтаа гажихад хүргэж болзошгүй, өөрөөр хэлбэл үйлчлүүлэгчтэй танил байх гэх мэт нөхцөл буюу харилцааг ойлгож мэдэх;
 - (б) Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий зүйлтэй холбоотой аудитын нотолгоо хангалттай бөгөөд тохиромжтой эсэхийг үнэлж байх үед дээрх нөхцөл эсвэл харилцааны улмаас нягтлан бодогчид үүсэж болох нөлөөг харгалзах.

Ингэхдээ, нягтлан бодогч нь мэргэжлийн үл итгэх үзлээ хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц арга хэлбэрээр өөрийгөө авч явах ёстой.

- Мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдал нь холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу нягт нямбай ажиллах, мэргэжлийн чадварлаг үйлчилгээ үзүүлэх хэмжээний мэргэжлийн мэдлэг ба ур чадвартай байхыг мэргэжлийн нягтлан бодогчдоос шаарддаг зарчим юм. Жишээлбэл, дараах алхмыг хийх нь нягтлан бодогчийг мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдлын зарчимд нийцсэн байхыг илтгэдэг. Үүнд:
 - (а) Материаллаг буруу тайлагналын эрсдэлийг зохих ёсоор тогтоохын тулд тодорхой үйлчлүүлэгчийн ажилладаг салбар ба бизнесийн үйл ажиллагаанд хамаарах мэдлэгийг ашиглах;
 - (б) Аудитын тохиромжтой горимыг зохиомжлон гүйцэтгэх;
 - (в) Аудитын нотолгоо хангалттай бөгөөд тохиромжтой эсэхийг үнэлж байх үедээ хамаарах мэдлэгийг ашиглах.

Ингэхдээ, нягтлан бодогч нь мэргэжлийн үл итгэх үзлээ хэрэгжүүлэхэд тус дэм болохуйц арга хэлбэрээр өөрийгөө авч явах ёстой.

БҮЛЭГ 2 – БИЗНЕС ДЭХ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД

		Хуудас
Хэсэг 200	Онолын Үзэл Баримтлалыг Дагаж Мөрдөх-Бизнесийн Салбар Дахь Мэргэжлийн Нягтлан Бодогчид	29
Хэсэг 210	Ашиг Сонирхлын Зөрчил	33
Хэсэг 220	Мэдээллийг Бэлтгэх ба Толилуулах	35
Хэсэг 230	Хангалттай Мэдлэг, Туршлага Эзэмшиж Ажиллах	39
Хэсэг 240	Санхүүгийн Ашиг Сонирхол, Санхүүгийн Тайлагнал Ба Шийдвэр Гаргалттай Холбоотой Урамшуулал, Шан Хүртээмж	40
Хэсэг 250	Бэлэг, Дайллага	42
Хэсэг 260	Хууль Тогтоомжийн Үл Нийцлийн Эсрэг Авах Хариу Арга Хэмжээ	47
Хэсэг 270	Суурь Зарчмыг Зөрчихөд Хүргэдэг Дарамт	54

БҮЛЭГ 2 – БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД

ХЭСЭГ 200

ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ДАГАЖ МӨРДӨХ- БИЗНЕСИЙН САЛБАР ДАХЬ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД

Танилцуулга

- 200.1 Ёс зүйн стандартын энэ Бүлэгт бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчид Хэсэг 120-д тусгасан онолын үзэл баримтлалыг мөрдөхдөө ашиглах шаардлага ба бусад материалыг тодорхойлсон болно. Энд бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчид тулгарч болох бөгөөд суурь зарчмын нийцэлд аюул занал учруулж болзошгүй мэргэжлийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцааны бүх бодит байдал, нөхцөлийг нэг бүрчлэн тодорхойлоогүй. Тиймээс бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчдыг ийм нөхцөл байдал, харилцаа холбооноос сэрэмжлэхийг шаарддаг.
- 200.2 Хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, ажил олгогчид болон бизнесийн бусад салбар, мөн засгийн газар, олон нийт бүхэлдээ бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчийн ажилд тулгуурлаж болно. Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчид нь өөрсдийн ажил олгогч байгууллага ба гуравдагч талын аль аль нь тулгуурлаж болох санхүүгийн болон бусад мэдээлэл бэлтгэх, тайлагнах хариуцлагыг дангаараа эсвэл хамтдаа хүлээж болно. Тэд мөн үр өгөөжтэй санхүүгийн удирдлага болон бизнестэй холбоотой олон янзын асуудлаар чадварлаг зөвлөгөөгөөр хангах хариуцлага хүлээж болно.
- 200.3 Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч нь цалинждаг албан хаагч, партнер, захирал (гүйцэтгэх, гүйцэтгэх бус аль нь ч байж болно), эзэн-менежер, сайн дурын ажилтан эсвэл ажил олгогч байгууллагад нэг ба түүнээс дээш ажиллаж буй өөр хэн нэгэн байж болно. Ажил олгогч байгууллагатай тогтоосон харилцааны хуулийн хэлбэр нь аливаа бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн үүрэг хариуцлагад нөлөөлөхгүй.
- 200.4 Энэ Бүлэгт, “мэргэжлийн нягтлан бодогч” гэсэн нэр томъёо нь дараах хүмүүстэй холбоотой ойлголт юм. Үүнд:
- (а) Бизнесийн салбарт ажилладаг мэргэжлийн нягтлан бодогч;
 - (б) Гэрээгээр эсвэл ажилтан эсвэл эзний хувьд нягтлан бодогчдын компанитай холбоотой мэргэжлийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа мэргэжлийн нягтлан бодогч хувь хүн. Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид Бүлэг 2-ыг мөрдөх тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг Ш120.4, Ш300.5, 300.5A1 параграфт тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- Ш200.5** Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Бүлэг 110-д тодорхойлсон суурь зарчим, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 200.5 A1 Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч нь ажил олгогч байгууллагынхаа хууль ёсны зорилтыг биелүүлэхэд үйлчлэх хариуцлага хүлээнэ. Энэ Дүрэм нь уг хариуцлагыг зохистойгоор биелүүлэхэд нь мэргэжлийн нягтлан бодогчид саад болохгүйг эрмэлзэх боловч суурь зарчмуудын нийцлийг алдагдуулж болзошгүй нөхцөл байдлуудыг авч үзнэ.
- 200.5 A2 Ажил олгогч байгууллагуудынхаа хууль ёсны зорилго болон зорилтуудын төлөө үйлчлэхдээ хийсэн аливаа мэдэгдлүүд нь хуурамч биш, мөн төөрөлдүүлсэн биш бол байгууллагын байр суурийг нэмэгдүүлэх сурталчилгаа хийж болно. Ийм үйл ажиллагаа нь ерөнхийдөө өмгөөлөх аюул заналыг бий болгодоггүй.
- 200.5 A3 Албан тушаалын зэрэглэл ахих тусам үйл явдал, практик, хандлагуудад нөлөөлөх чадамж өсдөг. Ёс зүйтэй зан төлөвт дээд удирдлагаас оноож буй ач холбогдлыг эрхэмлэн үздэг ёс зүйд суурилсан соёлыг ажил олгогч байгууллага дотроо хөхүүлэн дэмжихийг бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогчоос хүлээдэг. Авч болох арга хэмжээнд дараах баримт бичгийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хөндлөнгөөс хянах үйлдэл орно.

Үүнд:

- Ёс зүйн боловсрол ба сургалтын хөтөлбөр.
- Ёс зүй ба шүгэл-үлээгчийн бодлого.
- Хууль тогтоомжид үл нийцэх үйлдлээс урьдчилан сэргийлэхийн тулд боловсруулсан бодлого, горим.

Аюул Заналыг Олж Тогтоох

200.6 А1 Суурь зарчмын нийцэлд учрах аюул занал нь өргөн хүрээний бодит баримт, нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болно. 120.6А3-р параграфт аюул заналын ангилал буюу төрлийн талаар дурдсан болно. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нягтлан бодогчид аюул занал учруулж болох бодит байдал ба нөхцөлийг аюул заналын төрөл тус бүрээр жишээлэн харуулсан болно:

- (а) Хувийн ашиг сонирхлын аюул занал
- Ажил олгогч байгууллагадаа санхүүгийн ашиг сонирхол эзэмшдэг, түүнээс зээл эсвэл зээлийн баталгаа авсан мэргэжлийн нягтлан бодогч.
 - Ажил олгогч байгууллагын санал болгосон урамшууллын нөхөн олговрын хэлцэлд оролцож байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
 - Хувийн зорилгоор корпорацийн хөрөнгөд хүрсэн мэргэжлийн нягтлан бодогч.
 - Ажил олгогч байгууллагын бэлтгэн нийлүүлэгчээс бэлэг эсвэл онцгой дайллага цайллагад оролцох санал хүлээн авсан мэргэжлийн нягтлан бодогч.
- (б) Өөрийгөө хянах аюул занал
- Худалдан авалтын шийдвэрийг дэмжих зорилготой техник эдийн засгийн үндэслэл боловсруулсны дараа бизнесийн нэгдэлд тохирох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлж байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
- (в) Өмгөөлөх аюул занал
- Өөрт ашигтай санхүүжилт олж авахын тулд хөрөнгийн бирж дээр гарах компанийн танилцуулга дахь мэдээллийг овжиноор гуйвуулах боломжтой байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
- (г) Танилын аюул занал
- Тухайн байгууллагад ажилладаг ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь байгууллагын санхүүгийн тайлагналд нөлөөлөхүйц шийдвэр гаргадаг тохиолдолд уг ажил олгогч байгууллагын санхүүгийн тайлагналын хариуцлагыг хүлээж байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
 - Бизнесийн шийдвэрт нөлөө бүхий хувь хүмүүстэй урт хугацаанд холбоотой байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
- (д) Айлган сүрдүүлэх аюул занал
- Дараах зүйлийн талаар санал зөрүүтэй байсны улмаас мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түүний ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд ажлаас халагдах эсвэл өөр ажилд шилжих аюул занал учирч байгаа:
 - Нягтлан бодох бүртгэлийн зарчмыг мөрдөх.
 - Санхүүгийн мэдээллийг тайлагнах арга хэлбэр.
 - Мэргэжлийн нягтлан бодогчийн шийдвэр гаргах үйл явц, тухайлбал, гэрээ байгуулах, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг мөрдөх зэрэгт нөлөөлөхийг оролдох.

Аюул Заналыг Үнэлэх

- 200.7 А1 Параграф 120.6А1, 120.8А2-т тодорхойлсон нөхцөл, бодлого, горим нь суурь зарчмын нийцэлд учруулах аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх үнэлгээнд нөлөөлж болох юм.
- 200.7 А2 Аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогчийн хийх үнэлгээнд мэргэжлийн үйл ажиллагааны мөн чанар ба цар хүрээ мөн нөлөөлөх боломжтой.
- 200.7 А3 Аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогчийн хийх үнэлгээнд түүний ажиллаж байгаа байгууллагын ажлын орчин болон үйл ажиллагааны орчин нөлөөлөх боломжтой. Жишээлбэл:
- Ёс зүйтэй зан төлөвийг чухалчилдаг манлайлал ба ажиллагчид ёс зүйгээ баримтлан үйл ажиллагаа явуулна гэсэн хүлээлт.
 - Ажиллагчдын сэтгэл зовоож буй ёс зүйтэй холбоотой асуудал байвал шийтгэл хүлээх айдасгүйгээр дээд түвшний удирдлагад мэдээлэх боломжийг ажиллагчдад олгох, урамшуулах бодлого ба горим.
 - Ажиллагчдын гүйцэтгэлийн чанарыг хэрэгжүүлж, хянан шинжлэх бодлого ба горим.
 - Корпорацийн хөндлөнгийн хяналт буюу бусад хяналтын бүтэц, хүчтэй дотоод хяналтын систем/ тогтолцоо.
 - Чадавх сайтай, нэр хүндтэй ажилтан элсүүлж авахыг чухалчилсан боловсон хүчний горим.
 - Бодлого, горим болон тэдгээрт оруулсан өөрчлөлтийг цаг тухай бүрд бүх ажиллагчид мэдээлэх, тэдгээр бодлого, горимын талаар зохих сургалт, боловсролын үйл ажиллагаа явуулах.
 - Ёс зүйн дүрэм болон биеэ авч явах бодлого.
- 200.7 А4 Ажиллаж буй байгууллагын дотор, бусад хүмүүс ёс зүйгүй зан төлөв, үйлдэл гаргасан эсвэл гаргасаар байх магадлалтай гэж мэргэжлийн нягтлан бодогч итгэж байвал энэ талаар хууль зүйн зөвлөгөө авах талаар бодох хэрэгтэй.

Аюул Заналыг Тодорхойлох

- 200.8 А1 Бүлэг 210-270-д мэргэжлийн үйл ажиллагаа гүйцэтгэх явцад үүсэж болох зарим аюул заналыг тодорхойлж, эдгээр аюул заналыг илрүүлж болох үйлдлийг жишээгээр үзүүлсэн болно.
- 200.8 А2 Маш ховор тохиолдолд, хэрэв аюул заналыг устгаж чадахааргүй, бэлэн хамгаалалт байхгүй, эсвэл аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах чадваргүй нөхцөл үүсвэл, мэргэжлийн нягтлан бодогч ажил олгогч байгууллагаас халагдах нь зүйтэй байж болно.

Дээд шатны удирдлагатай харилцах

- Ш200.9** Ёс зүйн дүрмийн зүйл, заалтын хүрээнд дээд удирдлагатай харилцахдаа мэргэжлийн нягтлан бодогч нь тодорхой нөхцөл байдлын мөн чанар, ач холбогдол болон харилцах асуудал, үйлчлүүлэгч байгууллагын засаглалын бүтцийн хүрээнд харилцвал зохих хүмүүсийг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь дээд удирдлагын дэд бүлэгтэй харилцаж байвал дээд удирдлагад зохих ёсоор мэдээлэл хүргэх үүднээс тэдэнтэй бүгдтэй нь харилцах шаардлагатай эсэхийг тодорхойлох ёстой.
- 200.9 А1 Хэнтэй харилцахдаа тодорхойлохын тулд мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг харгалзана:
- (а) Үүссэн нөхцөл байдлын мөн чанар ба ач холбогдол;
 - (б) Харилцах буюу мэдээлэхээр зэхэж буй асуудал.
- 200.9 А2 Дээд шатны удирдлагын дэд бүлгийн жишээнд аудитын хороо, эсвэл дээд шатны удирдлагын хувь гишүүнийг нэрлэж болно.
- Ш200.10** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь гүйцэтгэх болон засаглах үүрэг хариуцлагын аль алийг хүлээдэг хувь хүмүүстэй харилцдаг бол, тухайн нягтлан бодогч үүнээс өөр тохиолдолд дээд шатны удирдлагад багтдаг бүх хүмүүст зохих ёсоор мэдээлэх байсан гэдэгт тэрээр сэтгэл хангалуун байх ёстой.
- 200.10 А1 Зарим тохиолдолд, засаглах эрхтэй удирдлагад тухайн ажил олгогч байгууллагыг удирдаж буй хүмүүс багтдаг, жишээлбэл, ганц эзэнтэй жижиг бизнест тухайн эзэн байгууллагаа удирддаг буюу түүнээс өөр

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

засаглах үүрэгтэй хүн байдаггүй. Энэ тохиолдолд, хэрэв Асуудлыг гүйцэтгэх үүрэг хариуцлага бүхий хувь хүн (хүмүүс) болон засаглах эрхтэй хувь хүн (хүмүүс)-т мэдээлж байвал, мэргэжлийн нягтлан бодогч дээд шатны удирдлагад багтдаг хүмүүстэй харилцах буюу мэдээлэх шаардлагыг биелүүлсэн гэдэгт сэтгэл хангалуун байдаг.

БҮЛЭГ 210

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Танилцуулга

- 210.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 210.2 Бизнесийн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байхдаа ашиг сонирхлын зөрчилтэй тулгарч болно. Ашиг сонирхлын зөрчил нь бодитой байх зарчим мөн бусад суурь зарчимд аюул учруулдаг. Ийм аюул занал дараах тохиолдолд учирна гэж үздэг:
- (а) Мэргэжлийн нягтлан бодогч тодорхой зүйлд хамаарах асуудлаар хоёр ба түүнээс дээш талд мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр талууд тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй байвал;
- (б) Мэргэжлийн нягтлан бодогчийн тодорхой зүйлд хамаарах ашиг сонирхол болон тухайн мэргэжлийн нягтлан бодогчоос тэрхүү тодорхой зүйлээр мэргэжлийн үйлчилгээ авч байгаа талын ашиг сонирхол зөрчилдөж байвал.
- Талууд гэдэгт ажиллаж байгаа байгууллага, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, хувьцаа эзэмшигч, эсвэл бусад талыг хэлнэ.
- 210.3 Энэ бүлэгт ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулан онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- Ш210.4** Мэргэжлийн эсвэл бизнесийн шүүн тунгаалтад муугаар нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг мэргэжлийн нягтлан бодогч зөвшөөрөхгүй байх ёстой.
- 210.4 A1 Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох нөхцөлүүдийн жишээ:
- Хоёр ажил олгогч байгууллагад гүйцэтгэх удирдлага эсвэл засаглах эрхтэй албан тушаал хашиж, нэг байгууллагаас олж авсан нууц мэдээллийг нөгөө ажил олгогч байгууллагад мэргэжлийн нягтлан бодогч давуу эсвэл давуу бус нөхцөл олгох байдлаар ашиглах боломжтой байх.
 - Мэргэжлийн нягтлан бодогч ажиллуулж байгаа нөхөрлөлийн хоёр тал аль аль нь нөхөрлөлийг татан буулгахад мэргэжлийн туслалцаа авдаг байх.
 - Менежментийн худалдан авалт хийхээр зэхэж байгаа аж ахуйн нэгжид ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч нь удирдлагын тодорхой гишүүдэд зориулан санхүүгийн мэдээлэл бэлтгэх.
 - Мэргэжлийн нягтлан бодогч нь ажиллаж байгаа байгууллагадаа бэлтгэн нийлүүлэгч сонгох үүрэгтэй бөгөөд түүний ам бүлийн гишүүн нь уг ажил гүйлгээнээс санхүүгийн ашиг хүртэх боломжтой.
 - Хөрөнгө оруулалтын аль нэг хэсгээс мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түүний ам бүлийн гишүүн нь хувийн хөрөнгө оруулалтын багцынхаа үнэ цэнийг өсгөх боломжтой тийм хөрөнгө оруулалтыг батлуулахын тулд ажиллаж байгаа байгууллагын засаглах эрхтэй удирдлагад үйлчлэх.

Сонирхлын Зөрчлийг Олж Тогтоох

- Ш210.5** Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байдал болон түүний улмаас нэг буюу хэд хэдэн суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг олж тогтоохын тулд мэргэжлийн нягтлан бодогч ул суурьтай алхам хийх хэрэгтэй. Үүнд дараах алхмыг дурдаж болно:
- Хамаарах талуудын хоорондын сонирхол, харилцаа холбооны мөн чанар;
 - Үйлчилгээний мөн чанар, түүний үр нөлөө хамаарах талуудад ямар байх.

Ш210.6 Мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбооны мөн чанарт цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтийг мэргэжлийн нягтлан бодогч дээрх аюулд тооцох ёстой.

Сонирхлын Зөрчлийн Улмаас Үүсэж Байгаа Аюул Занал

210.7 А1 Ерөнхийдөө, мэргэжлийн үйл ажиллагаа ба тэдгээрт холбогдох талуудын ашиг сонирхол зөрчилдөх асуудлын уялдаа холбоо шууд байх тусам, учрах аюул заналын түвшин хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд биш байх магадлал өндөр байдаг.

210.7 А2 Ашиг сонирхлын зөрчил үүсгэдэг асуудалтай холбоотой шийдвэр гаргах үйл явцаас татгалзах нь ашиг сонирхлын зөрчлөөс бий болсон аюул заналыг устгаж болох үйлдлийн жишээ юм.

210.7 А3 Ашиг сонирхлын зөрчил үүсэх аюул заналыг тогтоохдоо хэрэглэж болох хамгаалалтын үйлдлийн жишээг доор дурдсан болно:

- Тодорхой хариуцлага ба ажил үүргийн хязгаар тогтоож, хооронд нь зааглан тусгаарлах.
- Хөндлөнгөөс зохих ёсоор хянан шалгах эрх мэдэлтэй байх, жишээ нь, гүйцэтгэх эсвэл гүйцэтгэх бус захирлын хяналт дор ажил хийх.

Тодруулга ба Зөвшилцөл

Ерөнхий

210.8 А1 Ерөнхийдөө дараах зүйлийг хийх нь зүйтэй:

- (а) ашиг сонирхлын зөрчлийн мөн чанар болон аюул занал хэрхэн үүссэнийг холбогдох талууд буюу ажиллаж байгаа байгууллага доторх зөрчлийн нөлөөнд автсан талаар зохих түвшний ажилтнуудад тодруулга хийх;
- (б) аюул заналыг олж тогтоохдоо хамгаалалт ашиглаж байвал, мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид зориулан холбогдох талуудаас зөвшөөрөл авах.

210.8 А2 Зарим нөхцөлд, хэрэв гарааны нөхцөлийг үйлчлүүлэгч нь мэдэж байгаа гэсэн дүгнэлт хийхэд хангалттай нотолгоог мэргэжлийн нягтлан бодогч олсон бөгөөд ийм зөрчил байгаа гэдгийг үгүйсгээгүй тохиолдолд, ашиг сонирхлын зөрчил байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн аль нэг талын үйл ажиллагаагаар зөвшөөрөл гэдгийг тайлбарлаж болно.

210.8 А3 Хэрэв дээрх тодруулга эсвэл зөвшөөрлийг бичгээр үйлдээгүй бол, мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулбал зохино:

- (а) ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаа нөхцөл байдлын мөн чанар;
- (б) аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулахын тулд хэрэглэсэн хамгаалалт;
- (в) авсан зөвшөөрөл.

Харгалзвал Зохих бусад Зүйл

210.9 А1 Мэргэжлийн нягтлан бодогч ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлохдоо, ажиллаж байгаа байгууллага эсвэл бусдаас, тухайлбал мэргэжлийн байгууллага, хуулийн зөвлөх эсвэл өөр нягтлан бодогчоос удирдамж буюу чиглэл өгөхийг хүсдэг. Ажиллаж байгаа байгууллагын дотор мэдээллийг ил тод авах, хуваалцах, гуравдагч этгээдээс удирдамж хүсэхдээ мэргэжлийн нягтлан бодогч нь нууц хадгалах суурь зарчимд онцгой сэрэмжтэй хандах хэрэгтэй.

БҮЛЭГ 220

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭХ БА ТОЛИЛУУЛАХ

Танилцуулга

- 220.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 220.2 Мэдээлэл бэлтгэх буюу толилуулахад хувийн ашиг сонирхол, айлган сүрдүүлэлт эсвэл бусад аюул заналаар нэг эсвэл хэд хэдэн суурь зарчмын нийцэлд аюул үүсгэж болзошгүй. Дээр дурдсан тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 220.3 А1 Ажил олгогч байгууллагын бүх түвшинд ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч тухайн байгууллага доторх эсвэл гаднах этгээдүүдэд зориулсан мэдээллийг бэлтгэх ба тайлагнахад оролцдог.
- 220.3 А2 Ийм мэдээлэл зориулан бэлтгэж, толилуулдаг оролцогч талуудад дараах этгээдийг нэрлэнэ:
- Гүйцэтгэх болон засаглах эрхтэй удирдлага.
 - Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч болон бусад зээлдэгч.
 - Зохицуулагч байгууллага.

Энэ мэдээлэл нь ажил ологч байгууллагын үйл ажиллагаа явуулж буй байдлыг ойлгох ба үнэлэх, мөн уг байгууллагатай холбоотой шийдвэр гаргахад нь дээрх оролцогч талуудад тус дэм болдог. Мэдээлэлд санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн аль аль орох бөгөөд түүнийг нийтэд ил болгож, эсвэл дотоод зорилгоор ашиглах боломжтой.

Жишээлбэл:

- Үйл ажиллагаа ба гүйцэтгэлийн тайлан.
 - Шийдвэрийг дэмжих шинжилгээ.
 - Төсөв, төлөвлөлт.
 - Дотоод ба гадаад аудитуудад өгсөн мэдээлэл.
 - Эрсдэлийн шинжилгээ.
 - Ерөнхий ба тусгай зорилготой санхүүгийн тайлан.
 - Татварын тайлан.
 - Хууль эсвэл нийцлийн зорилгоор зохицуулагч байгууллагад хүргүүлсэн тайлангууд.
- 220.3 А3 Энэ бүлгийн зорилгоор, мэдээлэл бэлтгэх ба толилуулах гэдэгт мэдээллийг бүртгэх, хадгалах, батлах үйл явц багтана.

Ш220.4 Мэргэжлийн нягтлан бодогч мэдээллийг бэлтгэх ба толилуулахдаа дараах алхмыг хэрэгжүүлэх ёстой:

- (a) Мэдээллийг бэлтгэж, толилуулахдаа хамаарах тайлагналын үзэл баримтлалыг дагаж мөрдөх;
- (б) Мэдээллийг төөрөгдүүлэх эсвэл гэрээний буюу зохицуулах хүрээний үр дүнд зохисгүй байдлаар нөлөөлөхийн аль аль зорилгыг үл агуулсан арга замаар мэдээллийг бэлтгэж, толилуулах;
- (в) Мэргэжлийн шүүн тунгаалтыг дараах зүйлийн хувьд хэрэгжүүлэх. Үүнд:
 - (i) Бодит байдлыг бүх материаллаг хүрээнд нь үнэн зөв, бүрэн гүйцэт тусгах;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (ii) Бизнесийн ажил гүйлгээ буюу үйл ажиллагааны үнэн мөн чанарыг тод томруун тодорхойлох;
 - (iii) Мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв ангилж, бүртгэх.
- (г) Төөрөгдүүлэх эсвэл гэрээний буюу зохицуулах хүрээний үр дүнд зохисгүй байдлаар нөлөөлөх зорилгоор мэдээлэлд ямар нэг зүйлийг орхигдуулахгүй байх.

220.4 A1 Төөрөгдүүлэх эсвэл гэрээний буюу зохицуулах хүрээний үр дүнд зохисгүй байдлаар нөлөөлөх жишээнд өрийн тухай хэлцэлд гэрээгээр заасан шаардлага, эсвэл санхүүгийн байгууллагад зохицуулах байгууллагаас тавьдаг капиталын шаардлагаас санаатайгаар зайлсхийхийн тулд бодит бус тооцоолол ашиглахыг хэлж болно.

Мэдээлэл Бэлтгэх ба Толилуулахдаа Өөрийн Үзэмжийг Ашиглах

Ш220.5 Мэдээлэл бэлтгэх ба толилуулах үед мэргэжлийн шүүн тунгаалт хийхдээ өөрийн үзэмжийг ашиглах шаардлага гарч болзошгүй. Мэргэжлийн нягтлан бодогч нь бусдыг төөрөгдүүлэх эсвэл гэрээний буюу зохицуулах хүрээний үр дүнд зохисгүй байдлаар нөлөөлөх зорилгоор өөрийн үзэмжээ хэрэгжүүлж үл болно.

220.4A1 Зүй бус үр дүнд хүрэхийн тулд өөрийн үзэмжийг буруугаар ашиглаж болох арга замын жишээг доор дурдсан болно:

- Тооцооллыг тодорхойлох, тухайлбал, ашиг, алдагдлыг буруу илэрхийлэхийн тулд бодит үнэ цэнийн тооцооллыг тодорхойлох.
- Мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд зөвшөөрсөн хоёр буюу түүнээс дээш хэд хэдэн төстэй хувилбараас нягтлан бодох бүртгэлийн бодлого ба аргаа сонгох эсвэл түүнийг өөрчлөх, тухайлбал, ашиг, алдагдлыг буруу илэрхийлэхийн тулд урт хугацаат гэрээг бүртгэлд тусгах бодлогыг сонгох.
- Ажил гүйлгээний хугацааг тодорхойлох, тухайлбал, бусдыг төөрөгдүүлэхийн тулд хөрөнгийн борлуулалт хийх хугацааг санхүүгийн жилийн эцсийн хугацаатай ойрхон төлөвлөх.
- Ажил гүйлгээний бүтцийг тодорхойлох, тухайлбал, хөрөнгө ба өр төлбөр, эсвэл мөнгөн гүйлгээний ангиллыг буруу илэрхийлэхийн тулд хийсэн санхүүгийн ажил гүйлгээний бүтэц.
- Тодруулгыг сонгохдоо, жишээлбэл, бусдыг төөрөгдүүлэхийн тулд санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлд хамаарах мэдээллийг орхигдуулах эсвэл будилуулах.

Ш220.6 Мэргэжлийн үйл ажиллагаа, ялангуяа холбогдох тайлагналын үзэл баримтлалд нийцсэн байхыг шаарддаггүй үйл ажиллагаа гүйцэтгэхдээ мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг олж тогтоон, харгалзахын тулд мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

- (а) Тухайн мэдээллийг яг ямар зорилгоор ашиглах гэж байгаа;
- (б) Тухайн мэдээлэл өгөгдсөн орчин нөхцөл;
- (в) Мэдээллийг ямар сонсогчдод хаягласан.

220.6 A1 Жишээлбэл, урьдчилсан тайлан, төсөв, төлөвлөгөө бэлтгэж, толилуулах үед хамаарах тооцоолол, ойролцоо тоо болон төсөөллийг боломжит хэмжээнд оруулах нь ийм мэдээлэлд үндэслэн өөрийн шийдвэрээ гаргах хүмүүст ихээхэн тус дэмтэй байна.

220.6 A2 Мэргэжлийн нягтлан бодогч мөн мэдээллийг толилуулах гэж байгаа зорилготой сонсогч, орчин нөхцөл, зорилгыг тов тодорхой болгосон эсэхийг харгалзах нь зүйтэй.

Бусдын Ажилд Тулгуурлах

Ш220.7 Ажил олгогч байгууллагын доторх эсвэл түүний гаднах өөр хэн нэгний ажилд тулгуурлах гэж байгаа мэргэжлийн нягтлан хэрэв тохиромжтой гэж үзвэл Ш220.4-р параграфт заасан үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд хийх алхмаа тодорхойлох үүднээс мэргэжлийн шүүн тунгаалт хийх ёстой.

220.7 A1 Бусдын ажилд тулгуурлах нь ул үндэслэлтэй эсэхийг тогтоохын тулд заавал харгалзвал зохих хүчин зүйлд

дараах орно:

- Тулгуурлах гэж байгаа бусад хувь хүн эсвэл байгууллагын нэр хүнд, ажил мэргэжлийн чадавх, мөн тэдгээрт бэлэн байгаа нөөц.
- Тэрхүү бусад хувь хүн нь мөрдвөл зохих мэргэжлийн ба ёс зүйн стандартыг сахин биелүүлэх ёстой эсэх.

Ийм мэдээллийг бусад хувь хүн эсвэл байгууллагын тухай бусадтай хамтарч, эсвэл тэднээс зөвлөгөө авах замаар олж авах боломжтой.

Төөрөгдүүлсэн буюу Төөрөгдүүлсэн Байж Болзошгүй Мэдээллийг Олж Тогтоох

Ш220.8 Нягтлан бодогчид хамааралтай мэдээлэл нь төөрөгдүүлсэн мэдээлэл хэмээн тухайн мэргэжлийн нягтлан бодогч мэдэж байгаа эсвэл тэгж итгэх шалтгаантай бол тэрээр уг асуудлыг шийдвэл зохих үйлдлийг хийх нь зүйтэй.

220.8 A1 Хийвэл зохих үйлдэлд дараахыг дурдаж болно:

- Төөрөгдүүлсэн мэдээлэл байж болзошгүй талаар тухайн мэргэжлийн нягтлан бодогчийн ахлах түвшний нягтлан бодогч эсвэл түүний ажилладаг байгууллагын гүйцэтгэх эсвэл засаглах эрхтэй удирдлага дахь зохих түвшний албан тушаалтантай ярилцаж, энэ асуудлыг шийдэх тохиромжтой арга хэмжээ авахыг тэднээс хүсэж болно. Ийм арга хэмжээнд дараахыг дурдаж болно:
 - Мэдээллийг засаж залруулсан байх.
 - Хэрэв мэдээллийг зорилтот хэрэглэгчдэд аль хэдийн хүргэсэн бол, тэдэнд мэдээллийг засаж залруулсан тухай мэдэгдэх.
- Ийм асуудлыг дотооддоо хэрхэн олж тогтоох тухай ажил олгогч байгууллагын бодлого, горим (жишээлбэл, ёс зүй эсвэл шүгэл үлээгчийн бордлого)-ыг боловсруулсан байх.

220.8A2 Ажил олгогч байгууллага зохих арга хэмжээ аваагүй хэмээн мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлж болно. Хэрэв төөрөгдүүлсэн мэдээлэл хэвээр байгаа хэмээн үзэх шалтгаан нягтлан бодогчид байсаар байвал, тэрээр нууц хадгалах зарчмыг харгалзан, дараагийн алхмыг хийх нь зүйтэй. Үүнд:

- Дараах этгээдтэй зөвлөлдөх:
 - Холбогдох мэргэжлийн байгууллага.
 - Ажил олгогч байгууллагын дотоо болон гадаад аудитор.
 - Хуулийн зөвлөх.
- Дараах этгээдэд энэ талаар мэдээлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох:
 - Гуравдагч тал, үүнд мэдээллийн хэрэглэгчид.
 - Зохицуулагч болон хөндлөнгийн хяналтын эрх мэдэл бүхий байгууллага.

Ш220.9 Хэрэв боломжтой гэж үзсэн бүх сонголтыг авч үзсэний дараа, мэргэжлийн бодогч тохиромжтой арга хэмжээ аваагүй хэмээн үзэж, төөрөгдүүлсэн мэдээлэл хэвээр байгаа гэж итгэх шалтгаан байсаар байвал, тэрээр ийм мэдээлэлтэй цаашид холбогдох эсвэл холбогдсон хэвээр байх шийдвэрээс татгалзах ёстой.

220.9A1 Энэ тохиолдолд, ажил олгогч байгууллагаас халагдах нь мэргэжлийн нягтлан бодогчийн хувьд тохиромжтой шийдвэр болно.

Баримтжуулалт

220.10A1 Мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулах нь зүйтэй:

- Бодит байдал.
- Нягтлан бодох бүртгэлийн зарчим, мэргэжлийн холбогдох бусад стандарт.
- Тухайн асуудлыг хөндөж ярилцсан харилцаа холбоо ба талууд.

- Харгалзаж үзсэн үйлдлийн өрнөл.
- Тухайн асуудал (ууд)-ыг нягтлан бодогч хэрхэн олж тогтоосон.

Харгалзвал Зохих Бусад Асуудал

- 220.11A1 Мэдээллийг бэлтгэх ба толилуулахтай холбоотой суурь зарчмын нийцэлд учрах аюул занал санхүүгийн ашиг сонирхол буюу санхүүгийн тайлагнал ба шийдвэр гаргалтад хамаарах урамшуулал, шан хүртээмжээс үүссэн бол, Бүлэг 240-д заасан шаардлага болон ашиглах материалыг мөрдөнө.
- 220.11A2 Төөрөгдүүлсэн мэдээлэлд хууль тогтоомжид үл нийцсэн асуудал багтсан бол Бүлэг 260-д заасан шаардлага болон ашиглах материалыг мөрдөнө.
- 220.11A3 Мэдээллийг бэлтгэх ба толилуулахтай холбоотой суурь зарчмын нийцэлд учрах аюул занал дарамт шахалтаас үүссэн бол, Бүлэг 270-д заасан шаардлага болон ашиглах материалыг мөрдөнө.

БҮЛЭГ 230

ХАНГАЛТТАЙ МЭДЛЭГТЭЙ БАЙЖ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

Танилцуулга

- 230.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 230.2 Хангалттай мэргэжлийн ур чадваргүй байж ажил гүйцэтгэх нь мэргэжлийн ур чадвар ба хянамгай байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул заналыг учруулдаг. Энэ бүлэгт ашиг сонирхлын зөрчилтэй холбогдуулан онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг тайлбарласан болно.

Шаардлага ба ашиглах материал

Ерөнхий зүйл

- Ш230.3** Мэргэжлийн нягтлан бодогч нь эзэмшсэн ур чадвар буюу туршлагынхаа талаар ажил олгогч байгууллагад санаатай ташаа мэдээлж үл болно.
- 230.3A1 Мэргэжлийн ур чадвартай бөгөөд хянамгай байх зарчим нь мэргэжлийн нягтлан бодогчоос зөвхөн тухайн онцгой үүрэг даалгаварт шаардагдах хангалттай сургалт, туршлага эзэмшсэн эсвэл эзэмшиж чадахуйц байж гүйцэтгэхийг шаарддаг.
- 230.3A2 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогчийн хувьд дараах нөхцөл үүссэн бол мэргэжлийн ур чадвартай бөгөөд хянамгай байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй. Үүнд:
- Холбогдох үүрэг даалгаврыг гүйцэтгэх буюу дуусгах хугацаа хангалтгүй.
 - Үүрэг даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл бүрэн бус, хязгаарлагдмал эсвэл тохиромжтой биш байх.
 - Хангалтгүй туршлага, сургалт эсвэл боловсрол.
 - Үүрэг даалгавар гүйцэтгэхэд шаардагдах нөөц хангалтгүй байх.
- 230.3A3 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамаарах хүчин зүйлсэд дараах орно:
- Мэргэжлийн нягтлан бодогч бусадтай ажиллаж байгаа цар хүрээ.
 - Бизнес дэх тухайн нягтлан бодогчийн харьцангуй ахлах байр суурь.
 - Ажилдаа ашигласан хяналт шалгалтын түвшин.
- 230.3A4 Дээрх хувийн ашиг сонирхлын аюул заналыг багасгах хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Шаардлагатай мэдлэг туршлагатай хэн нэгнээс тусламж дэмжлэг авах.
 - Холбогдох үүрэг даалгаврыг гүйцэтгэх хангалттай цаг хугацаа байгаа эсэхийг магадлах
- Ш230.4** Хэрэв мэргэжлийн ур чадвартай бөгөөд хянамгай байх зарчмын нийцэлд учирдаг хувийн ашиг сонирхлын аюул заналыг мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлж чадахааргүй байвал тэрээр тухайн ажил үүргийг гүйцэтгэхээс татгалзах эсэх талаар эргэцүүлэх нь зүйтэй. Хэрэв нягтлан бодогч татгалзах нь зүйтэй хэмээн тодорхойлбол, үүний шалтгааныг ойлгомжтой тайлбарлан мэдээлэх ёстой.

Харгалзвал зохих бусад асуудал

- 230.5A1 Мэргэжлийн ур чадвартай бөгөөд хянамгай байх зарчмыг зөрчихөд хүргэж болзошгүй үйлдэл хийх дарамт шахалтыг мэргэжлийн нягтлан бодогчид үзүүлбэл баримтлах шаардлага ба ашиглах материалыг Хэсэг 270-д тусгасан болно.

ХЭСЭГ 240

САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХОЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ БА ШИЙДВЭР ГАРГАЛТТАЙ ХОЛБООТОЙ УРАМШУУЛАЛ, ШАН ХҮРТЭЭМЖ

Танилцуулга

- 240.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь Бүлэг 120-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 240.2 Ам бүл эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь санхүүгийн ашиг сонирхолтой, эсвэл санхүүгийн ашиг сонирхолтойг нь мэддэг байж болох нөхцөл нь бодитой байдал эсвэл нууц хадгалах суурь зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тайлбарласан болно.

Шаардлага ба ашиглах материал

Ерөнхий зүйл

- Ш240.3** Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч хувийн ашиг сонирхол эсвэл бусдын санхүүгийн ашиг сонирхлыг биелүүлэхийн тулд мэдээллийг хуурамчаар үйлдэх эсвэл нууц мэдээллийг ашиглах хориотой.
- 240.3A1 Мэргэжлийн нягтлан бодогч өөрөө санхүүгийн ашиг сонирхолтой, эсвэл түүний ам бүл эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь санхүүгийн ашиг сонирхолтой гэдгийг мэддэг байж болох зарим тодорхой нөхцөлд, суурь зарчмын нийцэлд аюул занал учруулж болох юм. Санхүүгийн ашиг сонирхол гэдэгт санхүүгийн тайлагнал ба шийдвэр гаргах үйл явцтай холбоотой урамшуулах, шан хүртээх тохиролцоо багтдаг.
- 240.3A2 Мэргэжлийн нягтлан бодогч, эсвэл түүний ам бүл эсвэл гэр бүлийн ойрын гишүүний дараах үйлдлийн үр дүнд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болох жишээг дор харуулсан болно:
- Санхүүгийн ашиг хонжоо олохын тулд үнийн хувьд эмзэг мэдээллийг хуурамчаар үйлдэх сэдэл ба боломжтой байх.
 - Ажиллаж байгаа байгууллагад шууд буюу шууд бус санхүүгийн хувь оролцоотой бөгөөд нягтлан бодогчийн гаргасан шийдвэр нь дээрх санхүүгийн хувь оролцооны үнэ цэнэд шууд нөлөөлөх боломжтой.
 - Ашгаас хамааралтай бонус хүртэх боломжтой бөгөөд нягтлан бодогчийн гаргасан шийдвэр нь дээрх бонусын үнэ цэнэд шууд нөлөөлөх боломжтой.
 - Ажиллаж байгаа байгууллагадаа хойшлуулсан хувьцааны бонус эсвэл хувьцааны опцион эзэмших шууд ба шууд бус эрхтэй бөгөөд нягтлан бодогчийн гаргасан шийдвэр нь дээрх хувьцааны үнэ цэнэд шууд нөлөөлөх боломжтой.
 - Тавьсан зорилгодоо хүрэх, ажиллаж байгаа байгууллагын хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх хүчин чармайлтыг дэмжиж ажилласны төлөө урамшуулал хүртдэг шан хүртээмжийн тохиролцоонд оролцох, жишээ нь, гүйцэтгэлийн зарим тодорхой нөхцөл хангагдвал урт хугацаатай урамшууллын төлөвлөгөөнд оролцох эрхтэй болох гэх мэт.
- 240.3A3 Аюул заналын хэмжээ далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна:
- Санхүүгийн ашиг сонирхлын ач холбогдол. Санхүүгийн ашиг сонирхлын ач холбогдол нь хувь хүний нөхцөл байдал ба тухайн хүнд санхүүгийн ашиг сонирхол хэр материаллаг байхаас шалтгаалдаг.
 - Дээд шатны удирдлагын урамшууллын хэлбэр ба түвшнийг тодорхойлоход удирдлагаас хараат бус хорооны баримтлах бодлого, журам.
 - Холбогдох дотоод бодлогын дагуу
 - Хамаарах бүх ашиг сонирхол.
 - Хамаарах хувьцааны эрх буюу түүгээр хийх арилжааны төлөвлөгөөний талаар

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тухайн байгууллагын засаглах эрхтэй удирдлагад мэдээлэх.

- Санхүүгийн ашиг сонирхол үүсгэдэг асуудлыг шийдэхэд онцгой ач холбогдолтой дотоод ба гадаад аудитын горимууд.

240.3A4 Урамшуулах эсвэл шан хүртээх тохиролцооноос үүсэх аюул заналд байгууллагын ахлах ажилтан эсвэл хамт ажилладаг хүмүүсийн ил эсвэл далд дарамт шахалт нэрмээс болж болно. *Суурь зарчмыг зөрчихөд хүргэдэг дарамт шахалт* гэсэн Бүлэг 270-ыг харна уу.

БҮЛЭГ 250

БЭЛЭГ, ДАЙЛЛАГА, УРАМШУУЛАЛ

Танилцуулга

- 250.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь Бүлэг 120-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 250.2 Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах нь суурь зарчим ялангуяа шударга байдал, бодитой байдал, мэргэжлийн зан төлөвийн зарчмын нийцэлд учрах хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй.
- 250.3 Энэ хэсэгт, хууль тогтоомжид үл нийцэх асуудал үүсгэхгүй мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байх үед урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахтай холбоотой онолын үзэл баримтлалыг хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно. Энэ хэсэгт мөн урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах үедээ холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байхыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

250.4 A1 Урамшуулал гэдэг нь хувь хүний зан төлөвт заавал зүй бусаар нөлөөлөх зорилгогүйгээр түүний зан төлөвт нөлөөлөх арга зам болгон ашигладаг объект, нөхцөл, эсвэл үйлдлийг хэлнэ. Урамшуулал нь бизнесийн нөхөд/ хамт олны дунд дайллага хийх гэх мэт жижиг үйлдлээс хууль тогтоомжид үл нийцэх байдалд хүргэж болох үйлдэл гэх мэт өргөн хүрээтэй байж болно. Урамшууллын янз бүрийн хэлбэр байдгийг дараах жишээгээр харуулж болно. Үүнд:

- Бэлэг
- Дайллага
- Зугаа цэнгэл
- Улс төрийн эсвэл буяны хандив
- Нөхөрлөл үнэнч байдлын төлөөх гуйлт
- Ажил олгох эсвэл бусад арилжааны боломж олгох
- Хөнгөлөлттэй үйлчилгээ, эрх буюу давуу эрх олгох

Хууль Тогтоомжоор Хориглодог Урамшуулал

Ш250.5 Зарим тодорхой нөхцөлд урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахыг хориглодог, тухайлбал, авилга, хээл хахуультай холбоотой хууль тогоомж бүхий хууль эрхзүйн орчин олон бий. Мэргэжлийн нягтлан бодогч нь холбогдох хууль тогтоомжийг сайтар ойлгож, ийм нөхцөл байдал тулгарсан үед тэдгээр хууль тогтоомжийг мөрдөн сахих ёстой.

Хууль Тогтоомжоор Хориглодоггүй Урамшуулал

250.6 A1 Санал болгосон эсвэл хүлээн авч байгаа урамшууллыг хууль тогтоомжоор хориглодоггүй байсан ч суурь зарчмын нийцэлд аюул учруулсаар байх боломжтой юм.

Зан Төлөвт Зүй Бусаар Нөлөөлөх Зорилготой Урамшуулал

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Ш250.7** Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой хийсэн гэж мэргэжлийн нягтлан бодогч өөрөө дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийнхүү дүгнэх боломжтой гэж үзсэн аливаа урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө санал болгох, эсвэл санал болгохыг бусдад зөвлөж үл болно.
- Ш250.8** Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой хийсэн гэж мэргэжлийн нягтлан бодогч өөрөө дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийнхүү дүгнэх боломжтой гэж үзсэн аливаа урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө хүлээн авах, эсвэл бусдыг хүлээн авахыг ятгаж үл болно.
- 250.9A1 Хэрэв урамшуулал нь тухайн хувь хүнийг ёс зүйгүй үйлдэл хийхэд хүргэж байвал ийм урамшууллыг тухайн хүнд зүй бусаар нөлөөлж байна хэмээн үздэг. Зүй бус ийм нөлөөлөл нь хүлээн авагч эсвэл түүнтэй холбоотой хүний аль алинд чиглэсэн байж болно. Мэргэжлийн нягтлан бодогчийн эсвэл адилтгах шинжтэй өөр нэг этгээдийн талд ёс зүйгүй зан төлөв үүсгэж байгаа эсэхийг тухайн мэргэжлийн нягтлан бодогч харгалзан үзэх нь түүний хувьд баримтлах суурь зарчим болдог.
- 250.9A2 Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө санал болгосон эсвэл хүлээн авсан, эсвэл санал болгохыг эсвэл хүлээн авахыг бусдад зөвлөсөн тохиолдолд шударга байдлын суурь зарчим алдагддаг.
- 250.9A3 Зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамагласан зорилго байгаа эсэхийг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүнтунгаалтаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд хамаарах хүчин зүйлсийн жишээг дурдвал:
- Урамшууллын мөн чанар, дамтамж, мөнгөн дүн, түүний нийт үр нөлөө.
 - Аливаа үйлдэл эсвэл түүний нөлөөлж болох шийдвэрт хамаарах урамшууллыг санал болгох хугацаа.
 - Урамшууллыг тухайн нөхцөл байдлын хувьд ердийн буюу соёлын уламжлалт практик гэж үзэх эсэх, үүний жишээнд, шашны ёс заншлыг тэмдэглэх баяр эсвэл хуримд зориулан бэлэг санал болгохыг дурдаж болно.
 - Урамшууллыг мэргэжлийн үйл ажиллагааны нэмэлт хэсэг гэж үзэх эсэх, үүний жишээнд, бизнес уулзалт хийхтэй холбоотой үдийн зоог барихыг санал болгох эсвэл зөвшөөрөхийг дурдаж болно.
 - Урамшуулал санал болгохдоо хүний тоог зөвхөн нэг хүлээн авагч эсвэл томоохон бүлэг хүмүүсээр хязгаарласан эсэх. Томоохон бүлэг гэдэгт ажил олгогч байгууллагын дотоод болон гаднын хүмүүс жишээлбэл, бусад худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгчдийг оруулна.
 - Урамшуулал санал болгосон эсвэл түүнийг хүлээн авах хүмүүсийн үүрэг, албан тушаал.
 - Урамшуулал авахыг зөвшөөрснөөр түншлэгч талын ажил олгогч байгууллагын бодлого, горим зөрчихөд хүргэнэ гэдгийг мэргэжлийн нягтлан бодогч мэдэж байгаа эсвэл ийнхүү итгэх шалтгаан түүнд байгаа эсэх.
 - Урамшуулал санал болгох үеийн нөхцөл хэр зэрэг ил тод байгаа.
 - Хүлээн авагч нь урамшуулал өгөхийг шаардсан эсвэл хүссэн эсэх.
 - Санал болгогч этгээдийн өмнөх үеийн зан төлөв ба нэр хүнд.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Цаашид Авах Арга Хэмжээ

- 250.10A1 Санал болгосон урамшуулал нь зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой гэдгийг хэрэв мэргэжлийн нягтлан бодогч мэдэж авсан бол, Ш205.7, Ш250.8-р параграфт заасан шаардлага хангагдсан ч гэсэн суурь зарчмын нийцэлд аюул занал учирсаар байх болно.
- 250.10A2 Дээрх аюул заналыг багасгах хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Уг саналын талаар мэргэжлийн нягтлан бодогч эсвэл санал болгосон хүний ажил олгогч байгууллагын ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагад мэдээлэх.
 - Санал болгосон хүнтэй тогтоосон бизнесийн харилцаагаа өөрчлөх эсвэл харилцааг цуцлах.

Зан Төлөвт Зүй Бусаар Нөлөөлөх Зорилгогүй Урамшуулал

- 250.11A1 Хүлээн авагч эсвэл өөр бусад этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамаглах зорилго байхгүй гэж мэргэжлийн нягтлан бодогч дүгнэсэн тохиолдолд тэрээр онолын үзэл баримтлалд тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг дагаж мөрддөг.
- 250.11A2 Хэрэв урамшуулал нь үл ялих бөгөөд хор уршиггүй байвал, учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна гэж үзнэ.
- 250.11A3 Санал болгосон урамшуулал нь зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодит эсвэл таамагласан зорилгогүй гэж мэргэжлийн нягтлан бодогч дүгнэсэн ч гэсэн ийм урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авснаар аюул занал учирсан хэвээр байх нөхцөлийг дараах жишээгээр харуулсан болно:
- Хувийн ашиг сонирхлын аюул занал
 - Мэргэжлийн нягтлан бодогчид бэлтгэн нийлүүлэгч талаас орон тооны бус ажил санал болгох
 - Танилын аюул занал
 - Мэргэжлийн нягтлан бодогч нь худалдан авагч эсвэл бэлтгэн нийлүүлэгчийг спортын арга хэмжээнд байнга дагуулж явдаг.
 - Айлган сүрдүүлэх аюул занал
 - Хэрэв олон нийгэд мэдэгдсэн тохиолдолд тохиромжгүй гэж үзэж болох шинжтэй дайллага цайллагыг мэргэжлийн нягтлан бодогч зөвшөөрсөн.
- 250.11A4 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн дээрх аюул заналын түвшнийг тодорхойлоход хамааралтай хүчин зүйлсэд, зорилгыг тодорхойлохдоо 250.9A3-р параграфт авч үзсэнтэй адил хүчин зүйлс багтдаг.
- 250.11A5 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн аюул заналын түвшнийг арилгаж болох арга хэмжээний жишээг дурдвал:
- Урамшууллаас татгалзах эсвэл санал болгохгүй байх.
 - Түншлэгч талын оролцоотой бизнесийн шийдвэр гаргах хариуцлагыг тухайн шийдвэр гаргахдаа зүй бусаар нөлөөлнө эсвэл нөлөөлөх боломжтой гэж мэргэжлийн нягтлан бодогч итгэх шалтгаан байхгүй тийм хүнд шилжүүлэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- 250.11A6 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн аюул заналыг багасгах хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах талаар мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түншлэгч талын ажил олгогч байгууллагын ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай ил тод харилцах.
 - Мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түншлэгч талын ажил олгогч байгууллагын хөтөлдөг бүртгэлд урамшууллыг бүртгүүлэн гэмдэглүүлэх.
 - Тухайн нягтлан бодогчийн хүлээн авсан урамшуулалыг өгсөн хувь хүн эсвэл байгууллагын талаар түүний гүйцэтгэсэн ажил эсвэл гаргасан шийдвэрийг уг ажилд ямар нэг байдлаар оролцоогүй өөр хүнээр хянуулан шалгуулах.
 - Хандив хүлэн авч, түүнийг засаглах эрхтэй удирдлага эсвэл урамшуулал санал болгосон хүмүүст зохих ёсоор мэдээлсний дараа, тухайн урамшууллыг буяны үйлсэд хандивлах.
 - Дайллага гэх мэт урамшууллын зардлыг буцаан төлөх.
 - Эхэлж зөвшөөрөн хүлээж авсан урамшууллыг дараа нь нэн даруй буцааж өгөх.

Ам Бүлийн Гишүүн эсвэл Гэр Бүлийн Ойрын Гишүүн

Ш250.12 Урамшуулал санал болгосоны улмаас нягтлан бодогчийн суурь зарчимд нийцэх нийцэлд учирч болзошгүй аюулд мэргэжлийн нягтлан бодогч дараах тохиолдлыг тооцох ёстой:

- (a) Нягтлан бодогчийн ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнээс тухайн нягтлан бодогчийн мэргэжлийн харилцаатай байдаг түншлэгч талд урамшуулал санал болгох; эсвэл
- (b) Тухайн нягтлан бодогчийн мэргэжлийн харилцаатай байдаг түншлэгч талаас уг нягтлан бодогчийн ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд урамшуулал санал болгох.

Ш250.13 Ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд, эсвэл ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнээс нь урамшуулал санал болгосон тухай мэргэжлийн нягтлан бодогч мэдэж авсан бөгөөд уг нягтлан бодогч эсвэл түүний түншлэгч талын зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилго агуулсан хэмээн дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийм зорилго байгаа гэж дүгнэх боломжтой хэмээн үзсэн бол тэрээр ийм урамшуулал санал болгохгүй эсвэл хүлээн авахгүй байхыг ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүдэд заавал зөвлөх нь зүйтэй.

250.13A1 Параграф 250.9A3-г дурдсан хүчин зүйлс бол мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түүний түншлэгч талын зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамагласан зорилго байгаа эсэхийг тодорхойлоход хамааралтай хүчин зүйлс болно. Өөр нэг хамаарах хүчин зүйл бол дараах хүмүүсийн хоорондох харилцааны шинж чанар буюу хэр дотно байх явдал юм:

- (a) Нягтлан бодогч ба түүний ам бүлийн эсвэл гэр бүлийн гишүүн;
- (b) Ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн ба түншлэгч тал;
- (b) Нягтлан бодогч ба түншлэгч тал.

Тухайлбал, түншлэгч талтай асар их дүн бүхий гэрээний тохиролцоо хийж байх үед тухайн түншлэгч талаас нягтлан бодогчийн эхнэр/ нөхөрт байгууллагын боловсон хүчний ердийн журмаас гадуур ажил эрхлэлт санал болгох нь ийм зорилго буюу санаархлыг илтгэж болох юм.

250.13 A2 Ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүд нь Ш250.13-т заасан зөвлөгөөг дагаж мөрдсөн байсан ч гэсэн мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түүний түншлэгч талын зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

таамагласан зорилго байгаа тохиолдолд үүсэх боломжтой аюул заналыг тодорхойлоход 250.10A2-р параграфт дурдсан ашиглах материал мөн хамааралтай юм.

Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх

- 250.14 A1 Мэргэжлийн нягтлан бодогч Ш250.12-т тодорхойлсон нөхцөлд санал болгосон урамшууллын талаар мэдсэн бол, суурь зарчмын нийцэлд дараах тохиолдолд аюул занал учрах боломжтой. Үүнд:
- (а) Ам бүлийн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь Ш250.13-т заасан нягтлан бодогчийн зөвлөгөөг дагалгүй урамшуулал санал болгосон эсвэл хүлэн авахыг зөвшөөрсөн;
 - (б) Нягтлан бодогч эсвэл түүний түншлэгч талын зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилго буюу санаархал бодитоор эсвэл таамаглалаар оршин байгаа гэж итгэх шалтгаан уг нягтлан бодогчид байхгүй.
- 250.14 A2 Ийм аюул заналыг үнэлэх ба тодорхойлох зорилгын хувьд, 250.11A1-250.11A6-д дурдсан ашиглах материалыг хамаатай гэж үзнэ. Эдгээр тохиолдолд, аюул заналын түвшнийг үнэлэхэд хамаатай хүчин зүйлсэд 250.13A1-ийн харилцааны шинж чанар ба хэр дотно байдлыг мөн багтаан авч үздэг.

Бусад Харгалзах Зүйлс

- 250.15 A1 Ажлын гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн ашиг сонирхол, нөхөн олговор, урамшууллыг ажил олгогч байгууллагын зүгээс мэргэжлийн нягтлан бодогчид санал болговол, Хэсэг 240 дэх шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.
- 250.15 A2 Хэрэв ажил олгогч байгууллагад эсвэл түүний удирдан чиглүүлснээр ажиллаж байгаа бусад хүмүүс мэргэжлийн бодогчид урамшуулал санал болгосон эсвэл санал болгосныг мэдсэн бөгөөд энэ нь хууль тогтоомж зөрчсөн эсвэл зөрчсөн гэж сэжиглэх нөхцөл байдал үүсгэвэл, Хэсэг 240 дэх шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.
- 250.15 A3 Хэрэв суурь зарчмын нийцэлд аюул занал учруулж болзошгүй урамшуулал санал болгох эсвэл хүлээн авах дарамт шахалтыг мэргэжлийн нягтлан бодогчид үзүүлбэл тэрээр Хэсэг 270-ын шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.

ХЭСЭГ 260

ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ ҮЛ НИЙЦЭХ ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Танилцуулга

- 260.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь Бүлэг 120-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 260.2 Мэргэжлийн нягтлан бодогч нь хууль тогтоомж зөрчсөнийг мэдсэн эсвэл зөрчсөн гэж сэжиглэж байвал шударга байдал ба мэргэжлийн зан төлөвийн зарчмын нийцэлд учрах хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсдэг.
- 260.3 Мэргэжлийн үйл ажиллагааны явцад үл нийцэлтэй тулгарсан эсвэл үл нийцэл үүссэн тухай сэжиг мэргэжлийн нягтлан бодогчид төрж болзошгүй. Энэ бүлэгт уг асуудлын урьдчилсан нөхцөлийг үнэлж, доор дурдсан чиглэлээр үл нийцэл гарсан эсвэл гарсан гэж сэжиглэх тохиолдолд авах боломжтой арга хэмжээний талаар нягтлан бодогчдоод тус болох удирдамжийг тодорхойлсон болно. Үүнд:
- (a) Ажил олгогч байгууллагын санхүүгийн тайлан дахь материаллаг дүн ба тодруулгыг тодорхойлоход шууд нөлөөтэй байхаар ерөнхийд нь хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж;
 - (b) Ажил олгогч байгууллагын санхүүгийн тайлан дахь материаллаг дүн ба тодруулгыг тодорхойлоход шууд нөлөөтэй биш боловч эдгээрт нийцсэн байх нь тухайн ажил олгогч байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, бизнесээ үргэлжлүүлэх чадавх болон материаллаг хэмжээний торгуулиас зайлсхийхэд чухал байх боломжтой бусад хууль тогтоомж.

Хууль Тогтоомжийг Зөрчихтэй Холбоотой Мэргэжлийн Нягтлан Бодогчийн Зорилго

- 260.4 Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн бусдаас ялгарах шинж чанар нь нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлах явдал юм. Үл нийцэл гарсан эсвэл гарсан гэж сэжиглэх тохиолдолд нягтлан бодогчийн авах арга хэмжээний зорилгыг дараах байдлаар тодорхойлно:
- (a) Шударга байдал ба мэргэжлийн зан төлөвийн зарчимд нийцүүлэх;
 - (b) Дараах зорилгоор гүйцэтгэх эсвэл засаглах эрхтэй удирдлагад урьдчилан сануулах:
 - (i) Олж илрүүлсэн эсвэл сэжиглэж буй үл нийцлийн үр дагаврыг засаж залруулах, хор уршгийг багасгах боломж олгох;
 - (ii) Үл нийцэл гарахаас өмнө, тийм тохиолдлыг таслан зогсоох;
 - (в) Цаашид нийтийн эрх ашигт тохирох тийм арга хэмжээ авах.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 260.5A1 Хууль тогтоомжийн үл нийцэл (“үл нийцэл”) нь зонхилох хууль тогтоомжийн эсрэг дараах талуудын үйлдсэн санаатай болон санаандгүй орхигдуулах үйлдэл эсвэл захиалгаас бүрддэг. Үүнд:
- (а) Мэргэжлийн нягтлан бодогчийн ажиллаж байгаа байгууллага;
 - (б) Ажил олгогч байгууллагын засаглах эрхтэй удирдлага;
 - (в) Ажил олгогч байгууллагын гүйцэтгэх удирдлага;
 - (г) Ажил олгогч байгууллагын төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад этгээд.
- 260.5A2 Энэ бүлэгт зааснаар зөрчсөнд тооцох хууль тогтоомжид дараах орно. Үүнд:
- Залилан мэхлэлт, авлига, хээл хахууль.
 - Мөнгө угаах, алан хядлагыг санхүүжүүлэх, хууль бус орлого.
 - Үнэт цаасны зах зээл ба арилжаа.
 - Банк болон бусад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ.
 - Тоон мэдээний хадгалалт, хамгаалалт.
 - Татвар ба тэтгэврийн өглөг ба төлбөр.
 - Хүрээлэн байгаа орчны хамгаалалт.
 - Нийтийн эрүүл мэнд ба аюулгүй байдал.
- 260.5A3 Үл нийцэл нь ажил олгогч байгууллагын санхүүгийн тайланд материаллаг хэмжээнд нөлөөлөхүйц торгууль, зарга, бусад үр дагаварт хүргэж болзошгүй. Хамгийн гол нь, үл нийцлийн улмаас хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, олон нийтэд томоохон гарз хохирол учруулж магадгүй гэдэг утгаараа нийтийн ашиг сонирхолд илүү өргөн нөлөөтэй байж болох талтай. Энэ бүлгийн зорилгоор, ийм томоохон гарз хохирол учруулдаг үл нийцэл бол дээрх талын аль нэгд санхүүгийн эсвэл санхүүгийн бус ноцтой сөрөг үр дагавар үүсгэдэг явдал юм. Үүний жишээнд, хөрөнгө оруулагчдад асар их санхүүгийн гарз учруулахуйц хэмжээнд залилан мэхлэх болон ажиллагч эсвэл олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд хүрээлэн байгаа орчны тухай хууль зөрчих үйлдлийг дурдаж болно.
- Ш260.6** Үл нийцэл эсвэл сэжигтэй үл нийцлийг мэргэжлийн нягтлан бодогчид хэрхэн шийдэх шаардлагыг зарим хууль эрх зүйн орчинд хуулиар, эсвэл дүрэм журмаар зохицуулсан байдаг. Эдгээр хуулийн эсвэл дүрэм журмын заалт нь энэ бүлэгт заасан шаардлагаас ялгаатай эсвэл илүү олон байж болно. Үл нийцэл эсвэл сэжигтэй үл нийцэл гарсан тохиолдолд, нягтлан бодогч тэдгээр хуулийн эсвэл дүрэм журмын заалтыг сайтар ойлгож, доор заасны дагуу нийцүүлэх ёстой:
- (а) Илэрсэн асуудлыг зохих түвшний эрх мэдэл бүхий хүн, эсвэл байгууллагад тайлагнах шаардлагатай эсэх;
 - (б) Холбогдох талд сэрэмжлүүлэхийг хориглосон эсэх.
- 260.6 A1 Мөнгө угаахын эсрэг хууль тогтоомжийн дагуу, хамаарах этгээдэд урьдчилан сануулахыг хориглох асуудал үүсэж болзошгүй.
- 260.5 A1 Ажил олгогч байгууллага нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгж мөн эсэхээс үл хамааран, энэ бүлгийг дагаж мөрдөнө.
- 260.7 A2 Муу үр дагавартай биш гэдэг нь илэрхий байгаа асуудалтай тулгарсан эсвэл ийм гэдгийг мэдсэн мэргэжлийн нягтлан бодогч энэ бүлгийг дагаж мөрдөх шаардлагагүй. Асуудлын үр дагавар илэрхий муу биш эсэхийг түүний санхүүгийн мөн чанар ба нөлөө нь ажил олгогч байгууллага, оролцогч талууд, нийт ард иргэдэд ямар байхаас хамааруулан шийднэ.
- 260.7 A3 Энэ бүлэгт дараах зүйлийг тусгаагүй:
- (а) Ажил олгогч байгууллагын бизнесийн үйл ажиллагаатай холбоогүй хувийн зохисгүй зан авир;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

(б) 260.5A1-д тодорхойлсноос бусад талуудын гаргасан үйл нийцэл.

Гэсэн хэдий ч, дээрх тохиолдолд авах арга хэмжээний талаар эргэцүүлэхэд тус дэм болохуйц удирдамжийг мэргэжлийн нягтлан бодогч энэ бүлгээс олж үзэх боломжтой.

Ажил Олгогч Байгууллагын Гүйцэтгэх ба Засаглах Эрхтэй Удирдлагын Хүлээх Хариуцлага

260.8 A1 Ажил олгогч байгууллагын гүйцэтгэх удирдлага нь засаглах эрхтэй удирдлагын хяналтын хамт тухайн ажил олгогч байгууллагын бизнесийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа гэдгийг бататгах үүрэгтэй. Гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлага нь дараах этгээдийн үйлдэж болох үл нийцлийг олж тогтоон, шийдвэрлэх хариуцлагыг мөн хүлээдэг. Үүнд:

- (а) Ажил олгогч байгууллага;
- (б) Ажил олгогч байгууллагын засаглах эрхтэй удирдлагад байдаг хувь хүн;
- (в) Гүйцэтгэх удирдлагын гишүүн;
- (г) Ажил олгогч байгууллагын төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад хувь хүн.

Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчийн Үүрэг Хариуцлага

Ш260.9 Хэрэв үл нийцэл эсвэл сэжигтэй үл нийцлийн үед түүнийг хэрхэн шийдэх талаар мэргэжлийн нягтлан бодогчийн ажиллаж байгаа байгууллагад протокол болон горим байдаг бол, тэрээр ийм үл нийцлийн үед авах арга хэмжээг тодорхойлохдоо харгалзах нь зүйтэй.

260.9 A1 Дотооддоо үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн асуудлыг хэрхэн гаргаж ирэхийг тусгасан протокол ба горимтой байгууллага олон бий. Эдгээр протокол ба горимд тухайлбал, ёс зүйн бодлого, дотоодын шүгэл үлээх механизм зэргийг оруулдаг. Ийм протокол ба горимд, түүнд тодорхойлсон сувгаар дамжуулан, нэрээ дурдалгүйгээр асуудлыг мэдээлэхийг зөвшөөрөх боломжтой.

Ш260.10 Энэ бүлэгт хамаарах асуудлын талаар мэргэжлийн нягтлан бодогч мэдсэн бол, энэ бүлэгт заасны дагуу түүний хийвэл зохих алхмыг тэрээр хугацаа алдалгүй хэрэгжүүлэх нь зүйтэй. Зохих алхмыг цаг хугацаанд нь хийхийн тулд, нягтлан бодогч тухайн асуудлын мөн чанар ба ажил олгогч байгууллага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, нийт ард иргэдийн ашиг сонирхолд учирч болзошгүй хор хохирлыг харгалзах хэрэгтэй.

Бизнес дэх Ахлах Түвшний Мэргэжлийн Нягтлан Бодогчийн Үүрэг Хариуцлага

260.11 A1 Бизнес дэх ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчид (“ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчид”) бол ажил олгогч байгууллагын хүний нөөц, санхүү, технологи, биет болон биет бус нөөцийн худалдан авалт, байршуулалт, хяналтад нөлөөлөх болон шийдвэр гаргах эрхтэй захирал, албан тушаалтан эсвэл ахлах түвшний ажилтан байна. Ажил олгогч байгууллагын доторх үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн хариуд, мэргэжлийн нягтлан бодогчдыг бодвол дээр дурдсан хүмүүс нийтийн эрх ашгийг хамгаалахуйц илүү дорвитой арга хэмжээ авна гэсэн хүлээлт байдаг. Учир нь ажил олгогч байгууллагын хэмжээнд ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчдын гүйцэтгэдэг үүрэг, байр суурь, нөлөөллийн хүрээ их байдаг.

Асуудлыг Ойлгох

Ш260.12 Хэрэв, ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцдаа үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотой мэдээллийг мэдэж авсан бол тэрээр тухайн асуудлын тухай ойлголттой болох хэрэгтэй. Ойлгох гэдэгт дараах зүйл багтана:

- (а) Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн мөн чанар, ийм зүйл гарсан эсвэл гарч болох нөхцөл байдал;
- (б) Холбогдох хууль тогтоомжийг тухайн нөхцөл байдалд мөрдөх;
- (в) Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, олон нийтэд хохирол учруулж болзошгүй үр дагаврын үнэлгээ.

260.12 A1 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийг мэдлэг, ур чадвараа ашиглан, мэргэжлийн шүүн тунгаалтыг хэрэгжүүлнэ хэмээн хүлээдэг. Гэхдээ, тухайн нягтлан бодогчийн хууль тогтоомжийн

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ойлголтын түвшин нь ажил олгогч байгууллагын дотор нягтлан бодогчийн гүйцэтгэдэг үүрэгт шаардагдах түвшнээс их байна хэмээн хүлээх боломжгүй. Аливаа үйлдэл нь үл нийцэл бий болгож байгаа эсэхэд шүүх буюу холбогдох хөндлөнгийн шүүхийн байгууллага тодорхойлох болно.

260.12 A2 Асуудлын мөн чанар ба ач холбогдлоос шалтгаалан, ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч тухайн асуудлыг дотоодоо мөрдөн шалгах эсвэл шалгалт хийх тохиромжтой арга хэмжээг авах боломжтой. Түүнээс гадна, нягтлан бодогч нь ажил олгогч байгууллагын доторх бусад хүмүүс, мэргэжлийн байгууллага, эсвэл хуулийн зөвлөхтэй, нууцлалыг хадгалах замаар зөвлөлдөх боломжтой.

Асуудлыг Шийдэх

Ш260.13 Хэрэв ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч үл нийцлийг олж тогтоосон, эсвэл гарч болзошгүй хэмээн сэжиглэж байвал тэрээр Ш206.9-д заасны дагуу энэ талаар өөрийнхөө дээд түвшний ахлах ажилтантай ярилцах хэрэгтэй. Хэрэв нягтлан бодогчийн өөрийнх нь дээд түвшний ахлах ажилтан тухайн асуудалд оролцсон гэдэг нь илэрвэл, тэрээр тухайн ажилтнаас дээгүүр эрх мэдэл бүхий албан тушаалтантай ярилцах ёстой.

260.13 A1 Энэ ярилцлагын зорилго нь тухайн асуудлыг хэрхэн шийдэх арга замаа тодорхойлоход оршино.

Ш260.14 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь мөн дараах арга хэмжээг авах нь зүйтэй:

- (a) Засаглах эрхтэй удирдлагад тухайн асуудлыг мэдээлсэн байх;
- (b) Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, үүнд үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийг зохих эрх мэдэл бүхий байгууллагад тайлагнах тухай хуулийн эсвэл зохицуулах байгууллагын дүрэм, журам;
- (b) Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн үр дагаврыг засаж залруулах, хор уршгийг багасгасан байх;
- (г) Дахин гарах буюу үйлдэх эрсдэлийг бууруулах;
- (д) Үл нийцэл хараахан гараагүй бол, тийм үйлдэлд оролцох тохиолдлыг таслан зогсоох.

260.14 A1 Засаглах эрхтэй удирдлагад тухайн асуудлыг мэдээлэх зорилго нь тохирсон хариу арга хэмжээ авахдаа тэдний дэмжлэгийг олж авах, тэдэнд үүрэг хариуцлагаа биелүүлэх боломж олгох явдал юм.

260.14 A2 Зарим хууль тогтоомжид, үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаар зохих эрх мэдэл бүхий байгууллагад ямар хугацааны дотор тайлагнахыг заасан байх боломжтой.

Ш260.15 Энэ бүлэгт дурдсаны дагуу, асуудлын хариуд авах арга хэмжээнээс гадна, хэрэв шаардлагатай гэж үзвэл, ажиллаж байгаа байгууллагын хөндлөнгийн аудиторт тухайн асуудлыг танилцуулах эсэхээ ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч харгалзах нь зүйтэй.

260.15 A1 Ийм танилцуулга хийхдээ, аудиторт аудитаа гүйцэтгэх боломж олгох бүх хэрэгцээт мэдээллээр хангах ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийн үүрэг буюу хуулийн хариуцлагаа мөрдөж байгаа хэрэг юм.

Цаашид Арга Хэмжээ Авах Хэрэгтэй Эсэхийг Тодорхойлох

Ш260.16 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь өөрөөсөө дээд түвшний ахлах албан тушаалтан болон засаглах эрхтэй удирдлагын хариу арга хэмжээ зохистой эсэхийг үнэлэх ёстой.

260.16 A1 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийн дээд түвшний албан тушаалтан болон засаглах эрхтэй удирдлагын хариу арга хэмжээ зохистой эсэхийг үнэлэхдээ харгалзаж үзэх хүчин зүйлс нь дараах байна. Үүнд:

- Хариу арга хэмжээг цагт нь авсан эсэх.
- Үл нийцлийн үр дагаврыг засаж залруулах, хор уршгийг багасгах, хэрэв үл нийцэл хараахан гараагүй бол, түүнийг гарахаас сэрэмжлэхийн тулд тохиромжтой бөгөөд зөвшөөрөгдсөн арга хэмжээ авсан байх;
- Шаардлагатай бол асуудлыг зохих эрх мэдэл бүхий этгээдэд ил болгож танилцуулсан, хэрэв тийм бол уг мэдээлэл зохистой байсан эсэх.

Ш260.17 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийн дээд түвшний албан тушаалтан болон засаглах эрхтэй

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

удирдлагын хариу арга хэмжээний үр дүнд, цаашид ийм арга хэмжээг нийтийн эрх ашгийн төлөө явуулах хэрэгтэй эсэхийг нягтлан бодогч тодорхойлох нь зүйтэй.

260.17 A1 Цаашид ийм арга хэмжээ авах хэрэгтэй эсэхийг түүний мөн чанар ба далайцын хамт тодорхойлох нь янз бүрийн хүчин зүйлээс хамаарах бөгөөд үүнд дараахыг багтаана. Үүнд:

- Хууль тогтоомжийн үзэл баримтлал.
- Тухайн нөхцөл байдлын ач холбогдол.
- Ажил олгогч байгууллагын хэмжээнд тухайн асуудал хэр тархмал буюу түгээмэл байгаа.
- Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь өөрийнхөө дээд түвшний албан тушаалтан болон засаглах эрхтэй удирдлагын шударга байдалд итгэлтэй хэвээр байгаа эсэх.
- Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэл дахин гарах магадлалтай эсэх.
- Ажил олгогч байгууллага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, нийт ард иргэдийн ашиг сонирхолд бодит болон боломжит томоохон гарз хохирол учрах илэрхий нотолгоо байгаа эсэх.

260.17 A2 Өөрийнхөө дээд түвшний албан тушаалтан болон засаглах эрхтэй удирдлагын шударга байдалд цаашид итгэхгүй байхад ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийг хүргэж болзошгүй нөхцөлийн жишээг доор дурдсан болно. Үүнд:

- Нягтлан бодогч тэдгээр хүмүүсийг ямар нэг үл нийцэх үйл ажиллагаанд оролцсон эсвэл оролцохыг завдсан гэж сэжиглэх, эсвэл тийм нотолгоо олж авсан бол.
- Хууль тогтоомжийн шаардлагын эсрэг, тэд тухайн асуудлын талаар зохих эрх мэдэл бүхий байгууллагад, үндэслэл бүхий хугацааны дотор тайлагнаагүй эсвэл тайлагнах зөвшөөрөл өгөөгүй байх.

Ш260.18 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь цаашид арга хэмжээ авах хэрэгцээ, мөн чанар, далайцыг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх нь зүйтэй. Ийнхүү тодорхойлохдоо, ухаалаг бөгөөд мэдлэгтэй аливаа гуравдагч талын зүгээс тухайн нягтлан бодогчийг нийтийн эрх ашигт тохирсон арга хэмжээ авсан хэмээн дүгнэж чадах эсэхийг тэрээр харгалзах нь зүйтэй.

260.18 A1 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийн цаашид авах боломжтой арга хэмжээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Хэрэв түүний ажиллаж байгаа байгууллага нь групп компанийн гишүүн бол, толгой компанийн удирдлагад асуудлыг мэдээлэх.
- Хууль тогтоомжоор шаардаагүй ч гэсэн, холбогдох эрх мэдэл бүхий этгээдэд асуудлыг танилцуулах.
- Ажил олгогч байгууллагад ажиллахаас татгалзах.

260.18 A2 Ажил олгогч байгууллагад ажиллахаас татгалзах нь, энэ бүлэгт тодорхойлсон ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийн зорилгод хүрэхийн тулд шаардагдаж болох бусад арга хэмжээг орлуулах үйлдэл биш юм. Гэхдээ, зарим эрх зүйн орчинд, тухайн нягтлан бодогчийн цаашид авах арга хэмжээнд хязгаарлалт тогтоодог байж болзошгүй. Энэ нөхцөлд, ажлаас татгалзах нь цорын ганц боломжит үйлдэл байх боломжтой.

Зөвлөгөө Хүсэх

260.19 A1 Асуудлыг үнэлэхдээ цогц шинжилгээ ба шүүн тунгаалт оруулж болох бөгөөд ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг харгалзах боломжтой. Үүнд:

- Дотооддоо зөвлөлдөх.
- Нягтлан бодогчийн сонголт, ямар нэг тодорхой арга хэмжээ авснаар бий болох мэргэжлийн эсвэл хуулийн нөлөөллийг ойлгохын тулд хуулийн зөвлөгөө авах.
- Зохицуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай нууц хадгалах зарчмын дагуу зөвлөлдөх

Зохих Эрх Мэдэл Бүхий Этгээдэд Асуудлыг Танилцуулах

260.20 A1 Зохих эрх мэдэл бүхий этгээдэд асуудлыг танилцуулах нь хууль тогтоомжийн эсрэг байвал үүнийгээ

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

болих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, танилцуулга хийх зорилго нь тухайн асуудлыг мөрдөн шалгах, нийтийн ашиг сонирхолд нийцсэн хариу арга хэмжээ авахад хүргэхүйц боломжийг зохих эрх мэдэл бүхий этгээдэд олгох явдал юм.

260.20 А2 Ийм танилцуулга хийх эсэхийг шийдэхэд ялангуяа, тухайн асуудлын мөн чанар ба ажил олгогч байгууллага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, нийт ард иргэдэд учирсан эсвэл учирч болзошгүй хор хохирлын далайц хамааралтай байдаг. Жишээлбэл, дараах тохиолдолд тухайн асуудлыг зохих эрх мэдэл бүхий этгээдэд танилцуулах нь тохиромжтой арга хэмжээ хэмээн ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлох боломжтой. Үүнд:

- Ажиллаж байгаа байгууллага нь хээл хахуулийн хэрэгт оролцсон (жишээлбэл, томоохон гэрээ байгуулахын тулд орон нутгийн болон гадаадын засгийн газрын ажилтнуудад хахууль өгсөн).
- Ажил олгогч байгууллагын үйл ажиллагааг зохицуулагч байгууллага зохицуулдаг бөгөөд тухайн асуудал нь үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлд аюул учруулахуйц нөлөөтэй.
- Ажил олгогч байгууллага хөрөнгийн биржид бүртгэлтэй бөгөөд тухайн асуудал нь байгууллагын үнэт цаасны шударга, тогтсон дүрмийн дагуух зах зээлийн арилжаанд сөрөг нөлөөтэй, эсвэл санхүүгийн зах зээлийн тогтолцоонд бүхэлд нь эрсдэл учруулж болзошгүй байвал.
- Ажил олгогч байгууллагын борлуулж байгаа бүтээгдэхүүн нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл учруулах магадлалтай.
- Ажил олгогч байгууллага нь үйлчлүүлэгчдээ татвараас зайлсхийхэд нь туслах схемийг сурталчилдаг.

260.20А3 Ийм танилцуулга хийх эсэхээ тодорхойлоход дараах гаднын хүчин зүйлс мөн нөлөөлдөг. Үүнд:

- Ийм мэдээлэл хүлээн авах боломжтой эрхтэй этгээд байдаг эсэх, мөн тэр этгээд нь тухайн асуудлыг мөрдөх, зохих арга хэмжээ авч чадах эсэх. Зохих эрх мэдэл бүхий этгээд нь тухайн асуудлын мөн чанараас хамаарна. Жишээлбэл, санхүүгийн тайланг залилан мэхэлсэн байвал ийм этгээд нь үнэт цаасны зохицуулагч байгууллага, орчны тухай хууль тогтоомж зөрчсөн асуудлын хувьд ийм байгууллага нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах агентлаг гэх мэт байгууллага байна.
- Иргэний, эрүүгийн эсвэл мэргэжлийн өр төлбөр эсвэл өс хонзонгоос хамгаалах бөх бат, найдвартай хууль тогтоомжоор зөвшөөрсөн арга хэрэгсэл, жишээлбэл, шүгэл үлээх хууль тогтоомж байдаг эсэх.
- Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч эсвэл бусад хүмүүсийн биет аюулгүй байдалд бодитоор учирсан эсвэл учрах боломжтой аюул занал бий эсэх.

Ш260.21 Хэрэв ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч, тухайн асуудлыг зохих эрх мэдэл бүхий албан тушаалтанд мэдээлэх нь нөхцөлд байдалд тохирсон үйл явц хэмээн тодорхойлсон бол Дүрмийн Ш114.1(г) параграфт заасны дагуу ийнхүү мэдээлэхийг зөвшөөрдөг. Ингэж мэдээлэхдээ, нягтлан бодогч нь шударга байж, тайлан ба батламж мэдэгдэл гаргахдаа болгоомжтой няхуур байх ёстой.

Зайлшгүй Зөрчил

Ш260.22 Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагч, олон нийтэд ихээхэн гарз хохирол учруулж болохуйц хэмжээнд хууль тогтоомжийг гарцаагүй зөрчихөд хүрсэн гэж итгэх шалтгаан бүхий ховор тохиолдолд, энэхүү бодит эсвэл төлөвлөсөн үйлдлийн талаар ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч мэдэх боломжтой. Ажиллаж байгаа байгууллагын удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай тухайн асуудлаар ярилцах нь зүйтэй гэж анх үзэхдээ нягтлан бодогч нь мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлэн, уг асуудлыг зохих эрх мэдэл бүхий этгээдэд нэн даруй мэдэгдсэнээр ийм зайлшгүй зөрчлийн үр дагавраас сэргийлж эсвэл түүнийг багасгаж чадна. Хэрэв мэдэгдсэн бол, үүнийг энэ Дүрмийн Ш114.1(г) параграфт зааснаар хийх ёстой.

Баримтжуулалт

260.23А1 Энэ бүлгийн хамрах хүрээнд багтдаг үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотойгоор, дараах зүйлийг баримтжуулсан байхыг мэргэжлийн нягтлан бодогчид зөвлөдөг:

- Уг асуудал.
- Нягтлан бодогчийн дээд түвшний ажилтан, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлага, бусад талтай

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

хийсэн ярилцлагын үр дүн.

- Нягтлан бодогчийн дээд түвшний ажилтан, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлага, бусад талтай хийсэн ярилцлагын үр дүн.
- Нягтлан бодогчид дээд түвшний ахлах ажилтан эсвэл засаглах эрхтэй удирдлага байдаг бол, тэд тухайн асуудалд ямар арга хэмжээ авсан болох.
- Нягтлан бодогчийн харгалзаж үзсэн үйл явц, гаргасан шүүн тунгаалт, авсан арга хэмжээ.
- Ш260.147-д заасан үүрэг хариуцлагаа биелүүлсэн нягтлан бодогч үүндээ хэр сэтгэл хангалуун байгаа тухай.

Ахлах Түвшний Мэргэжлийн Нягтлан Бодогчоос Бусад Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Үүрэг Хариуцлага

Ш260.24 Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байхдаа, үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн тухай мэдээллийг олж мэдсэн мэргэжлийн нягтлан бодогч уг асуудлын тухай ойлголттой болох ёстой. Энэ ойлголтод үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн шинж чанар болон ийм үйл явдал үүссэн эсвэл үүсэж болзошгүй нөхцөл байдал багтдаг.

260.24 A1 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчийг мэдлэг, ур чадвараа ашиглан, мэргэжлийн шүүн тунгаалтыг хэрэгжүүлнэ хэмээн хүлээдэг. Гэхдээ, тухайн нягтлан бодогчийн хууль тогтоомжийн ойлголтын түвшин нь ажил олгогч байгууллагын дотор нягтлан бодогчийн гүйцэтгэдэг үүрэгт шаардагдах түвшнээс их байна хэмээн хүлээх боломжгүй. Аливаа үйлдэл нь үл нийцэл бий болгож байгаа эсэхэд шүүх буюу холбогдох хөндлөнгийн шүүхийн байгууллага тодорхойлох болно.

260.24 A2 Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч нь асуудлын мөн чанар ба ач холбогдлыг харгалзан, ажил олгогч байгууллагын доторх бусад хүмүүс, мэргэжлийн байгууллага, эсвэл хуулийн зөвлөхтэй нууцлалыг хадгалах замаар зөвлөлдөх боломжтой.

Ш260.25 Хэрэв ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч үл нийцлийг олж тогтоосон, эсвэл гарч болзошгүй хэмээн сэжиглэж байвал тэрээр Ш206.9-д заасны дагуу энэ талаар өөрийнхөө дээд түвшний ахлах ажилтантай ярилцах хэрэгтэй. Хэрэв нягтлан бодогчийн өөрийнх нь дээд түвшний ахлах ажилтан тухайн асуудалд оролцсон гэдэг нь илэрвэл, тэрээр тухайн ажилтнаас дээгүүр эрх мэдэл бүхий албан тушаалтантай ярилцах ёстой.

Ш260.26 Ховор тохиолдолд, тухайн асуудлаар зохих эрх мэдэл бүхий этгээдтэй ярилцахыг тохиромжтой арга хэмжээ хэмээн ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлж болох юм. Хэрэв нягтлан бодогч 260.20A2 ба A3-ын дагуу ийнхүү мэдээлсэн бол тэрээр энэ Дүрмийн Ш114.1(г) параграфт зөвшөөрснөөр хийх ёстой. Ингэж мэдээлэхдээ, нягтлан бодогч нь шударга байж, тайлан ба батламж мэдэгдэл гаргахдаа болгоомжтой няхуур байх ёстой.

Баримтжуулалт

260.27 A1 Энэ бүлгийн хамрах хүрээнд багтдаг үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотойгоор, дараах зүйлийг баримтжуулсан байхыг мэргэжлийн нягтлан бодогчид зөвлөдөг:

- Уг асуудал.
- Нягтлан бодогчийн дээд түвшний ажилтан, гүйцэтгэх удирдлага, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлага мөн бусад талтай хийсэн ярилцлагын үр дүн.
- Дээд түвшний ахлах ажилтан тухайн асуудалд ямар арга хэмжээ авсан болох.
- Нягтлан бодогчийн харгалзаж үзсэн үйл явц, гаргасан шүүн тунгаалт, авсан арга хэмжээ.

БҮЛЭГ 270

СУУРЬ ЗАРЧМЫГ ЗӨРЧИХӨД ХҮРГЭДЭГ ДАРАМТ ШАХАЛТ

Танилцуулга

- 270.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь Бүлэг 120-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 270.2 Мэргэжлийн нягтлан бодогчид өөрт нь ирсэн эсвэл түүний үзүүлсэн дарамт шахалт нь айлган сүрдүүлэлт эсвэл бусад аюул занал нь нэг эсвэл хэд хэдэн суурь зарчмын нийцэлд аюул занал үүсгэж болзошгүй. Дээр дурдсан тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тайлбарласан болно.

Шаардлага ба ашиглах материал

Ерөнхий зүйл

- Ш270.3** Мэргэжлийн нягтлан бодогчид дараах үйлдлийг хориглох ёстой:
- (а) Үл нийцлийн суурь зарчмыг зөрчихөд хүргэдэг, бусдаас ирэх аливаа дарамт шахалтад орох;
 - (б) Нягтлан бодогч нь суурь зарчим зөрчихөд хүргэхийг мэдэж байгаа, эсвэл зөрчинө гэж итгэх шалтгааныг мэдсээр байж, бусад хүмүүст дарамт шахалт үзүүлэх.
- 270.3 А1 Суурь зарчмын нийцэлд жишээлбэл, айлган сүрдүүлэлтийн аюул занал үүсгэж болохуйц дарамт шахалттай мэргэжлийн нягтлан бодогч мэргэжлийн үйл ажиллагаа явуулах явцад учирч болзошгүй. Дарамт шахалт нь ил эсвэл далд байж болох бөгөөд дараах этгээдээс ирэх боломжтой. Үүнд:
- Ажиллаж байгаа байгууллага доторх, тухайлбал, хамтран ажиллаж байгаа хүн эсвэл түүний дээд түвшний ажилтан.
 - Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, зээлдүүлэгч зэрэг гаднын хүмүүс эсвэл байгууллага.
 - Дотоод ба гадаад төлөвлөлт ба хүлээлт.
- 270.3 А2 Суурь зарчмын нийцэлд аюул занал үүсгэж болзошгүй дарамт шахалтын жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Ашиг, сонирхлын зөрчилтэй холбоотой дарамт:
 - Мэргэжлийн нягтлан бодогчийн ажиллаж байгаа байгууллагын бэлтгэн нийлүүлэгч болохоор тендерт оролцож байгаа гэр бүлийн гишүүний дарамт, энэ тохиолдолд өөр боломжит бэлтгэн нийлүүлэгчийг биш, харин гэр бүлийн гишүүнээ сонгох.
- Бүлэг 210, *Ашиг сонирхлын зөрчил*-ийг үзнэ үү.
- Мэдээллийг бэлтгэх ба толилуулахад нөлөөлөхийг оролдсон дарамт:
 - Хөрөнгө оруулагч, шинжээч, зээлдүүлэгчийн хүлээлтийг биелүүлэхийн тулд санхүүгийн үр дүнг гуйвуулан тайлагнах дарамт.
 - Санал авахын тулд хөтөлбөр, төслийг сонгогчдод буруу танилцуулахыг улсын секторын нягтлан бодогчид даалгах сонгуульт албан тушаалтны дарамт.
 - Капитал төсөл ба худалдан авалтын талаар өрөөсгөл шийдвэр гаргуулахын тулд орлого, зарлага, өгөөжийн хувь хэмжээг буруу илэрхийлэх талаар хамт ажиллаж байгаа хүмүүсээс ирэх дарамт.
 - Бизнесийн хууль ёсны биш зардлыг батлах, гаргуулах талаар дээд түвшний ажилтнаас ирэх дарамт.
 - Сөрөг үр дүн агуулсан дотоод аудитын тайланг нуун дарагдуулах дарамт.
- Бүлэг 220, *Мэдээлэл бэлтгэх ба толилуулах*-г үзнэ үү.
- Хангалттай ур чадвар ба хянамгай байдал гаргахгүйгээр үйл ажиллагаа явуулах дарамт:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Гүйцэтгэсэн ажлын далайцыг зүй бусаар багасгах талаар дээд түвшний ажилтнаас ирэх дарамт.
- Хангалттай ур чадвар, эсвэл сургалтгүйгээр эсвэл бодит бус хугацаанд даалгавар гүйцэтгүүлэхээр дээд түвшний ажилтнаас ирэх дарамт.

Бүлэг 230, *Хангалттай ур чадвартай байж үйл ажиллагаа явуулах*-г үзнэ үү.

- Санхүүгийн ашиг сонирхолтой холбоотой дарамт:
 - Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг хуурамчаар гаргах замаар нөхөн олговор эсвэл урамшууллын хэлцлээс ашиг хүртэж болзошгүй дээд түвшний ажилтан, ажлын хамт олон эсвэл бусад хүмүүсээс ирэх дарамт.

Бүлэг 240, *Санхүүгийн ашиг сонирхол, санхүүгийн тайлагнал ба шийдвэр гаргалттай холбоотой нөхөн олговор ба урамшуулал*-ыг үзнэ үү.

- Бэлэг дайллагатай холбоотой дарамт:
 - Ажиллаж байгаа байгууллага дотор эсвэл гаднаас хувь хүн эсвэл байгууллагын шийдвэр гаргах үйл явцад зүй бусаар нөлөөлөх зорилгоор бэлэг, дайллага цайллага санал болгох дарамт.
 - Хамт ажилладаг хүмүүсээс хахууль, бусад бэлэг сэлт хүлээн авахыг шаардах дарамт, жишээлбэл, тендерийн үйл явцад боломжит бэлтгэн нийлүүлэгчдээс тохиромжгүй бэлэг өгөх эсвэл зугаа цэнгэл санал болгох.

Бүлэг 250, *Бэлэг, дайллага цайллага*-ыг үзнэ үү.

- Хууль тогтоомжид үл нийцэхтэй холбоотой дарамт:
 - Татвараас зугтаахын тулд ажил гүйлгээг будлиантуулах дарамт.

Бүлэг 260, *Хууль тогтоомжтой үл нийцэх тохиолдолд авах арга хэмжээ*-г үзнэ үү.

270.3 А3 Дарамт шахалтын улмаас үүссэн аюул заналын түвшнийг үнэлэхтэй холбоотой хүчин зүйлсэд дараахыг оруулна. Үүнд:

- Дарамт үзүүлж байгаа этгээдийн зорилго, уг дарамтын шинж чанар ба далайц.
- Тухайн нөхцөлд мөрдөх хууль тогтоомж, мэргэжлийн стандарт.
- Ажиллаж байгаа байгууллагын соёл, манлайлал, үүнд, байгууллагаас ёс зүйтэй зан төлөвийг хэр чухалд тооцдог, ач холбогдлыг хэр үнэлдэг, ажилтнууд нь ёс зүйтэй үйлдэл хийнэ гэсэн хүлээлт ямар байдаг зэрэг орно. Жишээлбэл, хэрэв корпорацын соёл нь ёс зүйгүй зан төлөвийг хүлцэн тэвчихээр байвал, суурь зарчмын нийцэлд аюул занал учрах магадлалыг нэмэгдүүлэх боломжтой.
- Хэрэв ёс зүйн эсвэл хүний нөөцийн бодлого зэрэг ажиллаж байгаа байгууллагын бодлого, дүрэм журам байдаг бол тэдгээрт дарамт шахалтыг тодорхойлох.

270.3 А4 Дарамт үүсгэж байгаа нөхцөлийг авч хэлэлцэх, үүний талаар бусад хүмүүстэй зөвлөлдөх нь аюул заналын түвшнийг үнэлэхэд мэргэжлийн нягтлан бодогчдод тус дэмтэй байж болзошгүй. Ийнхүү ярилцаж, зөвлөлдөхдөө дараах асуудлыг багтаах боломжтой бөгөөд нууц хадгалах зарчмыг гойд анхаарах шаардлагатай. Үүнд:

- Дарамт үзүүлж байгаа этгээдтэй ярилцаж, шийдэх арга зам хайх.
- Хэрэв дарамт үзүүлж байгаа этгээд нь тухайн нягтлан бодогчийн дээд түвшний албан тушаалтан биш бол, түүнтэй тулгарсан асуудлаар ярилцах.
- Ажиллаж байгаа байгууллагын дотор тухайн асуудлыг тавих, ингэхдээ, хэрэв боломжтой бол, байгууллагад үүсэх эрсдэлийг дараах этгээдэд тайлбарлах. Үүнд:
 - Дээд түвшний удирдлага.
 - Дотоод ба гадаад аудитууд.
 - Засаглах эрхтэй удирдлага.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Ажиллаж байгаа байгууллагын ёс зүй ба шүгэл үлээх бодлогын дагуу, нууц хадгалах ёс зүйн хөтлөгч зэрэг бий болгосон механизм ашиглан тухайн асуудлыг мэдээлэх.
- Дараах хүмүүстэй зөвлөлдөх:
 - Хамт ажиллаж байгаа ажилтан, дээд түвшний ажилтан, хүний нөөцийн ажилтан, бусад мэргэжлийн нягтлан бодогч;
 - Хамаарах мэргэжлийн эсвэл зохицуулах байгууллага, салбарын холбоод;
 - Хуулийн зөвлөх.

270.3 А5 Дарамт шахалтаас үүссэн аюул заналыг бууруулах боломжтой арга хэмжээний жишээнд, дарамт үзүүлж байгаа хүмүүс эсвэл байгууллагатай тухайн нягтлан бодогчийг цаашид харьцаж ажиллуулахгүй байлгахын тулд зарим үүрэг хариуцлага, ажлын чиг үүргийг өөрчлөх, тусгаарлах зэргийг дурдаж болно.

Баримтжуулалт

270.4 А1 Мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулах нь зүйтэй:

- Бодит байдал.
- Тухайн асуудлыг хөндөж ярилцсан харилцаа холбоо ба талууд.
- Харгалзаж үзсэн үйлдлийн өрнөл.
- Тухайн асуудлыг хэрхэн олж тогтоосон.

БҮЛЭГ 3 – НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧ

	Хуудас
Хэсэг 300 Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх – Нийтэд үйлчилдэг Мэргэжлийн Нягтлан Бодогчид	58
Хэсэг 310 Ашиг Сонирхлын Зөрчил	63
Хэсэг 320 Мэргэжлийн Томилгоо	68
Хэсэг 321 Хоёрдогч Дүгнэлт	71
Хэсэг 330 Хураамж болон Бусад Төрлийн Урамшуулал	72
Хэсэг 340 Бэлэг, Дайллага	74
Хэсэг 350 Үйлчлүүлэгчийн Хөрөнгийн Хамгаалалт	79
Хэсэг 360 Хууль Тогтоомжтой Үл Нийцэх Тохиолдолд Авах Арга Хэмжээ	80

БҮЛЭГ 3 – НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД

ХЭСЭГ 300

ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ МӨРДӨХ – НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ МЭРГЭЖЛИЙН НЯГТЛАН БОДОГЧИД

Танилцуулга

- 300.1 Ёс зүйн стандартын энэ Бүлэгт нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид Хэсэг 120-д тусгасан онолын үзэл баримтлалыг мөрдөхдөө ашиглах шаардлага ба бусад материалыг тодорхойлсон болно. Энд нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид тулгарч болох бөгөөд суурь зарчмын нийцэлд аюул занал учруулдаг эсвэл учруулж болзошгүй мэргэжлийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцааны бүх бодит байдал, нөхцөлийг нэг бүрчлэн тодорхойлоогүй. Тиймээс нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдыг ийм нөхцөл байдал, харилцаа холбооноос сэрэмжлэхийг шаарддаг.
- 300.2 Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид хамааралтай нэмэлт шаардлага ба ашиглах материалыг дараах хэсэгт тодорхойлсон болно. Үүнд:
- Бүлэг 3 – *Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч*, баталгаажуулах үйлчилгээ үзүүлдэг эсэхээс үл хамааран, нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын мөрддөг Хэсэг 300-390.
 - *Хараат бус байдлын олон улсын стандарт* буюу:
 - Бүлэг 4А – *Аудит ба нягтлах гэрээт ажлын хараат бус байдал*, аудит ба нягтлах гэрээт ажил гүйцэтгэхдээ нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын мөрддөг Хэсэг 400-899;
 - Бүлэг 4Б – *Аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах гэрээт ажлын хараат бус байдал*, аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах гэрээт ажил гүйцэтгэхдээ нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын мөрддөг Хэсэг 400-899.
- 300.3 Энэ Бүлэгт, “мэргэжлийн нягтлан бодогч” гэсэн нэр томъёо нь нийтэд үйлчилдэг болон тэдгээрийн компанид ажилладаг мэргэжлийн нягтлан бодогч хувь хүнийг хэлнэ.

Шаардлага ба ашиглах материал

Ерөнхий зүйл

- Ш300.4** Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Бүлэг 110-д тодорхойлсон суурь зарчим, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- Ш300.5** Ёс зүйтэй холбоотой асуудлыг авч үзэхдээ мэргэжлийн нягтлан бодогч, тухайн асуудал үүсээд байгаа эсвэл үүсэж болзошгүй орчин нөхцөлийг харгалзах нь зүйтэй. Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь компанитай харилцаа үүсгэсний дараа түүнд гэрээний дагуу, ажилтан эсвэл өмчлөгчийн хувиар мэргэжлийн үйл ажиллагаа гүйцэтгэж байвал; ийм нөхцөлд мөрддөг Бүлэг 2-ын заалтуудад нийцүүлэн ажиллах ёстой.
- 300.5 А1 Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын мөрддөг Бүлэг 2-т хамааралтай нөхцөл байдлын жишээ доор дурдсан болно. Үүнд:
- Нягтлан бодогчийн ам бүлийн гишүүн нь ажиллаж байгаа компанидаа бэлтгэн нийлүүлэгч сонгох үүрэгтэй бөгөөд уг гэрээнээс санхүүгийн ашиг хүртэх боломжтой байвал ашиг сонирхлын зөрчил үүснэ. Энэ тохиолдолд, Хэсэг 210-д тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг мөрдөнө.
 - Нягтлан бодогч нь өөрийн үйлчлүүлэгч эсвэл ажиллаж байгаа компанид санхүүгийн мэдээлэл бэлтгэж эсвэл толилуульж байвал. Энэ тохиолдолд, Хэсэг 220-д тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг мөрдөнө.
 - Спортын арга хэмжээнд үнэ төлбөргүй оролцох урилгыг компанийн бэлтгэн нийлүүлэгчийн зүгээс тогтмол бэлэглэж байх санал тавих. Энэ тохиолдолд, Хэсэг 250-д тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг мөрдөнө.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Үйлчлүүлэгчийн гэрээт ажилд үл тохирох төлбөртэй цагийн талаар тайлагнах тухай гэрээт ажлын партнерээс дарамт учруулах. Энэ тохиолдолд, Хэсэг 270-д тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг мөрдөнө.

Аюул Заналыг Олж Тогтоох

300.6A1 Суурь зарчмын нийцэлд учрах аюул занал нь өргөн хүрээний бодит баримт, нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болзошгүй. 120.6A3-р параграфт аюул заналын ангилал буюу төрлийн талаар дурдсан болно. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн нягтлан бодогчид аюул занал учруулж болзошгүй бодит байдал ба нөхцөлийг аюул заналын төрөл тус бүрээр жишээлэн харуулсан болно:

(а) Хувийн ашиг сонирхлын аюул занал

- Үйлчлүүлэгчтэйгээ санхүүгийн шууд ашиг сонирхолтой мэргэжлийн нягтлан бодогч.
- Шинэ ажил олж авахын тулд бага үнэ санал болгож байгаа мэргэжлийн нягтлан бодогч бөгөөд тэрхүү бага үнээр мөрдвөл зохих техникийн болон мэргэжлийн стандартын дагуу мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байх боломжтой.
- Үйлчлүүлэгчтэйгээ бизнесийн дотнын харилцаатай мэргэжлийн нягтлан бодогч.
- Хувийн эрх ашгийн төлөө ашиглаж болох нууц мэдээлэлд хүрэх эрхтэй мэргэжлийн нягтлан бодогч.
- Нягтлан бодогчийн компанийн аль нэг гишүүний өмнө нь гүйцэтгэсэн мэргэжлийн үйлчилгээний үр дүнг үнэлж байхдаа томоохон алдаа илрүүлсэн мэргэжлийн нягтлан бодогч.

(б) Өөрийгөө хянах аюул занал

- Үйл ажиллагааны системийг хэрэгжүүлсний дараа, уг системийн үр ашигтай эсэх талаар баталгаажуулах ажлын тайлан гаргаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч.
- Баталгаажуулах гэрээт ажлын гол асуудал бүхий бүртгэлийн боловсруулалтад ашигласан анхны тоон мэдээг бэлтгэж байгаа мэргэжлийн нягтлан бодогч.

(в) Өмгөөллийн аюул занал

- Мэргэжлийн нягтлан бодогч нь аудитын үйлчлүүлэгчийн Ашиг Сонирхол эсвэл хувьцааг сурталчлах.
- Мэргэжлийн нягтлан бодогч нь шүүхийн зарга эсвэл гуравдагч талтай үүсгэсэн маргааныг шийдвэрлэхэд аудитын үйлчлүүлэгчийн өмгөөлөгчөөр ажиллах.
- Мэргэжлийн нягтлан бодогч нь аудитын үйлчлүүлэгчийн өмнөөс хууль тогтоомжийг өөрт ашигтайгаар хэрэгжүүлэхэд лобби хийж байгаа.

(г) Танилын аюул занал

- Мэргэжлийн нягтлан бодогчийн ойрын эсвэл ам бүлийн гишүүн нь үйлчлүүлэгчийн захирал эсвэл ажилтан.
- Үйлчлүүлэгчийн захирал, ажилтан, эсвэл гэрээт ажлын гол асуудалд үлэмж нөлөө үзүүлдэг албан тушаал бүхий ажилтан нь саяхан болтол уг гэрээт ажил хариуцсан партнерээр ажиллаж байсан.
- Аудитын багийн гишүүн нь үйлчлүүлэгчтэй удаан хугацааны харилцаа холбоотой байх.

(д) Айлган сүрдүүлэх аюул занал

- Мэргэжлийн асуудлаар санал зөрөлдсөний улмаас мэргэжлийн нягтлан бодогчийг үйлчлүүлэгчийн гэрээт ажилд оролцохыг болиулах эсвэл компаниас халах аюул занал.
- Үйлчлүүлэгч нь тухайн шалгах асуудлаар илүү их мэдлэгтэй учраас түүний шүүн тунгаалтыг зөвшөөрөх дарамтад орж буйгаа мэргэжлийн нягтлан бодогч мэдрэх.
- Хэрэв нягтлан бодогч нь үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн зохисгүй арга хандлагыг эс хүлээн зөвшөөрвөөс түүнийг төлөвлөсөн албан тушаалд дэвшүүлэхгүй гэдгээ мэргэжлийн нягтлан бодогчид мэдэгдэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Үйлчлүүлэгчээс томоохон бэлэг хүлээн авсан бөгөөд ийнхүү хүлээн авсныг нь олон нийтэд мэдээлнэ гэж сүрдүүлэгт автсан мэргэжлийн нягтлан бодогч.

Аюул Заналыг Үнэлэх

300.7 А1 Параграф 120.6А1, 120.8А2-г тодорхойлсон нөхцөл, бодлого, горим нь суурь зарчмын нийцэлд учруулах аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх үнэлгээнд нөлөөлж болох юм. Ийм нөхцөл, бодлого, горим нь дараах зүйлтэй холбоотой байж болох юм. Үүнд:

- (а) Үйлчлүүлэгч ба түүний ажиллаж байгаа орчин;
- (б) Аудитын компани ба түүний ажиллаж байгаа орчин.

300.7 А2 Аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогчийн хийх үнэлгээнд мэргэжлийн үйл ажиллагааны мөн чанар ба цар хүрээ мөн нөлөөлөх боломжтой.

Үйлчлүүлэгч ба Түүний Ажиллаж Байгаа Орчин

300.7 А3 Аюул занал хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа эсэх талаар мэргэжлийн нягтлан бодогчийн хийх үнэлгээнд тухайн үйлчлүүлэгчийн дараах шинж төлөв нөлөөлөх боломжтой. Жишээлбэл:

- (а) Аудитын үйлчлүүлэгч бөгөөд тэр нь нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж мөн эсэх;
- (б) Аудитын үйлчлүүлэгч биш харин баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч;
- (в) Баталгаажуулалтын бус үйлчлүүлэгч.

Тухайлбал, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр аудиттай холбоотой бодитой байх зарчмын нийцэлд маш өндөр аюул занал учруулах үр дүнд хүрнэ хэмээн ойлгож болно.

300.7 А4 Корпорацийн засаглалын бүтэц, үүнд үйлчлүүлэгчийн манлайлал хэр байх нь суурь зарчмын нийцэлд түлхэц өгөх боломжтой. Иймээс, аюул заналын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчийн өгөх үнэлгээнд үйлчлүүлэгчийн ажиллаж байгаа орчин нөлөөлөх боломжтой. Үүнд:

- Гэрээт ажил гүйцэтгэх хүнийг удирдлагын бүрэлдэхүүнд ордоггүй хүнээр гүйцэтгүүлэх компанийн томилгоог батлах буюу зөвшөөрүүлэхийг үйлчлүүлэгч шаарддаг.
- Үйлчлүүлэгч нь удирдлагын шийдвэр гаргахын тулд ахлах түвшний, туршлагатай, чадварлаг ажилтнуудтай байх.
- Үйлчлүүлэгч нь баталгаажуулалтын бус гэрээт ажлыг удирдан чиглүүлэх бодитой сонголт дэмжлэг үзүүлэхүйц дотоод горимыг хэрэгжүүлсэн байх.
- Үйлчлүүлэгч нь компанийн үйлчилгээг хөндлөнгөөс хянаж, түүний талаар мэдээлэл өгдөг тийм корпорацийн засаглалын бүтэцтэй байх.

Компани ба Түүний Ажиллаж Байгаа Орчин

300.7 А5 Аюул заналын түвшинд мэргэжлийн нягтлан бодогчийн өгөх үнэлгээнд нягтлан бодогчийн компани ба түүний ажиллаж буй орчин нөлөөлөх боломжтой. Үүний жишээнд:

- Суурь зарчмын нийцлийг хөхүүлэн дэмжиж, баталгаажуулах ажлын багийн гишүүд нийтийн эрх ашгийн төлөө ажиллана гэсэн хүлээлт бий болгосон компанийн манлайлал.
- Ажилтнуудын суурь зарчмын нийцлийг хэрэгжүүлдэг болон түүнд мониторинг хийдэг бодлого буюу горим.
- Суурь зарчмын нийцлийг хөхүүлэн дэмжих зорилготой нөхөн олговор, гүйцэтгэлийн үнэлэмж, сахилгын бодлого ба горим.
- Нэг үйлчлүүлэгчээс хүлээн авсан орлогод удирдлагын тулгуурладаг байдал.
- Үйлчлүүлэгчээ хүлээн зөвшөөрөх эсвэл түүнд үйлчилгээ үзүүлэх зэрэг асуудлаар суурь зарчимд нийцсэн шийдвэрийг компанийн хэмжээнд гаргах эрх мэдэл бүхий гэрээт ажлын партнер.
- Боловсрол, сургалт, туршлагын хувьд тавих шаардлага.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Гаднын эсвэл дотоодын сэтгэл зовоосон асуудал буюу гомдлыг арилгах, олж илрүүлэх үйл явц.

Шинэ Мэдээлэл болон Бодит Байдал, Нөхцөлийн Өөрчлөлтийг Харгалзах

300.7 А6 Шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлт дараах зүйлд нөлөөлөх боломжтой.

- (а) Аюул заналын далайцад нөлөөлөх;
- (б) Ашигласан хамгаалалтын арга нь олж тогтоосон аюул заналыг тодорхойлоход цаашид тохиромжтой хэвээр байх эсэх талаар хийсэн нягтлан бодогчийн дүгнэлтэд нөлөөлөх.

Дээрх нөхцөлд, хамгаалалт болгон аль хэдийн хэрэгжүүлсэн арга хэмжээ нь цаашид аюул заналыг олж тогтооход үр дүнтэй байх боломжгүй. Иймээс, онолын үзэл баримтлалд шаардсаны дагуу, мэргэжлийн нягтлан бодогч нь аюул заналыг зохих ёсоор дахин үнэлж, тодорхойлох ёстой (Лав: Пара. Ш120.9 ба Ш120.10).

300.7 А7 Аюул заналын далайцад нөлөөлж болзошгүй шинэ мэдээлэл ба бодит байдал, нөхцөлийн өөрчлөлтийн жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Мэргэжлийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлсэн.
- Үйлчлүүлэгч нь хувьцаат компани болсон эсвэл өөр бизнесийн нэгж худалдаж авсан
- Компани өөр нэг компанитай нийлсэн.
- Мэргэжлийн нягтлан бодогч хоёр өөр үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсэн бөгөөд энэ хоёр үйлчлүүлэгчийн хооронд маргаан гарсан.
- Мэргэжлийн нягтлан бодогчийн өөрийнх нь буюу ам бүлийн харилцаа холбоонд өөрчлөлт орсон.

Аюул Заналыг Олж Тогтоох

300.8 А1 Хүлээн зөвшөөрөгдөхгүй түвшинд байгаа аюул заналыг олж тогтоохдоо баримтлах шаардлага ба ашиглах материалыг Ш120.10-120.10А2-г тодорхойлсон болно.

Хамгаалалтын Жишээ

300.8 А2 Бодит байдал ба нөхцөлөөс шалтгаалан хамгаалалт өөр өөр байдаг. Аюул заналыг олж тогтоохын тулд зарим тодорхой нөхцөлд хамгаалалт байж болзошгүй арга хэмжээний жишээг дурдвал:

- Хүлээн авсан гэрээт ажил нь хувийн ашиг сонирхлын аюул заналыг илтгэж байх үед шаардлагатай үүрэг даалгавар гүйцэтгүүлэхээр нэмэлт цаг өгөх, чадвартай боловсон хүчин томилох.
- Багийн гишүүн бус, гэхдээ тохирох хүнээр гүйцэтгэсэн ажлыг хянуулах, шаардлага гарвал зөвлөгөө өгүүлэх нь өөрийгөө хянах аюул заналыг илтгэх боломжтой.
- Баталгаажуулалтын бус үйлчилгээг баталгаажуулалтын үйлчилгээ авдаг үйлчлүүлэгчид үзүүлэхийн тулд тайлагналын тусдаа зорилготой өөр өөр партнер ба гэрээт ажлын баг ашиглах нь өөрийгөө хянах, өмгөөлөх, танилын аюул занал учруулж болзошгүй.
- Гэрээт ажил гүйцэтгэх эсвэл дахин гүйцэтгэхдээ өөр компани оролцуулах нь хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах, өмгөөлөх, танилын, айлган сүрдүүлэх зэрэг аюул занал учруулж болзошгүй.
- Үйлчилгээ буюу бүтээгдэхүүн санал болгосны төлөө хүлээн авсан гуйлтын төлбөр буюу шимтгэлийн тохиролцооны талаар үйлчлүүлэгчид мэдээлэх нь хувийн ашиг сонирхлын аюул занал учруулж болзошгүй.
- Нууцын шинжтэй асуудлыг шийдэхдээ багуудыг тусгаарлах нь хувийн ашиг сонирхлын аюул занал учруулж болзошгүй.

300.8 А3 Бүлэг 3-ийн үлдсэн хэсэг ба Хараат бус байдлын олон улсын стандартад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад гарч болзошгүй тодорхой аюул заналыг тодорхойлж, ийм аюул заналыг олж тогтоох боломжтой арга хэмжээг жишээгээр дурдсан байна.

Тохирох Хянан Шалгагч

300.8 А4 Гүйцэтгэсэн ажил буюу үзүүлсэн үйлчилгээг бодитоор хянан шалгахад хэрэгтэй мэдлэг, ур чадвар, туршлага, эрх мэдэлтэй мэргэжилтнийг тохирох хянан шалгагч гэнэ. Ийм хүн нь мэргэжлийн нягтлан бодогч байх боломжтой.

Дээд Шатны Удирдлагатай Харилцах

- Ш300.9** Ёс зүйн дүрмийн зүйл, заалтын хүрээнд дээд удирдлагатай харилцахдаа мэргэжлийн нягтлан бодогч нь тодорхой нөхцөл байдлын мөн чанар, ач холбогдол болон харилцах асуудал, үйлчлүүлэгч байгууллагын засаглалын бүтцийн хүрээнд харилцвал зохих хүмүүсийг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь дээд удирдлагын дэд бүлэгтэй харилцаж байвал дээд удирдлагад зохих ёсоор мэдээлэл хүргэх үүднээс тэдэнтэй бүгдтэй нь харилцах шаардлагатай эсэхийг тодорхойлох ёстой.
- 300.9 A1 Хэнтэй харилцахаа тодорхойлохын тулд мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг харгалзана:
- (а) Үүссэн нөхцөл байдлын мөн чанар ба ач холбогдол;
 - (б) Харилцах буюу мэдээлэхээр зэхэж буй асуудал.
- 300.9 A2 Дээд шатны удирдлагын дэд бүлгийн жишээнд аудитын хороо, эсвэл дээд шатны удирдлагын хувь гишүүнийг нэрлэж болно.
- Ш300.10** Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь гүйцэтгэх болон засаглах үүрэг хариуцлагын аль алийг хүлээдэг хувь хүмүүстэй харилцдаг бол, тухайн нягтлан бодогч үүнээс өөр тохиолдолд дээд шатны удирдлагад багтдаг бүх хүмүүст зохих ёсоор мэдээлэх байсан гэдэгт тэрээр сэтгэл хангалуун байх ёстой.
- 300.10 A1 Зарим тохиолдолд, засаглах эрхтэй удирдлагад тухайн ажил олгогч байгууллагыг удирдаж буй хүмүүс багтдаг, жишээлбэл, ганц эзэнтэй жижиг бизнест тухайн эзэн байгууллагаа удирддаг буюу түүнээс өөр засаглах үүрэгтэй хүн байдаггүй. Энэ тохиолдолд, хэрэв асуудлыг гүйцэтгэх үүрэг хариуцлага бүхий хувь хүн (хүмүүс) болон засаглах үүрэг хариуцлага бүхий хувь хүн (хүмүүс)-т мэдээлж байвал, мэргэжлийн нягтлан бодогч дээд шатны удирдлагад багтдаг хүмүүстэй харилцах буюу мэдээлэх шаардлагыг биелүүлсэн гэдэгт сэтгэл хангалуун байдаг.

ХЭСЭГ 310

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Танилцуулга

- 310.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 310.2 Ашиг сонирхлын зөрчил нь бодитой байх зарчмын нийцэлд аюул учруулдаг гадна бусад суурь зарчимд ч аюул учруулж болзошгүй. Ийм аюул занал дараах тохиолдолд учрах боломжтой:
- Мэргэжлийн нягтлан бодогч нь тодорхой зүйлд хамаарах асуудлаар, уг асуудалд ашиг сонирхлын зөрчилтэй хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгчдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байвал;
 - Мэргэжлийн нягтлан бодогчийн тодорхой зүйлд хамаарах ашиг сонирхол болон тухайн мэргэжлийн нягтлан бодогчоос тэрхүү тодорхой зүйлээр мэргэжлийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн ашиг сонирхол зөрчилдөж байвал.
- 310.3 Энэ хэсэгт, ашиг сонирхлын зөрчилд онолын үзэл баримтлалыг мөрдөхдөө түүнд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг тодорхойлсон болно. Аудит, нягтлах ажил, бусад баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн нягтлан бодогчоос *Хараат бус байдлын олон улсын стандартыг* дагаж мөрдөхийг мөн шаарддаг.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- Ш310.4** Мэргэжлийн эсвэл бизнесийн шүүн тунгаалтад муугаар нөлөөлж болзошгүй ашиг сонирхлын зөрчлөөс мэргэжлийн нягтлан бодогч зайлсхийх ёстой.
- 310.4 А1 Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөлүүдийн жишээ:
- Компанидаа аудитын үйлчлүүлэгч олж авахаар зэхэж байгаа үйлчлүүлэгчид гүйлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд аудитын явцад уг ажил гүйлгээнд хамаарч болзошгүй нууц мэдээллийг тухайн компани олж авсан.
 - Нэг ижил компани худалдаж авахын тулд өрсөлдөж байгаа хоёр үйлчлүүлэгчид нэгэн зэрэг зөвлөсөн бөгөөд уг зөвлөх үйлчилгээ нь өрсөлдөх байр суурь бүхий талуудтай хамаатай байж болзошгүй.
 - Нэг ижил ажил гүйлгээний бэлтгэн нийлүүлэгч ба худалдан авагчийн аль алинд үйлчлэх.
 - Тодорхой хөрөнгийн төлөө өрсөлдөх байр сууринд байгаа хоёр талд тухайн хөрөнгийн үнэлгээг хийж өгч байгаа.
 - Харилцан бие биедээ хуулийн маргаан үүсгэсэн нэг асуудал дээр талуудын аль алийг төлөөлөх, жишээ нь гэр бүл салалт, нөхөрлөл татан буулгах гэх мэт.
 - Лицензийн гэрээний дагуу роялти авах гэж байгаа лиценз олгогчид баталгаажуулах ажлын тайлангаа хүргүүлэх, үүний зэрэгцээ өглөгийн дүн зөв эсэх талаар лиценз эзэмшигчид зөвлөх.
 - Олон нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчийн гэр бүлийн хүн нь санхүүгийн Ашиг Сонирхолтой байдаг үйлчлүүлэгчид хөрөнгө оруулахыг зөвлөх.
 - Гол өрсөлдөгчтэй нь хамтарсан үйлдвэрийн тал байх эсвэл үүнтэй ойролцоо Ашиг Сонирхолтой байх тийм үйлчлүүлэгчид өрсөлдөх байр суурийнх нь талаар стратегийн зөвлөгөө өгөх.
 - Өөрийн компанийн худалдан авч эзэмших хүсэлтэй байгаа бизнесийг мөн адил худалдан авахыг сонирхож байгаа компанид энэ талаар зөвлөгөө өгөх.
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээний боломжит бэлтгэн нийлүүлэгчдийн хэн нэгтэй роялти эсвэл агентын гэрээтэй байхдаа тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтын талаар үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх.

Зөрчлийг Тогтоох

Ерөнхий зүйл

Ш310.5 Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь шинэ үйлчлүүлэгчтэй харилцаа тогтоох, гэрээт ажил эсвэл бизнесийн харилцаа тогтоохын өмнө ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл байдлыг тодорхойлохын тулд ул суурьтай алхам хийх хэрэгтэй. Ингэхдээ дараах зүйлийг тодорхойлно:

- Хамаарах талуудын хоорондын сонирхол, харилцаа холбооны мөн чанар;
- Үйлчилгээний мөн чанар, түүний үр нөлөө хамаарах талуудад ямар байх.

310.5 А1 Гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө, мөн гэрээт ажлын явцад бодит эсвэл боломжит ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ашиг сонирхол, харилцаа холбоог тодруулахын тулд ул үндэслэлтэй арга хэмжээ авахад нь мэргэжлийн нягтлан бодогчид зөрчил илрүүлэх үр өгөөжтэй үйл явц тусалдаг. Үүнд гаднын талууд, жишээ нь үйлчлүүлэгч эсвэл боломжит үйлчлүүлэгчийн тодорхойлсон асуудлууд багтдаг. Бодит эсвэл боломжит ашиг сонирхлын зөрчлийг хэдий чинээ эрт тодруулна, ашиг сонирхлын зөрчлөөс үүссэн аюул заналыг нягтлан бодогч олж тогтоох магадлал тэр хэрээр нэмэгдэнэ.

310.5 А2 Бодит ба боломжит ашиг сонирхлын зөрчил илрүүлэх үйл явц үр дүнтэй байх эсэх нь дараах хүчин зүйлээс хамаардаг:

- Үзүүлсэн мэргэжлийн үйлчилгээний мөн чанар.
- Компанийн хэмжээ.
- Үйлчлүүлэгчдийн баазын хэмжээ ба мөн чанар.
- Компанийн бүтэц, жишээлбэл салбарын тоо, газарзүйн байршил гэх мэт.

310.5 А3 Үйлчлүүлэгчийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой лүү дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 320, *Мэргэжлийн томилгоо*-нд тодорхойлсон болно.

Нөхцөл Байдлын Өөрчлөлт

Ш310.6 Мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбооны мөн чанарт цаг хугацааны явцад гарсан өөрчлөлтийг мэргэжлийн нягтлан бодогч дээрх аюулд тооцох ёстой.

310.6 А1 Үйлчилгээний шинж чанар, ашиг сонирхол, харилцаа холбоо нь гэрээт ажлын явцад өөрчлөгдөж болзошгүй. Ялангуяа, мэргэжлийн нягтлан бодогчийн хувьд сөрөг нөхцөл үүсгэж болзошгүй тохиолдолд, тэр бүү хэл тухайн нягтлан бодогчийг хөлсөлсөн талууд аливаа маргаанд эхэлж оролцохгүй байх боломжтой байсан ч, гэрээт ажилд оролцохыг мэргэжлийн нягтлан бодогчоос хүссэн гийм тохиолдолд дээрх өөрчлөлт гарна.

Сүлжээ Компаниуд

Ш310.7 Хэрэв компани нь сүлжээ компанийн гишүүн бол, сүлжээ компанийн ашиг сонирхол, харилцаа холбоонд үндэслэн, ашиг сонирхлын зөрчил байж болзошгүй эсвэл үүсэж болзошгүй хэмээн итгэх шалтгаан мэргэжлийн нягтлан бодогчид төрсөн бол тэрээр ашиг, сонирхлын зөрчлийг харгалзах ёстой.

310.7 А1 Сүлжээ компаниудын хоорондох ашиг сонирхол ба харилцаа холбоог илрүүлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзвал зохино:

- Үзүүлсэн мэргэжлийн үйлчилгээний мөн чанар.
- Сүлжээ компаниар үйлчлүүлсэн үйлчлүүлэгч.
- Хамаарах бүх талын газарзүйн байршил.

Ашиг Сонирхлын Зөрчлөөс Үүссэн Аюул Занал

310.8 А1 Ерөнхийдөө, мэргэжлийн үйлчилгээ ба талуудын ашиг сонирхол зөрчилдөж байж болох зүйлүүдийн хооронд хэр шууд холбоо байна, тэр хэрээр аюул заналыг хүлээн зөвшөөрөх түвшин өндөр байна.

310.8 А2 Ашиг сонирхол зөрчлийн улмаас үүссэн аюул заналын түвшнийг үнэлэхэд хамаарах хүчин зүйлсэд,

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тодорхой асуудлаар хоорондоо ашиг сонирхол нь зөрчилдөх хоёр ба түүнээс дээш тооны үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байхдаа нууц мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ багтдаг. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн нууц мэдээллийг практик ажлуудын хооронд дамжуулахад хаалт байх боломжтой тийм чиг үүргийн тусгаарлалтыг компанийн хэмжээний бүтцэд бий болгох.
- Үйлчлүүлэгчийн файлд нэвтрэх боломжийг хязгаарлах бодлого, горимтой байх.
- Нууц хадгалах гэрээг компанийн ажилтан ба партнертэй байгуулж, гарын үсэг зуруулах.
- Нууц мэдээллийг биет болон цахим хэлбэрээр тусад нь хадгалах.
- Тусгай болон зориулалтын сургалт явуулах, харилцаа мэдээлэлтэй байх.

310.8 АЗ Ашиг сонирхлын зөрчлөөс үүссэн аюул заналыг арилгах хамгаалалт байх боломжтой арга хэмжээнийн жишээнд дараахыг дурдана:

- Нууц хадгалах тодорхой бодлого, горимыг мөрддөг гэрээт ажлын тусдаа багуудтай болох.
- Чухал шүүн тунгаалт, дүгнэлтийн зохистой эсэхэд тухайлсан үйлчилгээнд оролцоогүй, эсвэл зөрчилд өртөөгүй этгээдээр үнэлгээ хийлгэхийн тулд гүйцэтгэсэн ажлыг хянаж байх хянагчтай болох.

Тодруулга Ба Зөвшөөрөл

Ерөнхий

Ш310.9 Ашиг сонирхлын зөрчлөөр үүсэж буй аюул занал нь заавал тусгайлан ил тод зарлах хэмжээний шинж чанар, ач холбогдолтой эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн шүүн тунгаалтаа ашиглах ёстой.

310.9 А1 Заавал тусгайлан ил тод зарлах хэмжээний шинж чанар, ач холбогдолтой эсэхийг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзвал зохино:

- Ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй нөхцөл байдал.
- Зөрчлийн нөлөө тусаж болзошгүй талууд.
- Гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн мөн чанар.
- Гэнэтийн тохиолдолд тодорхой асуудлаар боловсруулалт хийх боломж

310.9А2 Тодруулга ба зөвшөөрөл янз бүрийн хэлбэртэй байх боломжтой бөгөөд үүний жишээг дор дурдсан болно:

- Арилжааны нийтлэг үйл ажиллагааны дагуу мэргэжлийн нягтлан бодогчоос үйлчлүүлэгчид ерөнхий зөвшөөрөл өгөхийн тулд уг нягтлан бодогч хэн нэг үйлчлүүлэгчид онцгойлон үйлчилгээ (жишээ нь, тодорхой нэг зах зээл дээр тодорхой нэг үйлчилгээ үзүүлэх) үзүүлдэггүй. Энэ нь тухайн үйлчлүүлэгчийг ерөнхий зөвшилцлөөр хангах боломж өгдөг. Жишээлбэл, гэрээт ажил гүйцэтгэх стандарт нөхцөл, болзолд мэргэжлийн нягтлан бодогч ерөнхий тодруулга хийх боломжтой.
- Үүссэн асуудлаар мэдээлэл бүхий шийдвэр гаргаж, түүний дагуу зөвшөөрлийг ил тодорхой өгөх боломжоор үйлчлүүлэгчийг хангахын тулд, уг зөрчлийн нөлөөлөлд өртсөн үйлчлүүлэгчдэд зориулан зөрчлийн нөхцөл байдлыг маш дэлгэрэнгүй тодруулж мэдээлэх. Ийм тодруулгад, нөхцөл байдлын дэлгэрэнгүй танилцуулга, төлөвлөж байгаа хамгаалалт, эрсдийг нэг бүрчлэн тайлбарласан тайлбарыг оруулах боломжтой.
- Үйлчлүүлэгчид нь тухайн нөхцөл байдлыг анхнаасаа мэдэж байсан бөгөөд ашиг сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэх хангалттай нотолгоо мэргэжлийн нягтлан бодогчид байгаа тохиолдолд, оршин байгаа зөрчлийг эсэргүүцэхгүй байгаа тэдний зан төлөв нь зөвшөөрлийг илэрхийлэх боломжтой.

310.9 АЗ Дараах алхмыг хийх нь нийтлэг шаардлага юм:

- (а) ашиг сонирхлын зөрчлийн мөн чанар болон уг зөрчлийн нөлөө туссан үйлчлүүлэгчдэд учрах аюул заналыг хэрхэн олж тогтоосон талаар ил тод мэдээлэх;
- (б) аюул заналыг илрүүлэхийн тулд хамгаалалтын арга хэмжээ авч байгаа тохиолдолд, мэргэжлийн

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

үйлчилгээ үзүүлэхдээ зөрчлийн нөлөөнд автах үйлчлүүлэгчдээс зөвшөөрөл авах.

- 310.9 А4 Хэрэв ийм тодруулах мэдээлэл эсвэл зөвшөөрлийг бичгээр аваагүй бол, мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулах нь зүйтэй. Үүнд: аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулахын тулд хэрэглэсэн хамгаалалт, авсан зөвшөөрөл зэргээ дараах байдлаар баримтжуулбал зохино:
- (а) Ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй нөхцөл байдлын шинж чанар;
 - (б) Мөрдөх боломжтой тохиолдолд, аюул заналыг олж илрүүлэхийн тулд ашигласан хамгаалалтын арга хэмжээ;
 - (в) Авсан зөвшөөрөл.

Ил Тод Мэдээлэх Зөвшөөрөл Өгөхөөс Татгалзах

- Ш310.10** Хэрэв Ш310.9 параграфын дагуу ил тод мэдээлэх зөвшөөрөл авах зайлшгүй шаардлагатай хэмээн мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлсон боловч үйлчлүүлэгч ийм зөвшөөрөл өгөхөөс татгалзсан бол мэргэжлийн нягтлан бодогч дараах алхмын аль нэгийг хийх нь зүйтэй. Үүнд:
- (а) Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох үйлчилгээнээс татгалзах; эсвэл
 - (б) Аюул заналыг зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулахын тулд холбогдох харилцаа холбоогоо таслах, эсвэл өөрт хамаарах Ашиг Сонирхолгоо зарах.

Нууц Хадгалах

Ерөнхий

- Ш310.11** Компани эсвэл сүлжээ доторх компанийн хүрээнд, мэдээллийг ил тод болгох, хуваалцах, гуравдагч этгээдээс удирдамж хүсэхдээ мэргэжлийн нягтлан бодогч нууц хадгалах зарчимд онцгой сэрэмжтэй хандах хэрэгтэй.
- 310.11 А1 Дэд хэсэг 114-д, нууц хадгалах зарчмын нийцэлд аюул занал учруулж болзошгүй нөхцөлд хамаарах шаардлага болон ашиглах материалыг оруулсан болно.

Мэдээллийг Ил Тод Болгох Зөвшөөрөл Олж Авах нь Нууц Хадгалах Зарчмыг Зөрчих Тохиолдол

- Ш310.12** Ил тод мэдээлэх зөвшөөрөл авах зорилгоор онцгой тодруулга хийх нь нууц хадгалах зарчмыг зөрчихөд хүргэх учраас дээрх зөвшөөрлийг авч чадаагүй бол компани зөвхөн дараах нөхцөлд л гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөх, эсвэл үргэлжлүүлэх боломжтой:
- (а) Компани нэг үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд яг ижил асуудалтай холбоотой өөр нэг үйлчлүүлэгчээс эсрэг байр суурь баримтлахыг тухайн компаниас шаардаж байвал тэрээр ийм өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхгүй байх;
 - (б) Хоёр үйлчлүүлэгчид үйлчилж байгаа аудитын ажлын багууд нууц мэдээллийг хоорондоо солилцохоос сэргийлэхэд чиглэсэн тусгай арга хэмжээ авдаг байх;
 - (в) Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх компанийн боломжийг хязгаарласнаар, тухайн үйлчлүүлэгчид эсвэл хамааралтай гуравдагч талуудад зохисгүй сөрөг үр дүн авчирч болзошгүй тул компани гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөх буюу үргэлжлүүлэх нь тохиромжтой байна хэмээн ул суурьтай, мэдлэгтэй гуравдагч тал дүгнэх магадлалд компани сэтгэл хангалуун байх.

Ул суурьтай, мэдлэгтэй гуравдагч тал нь компанийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадварт үүссэн хязгаарлалтын улмаас бусад үйлчлүүлэгч эсвэл хамааралтай гуравдагч талуудад зохисгүй сөрөг үр дагавар авчрах тул гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөх эсвэл үргэлжлүүлэх нь тохиромжтой гэж дүгнэх магадлалд компани сэтгэл хангалуун байх.

- 310.12 А1 Дараах үйлчилгээг гүйцэтгэх зөвшөөрөл хүсэж байгаа үед нууц хадгалах зарчим зөрчигдөж болзошгүй юм. Үүнд:
- Компанийн нэг үйлчлүүлэгчийг нөгөө үйлчлүүлэгч нь хүчээр худалдан авахтай холбоотой ажил гүйлгээнд хамаарах үйлчилгээ үзүүлэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Сэжиг бүхий залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон үйлчлүүлэгчид шүүх магадлангийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд энэ тухай нууц мэдээллийг уг залилан мэхлэлтэд оролцсон байж болох өөр нэг үйлчлүүлэгчийн төлөө ашиглах.

Баримтжуулалт

ШЗ10.13 Параграф ШЗ10.12-т тодорхойлсон нөхцөлд, мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулбал зохино:

- (a) Мэргэжлийн нягтлан бодогчийн гүйцэтгэх үүргийг оролцуулан, тухайн нөхцөл байдлын шинж чанар;
- (б) Хоёр үйлчлүүлэгчид үйлчилж байгаа гэрээт ажлын багууд хоорондоо мэдээлэл солилцохоос сэргийлэхийн тулд тусгай арга хэмжээ бий болгох;
- (в) Гэрээт ажлыг зөвшөөрөх эсвэл үргэлжлүүлэхийг яагаад тохиромжтой гэж үзсэн тухай.

ХЭСЭГ 320

МЭРГЭЖЛИЙН ТОМИЛГОО

Танилцуулга

- 320.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 320.2 Шинэ үйлчлүүлэгчтэй тогтоосон харилцаа, эсвэл одоогийн гэрээт ажлын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх нь нэг буюу хэд хэдэн суурь зарчмын нийцэлд аюул занал учруулж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг мөрдөхтэй холбоотой тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Үйлчлүүлэгч болон Гэрээт Ажлыг Зөвшөөрөх

Ерөнхий

- 320.3 A1 Шударга байдал, мэргэжлийн зан төлөвийн зарчимтай үл нийцэх аюул занал жишээлбэл, үйлчлүүлэгч (мөн түүний эзэд ба удирдлага эсвэл үйл ажиллагаа)-тэй холбоотой эргэлзээтэй асуудлын улмаас үүсэх боломжтой. Ийм аюул занал учруулж болзошгүй асуудал нь, хэрэв мэдэгдэж байгаа бол хууль бус ажиллагаа, шударга бус байдал, санхүүгийн тайлагналын булхайтай практик эсвэл ёс зүйгүй зан төлөв зэрэг байж болно.
- 320.3 A2 Аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана. Үүнд:
- Үйлчлүүлэгч, түүний эзэд, гүйцэтгэх ба засаглах эрхтэй, мөн бизнесийн үйл ажиллагааг хариуцсан этгээдүүдийн тухай мэдлэг олж авах, ойлголттой болох.
 - Корпорацийн засаглалын практик эсвэл дотоод хяналтыг сайжруулах замаар анхаарал татсан асуудлыг олж тогтоох гэсэн үйлчлүүлэгчийн үүрэг хариуцлага.
- 320.3 A3 Хэрэв гэрээт ажлын баг нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хангалттай чадавх эзэмшээгүй буюу олж аваагүй бол мэргэжлийн ур чадвар, хянамгай байдлын зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал бий болдог.
- 320.3 A4 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхтэй холбоотой дараах хүчин зүйлс байдаг:
- Дараах зүйлсийн тухай зохих ойлголт:
 - Үйлчлүүлэгчийн бизнесийн мөн чанар;
 - Үйл ажиллагааны ярвигтай байдал;
 - Гэрээт ажлын шаардлага;
 - Гүйцэтгэсэн ажлын зорилго, мөн чанар ба хамрах хүрээ.
 - Холбогдох салбар ба гол зүйлийн талаарх мэдлэг.
 - Зохицуулалт эсвэл тайлагналын шаардлагад хамаарах туршлага.
 - Гэрээт ажлыг ур чадвартай гүйцэтгэж чадна гэсэн тохиолдолд л зөвхөн тухайн ажлыг зөвшөөрсөн гэсэн үндэслэл бүхий баталгаагаар хангахын тулд чанарын хяналтын бодлого ба горимтой байх.
- 320.3 A5 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг шийдэх хамгаалалтын арга хэмжээ байх боломжтой арга хэмжээний жишээг дор дурдсан болно. Үүнд:
- Шаардагдах чадавх бүхий хангалттай боловсон хүчнээр гэрээт ажлын багийг бүрдүүлэх.
 - Гэрээт ажлыг гүйцэтгэсэн байх хугацааг бодитой тохирч, тавих.
 - Шаардлагатай үед нарийн мэргэжлийн хүмүүсийг орролцуулах.

Мэргэжлийн Томилгооны Өөрчлөлт

Ерөнхий

Ш320.4 Мэргэжлийн нягтлан бодогч нь дараах тохиолдолд гэрээт ажлыг хүлээн авахгүй байх шалтгаан байгаа эсэхийг тодорхойлох ёстой. Үүнд:

- (а) Өөр нягтлан бодогчоор солих хүсэлтийг боломжит үйлчлүүлэгч гаргасан;
- (б) Өөр нягтлан бодогчийн ажиллаж байгаа гэрээт ажлыг тендерээр гүйцэтгүүлэхээр төлөвлөж байгаа;
- (в) Тэрхүү өөр нягтлан бодогчоор ажлыг гүйцээлгэх эсвэл нэмж өгөхөөр төлөвлөж байгаа.

320.4 А1 Гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөхгүй байх шалтгаан гарч болзошгүй. Ийм шалтгааны нэг нь хэрэв хамгаалалтуудыг ашиглаад ч шийдэх боломжгүй аюул заналыг арилгаж чадахааргүй нөхцөл байдал байж болно. Жишээлбэл, хэрэв мэргэжлийн нягтлан бодогч нь холбогдох бүх бодит нөхцөл байдлыг олж мэдэхээс өмнө гэрээт ажлыг зөвшөөрсөн байвал, мэргэжлийн ур чадвар болон хянамгай байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй.

320.4 А2 Одоогийн буюу өмнөх нягтлан бодогчийн ажлыг гүйцээх эсвэл нэмж хийхийг мэргэжлийн нягтлан бодогчоос хүсэх нь дутуу дулимаг мэдээлэл зэргээс шалтгаалан түүний мэргэжлийн ур чадвар ба хянамгай байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй.

320.4 А3 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхтэй холбоотой хүчин зүйлд, гэрээт ажлыг зөвшөөрөхийн өмнө, одоогийн буюу өмнөх нягтлан бодогчтой харилцаа тогтоохыг хүсэх талаар саналд тусгасан эсэх явдал юм. Ийм харилцаа нь, тухайн гэрээт ажлыг яагаад зөвшөөрөх ёсгүй хэмээн үзэж байгаа шалтгааныг дараагийн нягтлан бодогчоос лавлах боломж өгдөг.

320.4 А4 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээ байх боломжтой арга хэмжээг доор дурдсан. Үүнд:

- Одоогийн болон өмнөх нягтлан бодогчийн бодож байгаагаар, дараагийн нягтлан бодогч нь гэрээт ажлыг зөвшөөрөх эсэхээ шийдэхийн өмнө мэдвэл зохих бүх мэдээллээр хангахыг одоогийн болон өмнөх нягтлан бодогчоос хүсэх. Жишээлбэл, асуулга лавлагааны үр дүнд өмнө нь илрүүлээгүй байсан бөгөөд холбогдох баримт нөхцөлийг илрүүлснээр томилолтыг хүлээн зөвшөөрөх эсэх шийдвэрийн хувьд одоогийн болон өмнөх нягтлан бодогчийн саналтай зөрж байгааг илтгэхүйц хэмжээнд нөлөөлж болзошгүй.
- Гуравдагч талаас асуулга лавлагаа авах, үйлчлүүлэгчийн ахлах түвшний эсвэл засаглах эрхтэй удирдлагын тухай суурь судалгаа явуулах зэрэг бусад эх сурвалжаас шаардлагатай мэдээллээ олж авах.

Одоогийн болон Өмнөх Нягтлан Бодогчтой Харилцах

320.5 А1 Одоогийн болон өмнөх нягтлан бодогчтой харилцаж, ярилцахын тулд дараагийн нягтлан бодогч нь үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авах, ингэхдээ бичгээр авах хэрэгтэй.

Ш320.6 Хэрэв одоогийн болон өмнөх нягтлан бодогчтой харилцах боломж дараагийн нягтлан бодогчид олдохгүй байвал, болзошгүй аюул заналын талаарх мэдээлэл олж авахын тулд тэрээр бусад зохистой арга хэмжээг авах ёстой.

Дараагийн Нягтлан Бодогчтой Харилцах

Ш320.7 Одоогийн болон өмнөх нягтлан бодогчдыг хариу ирүүлэхийг дараагийн нягтлан бодогч хүссэн бол, одоогийн болон өмнөх нягтлан бодогч дараах алхмыг хийх нь зүйтэй:

- (а) Тухайн хүсэлттэй холбоотой хууль тогтоомжийг сахиж мөрдөх;
- (б) Мэдээллийг зөв шударгаар, салаа буюу хоёрдмол утгагүйгээр хүргэх.

320.7 А1 Одоогийн болон өмнөх нягтлан бодогч мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй. Үйлчлүүлэгчтэй холбоотой асуудлаар дараагийн нягтлан бодогчтой ярилцахыг одоогийн болон өмнөх нягтлан бодогчид зөвшөөрөх эсвэл түүнээс шаардах нь гэрээт ажлын мөн чанараас шалтгаална. Үүнд:

- (а) Одоогийн болон өмнөх нягтлан бодогч нь ийнхүү ярилцах зөвшөөрлийг үйлчлүүлэгчээс авсан эсэх;
- (б) Ийнхүү мэдээлэх болон ил тод болгох талаар хууль эрх зүйн эсвэл ёс зүйн шаардлага байдаг бөгөөд

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

эдгээр шаардлага нь эрх зүйн орчноор ялгаатай байдаг.

320.7 А2 Мэргэжлийн нягтлан бодогчоос нууц мэдээлэл толилуулахыг шаарддаг эсвэл шаардаж болох, түүнчлэн толилуулгыг хэзээ гаргах нь зохистой байж болох нөхцөл байдлыг энэ дүрмийн 114.1А1-д тодорхойлсон болно.

Аудит эсвэл Нягтлах Ажлын Томилгооны Өөрчлөлт

Ш320.8 Санхүүгийн тайлангийн аудит эсвэл нягтлах ажлын хувьд, мэргэжлийн нягтлан бодогч нь одоогийн буюу өмнөх нягтлан бодогчийн бодож байгаагаар, дараагийн нягтлан бодогч нь гэрээт ажлыг зөвшөөрөх эсэхээ шийдэхийн өмнө мэдвэл зохих аливаа бодит баримт болон бусад мэдээлэлд хамаарах мэдээллээр хангахыг одоогийн буюу өмнөх нягтлан бодогчоос хүсэх ёстой. Ш360.32-Ш360.22-т заасан хууль тогтоомжтой үл нийцэх эсвэл сэжиг бүхий үл нийцлийг багтаасан нөхцөл байдлаас гадна, дараахыг харгалзвал зохино:

- (а) Хэрэв үйлчлүүлэгч нь бодит баримт ба бусад мэдээллийг ил тод болгохыг одоогийн болон өмнөх нягтлан бодогчид зөвшөөрвөл, тэрээр эдгээр мэдээллийг шударга бөгөөд салаа буюу хоёрдмол утгагүйгээр хүргэх ёстой;
- (б) Хэрэв үйлчлүүлэгч нь түүний асуудлыг дараагийн нягтлан бодогчтой ярилцах зөвшөөрлийг одоогийн болон өмнөх нягтлан бодогчид өгөхгүй эсвэл өгөхөөс татгалзвал, одоогийн болон өмнөх нягтлан бодогч энэ тухай дараагийн нягтлан бодогчид мэдээлэх бөгөөд дараагийн нягтлан бодогч гэрээт ажлыг зөвшөөрөх эсэхийг шийдэхдээ ийнхүү зөвшөөрөөгүй эсвэл татгалзсан хариуг анхааралтай авч үзэх ёстой.

Үйлчлүүлэгч ба Гэрээт Ажлын Үргэлжлэл

Ш320.9 Гэрээт ажлыг давтан хийлгэж буй үйлчлүүлэгчийн хувьд, мэргэжлийн нягтлан бодогч гэрээт ажлаа үргэлжлүүлэх эсэхээ тогтмол нягтлах хэрэгтэй.

320.9 А1 Хэрэв эрт мэдсэн байсан бол мэргэжлийн нягтлан бодогчийг гэрээт ажлаас татгалзахад хүргэж болох байсан гэрээт ажлыг зөвшөөрсний дараа суурь зарчмын нийцэлд аюул занал учирч болзошгүй. Жишээлбэл, удирдлагын зүгээс ашиг эсвэл балансын үнэлгээг зүй зохисгүй гаргаснаар шударга байдлын зарчмын нийцэлд хувийн эрх ашгийн аюул занал учирч болзошгүй.

Шинжээчийн Ажлыг Ашиглах

Ш320.10 Шинжээчийн ажлыг ашиглахаар шийдсэн мэргэжлийн нягтлан бодогч ийнхүү ашиглах эрх олгосон эсэхийг тодорхойлох ёстой.

320.10А1 Шинжээчийн ажлыг ашиглахаар шийдсэн мэргэжлийн нягтлан бодогчийн анхаарвал зохих хүчин зүйлсэд тухайн шинжээчийн нэр хүнд, туршлага, түүнд бэлэн байх нөөц, мөн түүнд хамаарах мэргэжлийн ба ёс зүйн стандартууд болно. Ийм мэдээллийг тухайн шинжээчтэй тогтоосон урьдын харилцаа холбоо, эсвэл бусадтай зөвлөлдөх замаар олж авах боломжтой.

ХЭСЭГ 321

ХОЁРДОГЧ ДҮГНЭЛТ

Танилцуулга

- 321.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 321.2 Хуучин үйлчлүүлэгч биш аж ахуйн нэгжид хоёрдогч дүгнэлт гаргаж өгөх нь нэг буюу хэд хэдэн суурь зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учруулж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг мөрдөхтэй холбоотой тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- 321.3 А1 Мэргэжлийн нягтлан бодогчоос (а) онцгой нөхцөлд, эсвэл (б) одоогийн үйлчлүүлэгч биш ямар нэг компани эсвэл байгууллагын өөрөө эсвэл түүний өмнөөс гүйлгээ хийхдээ дагаж мөрдсөн нягтлан бодох бүртгэл, аудит, тайлагналын болон бусад стандартууд буюу зарчмуудыг хэрхэн хэрэглэж байгаа талаар хоёрдогч дүгнэлт гаргуулахыг хүсэж болзошгүй. Жишээлбэл, энэхүү хоёрдогч дүгнэлт нь одоогийн буюу өмнөх нягтлан бодогчид байсантай ижил баримт дээр үндэслээгүй эсвэл хангалтгүй нотлох баримт дээр үндэслэсэн бол, мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдлын зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй.
- 321.3 А2 Хувийн ашиг сонирхлын аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйл бол мэргэжлийн шүүн тунгаалтаа илэрхийлэхтэй холбоотой тухайн саналын нөхцөл байдал, бусад бүх бодит баримт ба төсөөлөл юм.
- 321.3 А3 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг олж тогтооход хамгаалалтын арга хэмжээ байх боломжтой арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр, одоогийн болон өмнөх нягтлан бодогчоос мэдээлэл олж авах.
 - Үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны тухай дүгнэлтэд тавьсан хязгаарлалтыг дурдах.
 - Одоогийн болон өмнөх нягтлан бодогчид тухайн дүгнэлтийн хуулбарыг хүргүүлэх.

Харилцаа Холбоо Тогтоох Зөвшөөрөх Өгөхгүй Байх Тохиолдол

- Ш321.4** Хэрэв хоёрдогч дүгнэлт гаргуулахыг мэргэжлийн нягтлан бодогчоос хүсэж байгаа аж ахуйн нэгж нь одоогийн буюу өмнөх нягтлан бодогчтой харилцахыг тухайн нягтлан бодогчид зөвшөөрөхгүй байвал тэдэнд хоёрдогч дүгнэлт гаргаж өгч болох эсэхээ эргэцүүлэх ёстой.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 330

ТӨЛБӨР БОЛОН БУСАД ТӨРЛИЙН УРАМШУУЛАЛ

Танилцуулга

- 330.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 321.2 Төлбөр ба бусад төрлийн урамшууллын хэмжээ ба мөн чанарын талаарх тохиролцоо нь нэг буюу хэд хэдэн суурь зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал учруулж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг мөрдөхтэй холбоотой тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тодорхойлсон болно.

Ашиглах Материал

Төлбөрийн Хэмжээ

- 330.3 A1 Санал болгож буй төлбөрийн хэмжээ нь мэргэжлийн стандартад нийцүүлэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нягтлан бодогчийн чадамжид нөлөөлж болзошгүй.
- 330.3 A2 Тохиромжтой гэж үзсэн төлбөрийн дүнгээ мэргэжлийн нягтлан бодогч санал болгох боломжтой. Өөр нэг этгээдийн төлбөрийн саналаас доогуур төлбөр санал болгох нь ёс зүйгүй үйлдэл биш юм. Гэхдээ, хэрэв санал болгож буй төлбөрийн хэмжээ нь тухайн гэрээт ажлыг мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхэд хүндрэлтэй байж болохуйц хэт бага байвал мэргэжлийн ур чадвар ба хянамгай байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсдэг.
- 330.3 A3 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлс нь дараах байна. Үүнд:
- Гэрээт ажлын нөхцлүүдийн талаар, ялангуяа төлбөр тогтоосон суурь, санал болгож буй төлбөрт багтсан мэргэжлийн үйлчилгээний талаар үйлчлүүлэгч мэдэж байгаа эсэх.
 - Зохицуулах байгууллага гэх мэт хараат бус гуравдагч талаас төлбөрийн хэмжээг тогтоодог эсэх.
- 330.3A4 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг олж тогтооход хамгаалалт байх боломжтой арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Төлбөрийн хэмжээ эсвэл гэрээт ажлын хамрах хүрээнд тохируулга хийх.
 - Гүйцэтгэсэн ажлыг хянан шалгадаг тохирох хянан шалгагчтай байх.

Болзошгүй Төлбөр

- 330.4 A1 Баталгаажуулалтын бус ажлын зарим тодорхой төрөлд болзошгүй төлбөрийг өргөнөөр ашигладаг. Гэхдээ, зарим тохиолдолд болзошгүй төлбөр нь суурь зарчмуудын нийцэл, ялангуяа бодитой байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэх боломжтой.
- 330.4 A2 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлс нь дараах байна. Үүнд:
- Гэрээт ажлын мөн чанар.
 - Боломжит төлбөрийн хязгаар /хүрээ/.
 - Төлбөр тогтоохдоо ашигласан суурь.
 - Мэргэжлийн нягтлан бодогчийн гүйцэтгэсэн ажлын зорилтот хэрэглэгчид болон урамшууллын суурийн талаар тодруулах.
 - Чанарын хяналтын бодлого, горим, журам.
 - Ажил гүйлгээний үр дүн ба үр дагаврыг хараат бус гуравдагч этгээд хянадаг эсэх.
 - Зохицуулах байгууллага гэх мэт хараат бус гуравдагч талаас төлбөрийн хэмжээг тогтоодог эсэх.
- 330.4 A3 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг олж тогтооход хамгаалалт болж чадах арга хэмжээний жишээнд

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

дараахыг дурдаж болно. Үүнд:

- Мэргэжлийн нягтлан бодогчийн гүйцэтгэсэн баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчтай байх.
- Урамшууллын нөхцөлийн талаар үйлчлүүлэгчтэй урьдчилан бичгээр тохиролцсон байх.

330.4 А4 Аудит эсвэл нягтлах ажлын үйлчлүүлэгч болон бусад баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчдэд үзүүлсэн үйлчилгээнд авах болзошгүй төлбөртэй холбоотой шаардлага ба ашиглах материалыг Хараат бус байдлын олон улсын стандартад тодорхойлсон болно.

Тусламж Үзүүлсний Хөлс буюу Шимтгэл

330.5 А1 Мэргэжлийн нягтлан бодогч нь ямар нэг үйлчлүүлэгчтэй холбоотой тусламж үзүүлсний төлөө төлбөр төлөх эсвэл хүлээн авах, эсвэл шимтгэл хүлээн авснаар бодитой хандлага, мэргэжлийн ур чадвар болон хянамгай байдлын зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болно. Ийм тусламжийн хөлс буюу шимтгэлд дараах орж болно. Үүнд:

- Тухайн үйлчлүүлэгч нь одоогийн нягтлан бодогчийн үйлчлүүлэгч хэвээр байх боловч түүний санал болгодоггүй онцлог үйлчилгээ авах шаардлагатай үед үйлчлүүлэгчээс тэрхүү шинэ ажлыг нь авахын тулд өөр нэг мэргэжлийн нягтлан бодогчид төлсөн төлбөр.
- Одоогийн нягтлан бодогч нь үйлчлүүлэгчид хэрэгтэй байгаа онцгой мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэггүй бол, тухайн үйлчлүүлэгчээ өөр нэг мэргэжлийн нягтлан бодогч эсвэл шинжээчид танилцуулсны төлөө хүлээн авсан төлбөр.
- Үйлчлүүлэгчид үйлчилгээ буюу бараа бүтээгдэхүүн борлуулж өгсөнтэй холбоотойгоор гуравдагч этгээд (жишээ нь, программ хангамжийн борлуулагч)-ээс хүлээн авсан шимтгэл.

330.5 А2 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг олж тогтооход хамгаалалт байх боломжтой арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Өөр этгээдийн бараа буюу үйлчилгээг тухайн үйлчлүүлэгчид борлуулж, үүний төлөө шимтгэл авах тухай тохиролцоо хийхийн тулд үйлчлүүлэгчээс урьдчилан зөвшөөрөл авахыг хувийн ашиг сонирхлын аюул занал хэмээн тодорхойлох боломжтой.
- Өөр нэг мэргэжлийн нягтлан бодогч эсвэл гуравдагч этгээдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгосны төлөө, уг нягтлан бодогчид танилцуулсны төлбөр эсвэл шимтгэл төлсөн эсвэл түүнээс хүлээн авсан талаар тухайн үйлчлүүлэгчид мэдээлэхийг хувийн ашиг сонирхлын аюул занал хэмээн тодорхойлох боломжтой

Компани Худалдан Авах эсвэл Худалдах

330.6 А1 Мэргэжлийн нягтлан бодогч нь өөр компанийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдан авч болох бөгөөд ингэхдээ уг компанийн өмнөх эзэмшигч хувь хүмүүс эсвэл тэдний хөрөнгийн өв залгамжлагчдад төлбөрийг төлөх нөхцөлтэй байна. Энэ төлбөрийг энэ хэсэгт дурдсан танилцуулсны төлбөр эсвэл шимтгэл хэмээн үздэггүй.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

БҮЛЭГ 340

БЭЛЭГ, ДАЙЛЛАГА, УРАМШУУЛАЛ

Танилцуулга

- 340.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь Хэсэг 120-д тодорхойлсон суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 340.2 Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах нь суурь зарчим ялангуяа шударга байдал, бодитой байдал, мэргэжлийн зан төлөвийн зарчмын нийцэлд учрах хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй.
- 340.3 Энэ хэсэгт, хууль тогтоомжид үл нийцэх асуудал үүсгэхгүй мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байх үед урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахтай холбоотой онолын үзэл баримтлалыг хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно. Энэ хэсэгт мөн урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах үедээ холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байхыг мэргэжлийн нягтлан бодогчоос шаарддаг.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

340.4 A1 Урамшуулал гэдэг нь хувь хүний зан төлөвт заавал зүй бусаар нөлөөлөх зорилгогүйгээр түүний зан төлөвт нөлөөлөх арга зам болгон ашигладаг объект, нөхцөл, эсвэл үйлдлийг хэлнэ. Урамшуулал нь бизнесийн нөхөд/ хамт олны дунд дайллага хийх гэх мэт жижиг үйлдлээс хууль тогтоомжид үл нийцэх байдалд хүргэж болох үйлдэл гэх мэт өргөн хүрээтэй байж болно. Урамшууллын янз бүрийн хэлбэр байдгийг дараах жишээгээр харуулж болно. Үүнд:

- Бэлэг.
- Дайллага.
- Зугаа цэнгэл.
- Улс төрийн эсвэл буяны хандив.
- Нөхөрлөл ба үнэнч байдлын төлөөх гуйлт.
- Ажил олгох эсвэл бусад арилжааны боломж олгох
- Хөнгөлөлттэй үйлчилгээ, эрх буюу давуу эрх олгох.

Хууль тогтоомжоор хориглодог урамшуулал

Ш340.5 Зарим тодорхой нөхцөлд урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахыг хориглодог, тухайлбал, авилга, хээл хахуультай холбоотой хууль тогтоомж бүхий хууль эрхзүйн орчин олон бий. Мэргэжлийн нягтлан бодогч нь холбогдох хууль тогтоомжийг сайтар ойлгож, ийм нөхцөл байдал тулгарсан үед тэдгээр хууль тогтоомжийг мөрдөн сахих ёстой.

Хууль тогтоомжоор хориглодоггүй урамшуулал

340.6 A1 Санал болгосон эсвэл хүлээн авч байгаа урамшууллыг хууль тогтоомжоор хориглодоггүй байсан ч суурь зарчмын нийцэлд аюул учруулсаар байх боломжтой юм.

Зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой урамшуулал

Ш340.7 Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой хийсэн гэж мэргэжлийн нягтлан бодогч өөрөө дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийнхүү дүгнэх боломжтой гэж үзсэн аливаа урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө санал болгох, эсвэл санал болгохыг бусдад зөвлөж үл болно.

Ш340.8 Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой хийсэн гэж

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

мэргэжлийн нягтлан бодогч өөрөө дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийнхүү дүгнэх боломжтой гэж үзсэн аливаа урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө хүлээн авах, эсвэл бусдыг хүлээн авахыг ятгаж үл болно.

- 340.9A1 Хэрэв урамшуулал нь тухайн хувь хүнийг ёс зүйгүй үйлдэл хийхэд хүргэж байвал ийм урамшууллыг тухайн хүнд зүй бусаар нөлөөлж байна хэмээн үздэг. Зүй бус ийм нөлөөлөл нь хүлээн авагч эсвэл түүнтэй холбоотой хүний аль алинд чиглэсэн байж болно. Мэргэжлийн нягтлан бодогчийн эсвэл адилтгах шинжтэй өөр нэг этгээдийн талд ёс зүйгүй зан төлөв үүсгэж байгаа эсэхийг тухайн мэргэжлийн нягтлан бодогч харгалзан үзэх нь түүний хувьд баримтлах суурь зарчим болдог.
- 340.9A2 Хүлээн авагчийн эсвэл өөр хэн нэг этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой урамшууллыг мэргэжлийн нягтлан бодогч өөрөө санал болгосон эсвэл хүлээн авсан, эсвэл санал болгохыг эсвэл хүлээн авахыг бусдад зөвлөсөн тохиолдолд шударга байдлын суурь зарчим алдагддаг.
- 340.9A3 Зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамагласан зорилго байгаа эсэхийг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалтаа хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд хамаарах хүчин зүйлсэд дараахыг багтаах боломжтой:
- Урамшууллын мөн чанар, дамтамж, мөнгөн дүн, түүний нийт үр нөлөө.
 - Аливаа үйлдэл эсвэл түүний нөлөөлж болзошгүй шийдвэрт хамаарах урамшууллыг санал болгох хугацаа.
 - Урамшууллыг тухайн нөхцөл байдлын хувьд ердийн буюу соёлын уламжлалт практик гэж үзэх эсэх, үүний жишээнд, шашны ёс заншлыг тэмдэглэх баяр эсвэл хуримд зориулан бэлэг санал болгохыг дурдаж болно.
 - Урамшууллыг мэргэжлийн үйл ажиллагааны нэмэлт хэсэг гэж үзэх эсэх, үүний жишээнд, бизнес уулзалт хийхтэй холбоотой үдийн зоог барихыг санал болгох эсвэл зөвшөөрөхийг дурдаж болно.
 - Урамшуулал санал болгохдоо хүний тоог зөвхөн нэг хүлээн авагч эсвэл томоохон бүлэг хүмүүсээр хязгаарласан эсэх. Томоохон бүлэг нь компанийн дотоод болон гаднын хүмүүс жишээлбэл, үйлчлүүлэгчийн бусад бэлтгэн нийлүүлэгч байх боломжтой.
 - Урамшуулал санал болгосон эсвэл түүнийг хүлээн авах хүмүүсийн компани эсвэл үйлчлүүлэгчийн байгууллага доторх ажил үүрэг ба албан тушаал.
 - Урамшуулал авахыг зөвшөөрснөөр үйлчлүүлэгчийн бодлого, горим зөрчихөд хүргэнэ гэдгийг мэргэжлийн нягтлан бодогч мэдэж байгаа эсвэл ийнхүү итгэх шалтгаан түүнд байгаа эсэх.
 - Урамшуулал санал болгох үеийн нөхцөл хэр зэрэг ил тод байгаа.
 - Хүлээн авагч нь урамшуулал өгөхийг шаардсан эсвэл хүссэн эсэх.
 - Санал болгогч этгээдийн өмнөх үеийн зан төлөв ба нэр хүнд.

Цаашид авах арга хэмжээ

- 340.10A1 Санал болгосон урамшуулал нь зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилготой гэдгийг хэрэв мэргэжлийн нягтлан бодогч мэдэж авсан бол, Ш205.7, Ш250.8-р параграфт заасан шаардлага хангагдсан ч гэсэн суурь зарчмын нийцэлд аюул занал учирч болзошгүй хэвээр байна.
- 340.10A2 Дээрх аюул заналыг багасгах хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Уг саналын талаар компанийн ахлах түвшний удирдлага эсвэл үйлчлүүлэгчийн засаглах эрхтэй удирдлагад мэдээлэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Үйлчлүүлэгчтэй тогтоосон бизнесийн харилцаагаа өөрчлөх эсвэл харилцаагаа цуцлах.

Зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилгогүй урамшуулал

- 340.11A1 Хүлээн авагч эсвэл өөр бусад этгээдийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамаглах зорилго байхгүй гэж мэргэжлийн нягтлан бодогч дүгнэсэн тохиолдолд тэрээр онолын үзэл баримтлалд тодорхойлсон шаардлага ба ашиглах материалыг дагаж мөрддөг.
- 340.11A2 Хэрэв урамшууллын хэмжээ ялихгүй бөгөөд хор уршиггүй байвал, учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна гэж үзнэ.
- 340.11A3 Санал болгосон урамшуулал нь зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодит эсвэл таамагласан зорилгогүй гэж мэргэжлийн нягтлан бодогч дүгнэсэн ч гэсэн ийм урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авснаар аюул занал учруулж болзошгүй хэвээр байх нөхцөлийг дараах жишээгээр харуулсан болно:
- Хувийн ашиг сонирхлын аюул занал
 - Үйлчлүүлэгчид корпорацийн санхүүгийн үйлчилгээ үзүүлж байх үед үйлчлүүлэгчийн ирээдүйн худалдан авагчийн зүгээс мэргэжлийн нягтлан бодогчид урамшуулал санал болгох
 - Танилын аюул занал
 - Мэргэжлийн нягтлан бодогч нь одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчийг спортын арга хэмжээнд байнга дагуулж явдаг.
 - Айлган сүрдүүлэх аюул занал
 - Хэрэв олон нийтэд мэдэгдсэн тохиолдолд тохиромжгүй гэж үзэж болох шинжтэй үйлчлүүлэгчийн санал болгосон дайллага цайллагыг мэргэжлийн нягтлан бодогч зөвшөөрсөн.
- 340.11A4 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн дээрх аюул заналын түвшнийг тодорхойлоход хамааралтай хүчин зүйлсэд, зорилгыг тодорхойлохдоо 340.9A3-р параграфт авч үзсэнтэй адил хүчин зүйлс багтдаг.
- 340.11A5 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн аюул заналын түвшнийг арилгах боломжтой арга хэмжээний жишээг дурдвал:
- Урамшууллаас татгалзах эсвэл санал болгохгүй байх.
 - Үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хариуцлагыг, ийм үйлчилгээ үзүүлэхдээ зүй бусаар нөлөөлнө эсвэл нөлөөлөх боломжтой гэж мэргэжлийн нягтлан бодогч итгэх шалтгаан байхгүй тийм хүнд шилжүүлэх.
- 340.11A6 Ийм урамшуулал санал болгосон эсвэл зөвшөөрсний улмаас үүссэн аюул заналыг багасгах боломжтой хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах талаар мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түншлэгч талын ажил олгогч байгууллагын ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай ил тод харилцах.
 - Компанийн ахлах түвшний удирдлага эсвэл компанийн ёс зүй хариуцсан өөр ажилтны хянадаг, эсвэл үйлчлүүлэгчийн хөтөлдөг бүртгэлд урамшууллыг бүртгүүлэн тэмдэглүүлэх.
 - Тухайн нягтлан бодогчийн хүлээн авсан урамшуулалыг өгсөн үйлчлүүлэгчийн талаар мэргэжлийн нягтлан бодогчийн гүйцэтгэсэн ажил эсвэл гаргасан шийдвэрийг уг үйлчилгээ үзүүлэхэд ямар нэг байдлаар оролцоогүй өөр хүнээр хянуулан шалгуулах.
 - Хандив хүлээн авч, түүнийг компанийн ахлах түвшний удирдлагын гишүүн эсвэл урамшуулал санал болгосон хүмүүст зохих ёсоор мэдээлсний дараа, тухайн урамшууллыг буяны үйлсэд хандивлах.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Дайллага гэх мэт урамшууллын зардлыг буцаан төлөх.
- Эхэлж зөвшөөрөн хүлээж авсан урамшууллыг дараа нь нэн даруй буцааж өгөх.

Ам Бүлийн Гишүүн эсвэл Гэр Бүлийн Ойрын Гишүүн

Ш340.12 Урамшуулал санал болгосоны улмаас нягтлан бодогчийн суурь зарчимд нийцэх нийцэлд учрах боломжит аюулд мэргэжлийн нягтлан бодогч дараах тохиолдлыг тооцох ёстой:

- (a) Нягтлан бодогчийн ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүдээс тухайн нягтлан бодогчийн одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчид урамшуулал санал болгох; эсвэл
- (б) Тухайн нягтлан бодогчийн одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчээс уг нягтлан бодогчийн ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд урамшуулал санал болгох.

Ш340.13 Ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд, эсвэл ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнээс нь санал болгосон урамшууллын талаар мэргэжлийн нягтлан бодогч мэдэж авсан бөгөөд уг нягтлан бодогч эсвэл одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилго агуулсан хэмээн дүгнэсэн, эсвэл ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл бүхий гуравдагч этгээд ийм зорилго байгаа гэж дүгнэх боломжтой хэмээн үзсэн бол тэрээр ийм урамшуулал санал болгохгүй эсвэл хүлээн авахгүй байхыг ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүнд заавал зөвлөх нь зүйтэй.

340.13A1 Параграф 340.9A3-т дурдсан хүчин зүйлс бол мэргэжлийн нягтлан бодогч эсвэл одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамагласан зорилго байгаа эсэхийг тодорхойлоход хамааралтай хүчин зүйлс болно. Өөр нэг хамаарах хүчин зүйл бол дараах хүмүүсийн хоорондох харилцааны шинж чанар буюу хэр дотно байх явдал юм:

- (a) Нягтлан бодогч ба түүний ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн;
- (б) Ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн ба одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгч;
- (в) Нягтлан бодогч ба одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгч.

Тухайлбал, ирээдүйд борлуулах гэж байгаа бизнесийг нь үнэлэх үйлчилгээг нягтлан бодогч үзүүлж байх үед уг үйлчлүүлэгчийн зүгээс түүний эхнэр/ нөхөрт байгууллагын боловсон хүчний ердийн журмаас гадуур ажил эрхлэлт санал болгох нь ийм зорилго буюу санаархлыг илтгэж болох юм.

340.13 A2 Ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь Ш340.13-т заасан зөвлөгөөг дагаж мөрдсөн байсан ч гэсэн мэргэжлийн нягтлан бодогч эсвэл түүний одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх бодитой эсвэл таамагласан зорилго байгаа тохиолдолд үүсэж болзошгүй аюул заналыг тодорхойлоход 340.10A2-р параграфт дурдсан ашиглах материал мөн хамааралтай юм.

Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх

340.14 A1 Мэргэжлийн нягтлан бодогч Ш340.12-т тодорхойлсон нөхцөлд санал болгосон урамшууллын талаар мэдсэн бол, суурь зарчмын нийцэлд дараах тохиолдолд аюул занал учирч болзошгүй. Үүнд:

- (a) Ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн нь Ш340.13-т заасан нягтлан бодогчийн зөвлөгөөг дагалгүйгээр урамшуулал санал болгосон эсвэл хүлэн авахыг зөвшөөрсөн;
- (б) Нягтлан бодогч эсвэл түүний одоогийн болон ирээдүйн үйлчлүүлэгчийн зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зорилго буюу санаархал бодитоор эсвэл таамаглалаар оршин байгаа гэж итгэх шалтгаан уг нягтлан бодогчид байхгүй.

340.14 A2 Ийм аюул заналыг үнэлэх ба тодорхойлох зорилгын хувьд, 340.11A1-340.11A6-д дурдсан ашиглах

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

материалыг хамаатай гэж үзнэ. Эдгээр тохиолдолд, аюул заналын түвшнийг үнэлэхэд хамаатай хүчин зүйлсэд 340.13A1-ийн харилцааны шинж чанар ба хэр дотно байдлыг мөн багтаан авч үздэг.

Бусад Харгалзах Зүйлс

- 340.15 A1 Хэрэв үйлчлүүлэгч эсвэл үйлчлүүлэгчийн удирдан чиглүүлснээр ажиллаж байгаа бусад хүмүүс мэргэжлийн бодогчид урамшуулал санал болгосон эсвэл санал болгосныг мэдсэн бөгөөд энэ нь хууль тогтоомж зөрчсөн эсвэл зөрчсөн гэж сэжиглэх нөхцөл байдал үүсгэвэл, Хэсэг 360 дахь шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.
- 340.15 A2 Хэрэв аудитын үйлчлүүлэгчийн зүгээс компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүдэд бэлэг, дайллага санал болговол, Хэсэг 420 дахь шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.
- 340.15 A3 Хэрэв баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн зүгээс компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүдэд бэлэг, дайллага санал болговол, Хэсэг 906 дахь шаардлага ба ашиглах материалыг мөрдөх нь зүйтэй.

БҮЛЭГ 350

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТ

Танилцуулга

- 350.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 350.2 Үйлчлүүлэгчийн хөрөнгийг хадгалах нь мэргэжлийн зан төлөв ба бодитой байх зарчмын нийцэлд хувийн ашиг сонирхлын болон өөр бусад аюул занал учруулдаг. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг мөрдөхтэй холбоотой тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ бүлэгт тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Хамгаалалтад Авахын Өмнө

- Ш350.3** Мэргэжлийн нягтлан бодогчид үйлчлүүлэгчийн мөнгө, бусад хөрөнгө хамгаалах эрх, үүргийг зохих нөхцөлийн дагуу, хуулиар зөвшөөрөөгүй бол тэрээр ийм үүргийг биелүүлэхгүй байх нь зүйтэй.
- Ш350.4** Үйлчлүүлэгчийн мөнгө, бусад хөрөнгийг хамгаалахтай холбоотой үйлчилгээг мэргэжлийн нягтлан бодогч нь үйлчлүүлэгч ба гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөх горимын нэг хэсэг гэж үзээд, дараах алхмыг хийх ёстой. Үүнд:
- (а) хөрөнгийн эх үүсвэрийн талаар зохих лавлагаа авах;
 - (б) холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг авч үзэх.
- 350.4A1 Үйлчлүүлэгчийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар зохих лавлагаа авснаар тухайн хөрөнгийг хууль бус үйл ажиллагаа, тухайлбал, мөнгө угаах гэх мэт үйлдлээр үүссэнийг илрүүлэх боломжтой. Энэ тохиолдолд, аюул занал учирч болох бөгөөд Хэсэг 360-ын шаардлагыг мөрдөнө.

Хамгаалалтад Авсны Дараа

- Ш350.5** Бусад хамааралтай мөнгө буюу бусад хөрөнгийг мэргэжлийн нягтлан бодогчид итгэн хариуцуулж өгсөн бол тэрээр дараах алхмыг хийх ёстой. Үүнд:
- (а) Хөрөнгө эзэмших, бүртгэхтэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх;
 - (б) Тухайн хөрөнгийг хувийн болон пүүсийн хөрөнгөөс тусад нь хадгалах;
 - (в) Ийм хөрөнгийг зөвхөн зориулалтынх нь дагуу ашиглах;
 - (г) Тэдгээр хөрөнгө, холбогдох орлого, ногдол ашиг эсвэл эсвэл бусад ашгийг хэрхэн бүртгэсэн талаар ийм тайлан тооцоо шаардах эрхтэй хүмүүст тайлагнахад бэлэн байх.

ХЭСЭГ 360

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ҮЛ НИЙЦЭЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ

Танилцуулга

- 360.1 Мэргэжлийн нягтлан бодогч нь суурь зарчмын нийцэлд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ суурь зарчимд нийцүүлж, Бүлэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 360.2 Мэргэжлийн нягтлан бодогч нь хууль тогтоомж зөрчсөнийг мэдсэн эсвэл зөрчсөн гэж сэжиглэж байвал шударга байдал ба мэргэжлийн зан төлөвийн зарчмын нийцэлд учрах хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсдэг.
- 360.3 Мэргэжлийн нягтлан бодогч нь үйлчлүүлэгчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад үл нийцэлтэй тулгарах эсвэл үл нийцэл үүссэн тухай сэжиглэх боломжтой. Энэ бүлэгт уг асуудлын урьдчилсан нөхцөлийг үнэлж, доор дурдсан чиглэлээр үл нийцэл гарсан эсвэл гарсан гэж сэжиглэх тохиолдолд авах боломжтой арга хэмжээний талаар нягтлан бодогчдоод тус болох удирдамжийг тодорхойлсон болно. Үүнд:
- (a) Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан дахь материаллаг дүн ба тодруулгыг тодорхойлоход шууд нөлөөтэй байхаар ерөнхийд нь хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж;
 - (b) Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлан дахь материаллаг дүн ба тодруулгыг тодорхойлоход шууд нөлөөтэй биш боловч эдгээрт нийцсэн байх нь тухайн ажил олгогч байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, бизнесээ үргэлжлүүлэх чадавч болон материаллаг хэмжээний торгуулиас зайлсхийхэд чухал байж болзошгүй бусад хууль тогтоомж.

Хууль Тогтоомжийг Зөрчихтэй Холбоотой Мэргэжлийн Нягтлан Бодогчийн Зорилго

- 360.4 Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн бусдаас ялгарах шинж чанар нь нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлах явдал юм. Үл нийцэл гарсан эсвэл гарсан гэж сэжиглэх тохиолдолд нягтлан бодогчийн авах арга хэмжээний зорилгыг дараах байдлаар тодорхойлно:
- (a) Шударга байдал ба мэргэжлийн зан төлөвийн зарчимд нийцүүлэх;
 - (b) Дараах зорилгоор гүйцэтгэх эсвэл засаглах эрхтэй удирдлагад урьдчилан сануулах:
 - (iii) Олж илрүүлсэн эсвэл сэжиглэж буй үл нийцлийн үр дагаврыг засаж залруулах, хор уршгийг багасгах боломж олгох;
 - (iv) Үл нийцэл гарахаас өмнө, тийм тохиолдлыг таслан зогсоох;
 - (в) Цаашид нийтийн эрх ашигт тохирох тийм арга хэмжээ авах.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- 360.5 А1 Хууль тогтоомжийн үл нийцэл (“үл нийцэл”) нь зонхилох хууль тогтоомжийн эсрэг дараах талуудын үйлдсэн санаатай болон санаандгүй орхигдуулах үйлдэл эсвэл захиалгаас бүрддэг. Үүнд:
- (a) Үйлчлүүлэгч;
 - (b) Үйлчлүүлэгчийн засаглах эрхтэй удирдлага;
 - (в) Үйлчлүүлэгчийн гүйцэтгэх удирдлага;
 - (г) Үйлчлүүлэгчийн төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад этгээд.
- 360.5 А2 Энэ бүлэгт зааснаар зөрчсөнд тооцох хууль тогтоомжид дараах орно. Үүнд:
- Залилан мэхлэлт, авлига, хээл хахууль.
 - Мөнгө угаах, алан хядлагыг санхүүжүүлэх, хууль бус орлого.
 - Үнэт цаасны зах зээл ба арилжаа.
 - Банк болон бусад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ.
 - Тоон мэдээний хадгалалт, хамгаалалт.
 - Татвар ба тэтгэврийн өглөг ба төлбөр.
 - Хүрээлэн байгаа орчны хамгаалалт.
 - Нийтийн эрүүл мэнд ба аюулгүй байдал.
- 360.5 А3 Үл нийцэл нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөх боломжтой торгууль, зарга, бусад үр дагаварт хүргэж болзошгүй. Үүнээс чухал нь, үл нийцлийн улмаас хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, олон нийтэд томоохон гарз хохирол учруулж магадгүй гэдэг утгаараа нийтийн ашиг сонирхолд илүү өргөн нөлөө үзүүлж болзошгүй. Энэ бүлгийн зорилгоор, ийм томоохон гарз хохирол учруулдаг үл нийцэл бол дээрх талуудын аль нэгд санхүүгийн эсвэл санхүүгийн бус ноцтой сөрөг үр дагавар үүсгэдэг явдал юм. Үүний жишээнд, хөрөнгө оруулагчдад асар их санхүүгийн гарз учруулахуйц хэмжээнд залилан мэхлэх болон ажиллагч эсвэл олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлэх хэмжээнд хүрээлэн байгаа орчны тухай хууль зөрчих үйлдлийг дурдаж болно.
- Ш360.6** Үл нийцэл эсвэл сэжигтэй үл нийцлийг мэргэжлийн нягтлан бодогчид хэрхэн шийдэх шаардлагыг зарим хууль эрх зүйн орчинд хуулиар, эсвэл дүрэм журмаар зохицуулсан байдаг. Эдгээр хуулийн эсвэл дүрэм журмын заалт нь энэ бүлэгт заасан шаардлагаас ялгаатай эсвэл илүү олон байх боломжтой. Үл нийцэл эсвэл сэжигтэй үл нийцэл гарсан тохиолдолд, нягтлан бодогч тэдгээр хуулийн эсвэл дүрэм журмын заалтыг сайтар ойлгож, доор заасны дагуу нийцүүлэх ёстой:
- (a) Илэрсэн асуудлыг зохих түвшний эрх мэдэл бүхий хүн, эсвэл байгууллагад тайлагнах шаардлагатай эсэх;
 - (b) Үйлчлүүлэгч талд сэрэмжлүүлэхийг хориглосон эсэх.
- 360.6 А1 Мөнгө угаахын эсрэг хууль тогтоомжийн дагуу, хамаарах этгээдэд урьдчилан сануулахыг хориглох асуудал үүсэж болзошгүй.
- 360.5 А1 Үйлчлүүлэгчийн мөн чанар нь нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгж мөн эсэхээс үл хамааран, энэ бүлгийг дагаж мөрдөнө.
- 360.7 А2 Муу үр дагавартай биш гэдэг нь илэрхий байгаа асуудалтай тулгарсан эсвэл ийм гэдгийг мэдсэн мэргэжлийн нягтлан бодогч энэ бүлгийг дагаж мөрдөх шаардлагагүй. Асуудлын үр дагавар илэрхий муу биш эсэхийг түүний санхүүгийн мөн чанар ба нөлөө нь үйлчлүүлэгч, оролцогч талууд, нийт ард иргэдэд ямар байхаас хамааруулан шийднэ.
- 360.7 А3 Энэ бүлэгт дараах зүйлийг тусгаагүй:
- (a) Үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаатай холбоогүй хувийн зохисгүй зан авир;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (б) 360.5A1-д тодорхойлноос бусад талуудын гаргасан үйл нийцэл. Үүнд жишээлбэл, үйлчлүүлэгч нь гуравдагч тал болох аж ахуйн нэгжийн хянамгай байдлыг шалгах даалгавар гүйцэтгүүлэхээр мэргэжлийн нягтлан бодогчтой гэрээ байгуулсан бөгөөд тэрхүү гуравдагч тал нь үл нийцэл гаргасан эсвэл гаргасан байж болох сэжиг илэрсэн тохиолдлыг дурдаж болно.

Гэсэн хэдий ч, дээрх тохиолдолд авах арга хэмжээний талаар эргэцүүлэхэд тус дэм болохуйц удирдамжийг мэргэжлийн нягтлан бодогч энэ бүлгээс олж үзэх боломжтой.

Ажил Олгогч Байгууллагын Гүйцэтгэх ба Засаглах Эрхтэй Удирдлагын Хүлээх Хариуцлага

360.8 A1 Үйлчлүүлэгчийн гүйцэтгэх удирдлага нь засаглах эрхтэй удирдлагын хяналтын хамт тухайн үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа гэдгийг бататгах үүрэгтэй. Гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлага нь дараах этгээдийн үйлдэж болох үл нийцлийг олж тогтоон, шийдвэрлэх хариуцлагыг мөн хүлээдэг. Үүнд:

- (а) Үйлчлүүлэгч;
- (б) Тухайн байгууллагын засаглах эрхтэй удирдлагад байдаг хувь хүн;
- (в) Гүйцэтгэх удирдлагын гишүүн;
- (г) Үйлчлүүлэгчийн төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад хувь хүн.

Бүх Мэргэжлийн Нягтлан Бодогчийн Үүрэг Хариуцлага

Ш360.9 Энэ бүлэгт хамаарах асуудлын талаар мэргэжлийн нягтлан бодогч мэдсэн бол, энэ бүлэгт заасны дагуу түүний хийвэл зохих алхмыг тэрээр хугацаа алдалгүй хэрэгжүүлэх нь зүйтэй. Зохих алхмыг цаг хугацаанд нь хийхийн тулд, нягтлан бодогч тухайн асуудлын мөн чанар ба ажил олгогч байгууллага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагчид, нийт ард иргэдийн ашиг сонирхолд учирч болзошгүй хор хохирлыг харгалзах хэрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудит

Асуудлыг Ойлгох

Ш360.10 Хэрэв, санхүүгийн тайланд аудит хийх гэрээ байгуулсан мэргэжлийн нягтлан бодогч нь үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотой мэдээллийг мэдэж авсан бол тэрээр тухайн асуудлын тухай ойлголтой болох хэрэгтэй. Ойлгох гэдэгт үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн мөн чанар, ийм зүйл гарсан эсвэл гарч болох нөхцөл байдал орно.

360.10 A1 Мэргэжлийн нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцдаа, эсвэл бусад талуудын өгсөн мэдээллийн үр дүнд үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн тухай мэдэх боломжтой.

360.10 A2 Мэргэжлийн нягтлан бодогчийг мэдлэг, ур чадвараа ашиглан, мэргэжлийн шүүн тунгаалтыг хэрэгжүүлнэ хэмээн хүлээдэг. Гэхдээ, тухайн нягтлан бодогчийн хууль тогтоомжийн ойлголтын түвшин нь гэрээт ажил гүйцэтгэхэд шаардлагатай түвшнээс их байна хэмээн хүлээх боломжгүй. Аливаа үйлдэл нь үл нийцэл бий болгож байгаа эсэх эцсийн дүгнэлтийг зөвхөн шүүх буюу холбогдох хөндлөнгийн шүүхийн байгууллага тодорхойлно.

360.10 A3 Асуудлын мөн чанар ба ач холбогдлоос шалтгаалан, мэргэжлийн нягтлан бодогч нь компанийн доторх бусад хүмүүс, сүлжээ компани, мэргэжлийн байгууллага, эсвэл хуулийн зөвлөлтэй нууцлалыг хадгалах замаар зөвлөлдөж болно.

Ш360.11 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч үл нийцлийг олж тогтоосон, эсвэл гарч болзошгүй хэмээн сэжиглэж байвал тэрээр энэ тухай өөрийнхөө дээд түвшний ахлах ажилтантай, боломжтой бол засаглах эрхтэй этгээдтэй ярилцах хэрэгтэй.

360.11 A1 Энэ ярилцлагын зорилго нь мэргэжлийн нягтлан бодогч тухайн асуудалд хамаарах нөхцөл байдал, түүний боломжит үр дагаврын талаарх ойлголтоо бэхжүүлэх явдал юм. Мөн энэ ярилцлага нь тухайн асуудлыг хянан шалгаж, тохирсон хариу арга хэмжээ авахад нь гүйцэтгэх болон засаглах эрхтэй удирдлагыг өдөөх боломжтой.

360.11 A2 Тухайн асуудлын талаар ярилцвал зохих удирдлагын түвшнийг тогтоох нь мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд авч үзэх асуудал юм. Харгалзвал зохих хүчин зүйлс нь дараах байна. Үүнд:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Асуудлын мөн чанар ба нөхцөл байдал.
- Бодитоор оролцсон эсвэл оролцсон байх боломжтой хувь хүмүүс.
- Үгсэн хуйвалдсан байх магадлал.
- Тухайн асуудлаас үүсэж болох үр дагавар.
- Ярилцахаар сонгосон удирдлагын түвшин нь тухайн асуудлыг мөрдөн шалгаж, зохих хариу арга хэмжээ авах боломжтой түвшин мөн эсэх.

360.11 А3 Удирдлагын зохих түвшин гэдэг нь илэрсэн асуудалд бодитоор оролцсон эсвэл оролцсон байх боломжтой хүмүүсээс дор хаяж нэг шат дээгүүр түвшний хүмүүс байх ёстой. Групп компанийн хувьд, зохих түвшин нь үйлчлүүлэгчийг хянадаг аж ахуй нэгжийн удирдлага байх боломжтой.

360.11 А4 Мэргэжлийн нягтлан бодогч мөн дотоод аудиторуудтай тухайн асуудлыг ярилцах эсэхийг эргэцүүлэн бодох боломжтой.

Ш360.12 Хэрэв, үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлд удирдлагын оролцоо байна хэмээн мэргэжлийн нягтлан бодогч итгэж байвал, тэрээр энэ тухай засаглах эрх мэдэл бүхий албан тушаалтантай ярилцах ёстой.

Асуудлыг Шийдэх

Ш360.13 Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаар гүйцэтгэх удирдлага, мөн боломжтой байвал засаглах эрхтэй удирдлагатай ярилцахдаа мэргэжлийн нягтлан бодогч нь хэрэв тэд хараахан арга хэмжээ аваагүй байвал доор дурдсан зохих арга хэмжээг цаг аладалгүй авахыг тэдэнд зөвлөх нь зүйтэй. Үүнд:

- (a) Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн үр дагаврыг засаж залруулах, хор уршгийг багасгасан байх;
- (b) Үл нийцэл хараахан гараагүй бол, тийм үйлдэл гарах нөхцөлийг таслан зогсоох;
- (b) Нийтийн эрх ашгийн төлөө, эсвэл хууль тогтоомжоор шаардсан бол тухайн асуудлыг зохих эрх мэдэл бүхий байгууллагад тайлагнах.

Ш360.14 Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотой хуулийн эсвэл зохицуулах үүрэг хариуцлагаа гүйцэтгэх удирдлага ба засаглах эрхтэй удирдлага ойлгож байгаа эсэхийг мэргэжлийн нягтлан бодогч авч үзэх ёстой.

360.14 А1 Удирдлага, засаглалын эрх мэдэлтэй этгээд эдгээр асуудлын талаарх хууль эрхзүйн болон зохицуулалтын үүргийг ойлгодоггүй бол мэргэжлийн нягтлан бодогч зохих мэдээллийн эх сурвалжийг санал болгох эсвэл хууль зүйн зөвлөгөө авахыг зөвлөх боломжтой.

Ш360.15 Мэргэжлийн нягтлан бодогч нь дараах зүйлийг дагаж мөрдөнө:

- (a) Хууль тогтоомж, зохицуулалт, түүний дотор хууль зөрчсөн буюу зөрчсөн гэж сэжиглэгдэж буй зөрчлийн тухай мэдээлэх хууль эрх зүйн болон зохицуулалтын заалтууд;
- (b) Аудитын стандартуудын дагуу дараах зүйлстэй холбоотой шаардлагуудыг багтаасан байна:
 - Залилан гэх мэт үл нийцлийг олж тогтоох, хариу арга хэмжээ авах
 - Засаглах эрхтэй удирдлагатай харилцах.
 - Аудиторын тайлан гаргахдаа үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн сөрөг нөлөөг авч үзэх.

360.15А1 Зарим хууль тогтоомж, зохицуулалтад үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн тухай мэдээллийг зохих эрхтэй байгууллагад хүргэх хугацааг заасан байж болно.

Групптэй Холбоотой Асуудлаар Харилцах

Ш360.16 Мэргэжлийн нягтлан бодогч дараах хоёр нөхцөлийн аль нэгний хувьд, группийн бүрэлдэхүүнтэй холбоотой үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаар мэдсэн бол тэрээр энэ тухай мэдээлэхийг хууль тогтоомжоор хориглосноос бусад тохиолдолд группийн гэрээт ажлын партнерт мэдээлэх ёстой. Үүнд:

- (a) Группийн ажлын партнер нь группийн санхүүгийн тайлангийн аудитын зорилгоор, тухайн бүрэлдэхүүнд хамаарах санхүүгийн мэдээлэлд ажил гүйцэтгэх хүсэлтийг нягтлан бодогчид тавих; эсвэл
- (b) Группийн аудитаас бусад, жишээ нь заавал хийх аудитын зорилгоор, бүрэлдэхүүн хэсгийн

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

санхүүгийн мэдээлэлд аудит хийлгэхээр нягтлан бодогчийг ажиллуулах.

Группийн гэрээт ажлын партнертэй харилцах нь энэ хэсэгт заасны дагуу асуудлыг шийдвэрлэхэд нэмэр болно.

360.16A1 Харилцааны зорилго нь группийн аудитын хүрээнд, тухайн асуудлын талаар группийн гэрээт ажлын партнерт мэдээлэх, хэрэв асуудал байвал энэ хэсгийн заалтын дагуу хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлох явдал юм. Ш360.16-р параграфт заасан харилцах шаардлагыг группийн гэрээт ажлын партнерийн компани эсвэл сүлжээ компани нь мэргэжлийн нягтлан бодогчдын компани эсвэл сүлжээ компанитай адил эсвэл ялгаатай байхаас үл хамааран мөрдвөл зохино.

Ш360.17 Группийн санхүүгийн тайланд аудит хийх явцад үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаар группийн гэрээт ажлын партнер мэдсэн бол тэрээр уг асуудал нь нэг буюу хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй дор дурдсан нөхцөлөөр хамаатай эсэхийг авч үзэх нь зүйтэй. Үүнд:

- (а) Группийн санхүүгийн тайланг аудитлах зорилготой ажлын хүрээнд санхүүгийн мэдээлэл нь багтсан;
- (б) Тухайн группийн аудитаас өөр зорилго, жишээ нь, заавал хийх аудитын ажлын хүрээнд санхүүгийн мэдээлэл нь багтсан.

Ийнхүү авч үзэх нь, группийн аудитын хүрээн дэх асуудлаар энэ хэсэгт заасны дагуу авах арга хэмжээний нэг хэсэг болно.

Ш360.18 Хэрэв үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэл нь Ш360.17 (а), (б)-д дурдсан нэг буюу түүнээс дээш бүрэлдэхүүн хэсэгт хамаарах боломжтой байвал группийн гэрээт ажлын партнер нь энэ тухай мэдээлэхийг хууль тогтоомжоор хориглосноос бусад тохиолдолд, бүрэлдэхүүнд ажил гүйцэтгэж байгаа хүмүүст заавал мэдээлэх арга хэмжээ авах ёстой. Шаардлагатай гэж үзвэл группийн гэрээт ажлын партнер нь Ш360.17(б)-д дурдсан холбогдох бүрэлдэхүүн хэсэгт аудит хийх ёстой эсэх, хэрэв тийм бол, аудитор нь хэн болохыг тодорхойлох боломжтой эсэхийг тогтоохын тулд зохих ёсны лавлагаа авах (удирдлагаас эсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээс) нь зүйтэй.

360.18 A1 Харилцааны зорилго нь бүрэлдэхүүний түвшинд ажил хариуцсан хүмүүст тухайн асуудлыг мэдээлэх, хэрэв асуудал байвал энэ хэсгийн заалтын дагуу хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлох явдал юм. Группийн гэрээт ажлын партнерийн компани эсвэл сүлжээ компани нь бүрэлдэхүүний түвшинд ажил гүйцэтгэж байгаа хүмүүсийн компани эсвэл сүлжээ компанитай адил эсвэл ялгаатай байхаас үл хамааран харилцах шаардлагыг мөрдвөл зохино.

Цаашид арга хэмжээ шаардлагатай эсэхийг тодорхойлох

Ш360.19 Мэргэжлийн нягтлан бодогч нь гүйцэтгэх удирдлага, хэрэв боломжтой бол засаглах эрхтэй удирдлагын арга хэмжээ тохиромжтой эсэхийг үнэлэх ёстой.

360.19A1 Гүйцэтгэх удирдлага, хэрэв боломжтой бол засаглах эрхтэй удирдлагын арга хэмжээ тохиромжтой эсэхийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараах орно:

- Хариу арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийг зохих ёсоор мөрдөн шалгасан.
- Аливаа үл нийцлийн үр дагаврыг арилгах, засаж залруулах, багасгах арга хэмжээ авсан, эсвэл авч байгаа.
- Хараахан гараагүй байгаа боловч гарч болох үл нийцлийг таслан зогсоохын тулд арга хэмжээ авсан эсвэл авч байгаа.
- Үл нийцэл дахин гарах эрсдэлийг бууруулахын тулд нэмэлт хяналт тавих, сургалт хийх зэрэг зохих алхмууд хийсэн эсвэл хийж байгаа.
- Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаар холбогдох эрхтэй байгууллагад мэдэгдсэн, хэрэв мэдэгдсэн бол үүнийгээ зохих ёсоор хийсэн эсэх.

Ш360.20 Гүйцэтгэх удирдлага болон тохиромжтой бол засаглалын эрхтэй удирдлагын авсан хариу арга хэмжээний хувьд, нийтийн эрх ашгийн төлөө цаашид дахин арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлох хэрэгтэй.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- 360.20A1 Цаашид арга хэмжээ авах шаардлагатай эсэх, түүний мөн чанар, цар хүрээг тодорхойлох нь дараах олон хүчин зүйлээс хамаарна:
- Хууль эрх зүй, зохицуулалтын орчин.
 - Нөхцөл байдлын яаралтай эсэх.
 - Тухайн асуудал үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд хэр өргөн тархсан.
 - Мэргэжлийн нягтлан бодогч нь гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлагын шударга байдалд итгэлтэй хэвээр байгаа эсэх.
 - Үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэл давтагдах магадлалтай эсэх.
 - Байгууллага, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажилчид болон нийтийн ашиг сонирхолд бодит эсвэл болзошгүй хохирол учруулахуйц үнэмшилтэй нотолгоо байгаа эсэх.
- 360.20A2 Гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлагын шударга байдалд итгэх мэргэжлийн нягтлан бодогчийн итгэлийг үгүй болгоход хүргэж болзошгүй нөхцөл байдалд дараахыг оруулна:
- Нягтлан бодогч нь аливаа үл нийцэлд эдгээр удирдлага оролцсон эсвэл оролцохоор завдсан хэмээн сэжиглэж байгаа эсвэл тийм нотолгоо байгаа.
 - Нягтлан бодогч нь тэдгээр хүмүүс ийм үл нийцлийн талаар мэдэж байгаа боловч хууль эрх зүйн эсвэл зохицуулалтын шаардлагын улмаас тухайн асуудлыг үл үндэслэл бүхий хугацаанд нь зохих эрх мэдэл бүхий этгээдэд мэдээлээгүй, эсвэл мэдээлэхийг зөвшөөрдөггүй.
- Ш360.21** Мэргэжлийн нягтлан бодогч нь цаашид авах арга хэмжээний хэрэгцээ, мөн чанар, цар хүрээг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалтаа ашиглана. Ийнхүү тодорхойлохдоо нягтлан бодогч нь үндэслэлтэй бөгөөд мэдлэгтэй гуравдагч этгээд түүнийг олон нийтийн эрх ашгийн төлөө зохих ёсоор нягт нямбай ажилласан хэмээн дүгнэсэн байхыг анхаарах ёстой.
- 360.21A1 Мэргэжлийн нягтлан бодогчоос цаашид авах боломжтой арга хэмжээ нь:
- Хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлага байхгүй байсан ч гэсэн тухайн илэрсэн асуудлыг зохих эрх мэдэл бүхий байгууллагад танилцуулах.
 - Хууль тогтоомжид зөвшөөрсөн тохиолдолд, гэрээт ажил болон мэргэжлийн харилцаа холбооноос татгалзах.
- 360.21A2 Гэрээт ажил болон мэргэжлийн харилцаа холбооноос татгалзах нь мэргэжлийн нягтлан бодогчийг энэ хэсэгт заасан зорилгод хүрэхийн тулд шаардагдаж болох бусад арга хэмжээг орлуулах үйлдэл биш юм. Гэхдээ, зарим эрх зүйн орчинд, тухайн нягтлан бодогчийн цаашид авах арга хэмжээнд хязгаарлалт тогтоодог байж болзошгүй. Энэ нөхцөлд, ажлаас татгалзах нь цорын ганц боломжит үйлдэл байх боломжтой.
- Ш360.22** Мэргэжлийн нягтлан бодогч нь Ш360.20, 360.21A1-р параграфын дагуу мэргэжлийн харилцаа холбооноос татгалзсан тохиолдолд, Ш320.8-р параграфт зааснаар дараагийн нягтлан бодогчийн хүсэлтийн дагуу, олж илрүүлсэн эсвэл сэжиг бүхий үл нийцлийн талаарх бүх баримт, мэдээллийг дараагийн нягтлан бодогчид өгөх ёстой. Өмнөх нягтлан бодогч нь, хууль тогтоомжид хориглосноос бусад тохиолдолд, Ш320.8(б)-д дурдсан нөхцөл буюу үйлчлүүлэгч өөрийнх нь асуудлаар дараагийн нягтлан бодогчтой ярилцахыг тухайн нягтлан бодогчид зөвшөөрөхгүй эсвэл татгалзсан ч гэсэн өмнөх нягтлан бодогч дээрх арга хэмжээг авах ёстой.
- 360.22 A2 Өмнөх нягтлан бодогчийн үзэж байгаагаар, өгөх ёстой баримт, бусад мэдээлэл гэдэг нь аудитын томилгоог зөвшөөрөх эсэхээ шийдэхээс өмнө дараагийн нягтлан бодогчийн заавал мэдсэн байх шаардлагатай мэдээлэл юм. Хэсэг 320-д дараагийн нягтлан бодогчоос хүлээн авах харилцаа буюу мэдээллийг дурдсан болно.
- Ш360.23** Хэрэв дараагийн нягтлан бодогч нь өмнөх нягтлан бодогчтой холбоо тогтоож чадахгүй бол дараагийн нягтлан бодогч өөр арга замаар томилгооны өөрчлөлтийн талаарх мэдээллийг өөр арга замаар олж авахын тулд үндэслэлтэй алхмуудыг хийх ёстой.
- 360.23A1 Томилгооны өөрчлөлтийн нөхцөлийн тухай мэдээллийг олж авах өөр арга зам нь гуравдагч этгээдийн лавлагаа, гүйцэтгэх ба засаглах удирдлагын хийсэн урьдчилсан судалгаа байна.
- 360.24 A1 Асуудлыг үнэлж дүгнэхэд нарийн төвөгтэй шинжилгээ, шүүн тунгаалт шаардагдах боломжтой тул мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг авч үзэх хэрэгтэй:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Дотооддоо зөвлөлдөх.
- Нягтлан бодогчийн санаа бодол, тодорхой үйл ажиллагаа явуулах мэргэжлийн эсвэл хууль зүйн үр дагаварыг ойлгохын тулд хуулийн зөвлөгөө авах.
- Зохицуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай нууц хадгалах замаар зөвлөлдөх.

Материалыг Зохих Эрх бүхий Байгууллагад Мэдэгдэх эсэхийг Шийдэх

360.25A1 Тухайн асуудлыг зохих эрхтэй байгууллагад танилцуулах нь хууль тогтоомжтой зөрчилдөж болзошгүй. Асуудлыг эрхтэй байгууллага мөрдөн шалгаж, нийтийн эрх ашгийн үүднээс зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ийнхүү танилцуулах шаардлага гардаг.

360.25A2 Ийнхүү танилцуулах эсэхийг тодорхойлох нь хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, ажилчид болон олон нийтэд учирч болох эсвэл үүсэж болох бодит эсвэл болзошгүй хор хөнөөлийн шинж чанар, цар хүрэнээс хамаарна. Жишээлбэл, мэргэжлийн нягтлан бодогч тухайн асуудлыг зохих эрхтэй байгууллагад ил болгон танилцуулах асуудлыг дараах байдлаар тодорхойлох боломжтой:

- Байгууллага нь хээл хахуультай холбогдсон (жишээлбэл, томоохон гэрээг баталгаажуулахын тулд орон нутгийн болон гадаадын төрийн албан хаагчидтай холбогдох).
- Байгууллагын үйл ажиллагаа нь зохицуулалттай бөгөөд үүссэн асуудал нь үйл ажиллагаа явуулах лицензэд аюул учруулахуиц нөлөөтэй.
- Байгууллага нь хөрөнгийн биржид бүртгэлтэй бөгөөд энэ нь байгууллагын үнэт цаасыг зах зээлд шударга, дэг журамтай арилжаалахад сөргөөр нөлөөлөх эсвэл санхүүгийн зах зээлд системийн эрсдэл учруулах магадлалтай.
- Байгууллага нь нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн борлуулах магадлалтай.
- Байгууллага нь татвараас зайлсхийх боломжтой схемийг үйлчлүүлэгчдэдээ сурталчилдаг.

360.25A3 Ийм тодруулга хийх эсэхийг тодорхойлоход мөн дараах гадаад хүчин зүйлс нөлөөлдөг:

- Мэдээлэл хүлээн авах боломжтой эрхтэй байгууллага байгаа эсэх, түүнийг шалгаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авдаг эсэх. Зохих эрх мэдэл нь тухайн асуудлын мөн чанараас хамаардаг. Жишээлбэл, залилан мэхлэлт агуулсан санхүүгийн тайлагналын хувьд үнэт цаасны зохицуулагч, байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд байгаль орчныг хамгаалах агентлагийг нэрлэж болно.
- Иргэний, эрүүгийн эсвэл мэргэжлийн үүрэг хариуцлагаас хамгаалах эсвэл шүгэл үлээх хууль тогтоомжийн дагуу хашраах гэх мэт хүчирхэг, найдвартай тогтолцоо байдаг эсэх.
- Мэргэжлийн нягтлан бодогч эсвэл бусад хүмүүсийн бие махбодын аюулгүй байдалд бодитой эсвэл болзошгүй аюул занал учрах эсэх.

Ш360.26 Хэрэв үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийг эрх мэдэл бүхий байгууллагад мэдээлэхийг тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ хэмээн мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлбол, энэ Дүрмийн Ш114.1(г)-д заасны дагуу ийнхүү танилцуулахыг зөвшөөрнө. Ийм мэдээллийг танилцуулахдаа нягтлан бодогч итгэл үнэмшилтэй байж, мэдэгдэл ба батламж мэдэгдэл хийхдээ болгоомжтой хандах ёстой. Мөн нягтлан бодогч тухайн асуудлыг мэдэгдэхийн өмнө нягтлан бодогчийн хүсэл эрмэлзлээ үйлчлүүлэгчид мэдээлэх нь хэр зохистойг тунгааж үзэх нь зүйтэй.

Зайлшгүй Зөрчил

Ш360.27 Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагч, олон нийтэд ихээхэн гарз хохирол учруулж болохуйц хэмжээнд хууль тогтоомжийг гарцаагүй зөрчихөд хүрсэн гэж итгэх шалтгаан бүхий ховор тохиолдолд, энэхүү бодит эсвэл төлөвлөсөн үйлдлийн талаар ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч мэдэх боломжтой. Ажиллаж байгаа байгууллагын удирдлага эсвэл засаглах эрхтэй этгээдтэй тухайн асуудлаар ярилцах нь зүйтэй гэж анх үзэхдээ нягтлан бодогч нь мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлэн, уг асуудлыг зохих эрх мэдэл бүхий этгээдэд нэн даруй мэдэгдсэнээр ийм зайлшгүй зөрчлийн үр дагавраас сэргийлж эсвэл түүнийг багасгаж чадна. Хэрэв мэдэгдсэн бол, үүнийг энэ Дүрмийн Ш114.1(г) параграфт зааснаар хийх ёстой.

Баримтжуулалт

Ш360.28 Энэ бүлгийн хамрах хүрээнд багтдаг үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотойгоор, мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг баримтжуулсан байх ёстой:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Гүйцэтгэх удирдлага, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлага нь тухайн асуудалд ямар хариу арга хэмжээ авсан.
- Ул үндэслэлтэй, мэдлэг бүхий гуравдагч этгээдийн тестийг харгалзсаны үндсэн дээр нягтлан бодогчийн авсан арга хэмжээ, хийсэн шүүн тунгаалт ба гаргасан шийдвэр.
- ШЗ60.20 параграфт тодорхойлсон үүрэг хариуцлагын биелэлтэд тухайн нягтлан бодогч хэр сэтгэл хангалуун байгаа.

360.28A1 Энэхүү баримтжуулалт нь холбогдох аудитын стандартуудын дагуу хийх баримтжуулалтын шаардлагыг хангасан байна. Жишээлбэл, АОУС нь санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэдэг мэргэжлийн нягтлан бодогчоос дараах зүйлийг шаарддаг:

- Аудитын явцад гарсан чухал асуудлыг ойлгох, дүгнэлт хийх, дүгнэлт хийхийн тулд гаргасан мэргэжлийн чухал шүүн тунгаалт зэргийг ойлгоход хангалттай байх хэмжээнд баримтжуулах;
- Гүйцэтгэх удирдлага, засаглах эрхтэй удирдлага болон бусад хүмүүстэй чухал асуудлуудын талаар хийсэн ярилцлага, үүнд ярилцаж хэлэлцсэн чухал асуудлуудын мөн чанар, ярилцлагад хэн хэн оролцсон тухай;
- Олж илрүүлсэн болон сэжиг бүхий үл нийцэл, мөн гүйцэтгэх удирдлага, засаглах эрхтэй удирдлага болон аж ахуйн нэгжээс гадуурх бусад талтай хийсэн дээрх ярилцлагын үр дүнг баримтжуулах.

Санхүүгийн Тайлангийн Аудитаас бусад Мэргэжлийн Үйлчилгээ

Асуудлыг ойлгож авах, энэ талаар гүйцэтгэх удирдлага болон засаглах эрхтэй удирдлагад мэдээлэх

ШЗ60.29 Санхүүгийн тайлангийн аудитаас бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа нягтлан бодогч үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн талаар олж мэдсэн бол, тэрээр энэ асуудлыг ойлгосон байх ёстой. Энэ ойлголтод үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн мөн чанар болон тийм тохиолдол гарсан эсвэл гарч болзошгүй нөхцөл байдал багтдаг.

360.29A1 Мэргэжлийн нягтлан бодогчийг мэдлэг, ур чадвараа ашиглан, мэргэжлийн шүүн тунгаалтыг хэрэгжүүлнэ хэмээн хүлээдэг. Гэхдээ, тухайн нягтлан бодогчийн хууль тогтоомжийн ойлголтын түвшин нь гэрээт ажил гүйцэтгэхэд шаардлагатай түвшнээс их байна хэмээн хүлээх боломжгүй. Аливаа үйлдэл нь үл нийцэл үүсгэж байгаа эсэх эцсийн дүгнэлтийг зөвхөн шүүх буюу холбогдох хөндлөнгийн шүүхийн байгууллага тодорхойлно.

360.29A2 Асуудлын мөн чанар ба ач холбогдлоос шалтгаалан, мэргэжлийн нягтлан бодогч нь компанийн доторх бусад хүмүүс, сүлжээ компани, мэргэжлийн байгууллага, эсвэл хуулийн зөвлөлтэй нууцлалыг хадгалах замаар зөвлөлдөх боломжтой.

ШЗ60.30 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч үл нийцлийг олж тогтоосон, эсвэл гарч болзошгүй хэмээн сэжиглэж байвал тэрээр энэ тухай дээд түвшний удирдлагатай ярилцах хэрэгтэй. Хэрэв боломжтой бол тэрээр засаглах эрхтэй этгээдтэй тухайн асуудлаар хандах нь зүйтэй. 99884842

360.30A1 Энэ ярилцлагын зорилго нь мэргэжлийн нягтлан бодогч тухайн асуудалд хамаарах нөхцөл байдал, түүний боломжит үр дагаврын талаарх ойлголтоо бэхжүүлэх явдал юм. Мөн энэ ярилцлага нь тухайн асуудлыг хянан шалгаж, тохирсон хариу арга хэмжээ авахад нь гүйцэтгэх болон засаглах эрхтэй удирдлагыг өдөөх боломжтой.

360.30A2 Тухайн асуудлын талаар ярилцвал зохих удирдлагын түвшнийг тогтоох нь мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд авч үзэх асуудал юм. Харгалзвал зохих хүчин зүйлс нь дараах байна. Үүнд:

- Асуудлын мөн чанар ба нөхцөл байдал.
- Бодитоор оролцсон эсвэл оролцсон байх боломжтой хувь хүмүүс.
- Үгсэн хуйвалдсан байх магадлал.
- Тухайн асуудлаас үүсэж болох үр дагавар.
- Ярилцахаар сонгосон удирдлагын түвшин нь тухайн асуудлыг мөрдөн шалгаж, зохих хариу арга хэмжээ авах боломжтой түвшин мөн эсэх.

Аж ахуйн нэгжийн хөндлөнгийн аудиторт тухайн асуудлыг мэдээлэх

ШЗ60.31 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч аудитын бус үйлчилгээг:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

(а) компанийн аудитын үйлчлүүлэгч;

(б) компанийн аудитын үйлчлүүлэгчийн бүрэлдэхүүн хэсэгт

үзүүлж байгаа бол тэрээр хууль тогтоомжоор хориглосноос бусад тохиолдолд үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн асуудлыг компани дотроо мэдээлнэ. Ингэж мэдээлэхдээ компанийн протокол, дүрэм журмыг дагаж мөрдөнө. Хэрэв ийм протокол, дүрэм журам байдаггүй бол, мэдээллийг шууд аудитын гэрээт ажлын партнерг дамжуулах ёстой.

Ш360.32 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч аудитын бус үйлчилгээг:

(а) сүлжээ компанийн аудитын үйлчлүүлэгч;

(б) сүлжээ компанийн аудитын үйлчлүүлэгчийн бүрэлдэхүүн хэсэгт

үзүүлж байгаа бол тэрээр үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн талаар сүлжээ компанид мэдээлэх эсэхээ тунгааж үзэх хэрэгтэй. Мэдээлэхээр бол сүлжээ компанийн протокол, дүрэм журмыг дагаж мөрдөнө. Хэрэв ийм протокол, дүрэм журам байдаггүй бол, мэдээллийг шууд аудитын гэрээт ажлын партнерг дамжуулах ёстой.

Ш360.33 Хэрэв мэргэжлийн нягтлан бодогч аудитын бус үйлчилгээг:

(а) компани эсвэл сүлжээ компанийн аудитын үйлчлүүлэгч биш;

(б) компани эсвэл сүлжээ компанийн аудитын үйлчлүүлэгчийн бүрэлдэхүүнд багтдаггүй

үйлчлүүлэгчид үзүүлж байгаа бол тэрээр үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн талаар тухайн үйлчлүүлэгчийн хөндлөнгийн аудитораар ажилладаг компанид мэдээлэх эсэхээ тунгааж үзэх хэрэгтэй.

Харгалзвал Зохих Хүчин Зүйлс

360.34A1 Параграф Ш360.31-Ш360.33-т нийцүүлэн мэдээлэхдээ харгалзвал зохих хүчин зүйлсэд дараах орно. Үүнд:

- Ийнхүү мэдээлэх нь хууль тогтоомжтой зөрчилдөх эсэх.
- Үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийг үргэлжлүүлэн мөрдөн шалгах үйл ажиллагаанд зохицуулах эсвэл прокурорын байгууллагаас тавьдаг ямар нэг хориг буюу хязгаарлалт байдаг эсэх.
- Тохирох арга хэмжээ авах боломжийг аж ахуйн нэгжид олгохын тулд боломжит үл нийцлийг уг аж ахуйн нэгжийн хэмжээнд мөрдөн шалгах нь гэрээт ажлын зорилго мөн эсэх.
- Гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлага нь аж ахуйн нэгжийн хөндлөнгийн аудиторт тухайн асуудлыг аль хэдийн мэдээлсэн эсэх.
- Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангийн аудитад тухайн асуудал материаллаг байх, эсвэл тухайн асуудал группийн бүрэлдэхүүнтэй холбоотой бол, уг группийн санхүүгийн тайлангийн аудитад тухайн асуудал материаллаг нөлөөтэй байх магадлал.

Мэдээлэх буюу Мэдэгдэх Зорилго

360.35A1 Параграф Ш360.31-Ш360.33-т заасан нөхцөлийн үед, мэдээлэх буюу мэдэгдэх зорилго нь үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийн талаар аудитын гэрээт ажлын партнерт мэдэгдэх, энэ хэсгийн заалтын дагуу хэрхэн шийдвэрлэхийг тодорхойлох явдал юм.

Цаашид Арга Хэмжээ Авах Шаардлагатай эсэхийг Бодох

Ш360.36 Мэргэжлийн нягтлан бодогч нь олон нийтийн эрх ашгийн төлөө цаашид арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг авч үзэх хэрэгтэй.

360.36A1 Цаашид арга хэмжээ авах шаардлагатай эсэх, ямар арга хэмжээг ямар цар хүрээнд авах нь дараах хүчин зүйлсээс шалтгаална:

- Хууль тогтоомжийн үзэл баримтлал.
- Гүйцэтгэх удирдлага, боломжтой бол засаглах эрхтэй удирдлагын хариу арга хэмжээний тохиромжтой байдал ба хугацаа.
- Нөхцөл байдал яаралтай эсэх.
- Гүйцэтгэх эсвэл засаглах эрхтэй удирдлагын оролцоо

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчид, ажилчид ба олон нийтийн ашиг сонирхолд үлэмж хор хөнөөл учруулах магадлал.

360.36A2 Мэргэжлийн нягтлан бодогчийн авч болох цаашдын арга хэмжээ нь:

- Хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлага байхгүй байсан ч гэсэн тухайн илэрсэн асуудлыг зохих эрх мэдэл бүхий байгууллагад танилцуулах.
- Хууль тогтоомжид зөвшөөрсөн тохиолдолд, гэрээт ажил болон мэргэжлийн харилцаа холбооноос тагталзах.

360.36A3 Тухайн асуудлыг зохих эрхтэй байгууллагад танилцуулах эсэхийг шийдэхдээ дараах хүчин зүйлийг харгалзвал зохино. Үүнд:

- Ийнхүү мэдээлэх нь хууль тогтоомжтой зөрчилдөж болох эсэх.
- Үл нийцэл ба сэжиг бүхий үл нийцлийг үргэлжлүүлэн мөрдөн шалгах үйл ажиллагаанд зохицуулах эсвэл прокурорын байгууллагаас хориг, хязгаарлалт тавьдаг эсэх.
- Гэрээт ажлын зорилго нь тохирох арга хэмжээ авах боломжийг аж ахуйн нэгжид олгохын тулд болзошгүй үл нийцлийг уг аж ахуйн нэгжийн хэмжээнд мөрдөн шалгах явдал мөн эсэх.

Ш360.37 Хэрэв үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцлийг эрх мэдэл бүхий байгууллагад мэдээлэхийг тухайн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ хэмээн мэргэжлийн нягтлан бодогч тодорхойлбол, энэ Дүрмийн Ш114.1(г)-д заасны дагуу ийнхүү танилцуулахыг зөвшөөрнө. Ийм мэдээллийг танилцуулахдаа нягтлан бодогч итгэл үнэмшилтэй байж, мэдэгдэл ба батламж мэдэгдэл хийхдээ болгоомжтой хандах ёстой. Мөн нягтлан бодогч тухайн асуудлыг мэдэгдэхийн өмнө нягтлан бодогчийн хүсэл эрмэлзлээ үйлчлүүлэгчид мэдээлэх нь хэр зохистойг тунгааж үзэх нь зүйтэй.

Зайлшгүй Зөрчил

Ш360.38 Хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, ажиллагч, олон нийтэд ихээхэн гарз хохирол учруулж болохуйц хэмжээнд хууль тогтоомжийг гарцаагүй зөрчихөд хүрсэн гэж итгэх шалтгаан бүхий ховор тохиолдолд, энэхүү бодит эсвэл төлөвлөсөн үйлдлийн талаар ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч мэдэх боломжтой. Ажиллаж байгаа байгууллагын удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай тухайн асуудлаар ярилцах нь зүйтэй гэж анх үзэхдээ нягтлан бодогч нь мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлэн, уг асуудлыг зохих эрх мэдэл бүхий этгээдэд нэн даруй мэдэгдсэнээр ийм зайлшгүй зөрчлийн үр дагавраас сэргийлж эсвэл түүнийг багасгаж чадна. Хэрэв мэдэгдсэн бол, үүнийг энэ Дүрмийн Ш114.1(г) параграфт зааснаар хийх ёстой.

Зөвлөгөө Хүсэх

360.39A1 Мэргэжлийн нягтлан бодогч дараах зүйлийг авч үзэх боломжтой:

- Дотооддоо зөвлөлдөх.
- Нягтлан бодогчийн санаа бодол, тодорхой үйл ажиллагаа явуулах мэргэжлийн эсвэл хууль зүйн үр дагаврыг ойлгохын тулд хуулийн зөвлөгөө авах.
- Зохицуулах эсвэл мэргэжлийн байгууллагатай нууц хадгалах замаар зөвлөлдөх.

Баримтжуулалт

360.40A1 Энэ бүлгийн хамрах хүрээнд багтдаг үл нийцэл эсвэл сэжиг бүхий үл нийцэлтэй холбоотойгоор, дараах зүйлийг баримтжуулсан байхыг мэргэжлийн нягтлан бодогчид зөвлөдөг:

- Уг асуудал.
- Гүйцэтгэх удирдлага, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлага, бусад хүмүүстэй хийсэн ярилцлагын үр дүн.
- Гүйцэтгэх удирдлага, хэрэв байдаг бол засаглах эрхтэй удирдлагаас тухайн асуудалд ямар арга хэмжээ авсан.
- Нягтлан бодогчийн харгалзаж үзсэн үйл явц, гаргасан шүүн тунгаалт, авсан арга хэмжээ.
- Ш360.36-д заасан үүрэг хариуцлагаа биелүүлсэн нягтлан бодогч үүндээ хэр сэтгэл хангалуун байгаа тухай.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

БҮЛЭГ 4А – АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

		Хуудас
Хэсэг 400	Аудит ба нягтлах гэрээт ажлын хараат бус байдалд онолын үзэл баримтлалыг мөрдөх	91
Хэсэг 410	Төлбөр, хураамж	100
Хэсэг 411	Нөхөн олговор ба үнэлгээний бодлого	103
Хэсэг 420	Бэлэг, дайллага	104
Хэсэг 430	Бодит ба айлган сүрдүүлсэн зарга	105
Хэсэг 510	Санхүүгийн ашиг сонирхол	106
Хэсэг 511	Зээл ба баталгаа	138
Хэсэг 520	Бизнесийн харилцаа холбоо	140
Хэсэг 521	Гэр бүлийн ба хувийн харилцаа холбоо	142
Хэсэг 522	Аудитын үйлчлүүлэгчид үзүүлсэн өнөөгийн үйлчилгээ	145
Хэсэг 523	Аудитын үйлчлүүлэгчид захирал эсвэл ажилтан байдлаар үйлчлэх	146
Хэсэг 524	Аудитын үйлчлүүлэгч байгууллагад ажил эрхлэх	147
Хэсэг 525	Түр зуурын ажилтны үүрэг гүйцэтгэх	150
Хэсэг 540	Удаан хугацаанд аудитын үйлчлүүлэгчтэй ажилтны холбоотой байх (партнерийн эргэцийг оруулна)	151
Хэсэг 600	Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх	155
	Дэд хэсэг 601 – Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ	158
	Дэд хэсэг 602 – Захиргааны үйлчилгээ	160
	Дэд хэсэг 603 – Үнэлгээний үйлчилгээ	161
	Дэд хэсэг 604 – Татварын үйлчилгээ	162
	Дэд хэсэг 605 – Дотоод аудитын үйлчилгээ	166
	Дэд хэсэг 606 – Мэдээллийн технологийн системийн үйлчилгээ	168
	Дэд хэсэг 607 – Зарга шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	170
	Дэд хэсэг 608 – Хууль эрхзүйн үйлчилгээ	172
	609– Ажилтан Ажилд Авах Үйлчилгээ	173
	610 – Корпорацийн Санхүүгийн Үйлчилгээ	173
Хэсэг 800	Ашиглах ба түгээхэд нь хязгаарлалт тавьсан тусгай зорилготой санхүүгийн тайланг тайлагнах (Аудит ба нягтлах гэрээт ажил)	175

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

БҮЛЭГ 4А- АУДИТ БА НЯГТЛАХ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

ХЭСЭГ 400

АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛД

ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ МӨРДӨХ

Танилцуулга

Ерөнхий

- 400.1 Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид аудит ба нягтлах гэрээт ажил гүйцэтгэхдээ хараат бус байх зарчмыг баримтлах нь олон нийтийн эрх ашигт нийцэх бөгөөд энэ Ёс зүйн дүрмийн шаардлага мөн юм.
- 400.2 Энэ Хэсгийг аудит ба нягтлах ажлын аль алинд мөрдөнө. "Аудит", "аудитын баг", "аудитын гэрээт ажил", "аудитын үйлчлүүлэгч", "аудитын тайлан" гэсэн нэр томъёог нягтлах ажил, нягтлах ажлын баг, нягтлах гэрээт ажил, нягтлах ажлын үйлчлүүлэгч, нягтлах ажлын тайланд ижил агуулгаар хэрэглэнэ.
- 400.3 Энэ Хэсэгт ашигласан "мэргэжлийн нягтлан бодогч" гэсэн нэр томъёо нь нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч ба тэдний ажилладаг компанид хамааралтай болно.
- 400.4 Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт 1-д, компани ба түүний ажилтнууд, хамааралтай гэж үзвэл хараат бус шаардлагыг биелүүлбэл зохих бусад этгээд (сүлжээ компанийн ажилтнууд)-ийг холбогдох ёс зүйн шаардлагын дагуу хараат бус байдлаа хангасан гэсэн ул үндэслэлтэй баталгаагаар хангахуйц бодлого, горимыг боловсруулан мөрдүүлэхийг компаниас шаарддаг. АОУС ба НГАОУС-д аудит ба нягтлах ажил тус бүрээр, гэрээт ажлын түвшинд партнер болон багийн хувьд хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон болно. Компани дотор үүрэг хариуцлагыг хэрхэн хуваарилах нь тухайн байгууллагын хэмжээ, бүтэц, зохион байгуулалтаас хамаардаг. Энэ Хэсгийн ихэнх заалтаар, хараат бус байдалд хамаарах үйлдлийн төлөө компани доторх хүмүүсийн тус тусын онцлог үүрэг хариуцлагыг тодорхойлоогүй бөгөөд харин үүний оронд "компани" гэдэг үгээр арай хялбаршуулан илэрхийлсэн байгаа. Компаниуд ЧХОУС 1-д нийцүүлэн тодорхой үйлдлийн төлөө хүлээх хариуцлагыг хувь хүн эсвэл бүлэг (аудитын баг)-т хуваарилан ноогдуулдаг. Түүнээс гадна, мэргэжлийн нягтлан бодогч хувь хүнд өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбоонд мөрдвөл зохих аливаа заалтад нийцүүлэн ажиллах хариуцлага хэвээр хадгалагдана.
- 400.5 Хараат бус байдал нь бодитой хандлага ба шударга байдлын суурь зарчимтай холбоотой юм. Хараат бус байдал нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (а) Сэтгэл санааны хараат бус байдал - мэргэжлийн шүүн тунгаалтын үнэ цэнийг алдагдуулах нөлөөнд үл автуулах, тэгснээрээ шударга, бодитой, мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандан дүгнэлт илэрхийлэх боломж олгохуйц сэтгэл санааны байдал.
 - (б) Гадна төрхийн хараат бус байдал – ухаалаг бөгөөд мэдлэгтэй гуравдагч этгээд нь компанийн эсвэл аудит, эсвэл баталгаажуулах багийн гишүүний шударга ёс, бодитой хандлага, мэргэжлийн үл итгэх үзэл алдагдсан гэж үндэслэлтэйгээр дүгнэж болохуйц бодит баримт, нөхцөл байдлаас зайлсхийх явдал.
- Энэ Хэсэгт, хэн нэг хувь хүн эсвэл компани "хараат бус байх"-ыг тухайн хувь хүн эсвэл компани энэ Хэсгийн заалтуудыг сахин мөрдсөн гэсэн утгаар авч үзсэн болно.
- 400.6 Аудитын ажил гүйцэтгэхдээ суурь зарчмуудад нийцүүлж, хараат бус байхыг компаниас шаарддаг. Ийм гэрээт ажил гүйцэтгэхдээ хараат бус байдлаа хадгалахын тулд онолын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах материал ба тусгай шаардлагыг энэ Хэсэгт тодорхойлсон байна. Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг Хэсэг 110-д заасан суурь зарчмуудыг мөрддөгийн нэгэн адил хараат бус байдалд дагаж мөрдөнө.
- 400.7 Энэ хэсэгт дараах зүйлийг тайлбарласан болно:
- (а) Хараат бус байдалд аюул занал учруулдаг эсвэл учруулж болзошгүй мэргэжлийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбооны талаарх бодит баримт ба нөхцөл байдал;
 - (б) Ийм аюул заналыг тодруулахад тохиромжтой байж болзошгүй арга хэмжээ, үүний дотор

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

хамгаалалтын арга хэмжээ;

- (в) Тухайн аюул заналыг арилгах боломжгүй эсвэл зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах хамгаалалтын арга хэмжээ авч болох зарим нөхцөл байдал.

Нийтийн Сонирхол бүхий Байгууллага

400.8 Энэ Хэсэгт дурдсан зарим шаардлага болон ашиглах материалд, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж хэмээн тодорхойлсон зарим тодорхой байгууллага дахь олон нийтийн ашиг сонирхлын хэмжээг тусгасан болно. Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж ба янз бүрийн оролцогч талын тоо олон байдаг тул ийм тодорхойлолтод нэмж өөр аж ахуйн нэгж, эсвэл зарим ангиллын аж ахуйн нэгжийг багтаан авч үзэхийг компаниудад зөвлөдөг. Үүнд:

- Олон тооны оролцогч талын итгэмжлэлийн сан дахь хөрөнгө эзэмших гэх мэт бизнесийн шинж чанар. Үүний жишээнд, банк, даатгалын компани, тэтгэврийн сан гэх мэт санхүүгийн байгууллагыг дурдаж болно.
- Хэмжээ.
- Ажиллагчдын тоо.

Ашиглах ба Түгээхэд нь Хязгаарлалт Тавьсан Тайлан

400.9 Аудитын тайланг ашиглах, бусдад түгээн илчлэхийг хязгаарласан нөхцөлтэйгээр гаргаж болно. Хэрэв ийм хязгаарлалт байгаа бөгөөд энэ нь Хэсэг 800-д заасан нөхцлийг хангаж байвал энэ Бүлэг дэх хараат бус байх шаардлагыг Хэсэг 800-д заасны дагуу өөрчлөх боломжтой.

Аудит ба Нягтлах Ажлаас бусад Баталгаажуулах Гэрээт Ажил

400.10 Аудит ба нягтлах ажлаас бусад баталгаажуулах гэрээт ажилд баримтлах хараат бус байдлын стандартыг Бүлэг 4Б- *Аудит ба нягтлах ажлаас бусад баталгаажуулах ажлын хараат бус байдал*-д тусгасан болно.

Шаардлага ба ашиглах материал

Ерөнхий зүйл

Ш400.11 Аудитын ажил гүйцэтгэх компани хараат бусаар ажилллах ёстой.

Ш400.12 Компани нь аудитын гэрээт ажилд хамаарах хараат бус байдалд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.

[400.13-400.19-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Холбоотой Аж Ахуйн Нэгжүүд

Ш400.20 Өмнө тодорхойлсончлон, аудитын үйлчлүүлэгч болох хувьцаат компанид түүний хамаарал бүхий бүх аж ахуйн нэгж ордог. Бусад бүх аж ахуйн нэгжийн хувьд, энэ Хэсэгт дурдсан аудитын үйлчлүүлэгч гэдэгт уг үйлчлүүлэгчийн шууд эсвэл шууд бус хяналтад байдаг, холбоотой аж ахуйн нэгжийг авч үздэг. Үйлчлүүлэгчтэй холбоотой бусад аж ахуйн нэгжид хамаарах харилцаа холбоо, нөхцөл байдал нь тухайн компанийн үйлчлүүлэгчээс хэр зэрэг хараат бус байх үнэлгээтэй хамааралтай гэдгийг аудитын баг мэдсэн эсвэл ийнхүү итгэх шалтгаан байвал тэрээр хараат бус байдлын аюул заналыг тогтоох, үнэлэх, тодорхойлох үедээ холбоотой аж ахуйн нэгжийг оруулж тооцдог.

[400.21-400.29-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Хараат Бус Байдлаа Хадгалах Шаардлагатай Хугацаа

Ш400.30 Энэ Хэсэгт шаардсаны дагуу, хараат бус байдлыг дараах хугацаанд хадгалах ёстой. Үүнд:

- (а) Гэрээт ажлын хугацаа;
- (б) Санхүүгийн тайланд хамрагдсан хугацаа.

400.30A1 Аудитын баг аудитыг гүйцэтгэж эхэлмэгц гэрээт ажлын хугацаа эхэлсэнд тооцно. Аудитын тайлан гаргах үед гэрээт ажлын хугацаа дуусна. Хэрэв гэрээт ажлыг давтан гүйцэтгэж байгаа бол мэргэжлийн харилцаа холбоо дууссан эсвэл аудитын эцсийн тайлан гарсан тухай аль нэг талаас мэдэгдсэн хугацааны сүүлд байгаа хугацаагаар дуусгавар болгоно.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Ш400.31 Хэрэв аж ахуйн нэгж нь аудитын дүгнэлт гаргуулах гэж байгаа санхүүгийн тайлангийн хамарсан хугацаанд эсвэл түүний дараа аудитын үйлчлүүлэгч болсон байвал, компани дараах нөхцөлийг харгалзах замаар түүний хараат бус байдалд аюул занал учирч байгаа эсэхийг тодорхойлно:

- (а) Санхүүгийн тайлангийн хамарсан хугацаанд эсвэл түүний дараа, гэхдээ гэрээт ажлыг зөвшөөрөхөөс өмнө тухайн аудитын үйлчлүүлэгчтэй санхүүгийн эсвэл бизнесийн харилцаатай болсон; эсвэл
- (б) Тухайн компани эсвэл түүний сүлжээ компани уг аудитын үйлчлүүлэгчид өмнө нь үйлчилгээ үзүүлж байсан.

400.31A1 Санхүүгийн тайлангийн хамарсан хугацаанд эсвэл түүний дараа, гэхдээ аудитын баг аудитын ажлыг гүйцэтгэж эхлэхээс өмнө тухайн аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд, хараат бус байдалд аюул занал учрах бөгөөд гэрээт ажлын хугацаанд ийм үйлчилгээ үзүүлэхийг үл зөвшөөрөх нь зүйтэй.

400.31A2 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын багийн гишүүн бус мэргэжилтнүүдийг ашиглах.
- Аудит болон баталгаажуулалтын бус ажлыг шалгадаг тохирох хянан шалгагчтай байх.
- Баталгаажуулалтын бус үйлчилгээний үр дүнг үнэлэхийн тулд сүлжээнд үл багтдаг өөр компани ажиллуулах, эсвэл баталгаажуулалтын бус үйлчилгээг давтан гүйцэтгүүлэхээр сүлжээнд үл багтдаг өөр компани сонгож, уг үйлчилгээний төлөө шаардлагатай хэмжээнд хариуцлага хүлээдэг болгох.

[400.32-400.39-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Засаглах Эрхтэй Удирдлагатай Харилцах

400.40A1 Засаглах эрхтэй удирдлагатай харилцах шаардлагыг Ш300.9-Ш300.10-т тодорхойлсон болно.

400.40A2 Ёс Зүйн Дүрэм, мөрдвөл зохих мэргэжлийн стандарт, хууль тогтоомжид шаардаагүй байсан ч гэсэн, компани ба үйлчлүүлэгчийн засаглах эрхтэй удирдлага хоорондоо байнга харилцаж, компанийн үзэж байгаагаар хараат бус байдал руу чиглэх харилцаа ба бусад зүйлийг ярилцдаг. Ингэснээр, засаглах эрхтэй удирдлага дараах зүйлсийг эргэцүүлэн авч үзэх боломжтой:

- (а) Аюул заналыг олж тогтоох ба үнэлэхтэй холбоотой компанийн шүүн тунгаалтыг харгалзах;
- (б) Хамгаалалтын тохиромжтой арга хэмжээ авахад бэлэн байгаа эсэх, түүнийг хэрэгжүүлэх чадвартай эсэх зэрэг аюул заналыг хэрхэн шийдвэрлэх талаар авч үзэх;
- (в) Шаардлагатай арга хэмжээ авах.

Ийм хандлага нь айлган сүрдүүлэх ба танилын аюул заналын хувьд онцгой үр дүнтэй байж болно.

[400.41-аас 400.49-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Сүлжээ Компаниуд

400.50 A1 Компаниуд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадвараа сайжруулахын тулд бусад компани ба аж ахуйн нэгжтэй нийлэн илүү том бүтцийг бүрдүүлдэг. Ийм том бүтэц сүлжээ болох эсэх нь тодорхой баримт, нөхцөл байдлаас хамаардаг. Эдгээр компани, аж ахуйн нэгж нь хууль эрхзүйн хувьд тусдаа бөгөөд төрөлжсөн байх эсэх нь харин үүнд хамааралгүй болно.

Ш400.51 Сүлжээ компани нь энэ Хэсэгт шаардсаны дагуу, өөрийн сүлжээн дэх бусад компанийн аудитын үйлчлүүлэгчээс хараат бус байх ёстой.

400.51A1 Энэ Хэсэгт заасан, сүлжээ компанид хамааралтай хараат бус байдлын шаардлагыг сүлжээ компанийн тодорхойлолтыг хангадаг аль ч байгууллага дагаж мөрддөг. Тэдний хувьд компанийн тодорхойлолтыг мөн хангах шаардлагагүй. Жишээлбэл, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч эсвэл мэргэжлийн хуулийн үйлчилгээ үзүүлэгч нь сүлжээ компани байх боломжтой, харин заавал компани байх албагүй.

Ш400.52 Бусад компани ба аж ахуйн нэгжтэй нийлэн илүү том бүтэцтэй болсон компани дараах үүрэгтэй байна:

- (а) Ийм том бүтцээр сүлжээ компани бий болгосон эсэхийг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (б) Илүү том бүтэц дэх бусад компани, аж ахуйн нэгжүүд нь сүлжээ үүсгэсэн байх арга замаар нэгдсэн гэдэг дүгнэлтийг ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэл сайтай гуравдагч этгээд өгөх магадлалтай эсэхийг авч үзэх;
- (в) Ийм томоохон бүтцэд нийтэд нь дээрх шүүн тунгаалтыг тууштай мөрдөх.

Ш400.53

Компани болон бусад аж ахуйн нэгжүүд том бүтэц бүхий сүлжээ үүсгэсэн эсэхийг тодорхойлохдоо, тэдгээр нь хамтарч ажиллахыг зорихоос гадна дараах зорилтыг хэрэгжүүлж байвал сүлжээ бий болсон гэж дүгнэх нь зүйтэй. Үүнд:

- (а) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь ашиг эсвэл зардлаа хуваалцахыг илэрхий зорьдог бол (Лав: Пара. 400.53A2);
- (б) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь нэгдсэн өмчлөл, хяналт буюу удирдлагатай байвал (Лав: Пара. 400.53A3);
- (в) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь нэгдсэн чанарын хяналтын бодлого, горимтой байвал (Лав: Пара. 400.53A4);
- (г) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь нэгдсэн бизнесийн стратегитай байвал (Лав: Пара. 400.53A5) ;
- (д) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь нэгдсэн брэнд нэр ашигладаг бол (Лав: Пара. 400.53A6, 400.53A7);
- (е) Бүтэц доторх аж ахуйн нэгжүүд нь мэргэжлийн нөөцийн томоохон хэсгийг хуваадаг бол (Лав: Пара. 400.53A8, 400.53A9)

400.53A1 Сүлжээ бүрдүүлж байгаа томоохон бүтэц доторх компани ба аж ахуйн нэгжүүдийн хооронд Ш400.53-р параграфт тодорхойлсноос гадна өөр бусад тохиролцоо байж болзошгүй. Гэхдээ, томоохон бүтэц нь зөвхөн ажлаа шилжүүлэхэд төвлөрөх боломжтой бөгөөд сүлжээ байгуулахад шаардлагатай шалгуурыг өөрөө хангадаггүй байж болно.

400.53A2 Материаллыг бус зардлыг хуваалцсанаар сүлжээ үүсдэггүй. Үүнээс гадна, хэрэв зардал хуваалцах тохиролцоо нь зөвхөн аудитын аргачлал, гарын авлага боловсруулах эсвэл сургалт явуулахтай холбоотой зардлын хэмжээгээр хязгаарлагддаг бол энэ нь өөрөө сүлжээ биш юм. Цаашилбал, үйлчилгээ үзүүлэх эсвэл бүтээгдэхүүн хөгжүүлэхийн тулд компани ба түүнтэй холбоогүй өөр нэг аж ахуйн нэгж хоорондоо хамтарч байвал үүнийг сүлжээ гэж үзэхгүй. (Лав: Пара. Ш400.53 (а)).

400.53A3 Гэрээ эсвэл бусад аргаар нэгдмэл өмчлөл, хяналт, менежментийг хийх боломжтой. (Лав: Пара. Ш400.53 (б)).

400.53A4 Нэгдсэн чанарын хяналтын бодлого, горим гэдэг нь томоохон бүтцийн хэмжээнд зохиомжилж, хэрэгжүүлж, хянан шинжилж байдаг бодлого, горим юм. (Лав: Пара. Ш400.53(в)).

400.53A5 Нэгдсэн бизнесийн стратегитэй байхын тулд байгууллагууд нэгдсэн стратегийн зорилго бүхий гэрээ байгуулдаг. Аж ахуйн нэгж нь зөвхөн мэргэжлийн үйлчилгээгээр хангах саналын төсөл явуулах хүсэлтэд хамтарсан хариулт өгөх ганц зорилгоор өөр нэг аж ахуй нэгжтэй хамтран ажиллаж байгаа бол үүнийг сүлжээ гэж үзэхгүй. (Лав: Пара. Ш400.53 (г)).

400.53A6 Нэгдсэн брэнд нэр гэдэг нь нийтлэг гарын үсэг эсвэл нийтлэг нэр ашиглахыг хэлнэ. Компанийн партнер аудитын тайланд гарын үсэг зурахдаа компанийн нэртэй хамт эсвэл компанийн нэрийн нэг хэсэг болгож нэгдсэн брэнд нэрийг оруулж байвал нэгдсэн брэнд нэрийг ашиглаж байна гэж үзнэ. (Лав: Пара. Ш400.53(д)).

400.53A7 Компани нь сүлжээ компанид харьяалагддаггүй бөгөөд нэгдсэн брэнд нэрийг нэрнийхээ нэг хэсэг болгон ашигладаггүй байсан ч гэсэн түүний нэрийг бичиг хэрэгсэл, тараах материал дээр сүлжээ компанийн гишүүн байдлаар хэвлүүлэх нь сүлжээ компанид харьяалагддаг мэтээр харагдаж болзошгүй. Иймээс, компани гишүүнчлэлээ хэрхэн тодорхойлохыг ойшоож үздэггүй бол түүнийг сүлжээ компанид харьяалагддаг мэт ойлголт төрүүлж болзошгүй. (Лав: Пара. Ш400.53(д)).

400.53A8 Мэргэжлийн нөөцөд доорх зүйлс багтана:

- Үйлчлүүлэгчдийн талаарх тоон мэдээ, нэхэмжлэх болон цагийн бүртгэлийн тухай мэдээллээ солилцох боломжийг бүрдүүлж буй нэгдсэн систем.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Партнер ба ажилтнууд.
- Техникийн эсвэл салбарын онцлог асуудлууд, баталгаажуулах гэрээт ажилд хамаарах ажил гүйлгээ, үйл явдалд зөвлөгөө өгөх техникийн хэлтсүүд.
- Аудитын аргазүй, аудитын гарын авлага.
- Сургалт болон сургалт явуулах байр танхим, тоног төхөөрөмж, хэрэгсэл. (Лав: Пара. Ш400.53 (е)).

400.53A9 Мэргэжлийн нөөцөө хуваалцах үйл ажиллагааны ач холбогдлыг холбогдох нөхцөл байдлаас хамааруулан тодорхойлдог. Жишээлбэл:

- Мэргэжлийн нөөцөө хуваалцах үйл ажиллагаа нь аудитын нэгдсэн аргазүй ба гарын авлагаар хязгаарлагдах боломжтой бөгөөд ингэхдээ ажилтан, үйлчлүүлэгч, зах зээлийн мэдээллээ солилцдоггүй. Энэ тохиолдолд, мэргэжлийн нөөцөө хуваалцах үйл ажиллагааг ач холбогдолгүй гэж үзэх магадлалтай. Нэгдсэн сургалт хийх хичээл зүтгэл ч үүнд бас хамаатай.
- Ажилтан эсвэл мэдээлэл солилцох, жишээлбэл дундын нөөцөөс ажилтан авах, эсвэл томоохон бүтэц доторх компаниудын дагаж мөрдөх ёстой техникийн зөвлөгөө өгөх зорилгоор техникийн нэгдсэн нэг хэлтэс байгуулагдсан зэрэг нь нөөцөө хуваалцаж буй хэрэг юм. Энэ тохиолдолд, ул суурьтай бөгөөд мэдээлэлтэй гуравдагч этгээдийн зүгээс мэргэжлийн нөөцөө хуваалцах үйл ажиллагааг ач холбогдолтой хэмээн дүгнэх магадлал өндөр байна. (Лав: Пара. Ш400.53(е)).

Ш400.54 Хэрэв компани эсвэл сүлжээ компани нь өөрийн үйл ажиллагааны нэг хэсгийг зарсан бөгөөд уг зарагдсан хэсэг нь компани эсвэл сүлжээний нэрийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг тодорхой хязгаарласан хугацаанд үргэлжлүүлэн ашиглаж байвал тухайн холбогдох аж ахуйн нэгж нь гаднын талуудад өөрсдийгөө танилцуулахдаа сүлжээ компани биш гэдгээ хэрхэн илэрхийлэхийг сайтар тодорхойлсон байх хэрэгтэй.

400.54A1 Үйл ажиллагааныхаа бүрэлдэхүүн хэсгийг худалдах тохиролцоо хийж байхдаа, цаашид компани эсвэл сүлжээнд хамаарахаа больсон ч гэсэн, уг компани эсвэл сүлжээний нэрийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг тодорхой хязгаарласан хугацаанд ашиглаж болох тухай нөхцөл оруулах боломжтой. Энэ тохиолдолд, хоёр аж ахуйн нэгж нэгдмэл нэг нэрийн дор ажиллаж байгаа хэдий ч, тэд хамтын ажиллагаанд чиглэсэн томоохон бүтэцэд бүтэцэд харъяалагдахгүй гэдэг бол бодит баримт юм. Ийм учраас энэ хоёр аж ахуйн нэгжийг сүлжээ компаниуд гэж үзэхгүй.

[400.55-400.59-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Аудит ба Нягтлах Гэрээт Ажлын Хараат Бус Байдлын Ерөнхий Баримтжуулалт

Ш400.60 Энэ Хэсгийн шаардлагад нийцсэн гэсэн дүгнэлт болон ингэж дүгнэснийг дэмжин нотлох аливаа ярилцлага хэлэлцүүлгийн гол утга агуулгыг компани баримтжуулах ёстой. Ялангуяа:

- (a) Аюул заналыг тодорхойлохын тулд хамгаалалтын арга хэмжээ авсан бол компани ийм аюул заналын шинж чанар, хэрэглэхэд бэлэн эсвэл хэрэглэсэн хамгаалалтыг баримтжуулах ёстой;
- (б) Аюул заналыг тодорхойлохын тулд ихээхэн шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд тухайн аюул занал нь зөвшөөрөгдөх түвшинд байгаа гэж компани дүгнэсэн бол ийм аюул заналын шинж чанарыг дүгнэлтийн шалтгааны хамт баримтжуулах ёстой.

400.60A1 Баримтжуулалт нь энэ Хэсгийн шаардлагын нийцлийн талаар дүгнэлт гаргахдаа компани өөрийн шүүн тунгаалтыг ашигласан гэсэн нотолгоогоор хангах юм. Гэхдээ, баримтжуулалт байхгүй бол, энэ нь тухайн компанийг тодорхой асуудлыг харгалзаж үзсэн, эсвэл компани нь хараат бус эсэхийг тодорхойлдоггүй.

[400.61-400.69-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэгдэлт ба Худалдан Авалт

Үйлчлүүлэгчийг Нэгтгэснээр Аюул бий болох

400.70A1 Нэгдэл, эсвэл худалдан авалтын үр дүнд аж ахуйн нэгж нь аудитын үйлчлүүлэгчийн холбоотой этгээд байх боломжтой. Ингэснээр, компани эсвэл сүлжээ компани ба тэрхүү холбоотой аж ахуйн нэгжийн хоорондох өмнөх болон одоогийн ашиг сонирхол, харилцаа холбоо нь компанийн хараат бус байдал болон компани аудитын гэрээт ажлаа үргэлжүүлэх чадамжид аюул учруулж болзошгүй.

Ш400.71 Дээрх 400.70A1 параграф дахь нөхцөл байдлын хувьд:

- (а) Компани нь аюул заналыг тодорхойлоход хэрэглэсэн хамгаалалтын арга хэмжээг харгалзан, тухайн холбоотой аж ахуйн нэгжтэй тогтоосон өмнөх ба одоогийн ашиг сонирхол, харилцаа нь түүний хараат бус байдалд нөлөөлж болзошгүй тул тухайн аудитын ажлыг нэгдэл буюу худалдан авалтын өдрөөс хойш үргэлжлүүлэх чадамжид нөлөөлж болох эсэхийг тогтоож, үнэлэх ёстой;
- (б) Энэ Дүрмийн Ш400.72-р параграфын дагуу компани нь Ёс Зүйн дүрмээр хориглосон бөгөөд нэгдэл буюу худалдан авалтын өдрөөр хүчинтэй байсан аливаа ашиг сонирхол ба харилцааг эцэслэх алхам хийх ёстой.

Ш400.72 Ашиг сонирхол буюу харилцаагаа 400.71(б)-д шаардсанаар нэгдэл буюу худалдан авалтын хүчинтэй өдөр эцэслэх боломжгүй бол, компани дараах алхмыг хийх ёстой. Үүнд:

- (а) Ашиг сонирхол ба харилцааны улмаас үүссэн аюул заналыг үнэлэх;
- (б) Ашиг сонирхол ба харилцаагаа нэгдэл буюу худалдан авалтын хүчинтэй өдөр эцэслэх боломжгүй байгаа шалтгаан болон аюул заналын үнэлгээний түвшний талаар засаглах эрхтэй удирдлагатай ярилцах.

400.72A1 Зарим тохиолдолд, нэгдэл буюу худалдан авалтын хүчинтэй өдөр аюул занал үүсгэж байгаа ашиг сонирхол ба харилцааг эцэслэх нь үнэхээр боломжгүй байж болно. Учир нь, компани баталгаажуулалтын бус үйлчилгээг холбоотой аж ахуйн нэгжид үзүүлж, үүнийг тухайн аж ахуйн нэгж тухайн өдөр өөр компани руу ердийн аргаар шилжүүлэх боломжгүй байдаг.

400.72A2 Ашиг сонирхол ба харилцааг эцэслэх боломжгүй үед нэгтгэх, худалдан авах замаар бий болсон аюул заналын түвшинг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлэд дараах орно. Үүнд:

- Ашиг сонирхол эсвэл харилцааны мөн чанар ба ач холбогдол;
- Холбоотой аж ахуй нэгжтэй тогтоосон харилцааны мөн чанар ба ач холбогдол (жишээлбэл, холбоотой аж ахуй нэгж нь охин компани эсвэл толгой компани мөн эсэх);
- Ашиг сонирхол эсвэл харилцааг бодитой эцэслэх буюу дуусгах хүртэлх хугацаа.

Ш400.73 Хэрэв засаглах эрхтэй удирдлага нь аудитын ажлыг үргэлжлүүлэхийг компаниас хүсвэл, тэрээр зөвхөн дараах тохиолдолд л үүнийг зөвшөөрөх ёстой:

- (а) Ашиг сонирхол буюу харилцааг аль болох шуурхай, гэхдээ нэгдэл буюу худалдан авалтын хүчинтэй болох өдрөөс хойш зургаан сарын дотор эцэслэхээр шийдсэн;
- (б) Хэсэг 600 болон түүний дэд хэсгүүдэд зөвшөөрдөггүй баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх замаар үүссэн ашиг сонирхол буюу харилцаатай этгээд нь аудитын гэрээт ажлын багийн гишүүн биш эсвэл гэрээт ажлын чанарын хяналт хариуцсан ажилтан биш байх;
- (в) Шилжилтийн арга хэмжээг зохих хэмжээнд авсан бөгөөд энэ талаар засаглах эрхтэй удирдлагатай ярилцсан.

400.73A1 Шилжилтийн арга хэмжээний жишээг дурдвал:

- Аудит эсвэл баталгаажуулалтын бус ажлыг зохих ёсоор хянах мэргэжлийн нягтлан бодогчтой байх;
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгч байгаа компанийн гишүүн бус мэргэжлийн нягтлан бодогчоор аудитын ажлын чанарын хяналттай дүйцэхүйц хэмжээний шалгалт хийлгүүлэх;
- Баталгаажуулалтын бус үйлчилгээний үр дүнг үнэлүүлэхээр өөр компани хөлслөх, эсвэл уг үйлчилгээний төлөө хариуцлага хүлээх хүртэл нь тухайн баталгаажуулалтын бус үйлчилгээг дахин гүйцэтгүүлэхээр өөр компани хөлслөх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Ш400.74 Компани нь нэгдэл буюу худалдан авалт хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө аудитын ажлын дийлэнх хэсгийг дуусгасан байж болох бөгөөд үлдсэн аудитын горимуудыг богино хугацаанд дуусгах боломжтой байж болно. Ийм тохиолдолд, 400.70A1-д дурдсанэ ашиг сонирхол буюу харилцаа үргэлжилж байх зуур засаглах эрхтэй удирдлагын зүгээс аудитыг цааш үргэлжлүүлэхийг хүсвэл, зөвхөн дараах тохиолдолд компани үүнийг зөвшөөрөх ёстой:

- (a) Аюул заналын түвшнийг үнэлж, засаглах эрхтэй удирдлагатай үнэлгээний үр дүнгийн талаар ярилцсан бол;
- (б) Параграф 400.73 (a)-(в) шаардлагуудтай нийцэж байвал;
- (в) Аудитын тайлан гарах өдрөөс өмнө уг байгууллагын аудитор байхаа больсон.

Бодит Байдал Алдагдсан бол

Ш400.75 Параграф Ш400.71-400.74-д заасан бүх шаардлага хангагдсан байсан ч гэсэн, 400.70A1-д тодорхойлсон нөхцөл байдлын улмаас бодитой байдал алдагдсан хэвээр байхуйц аюул занал учирч болох эсэхийг компани заавал тодорхойлох нь зүйтэй. Хэрэв ийм байвал, тэрээр аудитор байхаа болих ёстой.

Баримтжуулалт

Ш400.76 Компани дараах асуудлыг баримтжуулах ёстой. Үүнд:

- (a) 400.70A1-д тодорхойлсон бөгөөд нэгдэл буюу худалдан авалтын хүчинтэй өдөр эцэслэх боломжгүй ашиг сонирхол буюу харилцаа болон яагаад эцэслэх боломжгүй байгаа шалтгаан;
- (б) Авч хэрэгжүүлсэн шилжилтийн үеийн арга хэмжээ;
- (в) Засаглах эрхтэй удирдлагатай хийсэн ярилцлагын үр дүн;
- (г) Өмнөх ба одоогийн ашиг сонирхол, харилцаа нь бодитой байдлыг алдагдуулж болох аюул заналыг яагаад үүсэхгүй байгаа шалтгаан.

[400.77-400.79-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно]

Аудит ба Нягтлах Гэрээт Ажлын Хараат бус Байдлын Заалтыг Зөрчих

Компани Зөрчил Илрүүлсэн бол

Ш400.80 Хэрэв компани энэ Хэсэгт заасан шаардлагыг зөрчсөн гэж тогтоосон бол тэрээр:

- (a) Зөрчил үүсгэсэн ашиг сонирхол буюу харилцааг зогсоох, цуцлах болон арилгаж, зөрчлийн үр дагаврыг тодорхойлох;
- (б) Хуулийн болон зохицуулалтын шаардлагыг тухайн зөрчилтэй хамаатай эсэхийг авч үзэх ба хэрэв тийм бол:
 - (i) Эдгээр шаардлагад нийцүүлэх;
 - (ii) Хэрэв ийм зөрчлийг тайлагнадаг практик нь нийтлэг бөгөөд тухай хууль эрхзүйн орчинд хүлээж болох үйл явдал бол энэ талаар мэргэжлийн эсвэл зохицуулагч байгууллага буюу хянан шийдвэрлэх эрхтэй байгууллагад мэдээлэх;
- (в) Хууль тогтоомж, журмын дагуу дараах этгээдэд зөрчлийн талаар нэн даруй мэдэгдэх:
 - (i) Гэрээт ажлын партнер;
 - (ii) Хараат бус байдалд хамаарах бодлого, горимыг хариуцах хүмүүс;
 - (iii) Компани болон тохиромжтой бол сүлжээ компанийн дотоод дахь бусад холбогдох хүмүүс;
 - (iv) Бүлэг 4A-д заасны дагуу тодорхой арга хэмжээ авах шаардлагатай хараат бус байдал хариуцсан хүмүүс;
- (г) Зөрчлийн ач холбогдол ба компанийн шударга байдал ба аудитын тайлан гаргах чадамжид түүний үзүүлэх нөлөөг үнэлэх;
- (д) Зөрчлийн ач холбогдлоос хамааран дараах зүйлийг тодорхойлно:
 - (i) Аудитын гэрээт ажлыг зогсоох эсэх;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (ii) Зөрчлийн үр дагаврыг хангалттай хэмжээнд шийдвэрлэх арга хэмжээ байгаа эсэх, ийм арга хэмжээ авч чадах эсэх, тэр нь тухайн нөхцөл байдалд тохирох эсэх.

Ийнхүү тодорхойлохдоо компани мэргэжлийн шүүн тунгаалт ашиглах бөгөөд ул суурьтай, мэдлэгтэй гуравдагч этгээд нь компанийг бодитой байдлаа алдаж болзошгүй учраас аудитын тайлан гаргаж чадахгүй гэсэн дүгнэлт хийх магадлалтай эсэхийг харгалзах ёстой.

400.80A1 Хараат бус байдлаа хадгалж байгаа гэсэн ул үндэслэлтэй баталгаагаар хангах зорилго бүхий бодлого, горимыг компани мөрддөг ч гэсэн энэ Хэсгийн шаардлагыг зөрчих тохиолдол үүсэж болзошгүй. Ийм зөрчлийн улмаас аудитын гэрээт ажлыг дуусгах хэрэгтэй байж болзошгүй.

400.80A2 Тухайн зөрчил нь компанийн бодитой байх зарчим ба аудитын тайлан гаргах чадамжид үзүүлэх нөлөө нь дараах хүчин зүйлсээс хамаарна:

- Зөрчлийн шинж чанар ба үргэлжлэх хугацаа.
- Одоогийн аудитын ажилтай холбоотой өмнөх зөрчлийн тоо ба шинж чанар.
- Зөрчил үүсгэсэн ашиг сонирхол ба харилцаа холбооны талаар аудитын багийн гишүүн мэдэж байгаа эсэх.
- Зөрчил гаргасан хүн нь аудитын багийн гишүүн, эсвэл хараат бус байх шаардлагыг хэрэгжүүлэх хүн мөн эсэх.
- Хэрэв зөрчил нь аудитын багийн гишүүнд хамааралтай бол тухайн хүний гүйцэтгэх үүрэг.
- Хэрэв зөрчил нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад үүссэн бол энэ үйлчилгээний үр нөлөө нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт ба санхүүгийн тайланд тусгагдсан дүн, түүнд өгөх аудитын дүгнэлтэд хэрхэн тусах.
- Зөрчлөөс үүссэн хувийн ашиг сонирхол, өмгөөлөл, айлган сүрдүүлэлт болон бусад аюул заналын далайц.

400.80A3 Зөрчлийн ач холбогдлоос хамааран, түүний үр дагаврыг хангалттай тодорхойлохын тулд компанийн авбал зохих арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Хамааралтай хүнийг аудитын багаас гаргах;
- Нөлөө орсон аудитын ажлыг эргэж хянах, эсвэл уг ажлыг шаардлагатай хүрээнд дахин гүйцэтгэх, энэ хоёр тохиолдлын аль алинд өмнөхөөс өөр хүмүүсийг ажиллуулах;
- Нөлөө орсон аудитын ажлыг шаардлагатай хэмжээнд нягтлах, эсвэл дахин гүйцэтгүүлэхээр өөр аудитын компани хөлслөхийг аудитын үйлчлүүлэгчид зөвлөх;
- Хэрэв зөрчил нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан дүнд нөлөөлөх баталгаажуулалтын бус үйлчилгээтэй холбоотой байвал, баталгаажуулалтын бус үйлчилгээний үр дүнг үнэлэхийн тулд өөр компани хөлслөх, эсвэл үйлчилгээний төлөө хариуцлага хүлээлгэх үүднээс шаардлагатай хэмжээнд баталгаажуулалтын бус үйлчилгээг өөр компаниар дахин гүйцэтгүүлэх хэрэгтэй.

Ш400.81 Хэрэв компани зөрчлийн үр дагаврыг арилгах үйл ажиллагааг хангалттай явуулж чадахгүй хэмээн тодорхойлж байвал энэ тухай засаглах эрхтэй удирдлагад аль болох шуурхай мэдээлж, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын бусад шаардлагын дагуу аудитын гэрээт ажлыг цуцлах ёстой. Хэрэв ажил цуцлахыг хууль тогтоомжоор хориглодог бол компани тайлагналын болон бусад ямар нэг ил тод мэдээлэх шаардлагын дагуу шийдэх нь зүйтэй.

Ш400.82 Хэрэв компани зөрчлийн үр дагаврыг арилгах үйл ажиллагааг хангалттай явуулж чадна хэмээн тодорхойлж байвал, тэрээр засаглах эрхтэй дээд удирдлагатай дараах зүйлийг ярилцах ёстой. Үүнд:

- Зөрчлийн ач холбогдол, шинж чанар ба үргэлжлэх хугацаа;
- Зөрчил хэрхэн гарсан, түүнийг хэрхэн олж тогтоосон;
- Хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагаа, зөрчлийн үр дагаврыг хангалттай арилгаж, аудитын тайлан гаргах боломжтой болгоход тухайн үйл ажиллагааг компани яагаад хангалттай гэж үзсэн тухай.
- Мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд бодитой байдлаа алдаагүй гэсэн компанийн дүгнэлт, ийм

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

дүгнэлт хэр оновчтой болох тухай.

- Цаашид гарч болзошгүй зөрчлийг бууруулах, тохиолдох эрсдлээс сэргийлэхийн тулд компанийн хийсэн ба хийхээр төлөвлөж байгаа үйл ажиллагаа.

Засаглах эрхтэй удирдлагын зүгээс ач холбогдол багатай зөрчлийг тайлагнах тодорхой хугацаа заагаагүй бол компани зөрчил ба үйл ажиллагааны тухай аль болох шуурхай ярилцах нь зүйтэй.

Засаглах Эрхтэй Удирдлагад Зөрчлийн Талаар Мэдээлэх

400.83A1 Засаглах эрхтэй удирдлагатай ярилцах тухай шаардлагыг Ш300.9-Ш300.10-т тусгасан болно.

Ш400.84 Компани нь зөрчилтэй холбоотой дараах асуудлыг засаглах эрхтэй удирдлагад бичгээр хүргүүлж, мэдээлэх ёстой:

(a) Ш400.82-р параграфт заасан бүх асуудлаар ярилцан, зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгахуйц үйл ажиллагааг хэрэгжүүлсэн эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа талаар засаглах эрхтэй удирдлага санал нийлж байгаа эсэх;

(a) Дараах зүйлийн тодорхойлолт:

(i) Компани хараат бус байдлаа хадгалж байгаа гэсэн үндэслэлтэй баталгаагаар хангах зорилготой бөгөөд зөрчилд хамаарах бодлого, горим;

(ii) Цаашид гарах зөрчлийг бууруулах, тохиолдох эрсдлээс сэргийлэхийн тулд компанийн хийсэн ба хийхээр төлөвлөж байгаа үйл ажиллагаа.

Ш400.85 Хэрэв засаглах эрхтэй удирдлагын зүгээс, Ш400.80(д)(ii) параграфт заасны дагуу төлөвлөж буй үйл ажиллагаагаар зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгана гэдэгтэй санал нийлэхгүй байвал компани хууль тогтоомжид хориглосноос бусад тохиолдолд, аудитын гэрээт ажлыг цуцлахтай холбоотой Ш400.81-р параграфт нийцүүлэн гэрээт ажлыг цуцлах арга хэмжээ авах нь зүйтэй.

Өмнөх Аудитын Тайлан Гарахаас Өмнө Үүссэн Зөрчил

Ш400.86 Хэрэв өмнөх аудитын тайлан бэлтгэхээс өмнө зөрчил гарсан бол зөрчлийн ач холбогдол, компанийн бодит байдал ба тайлант хугацааны аудитын тайлан гаргахад түүний үзүүлэх нөлөө зэргийг үнэлэхдээ компани энэ Бүлэг 4А-ийн заалтыг дагаж мөрдвөл зохино.

Ш400.87 Түүнчлэн компани:

(a) Тухайн зөрчил нь өмнө гаргаж байсан аудитын тайланд нөлөөлж болох, мөн энэхүү аудитын тайланг буцаан татах боломжийг харгалзах;

(b) Эдгээр асуудлыг засаглах эрхтэй удирдлагатай ярилцах.

Баримтжуулалт

Ш400.88 Компани Ш400.80-Ш400.87-р параграфт нийцүүлэх үүднээс дараах зүйлсийг баримтжуулах ёстой. Үүнд:

(a) илэрсэн зөрчил;

(b) хэрэгжүүлсэн үйл ажиллагаа;

(в) гаргасан гол чухал шийдвэр;

(г) засаглах эрхтэй удирдлагатай ярилцсан бүх асуудал;

(д) гишүүн байгууллага, зохицуулагч байгууллага болон хяналтын байгууллагатай хийсэн ярилцлага.

Ш400.89 Хэрэв компани гэрээт ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх бол тэрээр дараах зүйлсийг баримтжуулах ёстой. Үүнд:

(a) компани мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд, бодитой байдлаа алдаагүй гэсэн дүгнэлт;

(b) зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгаж, аудитын тайлан гаргах боломжтой болгоход тухайн арга хэмжээг яагаад хангалттай гэж үзсэн тухай.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 410 ТӨЛБӨР

Танилцуулга

- 410.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 410.2 Төлбөр болон нөхөн олговрын бусад хэлбэрийн шинж чанар ба хэмжээ нь хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэх боломжтой. Дээр дурдсан тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Шаардлага ба ашиглах материал

Төлбөр–харьцангуй хэмжээ

Аудитын бүх үйлчлүүлэгч

- 410.3A1 Аудитын ажлын нэг үйлчлүүлэгчээс авсан нийт төлбөр нь уг аудитын дүгнэлт гаргаж буй компанийн хүлээн авч буй нийт төлбөрийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа үед тухайн үйлчлүүлэгчээс хараат байх, мөн уг үйлчлүүлэгчийг алдаж болзошгүй гэсэн болгоомжлол нь хувийн ашиг сонирхлын, эсвэл айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэдэг.
- 410.3A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамаарах хүчин зүйлсэд дараахыг оруулж үздэг. Үүнд:
- Компанийн үйл ажиллагааны бүтэц;
 - Компанийн үйл ажиллагаа тогтворжсон эсвэл шинээр байгуулагдсан эсэх;
 - Тухайн үйлчлүүлэгч нь тоо хэмжээ болон чанарын хувьд компанид хэр чухал болох.
- 410.3A3 Хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд аудитын үйлчлүүлэгчээс хараат байдлаа багасгахын тулд үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх аргыг дурдаж болно.
- 410.3A4 Аудитын нэг үйлчлүүлэгчээс авах нийт төлбөр нь нэг партнер эсвэл компанийн нэг салбарын орлогын дийлэнх хувийг бүрдүүлж байвал мөн хувийн ашиг сонирхлын, эсвэл айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болно.
- 410.3A5 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийг дурдвал:
- Тухайн үйлчлүүлэгч нь тоо хэмжээ болон чанарын хувьд уг партнер эсвэл компанийн салбарын хувьд хэр чухал болох;
 - Партнер эсвэл компанийн салбар дахь партнерүүдийн шагнал урамшуулал нь тухайн үйлчлүүлэгчээс авдаг төлбөрийн хэмжээнээс хамаарах далайц.
- 410.3A6 Хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Партнер эсвэл компанийн салбарын үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх замаар уг үйлчлүүлэгчээс хараат байх байдлыг бууруулна.
 - Тухайн аудитын гэрээт ажилд оролцоогүй хүнээр ажлыг нь хянуулах.
 - Аудитын үйлчлүүлэгчид нь нийтийн сонирхол бүхий байгууллага байх
- Ш410.4** Аудитын үйлчлүүлэгч нь нийтийн сонирхол бүхий байгууллага бөгөөд дараалсан 2 жилийн хугацаанд уг үйлчлүүлэгч болон түүний холбоотой аж ахуйн нэгжүүдээс хүлээн авсан төлбөр нь санхүүгийн тайланд нь дүгнэлт өгч буй компанийн нийт орлогын 15-аас дээш хувийг эзэлж байвал, компани дараах алхмыг хийх ёстой. Үүнд:
- (а) Тухайн аудитын үйлчлүүлэгчийн засаглах эрхтэй удирдлагад, компанийн хүлээн авсан нийт төлбөрийн 15%-аас дээш хувийг уг үйлчлүүлэгчийн төлбөр бүрдүүлж байгаа тухай мэдэгдэх;
- (б) Уг үйлчлүүлэгчээс компанийн хүлээн авсан нийт төлбөрийн улмаас үүссэн аюул заналыг

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тодорхойлохдоо дараах арга хэмжээний аль нэгийг ашиглаж болох эсэх, хэрэв тийм бол хэзээ мөрдөх тухай ярилцах:

- (i) Хоёрдахь жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг гаргахаас өмнө, уг санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж буй компанийн гишүүн бус хүн уг ажлын чанарын хяналтыг нягтлах шалгалтыг гүйцэтгэнэ; эсвэл мэргэжлийн байгууллага уг гэрээт ажлын ажлыг чанарын хяналт шалгалттай дүйцэхүйц байдлаар гүйцэтгэнэ (“тайлан гаргахын өмнөх шалгалт”);
- (ii) Хоёрдахь жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гарсна дараа, гэхдээ гуравдахь жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гарахаас өмнө, уг санхүүгийн тайланд дүгнэлт өгч байгаа компанийн гишүүн бус мэргэжлийн нягтлан бодогч эсвэл мэргэжлийн байгууллага нь чанарын хяналт шалгалттай дүйцэхүйц байдлаар хоёрдахь жилийн аудитын ажлыг шалгаж нягтална (“тайлан гарсны дараах шалгалт”).

Ш410.5 Хэрэв Ш410.4-р параграфт заасан нийт төлбөр нь 15%-иас хэт давбал компани, тайлан гарсны дараах шалгалт хийгээд аюул заналын далайцыг зөвшөөрөгдөх түвшин бууруулж чадахааргүй байгаа эсэхээ тодорхойлох ёстой. Хэрэв ингэж тодорхойлсон бол, тайлан гаргахын өмнөх шалгалтыг заавал гүйцэтгэх хэрэгтэй.

Ш410.6 Хэрэв Ш410.4-р параграфт заасан нийт төлбөр нь 15%-иас хэтэрсэн хэвээр байвал компани жил бүр дараах арга хэмжээ авах нь зүйтэй. Үүнд:

- (a) Ш410.4-р параграфт дурдсан асуудлыг засаглах бүхий удирдлагад мэдэгдэж, ярилцах;
- (b) Ш410.4(б) болон Ш410.5-р параграфын шаардлагыг дагаж мөрдөх.

Төлбөр - Хугацаа Хэтэрсэн

410.7A1 Дараагийн жилийн аудитын тайлан гарахаас өмнө, аудитын үйлчлүүлэгчийн төлбөл зохих төлбөрөөс томоохон хэсэг нь төлөгдөөгүй бол хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болзошгүй. Ерөнхийдөө, компани аудитын тайлан гаргахын өмнө үйлчилгээний төлбөрөө төлөхийг үйлчлүүлэгчээс шаарддаг. Хэсэг 511-ийн зээл ба баталгаатай холбоотой шаардлага, ашиглах материалыг төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл байгаа тохиолдолд мөн ашиглах боломжтой.

410.7A2 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Хугацаа хэтэрсэн төлбөрийн зарим хэсгийг төлүүлэх.
- Тухайн аудитын ажилд оролцоогүй ажлтнаар гүйцэтгэсэн ажлыг хянуулах.

Ш410.8 Аудитын үйлчлүүлэгчээс авах төлбөрийн үлэмж хэсэг удаан хугацаагаар төлөгдөөгүй бол, компани дараах зүйлийг тодорхойлох ёстой. Үүнд:

- (a) Хугацаа хэтэрсэн төлбөрийг үйлчлүүлэгчид өгсөн зээлтэй адилтган үзэх боломжтой эсэх;
- (b) Уг компанийг аудитын гэрээт ажил гүйцэтгүүлэхээр дахин томилох эсвэл үргэлжлүүлэх нь тохиромжтой эсэх.

Болзошгүй Төлбөр

410.9A1 Болзошгүй төлбөр гэдэг нь ажил гүйлгээний үр дүн, эсвэл гүйцэтгэсэн үйлчилгээний үр дүнтэй холбож урьдчилан тодорхойлсон сууриар тооцоолсон төлбөр юм. Зуучлагчаар дамжуулан нэхэмжилсэн болзошгүй төлбөр бол шууд бус болуошгүй төлбөрийн жишээ юм. Энэ хэсэгт, шүүх эсвэл төрийн бусад эрхтэй байгууллагаас тогтоосон төлбөрийг болзошгүй хэмээн үзэхгүй байхаар заасан болно.

Ш410.10 Компани аудитын гэрээт ажлын төлөө болзошгүй төлбөрийг шууд эсвэл шууд бусаар ноогдуулж болохгүй.

Ш410.11 Дараах тохиолдолд, аудитын үйлчлүүлэгчид үзүүлсэн баталгаажуулалтын бус үйлчилгээний төлөө компани болзошгүй төлбөрийг шууд болон шууд бусаар ноогдуулж болохгүй: Үүнд:

- (a) Хэрэв санхүүгийн тайланд дүгнэлт өгч буй компани төлбөрийг оноож байгаа бөгөөд төлбөр нь тухайн компанийн хувьд материаллаг, эсвэл материллаг байх магадлалтай бол;
- (b) Аудитын ажлын томоохон хэсэгт оролцож буй сүлжээ компани болзошгүй төлбөрийг оноож байгаа бөгөөд тухайн компанийн хувьд материаллаг, эсвэл материллаг байх магадлалтай бол;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (в) Баталгаажуулалтын бус үйлчилгээний үр дүн болон төлбөрийн хэмжээ нь санхүүгийн тайлан дахь материаллаг дүнгийн аудиттай холбоотой ирээдүйн эсвэл одооны шүүнтунгаалтаас хамааралтай байх.

410.12A1 Болзошгүй төлбөрийн талаар аудитын үйлчлүүлэгчтэй ямар нэг тохиролцоо хийхийг компани эсвэл сүлжээ компанид Ш410.10-Ш410.11-р параграфын дагуу зөвшөөрдөггүй. Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлж байхад болзошгүй төлбөрийн тохиролцоо хийхийг хориглодоггүй ч гэсэн хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэх боломж байсаар байна.

410.12A2 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийн жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Төлбөрийн боломжит дүнгийн хүрээ.
- Холбогдох эрх бүхий байгууллага нь үр нөлөөнөөс хамааралтай болзошгүй төлбөрийн хэмжээг тодорхойлсон эсэх.
- Компанийн гүйцэтгэсэн ажлын зорилтот хэрэглэгчдэд зориулсан тодруулга ба цалин хөлс, урамшууллын суурь.
- Тухайн үйлчилгээний шинж чанар.
- Тухайн үйл явдал буюу ажил гүйлгээний санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө.

410.12A3 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:

- Баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй хүнээр компанийн гүйцэтгэсэн ажлыг хянуулах.
- Цалин хөлс, урамшууллын талаар үйлчлүүлэгчтэй урьдчилж бичгээр тохиролцох.

ХЭСЭГ 411

УРАМШУУЛАЛ БА ҮНЭЛГЭЭНИЙ БОДЛОГО

Танилцуулга

- 411.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 411.2 Компанийн урамгуулал ба үнэлгээний бодлого нь хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий зүйл

- 411.3A1 Тодорхой нэг аудитын үйлчлүүлэгчийн аудитад ажиллаж байгаа аудитын багийн гишүүнийг тухайн аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр үнэлж, зохих төлбөр эсвэл урамшуулал хүргээх тохиолдолд учрах хувийн ашиг сонирхлын аюул заналын түвшин нь дараах зүйлсээс хамаарна:
- (a) Урамшуулал буюу үнэлгээний хэдэн хувийг ийм үйлчилгээний борлуулалтад үндэслэн тогтоож байгаа хэмжээ;
 - (б) Тухайн хүний аудитын багт гүйцэтгэх үүрэг;
 - (в) Баталгаажуулалтын бус үйлчилгээний борлуулалт нь сурталчилгааны шийдвэрт нөлөөлдөг эсэх.
- 411.3A2 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээнд, дараахыг дурдаж болно. Үүнд:
- Уг хүний нөхөн олговорын төлөвлөгөө эсвэл үнэлгээний үйл явцыг өөрчлөх.
 - Ийм ажилтныг аудитын багаас гаргах.
- 411.3A3 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд аудитын багийн гишүүний ажлыг нягталдаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.
- Ш411.4 Партнерийн аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээг борлуулсан амжилтад нь үндэслэн аудитын гол партнерийг үнэлэх эсвэл урамшуулал олгох ёсгүй. Энэ шаардлагаар, компанийн партнерүүдийн хооронд ашиг хуваадаг ердийн тохиролцоог хориглохгүй болно.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 420

БЭЛЭГ БА ДАЙЛЛАГА

Танилцуулга

- 420.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 420.2 Аудитын үйлчлүүлэгчээс бэлэг, дайллага хүлээн авах нь хувийн ашиг сонирхлын, танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

- Ш420.3** Компани, сүлжээ компани эсвэл аудитын ажлын багийн гишүүн хүн аудитын үйлчлүүлэгчээс үнэ цэнэ нь илт ялимгүй байхаас бусад тохиолдолд, ямар ч бэлэг авч, дайлуулж болохгүй.
- 420.3A1 Компани, сүлжээ компани эсвэл аудитын ажлын багийн гишүүн хүн нь аудитын үйлчлүүлэгчид урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах тохиолдолд, Хэсэг 340-д дурдсан шаардлага ба ашиглах материалыг мөрдөх ба эдгээр шаардлагад үл нийцсэн үйлдэл хийвэл хараат бус байдалд аюул занал учирч болзошгүй.
- 420.3A2 Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахтай холбоотой Хэсэг 340-ийн шаардлагад, ялимгүй үнэ цэнэтэй ч зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зоригтой тийм бэлэг, дайллагыг хүлээн авахыг компани, сүлжээ компани эсвэл аудитын ажлын багийн гишүүнд зөвшөөрдөггүй.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 430

БОДИТ ЭСВЭЛ БОЛЗОШГҮЙ ЗАРГА МАРГААН

Танилцуулга

- 430.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 420.2 Аудитын үйлчлүүлэгчтэй холбоотой зарга үүссэн, эсвэл үүсэх магадлалтай бол, хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул занал учирч болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 430.3A1 Үйлчлүүлэгчийн удирдлага ба аудитын багийн гишүүдийн хоорондох харилцаа нь үйлчлүүлэгч бизнесийн үйл ажиллагаагаа бүхэлд нь хэр ил тод, илэн далангүй илэрхийлж байгаагаар тодорхойлогдох ёстой. Аудитын үйлчлүүлэгч ба компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүний хоорондох бодит эсвэл болзошгүй заргын улмаас тэдний дунд эсрэг тэсрэг буюу сөргөлдөгч байр суурь үүсэж болзошгүй. Ийм сөргөлдөгчийн байр суурь нь удирдлагын бүрэн тодруулга хийх хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлж, хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэдэг.
- 430.3A2 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийн жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Зарга маргааны материаллагийн түвшин.
 - Тухайн зарга маргаан нь өмнөх аудитын гэрээт ажилтай холбоотой эсэх.
- 430.3A3 Хэрэв зарга маргаанд аудитын ажлын багийн гишүүн оролцсон бол хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээ бол тухайн хүнийг аудитын ажлын багаас гаргах явдал юм.
- 430.3A4 Хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд гүйцэтгэсэн ажлыг нягталдаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 510

САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХОЛ

Танилцуулга

- 510.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 510.2 Аудитын үйлчлүүлэгчтэй санхүүгийн сонирхлоор холбоотой байх нь хувийн сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 510.3A1 Санхүүгийн ашиг сонирхлыг шууд эсвэл хамтын хөрөнгө оруулалтын хэрэглүүр, эд хөрөнгө, итгэмжлэл зэрэг зуучлалаар дамжуулан шууд бусаар эзэмших боломжтой. Ашиг хүртэх өмчлөгч нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэглүүрийг хянадаг, эсвэл хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх чадамжтай байвал ийм санхүүгийн ашиг сонирхлыг Ёс зүйн дүрэмд шууд сонирхол хэмээн тодорхойлсон болно. Эсрэгээр, ашиг хүртэх өмчлөгч нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэглүүрийг хянадаггүй, хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх чадамжгүй бол ийм санхүүгийн сонирхлыг шууд бус хэмээн энэ Дүрэмд тодорхойлсон байна.
- 510.3 A2 Энэ хэсэгт санхүүгийн ашиг сонирхолын "материаллаг байдал"-ыг авч үзсэн болно. Ашиг сонирхол нь тухайн хүний хувьд материаллаг эсэхийг тодорхойлохдоо, тухайн хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзаж болох юм.
- 510.3 A3 Аудитын үйлчлүүлэгчтэй санхүүгийн ашиг сонирхолтой болсноор үүссэн хувийн сонирхлын аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлүүдэд дараах орно:
- Санхүүгийн сонирхол бүхий этгээдийн үүрэг оролцоо.
 - Санхүүгийн сонирхол нь шууд ба шууд бусын алин болох.
 - Санхүүгийн сонирхлын материаллаг байдал.

Компани, Сүлжээ Компани, Аудитын Багийн Гишүүд болон Бусад Хүмүүсийн Эзэмшиж байгаа Санхүүгийн Хувь Оролцоо

Ш510.4 Дараах этгээд нь Ш510.5-р зүйлийн дагуу санхүүгийн аудитын үйлчлүүлэгчээс шууд болон шууд бусаар санхүүгийн хувь оролцоо эзэмшиж болохгүй:

- (a) Компани эсвэл сүлжээ компани;
- (b) Аудитын багийн гишүүн эсвэл түүний ам бүлийн гишүүн;
- (в) Гэрээт ажлын партнер нь аудитын гэрээт ажил эсвэл тэрхүү бусад партнерийн ам бүлийн гишүүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулж буй бусад партнер; эсвэл
- (г) Партнер эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүний оролцоо бага байхаас бусад тохиолдолд, аудитын үйлчлүүлэгчид аудитын бус үйлчилгээ үзүүлдэг бусад партнер эсвэл удирдах ажилтан.

510.4A1 Аудитын гэрээт ажилтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг гэрээт ажлын партнерийн ажлын байр нь заавал тухайн партнерийн хариуцан гүйцэтгэдэг ажлын байр байх албагүй. Гэрээт ажлын партнер нь бусад аудитын багийн гишүүдээс өөр ажлын байранд ажилладаг бол тухайн партнерийн хариуцан гүйцэтгэдэг ажлын байрыг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт ашиглах нь зүйтэй.

Ш510.5 Дээрх Ш510.4-р параграфыг үл харгалзан, Ш510.4 (в), (г)-д тодорхойлсон ам бүлийн гишүүдийг дараах тохиолдолд аудитын үйлчлүүлэгчээс шууд эсвэл материаллаг хэмжээний шууд бус хувь эзэмшдэг хэмээн үзэж болох юм. Үүнд:

- (a) Гэр бүлийн гишүүд нь ажил эрхлэлтийн эрх, тухайлбал тэтгэвэр эсвэл хувьцааны опционы төлөвлөгөөний улмаас санхүүгийн ашиг хүлээн авсан бөгөөд шаардлагатай бол тухайн компани ийм хувь оролцооны улмаас үүссэн аюул заналыг тодорхойлдог;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (б) Гэр бүлийн гишүүд нь аль болох богино хугацаанд санхүүгийн хувь оролцоогоо худалдах эсвэл түүнээс татгалзах эрхтэй байх, эсвэл хувьцааны опционы тухайд тэрхүү эрхээ хэрэгжүүлэх эрхийг гэр бүлийн гишүүд эдэлдэг байх.

Аудитын Үйлчлүүлэгчийг Хянадаг Аж Ахуйн Нэгж дэх Санхүүгийн Хувь Оролцоо

Ш510.6 Аж ахуйн нэгж нь аудитын үйлчлүүлэгчид хяналтын хувь оролцоотой бөгөөд тухайн аудитын үйлчлүүлэгч нь уг аж ахуйн нэгжид материаллаг нөлөөтэй бол компани эсвэл сүлжээ компани, аудитын багийн гишүүн, тухайн хүний ам бүлийн гишүүдийн хэн нь ч тухайн аж ахуйн нэгжид шууд эсвэл материаллаг хэмжээний шууд бус санхүүгийн хувь оролцоотой байж болохгүй.

Итгэмжлэгчийн Хувьд Эзэмшдэг Санхүүгийн Хувь Оролцоо

Ш510.7 Аудитын үйлчлүүлэгч нь итгэмжлэлийн сангийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд компани, сүлжээ компани эсвэл хувь хүн нь уг санд итгэмжлэгчийн хувьд санхүүгийн хувь оролцоотой бол дараахаас бусад тохиолдолд дээрх Ш510.4-р параграфыг дагаж мөрдөх ёстой:

- (а) Итгэмжлэгч, гэрээт ажлын гишүүн эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн, компани эсвэл сүлжээ компанийн аль нь ч тухайн итгэмжлэлийн сангаас ашиг хүртэгч биш байх;
- (б) Итгэмжлэлийн сангаас хувь эзэмшдэг аудитын үйлчлүүлэгчийн хувь хэмжээ нь тухайн сангийн хувьд материаллаг бус байх;
- (в) Итгэмжлэлийн сан нь аудитын үйлчлүүлэгчид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжгүй байх;
- (г) Итгэмжлэгч, гэрээт ажлын гишүүн эсвэл тухайн хүний өөрийнх нь ам бүлийн гишүүн, компани эсвэл сүлжээ компанийн аль нь ч аудитын үйлчлүүлэгч дэх санхүүгийн хувь оролцоог хөндсөн хөрөнгө оруулалтын шийдвэрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжгүй байх.

Санхүүгийн Хувь Оролцоо нь Аудитын Үйлчлүүлэгчтэй Нийтлэг байх

Ш510.8 (а) Аудитын үйлчлүүлэгчийн санхүүгийн хувь оролцоо бүхий аж ахуйн нэгжид компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүн эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүд дараахаас бусад тохиолдолд мөн санхүүгийн хувь эзэмшиж болохгүй. Үүнд:

- (i) Санхүүгийн хувь оролцоо нь компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүн эсвэл тухайн хүний ам бүл болон аудитын үйлчлүүлэгчийн хувьд боломжийн хэрээр материаллаг бус байх;
 - (ii) Аудитын үйлчлүүлэгч нь уг аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чадахааргүй байх.
- (б) Ш510.8 (а) параграфт тодорхойлсон санхүүгийн хувь оролцоо бүхий хувь хүн аудитын багийн гишүүн болохоос өмнө уг хувь хүн эсвэл түүний ам бүлийн гишүүн дараах арга хэмжээний аль нэгийг авах ёстой:
- (i) Эзэмшиж буй хувь оролцоогоо зарж борлуулах; эсвэл
 - (ii) Үлдэж байгаа хувийг материаллаг биш байхуйц хэмжээний хувь оролцоогоо зарж борлуулах.

Санаандгүй Хүлээн Авсан Санхүүгийн Хувь Оролцоо

Ш510.9 Хэрэв компани, сүлжээ компани, тэдгээр компани эсвэл сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан, эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн нь аудитын үйлчлүүлэгчээс санхүүгийн шууд хувь оролцоо, эсвэл санхүүгийн шууд бус материаллаг хувь оролцоог нэгдэлт эсвэл түүнтэй адилтгах нөхцлийн үр дүнд үүссэн өв залгамжлал, бэлгийн хэлбэрээр хүлээн авсан бөгөөд ийм хувь оролцоо эзэмшихийг энэ бүлгийн дагуу хүлээн зөвшөөрөхөөргүй бол дараах алхмыг хийнэ:

- (а) Хэрэв компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүн эсвэл тухайн хүний ам бүлийн гишүүдээс ийм хувь оролцоо хүлээн авсан бол тэрхүү хувиа нэн даруй зарж борлуулах эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцоог хангалттай материаллаг бус хэмжээгээр зарж борлуулах;
- (б) (i) Хэрэв ийм хувь оролцоог аудитын багийн гишүүн биш хүн, эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн биш хүн хүлээн авсан бол ийм санхүүгийн хувь оролцоог аль болох ойрын хугацаанд зарж борлуулах эсвэл үлдэж байгаа хувь оролцоог материаллаг биш байхуйц хэмжээнд зарж борлуулах;
- (ii) Шаардлагатай тохиолдолд, санхүүгийн хувь оролцоогоо зарахаар зэхэж байх үедээ компани

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

үүссэн аюул заналыг тодорхойлох ёстой.

Санхүүгийн Хувь Оролцоо - Бусад Нөхцөл

Гэр Бүлийн Ойрын Гишүүн

- 510.10 A1 Баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл түүний ам бүлийн гишүүн, эсвэл компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчийн захирал, албан тушаалтан, хяналтын багц бүхий эзэмшигчийн аж ахуйн нэгжид мөн санхүүгийн хувь оролцоотой байх нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 510.10A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна:
- Тухайн хувь хүний аудитын багт гүйцэтгэдэг үүрэг.
 - Тухайн аж ахуйн нэгжийн өмчлөлийг хэр нягт эсвэл өргөн хүрээнд эзэмшиж байгаа.
 - Хувь оролцоо нь тухайн аж ахуйн нэгжийг хянах эсвэл мэдэгдэхүйц нөлөөлөх боломжийг хөрөнгө оруулагчид олгож байгаа эсэх.
 - Санхүүгийн хувь оролцооны материаллаг байдал.
- 510.10 A3 Ийм хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой хамгаалалтын арга хэмжээний жишээ бол санхүүгийн хувь эзэмшдэг тухайн хүнийг аудитын багаас чөлөөлөх явдал юм.
- 510.10 A4 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааны жишээ нь аудитын багийн гишүүний ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

Ойрын Гэр Бүл

- 510.10 A5 Аудитын ажлын багийн гишүүний гэр бүлийн ойрын гишүүн нь аудитын үйлчлүүлэгчтэй шууд санхүүгийн хувь оролцоотой эсвэл материаллаг хэмжээний шууд бус санхүүгийн хувь оролцоотой гэдгийг мэдэж байвал хувийн сонирхлын аюул занал үүсэж болзошгүй.
- 510.10 A6 Ийм аюул заналын далайцыг үнэлэх хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна. Үүнд:
- Аудитын ажлын багийн гишүүн ба түүний гэр бүлийн ойрын гишүүн хоорондын харилцаа холбооны шинж чанар;
 - Санхүүгийн хувь оролцоо нь шууд эсвэл шууд бусын алин болох.
 - Тухайн санхүүгийн хувь оролцоо нь гэр бүлийн ойрын гишүүний хувьд хэр материаллаг болох.
- 510.10 A7 Ийм хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгаж болох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Гэр бүлийн ойрын гишүүн нь санхүүгийн хувь оролцоогоо бүгдийг эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцооны үлдэх хэсгийг цаашид материаллаг гэж үзэхгүй байх хэмжээгээр зарж борлуулах.
 - Аудитын ажлын багаас тухайн хувь хүнийг чөлөөлөх.
- 510.10A8 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлоход чиглэсэн арга хэмжээний жишээ бол аудитын багийн гишүүний ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

Бусад Хувь Хүмүүс

- 510.10 A9 Хэрэв аудитын багийн гишүүн нь дараах хувь хүмүүс аудитын үйлчлүүлэгчтэй санхүүгийн хувь оролцоотой гэдгийг мэдэж байвал энэ нь хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй:
- Ш510.4-д дурдсан санхүүгийн хувь оролцоотой байхыг тусгайлан хориглосон хүмүүсээс тусад нь тодорхойлсон компани, сүлжээ компанийн партнер, мэргэжлийн ажилтнууд эсвэл тэдний ам бүлийн гишүүд;
 - Аудитын ажлын багийн гишүүнтэй хувийн дотно харилцаа холбоотой хувь хүмүүс
- 510.10A10 Ийм аюул заналын далайцыг үнэхэлэд хамааралтай дараах хүчин зүйлс байна:
- Компанийн зохион байгуулалтын, үйл ажиллагааны болон тайлагналын бүтэц;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Аудитын багийн гишүүн ба тухайн хувь хүн хоорондын харилцаа холбооны шинж чанар.
- 510.10A11 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол аудитын ажлын багаас хувийн харилцаа холбоо бүхий гишүүнийг чөлөөлөх явдал юм.
- 510.10A12 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг оруулдаг:
- Аудитын гэрээт ажлын талаар чухал шийдвэр гаргахдаа аудитын багийн тухайн гишүүнийг оролцуулахгүй байх.
 - Аудитын ажлын багийн тухайн гишүүний ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

Компани эсвэл Сүлжээ Компанийн Тэтгэвэр Тэтгэмжийн Төлөвлөгөө

- 510.10A13 Компани эсвэл сүлжээ компанийн тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөөнд аудитын үйлчлүүлэгчийн шууд болон шууд бус материаллаг санхүүгийн хувь оролцоотой байвал энэ нь хувийн ашиг сонирхлын аюул үүсгэж болзошгүй.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 511

ЗЭЭЛ БА БАТАЛГАА

Танилцуулга

- 511.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 511.2 Аудитын үйлчлүүлэгчтэй зээл эсвэл зээлийн баталгааны талаар холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 511.3A1 Энэ хэсэгт зээл ба зээлийн баталгааны "материаллаг байдал"-ыг авч үзсэн болно. Зээл ба зээлийн баталгаа нь хувь хүний хувьд материаллаг эсэхийг тодорхойлохдоо, тухайн хувь хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Аудитын Үйлчлүүлэгчтэй Хийсэн Зээл ба Баталгаа

- Ш511.4** Зээл эсвэл зээлийн баталгаа нь дараах этгээдүүдэд материаллаг бус байхаас бусад тохиолдолд компани, сүлжээ компани, аудитын ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нь ч аудитын үйлчлүүлэгчид зээл эсвэл зээлийн баталгаа гаргах ёсгүй.
- (а) Зээл эсвэл зээлийн баталгаа гаргаж байгаа компани, сүлжээ компани эсвэл хувь хүний аль тохирох;
- (б) Үйлчлүүлэгч.

Банк, Түүнтэй Ижил Төстэй Байгууллага болох Аудитын Үйлчлүүлэгчтэй Холбоотой Зээл ба Зээлийн Баталгаа

- Ш511.5** Банк ба түүнтэй ижил төстэй байгууллага болох аудитын үйлчлүүлэгчээс компани, сүлжээ компани, аудитын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь зээл авах эсвэл зээлийн баталгаа гаргуулж үл болно.
- 511.5 A1 Зээлийн жишээнд, моргэйж, банкны овердрафт, автомашины зээл ба зээлийн картан үлдэгдэл зэргийг оруулдаг.
- 511.5 A2 Банк ба түүнтэй ижил төстэй байгууллага болох аудитын үйлчлүүлэгчээс компани, сүлжээ компани нь зээл олгох ердийн горим, нөхцөл ба болзлын дагуу зээл авсан ч гэсэн ийм зээл нь аудитын үйлчлүүлэгч эсвэл зээл авч байгаа компанийн хувьд материаллаг ач холбогдолтой бол хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй.
- 511.5 A3 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол сүлжээ компаниас зээл хүлээн авагч бус, мөн аудитын багийн гишүүн биш хүнээр хийсэн ажлыг нь зохих ёсоор хянан шалгуулах явдал юм.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Хадгаламж эсвэл Брокерын Данс

Ш511.6 Банк, боркер ба түүнтэй ижил төстэй байгууллага болох аудитын үйлчлүүлэгчээс компани, сүлжээ компани, аудитын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь хадгаламж эсвэл дансыг арилжааны ердийн нөхцөлөөр эзэмшиж байхаас бусад тохиолдолд хадгаламж, эсвэл брокерын данстай байж болохгүй.

Банк, Түүнтэй Ижил Төстэй Байгууллага биш Аудитын Үйлчлүүлэгчтэй Холбоотой Зээл ба Зээлийн Баталгаа

Ш511.7 Зээл эсвэл зээлийн баталгаа нь дараах этгээдүүдэд материаллаг бус байхаас бусад тохиолдолд, банк ба түүнтэй ижил төстэй байгууллага биш аудитын үйлчлүүлэгчээс компани, сүлжээ компани, аудитын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь зээл авах эсвэл зээлийн баталгаа гаргуулж үл болно:

- (а) Зээл эсвэл зээлийн баталгаа хүлээн авч байгаа компани, сүлжээ компани эсвэл хувь хүний аль тохирох;
- (б) Үйлчлүүлэгч.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Хэсэг 520

Бизнесийн Харилцаа Холбоо

Танилцуулга

- 520.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 520.2. Аудитын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлагатай бизнесийн ойр дотно харилцаа холбоотой байх нь хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 520.3 A1 Энэ хэсэгт санхүүгийн хувь оролцооны "материаллаг байдал" ба бизнесийн харилцаа холбооны "ач холбогдол"-ыг авч үзсэн болно. Хувь оролцоо нь тухайн хүнд материаллаг мөн эсэхийг тодорхойлохдоо, уг хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үзэж болно.
- 520.3 A2 Арилжааны харилцаа холбоо буюу санхүүгийн нийтлэг ашиг сонирхлоос үүсдэг бизнесийн ойр дотно харилцааны жишээнд дараахыг багтаана:
- Үйлчлүүлэгч эсвэл түүний хяналтын эрхтэй өмчлөгч, захирал, албан тушаалтан, тухайн үйлчлүүлэгчийн компанид дээд түвшний удирдах албан тушаал хашдаг бусад хувь хүнтэй хамт хамтарсан компанид санхүүгийн хувь эзэмшдэг;
 - Компани, сүлжээ компанийн нэг буюу түүнээс дээш тооны үйлчилгээ эсвэл бүтээгдэхүүнийг аудитын үйлчлүүлэгчийн нэг буюу түүнээс дээш тооны үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй нэгтгэж, багцлан хоёр талын нэр дээр зах зээлд гаргахаар тохиролцох;
 - Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх буюу зах зээлд гаргах, эсвэл аудитын үйлчлүүлэгч нь компани, сүлжээ компанийн бүтээгдэхүүн үйлчилгээг түгээх буюу зах зээлд гаргахаар тохиролцох.

Компани, Сүлжээ Компани, Аудитын Багийн Гишүүн эсвэл Ам Бүлийн Гишүүдийн Бизнесийн Харилцаа Холбоо

Ш520.4 Санхүүгийн ашиг сонирхол нь материаллаг бус бөгөөд тухайн бизнесийн харилцаа холбоо нь аудитын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлага болон компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүнд чухал ач холбогдолтой байхаас бусад тохиолдолд, компани, сүлжээ компани эсвэл аудитын багийн гишүүний хэнд нь ч аудитын үйлчлүүлэгчтэй бизнесийн ойр дотно харилцаа холбоо тогтоохыг хориглох ёстой.

520.4 A1 Аудитын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлага болон аудитын багийн гишүүний ам бүлийн гишүүний хооронд бизнесийн ойр дотно харилцаа холбоо байх нь хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй.

Адил Тэнцүү Эзэмшил бүхий Аж Ахуйн Нэгж дэх Нийтлэг Ашиг Сонирхол

Ш520.5 Компани, сүлжээ компани, аудитын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь дараахаас бусад тохиолдолд, аудитын үйлчлүүлэгч эсвэл түүний захирал эсвэл ажилтан эсвэл бүгд адил тэнцүү эзэмшдэг аж ахуйн нэгжид мөн хувь эзэмшдэг аж ахуйн нэгжтэй бизнесийн харилцаа холбоотой байх ёсгүй:

- (a) Тухайн бизнесийн харилцаа холбоо нь компани, сүлжээ компани, эсвэл тухайн хувь хүн болон аудитын үйлчлүүлэгчид онцын ач холбогдолгүй байх;
- (b) Тухайн хөрөнгө оруулагч эсвэл хөрөнгө оруулагчдын бүлгийн эзэмшиж байгаа санхүүгийн хувь оролцоо нь материаллаг биш;
- (b) Эзэмшиж байгаа санхүүгийн хувь оролцоо нь тухайн хөрөнгө оруулагч эсвэл хөрөнгө оруулагчдын бүлэгт адил тэнцүү эзэмшиж байгаа аж ахуйн нэгжийг хянах боломж олгохооргүй байгаа.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Бараа, Үйлчилгээ Худалдан Авах

- 520.6 A1 Компани, сүлжээ компани, аудитын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэгнээс бараа, үйлчилгээ худалдаж авах ажил гүйлгээ нь бизнесийн ердийн нөхцлөөр хийгдсэн бөгөөд холбоогүй талуудынх байвал ерөнхийдөө хараат бус байдалд аюул занал учруулдаггүй. Гэхдээ ийм ажил гүйлгээ нь хувийн ашиг сонирхлын аюул заналыг үүсгэхүйц шинж чанар, далайцтай байж болзошгүй.
- 520.6A2 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээнд дараахыг оруулж болно:
- Тухайн ажил гүйлгээг зогсоох эсвэл түүний цар хэмжээг багасгах;
 - Тухайн хувь хүнийг аудитын багаас чөлөөлөх.

ХЭСЭГ 521

ГЭР БҮЛИЙН БОЛОН ХУВИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО

Танилцуулга

- 521.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 521.2. Аудитын үйлчлүүлэгчийн ажилтнуудтай тогтоосон гэр бүлийн эсвэл хувийн харилцаа холбоо нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 521.3 A1 Аудитын багийн гишүүн ба аудитын үйлчлүүлэгчийн захирал, эсвэл гүйцэтгэх үүргээс хамааран зарим албан тушаалтан, ажилтнуудын хооронд гэр бүлийн ба хувийн харилцаа холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 521.3 A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:
- Аудитын багт тухайн хувь хүний хариуцаж буй ажил үүрэг.
 - Аудитын үйлчлүүлэгчид гэр бүлийн гишүүн ба бусад хувь хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, уг харилцаа холбоо хэр ойр дотно байх.

Аудитын Багийн Гишүүний Ам Бүл

- 521.4A1 Аудитын багийн гишүүний ам бүлийн гишүүн нь үйлчлүүлэгчийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх түвшний албан тушаал эрхэлдэг бол хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүсдэг.
- 521.4A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:
- Ам бүлийн гишүүний хашиж байгаа албан тушаал.
 - Аудитын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.
- 521.4A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээ бол тухайн хувь хүнийг аудитын багаас чөлөөлөх явдал юм.
- 521.4A4 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн тухайн гишүүн нь өөрийн ам бүлийн гишүүний үүрэг хариуцлагад хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар аудитын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.
- Ш521.5** Аудитын багийн гишүүний ам бүлийн аль нэг гишүүн дараах албан тушаал хашдаг бол түүнийг аудитын багийн ажилд оролцуулах ёсгүй:
- (а) Аудитын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан;
 - (б) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, эсвэл аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.
 - (в) Гэрээт ажил эсвэл санхүүгийн тайлангийн хамарсан хугацаанд дээр дурдсан албан тушаал хашиж байсан бол.

Аудитын Багийн Гишүүний Ойрын Гэр Бүл

- 521.6A1 Аудитын багийн гишүүний ойрын гэр бүл нь дараах тохиолдолд хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэдэг:
- (а) Аудитын үйлчлүүлэгчийн захирал буюу ажилтан;
 - (б) Үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бүртгэл, эсвэл аудитын компанийн дүгнэлт гаргах гэж

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.

- 521.6A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Аудитын багийн гишүүн ба түүний гэр бүлийн ойрын гишүүний хоорондох харилцаа холбооны шинж чанар.
 - Гэр бүлийн ойрын гишүүний хашдаг албан тушаал.
 - Аудитын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.
- 521.6 A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол аудитын ажлын багаас тухайн гишүүнийг чөлөөлөх явдал юм.
- 521.6 A4 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн тухайн гишүүн нь гэр бүлийн ойрын гишүүний үүрэгт хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар аудитын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.

Аудитын Багийн Гишүүний Бусад Ойр Дотнын Харилцаа Холбоо

- Ш521.7** Хэрэв аудитын багийн гишүүн нь түүний ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн биш боловч дараах албан тушаал хашдаг этгээдтэй ойр дотны харилцаа холбоотой бол тэрээр өөрийн компанийн бодлого, горим журамд нийцүүлэн үүнийг авч үзэх хэрэгтэй:
- (а) Аудитын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан;
- (б) Үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, эсвэл аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.
- 521.7A1 Ийм харилцаа холбооны үр дүнд үүссэн хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Тухайн хувь хүн ба аудитын багийн гишүүний хоорондох харилцаа холбооны шинж чанар.
 - Аудитын үйлчлүүлэгчид тухайн хувь хүний хашдаг албан тушаал.
 - Аудитын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.
- 521.7 A2 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол аудитын ажлын багаас тухайн гишүүнийг чөлөөлөх явдал юм.
- 521.7 A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн тухайн гишүүн нь өөрийнхөө ойр дотно харилцаатай байдаг тухайн хувь хүний үүрэг хариуцлагад хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар аудитын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.

Компанийн Партнер ба Ажилтнуудын Харилцаа Холбоо

- Ш521.8** Компанийн партнер ба ажилтнууд дараах хүмүүсийн хоорондох хувийн эсвэл гэр бүлийн харилцааны талаар мэдсэн бол тэрээр өөрийн компанийн бодлого, горим журамд нийцүүлэн үүнийг авч үзэх хэрэгтэй:
- (а) Компани, сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан боловч тухайн аудитын багийн гишүүн биш хүн;
- (б) Аудитын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан, эсвэл нягтлан бодох бүртгэл хөтлөлт, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.
- 521.8 A1 Ийм харилцаанаас үүссэн хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:
- Компанийн партнер эсвэл ажилтан ба үйлчлүүлэгчийн захирал, албан тушаалтан эсвэл ажилтны хоорондох харилцаа холбооны шинж чанар.
 - Компанийн партнер эсвэл ажилтаны аудитын багтай харилцан хамтрах түвшин.
 - Партнер эсвэл ажилтны тухайн компанид хашиж буй албан тушаал.
 - Үйлчлүүлэгчийн дотор хашиж байгаа тухайн хувь хүний албан тушаал.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

521.8 А2 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараахыг оруулна:

- Аудитын гэрээт ажилд нөлөөлөх аливаа боломжийг багасгахын тулд партнер эсвэл ажилтны ажил үүргийг хуваарилах.
- Гүйцэтгэсэн аудитын ажлыг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх.

ХЭСЭГ 522

АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД СҮҮЛИЙН ҮЕД АЛБА ХАШСАН БАЙДАЛ

Танилцуулга

- 522.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 522.2 Хэрэв аудитын багийн гишүүн нь сүүлийн үед аудитын үйлчлүүлэгч байгууллагад захирал эсвэл албан ташуултан эсвэл түүний ажилтнаар ажиллаж байсан бол хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

Аудитын Тайланд Хамрагдсан Хугацаанд Албан Хашсан Байдал

- Ш522.3** Аудитын багт, аудитын тайланд хамрагдсан хугацааны туршид дараах үйлчилгээ үзүүлж байсан хүмүүсийг оруулах ёсгүй. Үүнд:
- (а) Аудитын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл өөр албан тушаал эрхэлж байсан;
 - (б) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байсан ажилтан.

Аудитын Тайланд Хамрагдсан Хугацаанаас Өмнө Алба Хашсан Байдал

- 522.4 А1 Хэрэв аудитын тайланд хамрагдсан хугацаанаас өмнө аудитын багт гишүүн дараах алба хашиж байсан бол хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул занал үүсэж болзошгүй. Үүнд:
- (а) Аудитын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл өөр албан тушаал эрхэлж байсан;
 - (б) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байсан ажилтан.
- Жишээлбэл, хэрэв дурдаж байгаа өмнөх хугацаанд уг аудитын үйлчлүүлэгч байгууллагад ажиллаж байхдаа тухайн хувь хүний гаргасан шийдвэр эсвэл гүйцэтгэсэн ажлыг тайлант үеийн аудитын гэрээт ажлын нэг хэсэг болгож одоо үнэлэх гэж байгаа бол энэ нь дээрх аюул заналыг үүсгэнэ.
- 522.4 А2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Үйлчлүүлэгч байгууллагад тухайн хүний хашиж байсан албан тушаал;
 - Тухайн хувь хүн үйлчлүүлэгч байгууллагад ажиллахаа больсноос хойш өнгөрсөн хугацаа;
 - Аудитын ажлын багт тухайн хувь хүний гүйцэтгэдэг үүрэг.
- 522.4 А3 Хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн гишүүний гүйцэтгэсэн ажлыг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх явдал юм.

ХЭСЭГ 523

АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ЗАХИРАЛ, АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Танилцуулга

- 523.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 523.2. Аудитын үйлчлүүлэгч байгууллагад захирал эсвэл албан тушаалтнаар ажилласан байх нь өөрийгөө хянах болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг бий болгодог. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Захирал эсвэл Албан Тушаалтнаар Ажилладаг Байх

- Ш523.3** Компани, сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан нь уг компанийн аудитын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл албан тушаалтнаар ажиллаж болохгүй.

Компанийн Нарийн Бичгийн Даргын Алба Хаших

- Ш523.4** Дараахаас бусад тохиолдолд, компани, сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан нь уг компанийн үйлчлүүлэгч байгууллагын нарийн бичгийн даргын албыг хаших ёсгүй:

- (а) Ийм практикийг дотоодын хууль тогтоомж, мэргэжлийн дүрэм журам, эсвэл үйл ажиллагааны практикт тусгайлан зөвшөөрсөн;
- (б) Удирдлага нь холбогдох бүх шийдвэрийг гаргадаг;
- (в) Гүйцэтгэдэг албан үүрэг ба үйл ажиллагаа нь ярианы тэмдэглэл бэлтгэх, албан бичиг хөтлөлт хийх зэрэг байнга давтагддаг бөгөөд захиргааны шинжтэй үүргээр хязгаарлагддаг бол.

- 523.4 А1 Компанийн нарийн бичгийн даргын албан тушаал нь хууль эрх зүйн янз бүрийн орчинд мөн өөр өөр шинжтэй байдаг. Энэ ажил үүрэг нь хүний нөөцийг удирдах ба компанийн бичиг баримтын бүртгэлийг хөтлөх зэрэг захиргааны үүргээс эхлээд компанид хууль тогтоомжийг мөрдөн сахиулах буюу компанийн засаглалын асуудлаар зөвлөгөө өгөх хүртэлх олон талтай үүрэгт ажил байж болно. Энэ албан тушаал ихэвчлэн тухайн байгууллагын үйл ажиллагаатай илүү нягт уялдаатай байдлыг илэрхийлдэг. Тиймээс, компани эсвэл сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан нь аудитын үйлчлүүлэгчийн компанийн нарийн бичгийн даргаар ажилладаг бол аюул занал үүснэ. (Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээг үзүүлэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хэсэг 600, *Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээг үзүүлэх*-д тодорхойлсон болно.)

ХЭСЭГ 524

АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД АЖИЛ ЭРЛЭХ

Танилцуулга

- 524.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 524.2. Аудитын үйлчлүүлэгчтэй ажил эрхлэлтийн талаар холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 524.3 A1 Доор дурдсан этгээдийн хэн нэг нь аудитын багийн гишүүн эсвэл компани, сүлжээ компанийн партнер бол танил талын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэж болзошгүй:
- Аудитын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл албан тушаалтан.
 - Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бүртгэл, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлдэг ажилтан.

Өмнөх Партнер эсвэл Аудитын Багийн Гишүүнд Тавих Хязгаарлалт

Ш524.4 Компани эсвэл сүлжээ компани ба доор дурдсан этгээдийн хооронд чухал ач холбогдол бүхий харилцаа холбоо үлдээгүй гэдгийг тухайн компани бататгах ёстой:

- (a) Тухайн компанийн аудитын үйлчлүүлэгч болсон өмнөх буюу хуучин партнер;
- (b) Аудитын үйлчлүүлэгч болоод байгаа хүн өмнө нь аудитын багийн гишүүн байсан хүмүүсийн хэн хэн нь аудитын үйлчлүүлэгч болох үед дараах алба хашиж байвал:
 - (i) Захирал эсвэл албан тушаалтан;
 - (ii) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлдэг ажилтан.

Дараахаас бусад тохиолдолд компани эсвэл сүлжээ компани ба дараах этгээдийн хоорондох чухал ач холбогдол бүхий харилцаа холбоо хэвээр үргэлжилж байна хэмээн үзнэ:

- (a) Урьдчилан тодорхойлсон тохиролцооны дагуу хийгдээгүй аливаа ашиг/ урамшуулал, төлбөрийг тухайн хувь хүн компаниас авах эрхгүй байх тохиролцоо;
- (b) Тухайн хувь хүнд өгөх ёстой төлбөрийн дүн нь компанид материаллаг бус байхаар хийсэн тохиролцоо;
- (в) Тухайн хувь хүн нь компани, сүлжээ компанийн бизнес буюу мэргэжлийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцохгүй байх.

524.4 A1 Хэдийгээр Ш524.4-р параграфын шаардлага хангагдсан ч гэсэн танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал байсаар байх боломжтой.

524.4 A2 Хэрэв компани, сүлжээ компанийн өмнөх партнер 524.3A1-р параграфт заасан албан тушаалын аль нэгийг хашиж, улмаар тухайн аж ахуйн нэгж нь компанийн аудитын үйлчлүүлэгч болсон байвал бол танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэж болзошгүй.

524.4A3 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараах багтана:

- Үйлчлүүлэгч байгууллагын хувьд тухайн хувь хүний хашиж байгаа албан тушаал.
- Тухайн хувь хүнийн зүгээс аудитын багийн ажилд оролцох байдал.
- Тухайн хувь хүн аудитын багийн гишүүн эсвэл компани, сүлжээ компанийн партнер байснаас хойш өнгөрсөн хугацаа.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Аудитын баг, компани, сүлжээ компанид тухайн хувь хүний хашиж байсан хуучин албан тушаал. Жишээлбэл, тухайн хувь хүний ажил үүрэгт үйлчлүүлэгчийн удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай тогтмол холбоотой байх хэрэгцээ шаардлага байсан эсэх.

524.4A4 Танилын эсвэл айлган сүрдүүлэх ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Аудитын төлөвлөгөөг өөрчлөх.
- Аудитын үйлчлүүлэгч болсон хувь хүнтэй харьцах талаар хангалттай туршлага бүхий хүмүүсийг аудитын багт томилох.
- Аудитын багийн өмнөх гишүүний гүйцэтгэсэн ажлыг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх.

Үйлчлүүлэгч Байгууллагад Ажил Эрхлэхээр Тохиролцсон Аудитын Багийн Гишүүд

Ш524.5 Компани, сүлжээ компани нь ажил эрхлэлтийн талаар аудитын үйлчлүүлэгчидтэй аудитын багийн гишүүд гэрээ хэлцэл хийхдээ энэ талаар компани, сүлжээ компанидаа мэдэгдэхийг шаарддаг бодлого, горимтой байна.

524.4 A1 Аудитын багийн гишүүн ирээдүйд үйлчлүүлэгч байгууллагад ажилд орох эсвэл орж болзошгүй талаар мэдэж байх үедээ уг аудитын ажилд аудитын багийн гишүүн оролцож байгаа тохиолдолд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсдэг.

524.5 A2 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол тухайн хувь хүнийг аудитын багаас чөлөөлөх явдал юм.

524.5 A3 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний нэг жишээ бол, тухайн хүн багт ажиллаж байхдаа гаргасан нөлөө бүхий шийдвэрийг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх явдал юм.

Нийтийн Ашиг Сонирхол бүхий Аудитын Үйлчлүүлэгч

Аудитын Гол Партнер

Ш524.6 Ш524.8-д дурдсаны дагуу, хэрэв аудитын гол партнер болох хувь хүн нь нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгж болох үйлчлүүлэгчид доор дурдсан албан тушаал эрхлэхээр ажилд орсон бол танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүснэ:

- (а) Тухайн байгууллагын захирал эсвэл албан тушаалтан;
- (б) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлдэг ажилтан.

Тухайн хувь хүн цаашид аудитын гол партнер байхаа больсоны дараа, доор дурдсанаас бусад тохиолдолдхараат бус байдал алдагдана:

- (i) Тухайн түнш аудитын гол түнш байхаа больсон үеэс хойш нийтийн сонирхол бүхий компани нь 12 сараас багагүй хугацааг хамарсан, аудитлагдсан санхүүгийн тайлангаа гаргасан;
- (ii) Тухайн хувь хүн нь дээрх санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой аудитын багийн гишүүн биш байсан.

Компанийн ахлах буюу удирдах түвшний партнер (Гүйцэтгэх Захирал буюу түүнтэй адилтгах)

Ш524.7 Ш524.8-д дурдсаны дагуу, хэрэв компанийн ахлах буюу удирдах түвшний партнер (Гүйцэтгэх Захирал буюу түүнтэй адилтгах) байсан хувь хүн нь нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгж болох үйлчлүүлэгчид:

- (а) Тухайн байгууллагын захирал эсвэл албан тушаалтан;
- (б) Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан бэлтгэхэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлдэг ажилтанаар орсон бол, тухайн хувь хүн компанийн ахлах буюу удирдах түвшний партнер (Гүйцэтгэх Захирал буюу түүнтэй адилтгах) байснаас хойш арван хоёр сар өнгөрөөгүй бол хараат бус байдал алдагдана.

Бизнесийн Нэгдэл

Ш524.8 Ш524.6, Ш524.7-р параграфт зааснаас бусад тохиолдолд, хэрэв эдгээр параграфт дурдсан нөхцөл нь

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

бизнесийн нэгдлийн үр дүнд үүссэн бол хараат бус байдал алдагдахгүй бөгөөд:

- (a) Бизнесийн нэгдэлтэй холбоотойгоор тухайн албан тушаалыг аваагүй;
- (б) Урьдчилан тодорхойлсон тохиролцооны дагуу хийгдсэн бөгөөд тухайн хувь хүнд өгөх ёстой төлбөр нь компани, сүлжээ компанид материаллаг бус байхаас бусад тохиолдолд, компани, сүлжээ компаниас өмнөх партнерт өгөх аливаа ашиг, урамшуулал, төлбөрийг бүрэн барагдуулсан;
- (в) Өмнөх партнер нь компани, сүлжээ компанийн бизнес буюу мэргэжлийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцохгүй байх.
- (г) Компани нь өмнөх партнерийн үйлчлүүлэгч байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын талаар засаглах эрхтэй удирдлагатай ярилцаж хэлэлцсэн.

ХЭСЭГ 525

АЖИЛТАНУУДЫН ТҮР ТОМИЛГОО

Танилцуулга

- 525.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 525.2. Аудитын үйлчлүүлэгчид ажилтнуудаа ажиллуулах нь өөрийгөө хянах, өмгөөллийн болон танилын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 525.3 A1 Компани, сүлжээ компаниас өөрийн ажилтнуудаа аудитын үйлчлүүлэгч компанид ажиллуулснаар үүссэн аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Түр ажиллуулсан ажилтны гүйцэтгэсэн ажлыг хянах нэмэлт хяналтын ажил явуулах;
 - Түр ажиллуулахаар томилсон ажилтнуудыг аудитын ажлын багийн гишүүнд оруулахгүй байх нь танилын эсвэл өмгөөллийн аюул занал үүсгэж болзошгүй.
 - Түр ажиллах томилгооны явцад тухайн ажилтны гүйцэтгэсэн чиг үүрэг, үйл ажиллагааных нь төлөө түүнд аудитын үүрэг хариуцлага оногдуулахгүй байх нь өөрийгөө хянах аюул занал үүсгэж болзошгүй.
- 525.3A2 Компани, сүлжээ компаниас өөрийн ажилтнуудаа аудитын үйлчлүүлэгч компанид ажиллуулснаар, уг компани, сүлжээ компани нь удирдлагын үзэл бодол, ашиг сонирхолтой хэт уялдаатай болох танилын ба өмгөөллийн аюул занал үүсэх бөгөөд энэ тохиолдолд ямар ч хамгаалалтын арга хэмжээ авах боломжгүй байна.
- Ш525.4** Компани, сүлжээ компани нь дараахаас бусад тохиолдолд, аудитын үйлчлүүлэгчид өөрийн ажилтнаа түр ажиллуулж болохгүй:
- (a) Ийм туслалцааг зөвхөн богино хугацаанд үзүүлэх;
 - (б) Хэсэг 600 болон түүний дэд хэсэгт заасны дагуу хүлээн зөвшөөрөхгүй байх баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхэд тухайн ажилтан оролцдоггүй;
 - (в) Тухайн түр ажилтнууд удирдлагын үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд аудитын үйлчлүүлэгч нь эдгээр ажилтнуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ба хянах үүрэгтэй байх.

ХЭСЭГ 540

АЖИЛТНУУД (ПАРТНЕРИЙН СЭЛГЭЭ) БА АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХООРОНДЫН УДААН ХУГАЦААНЫ ХАРИЛЦАА

Танилцуулга

- 540.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 540.2. Аудитын гэрээт ажилд оролцдог аливаа хувь хүн удаан хугацааны турш ийнхүү дахин ажиллах нь танилын болон хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 540.3A1 Хэдийгээр аудитын үйлчлүүлэгч, түүний хүрээлэн буй орчны талаар ойлголттой байх нь аудитын чанарт чухал боловч аудитын багийн гишүүний хувьд тухайн хүн урт хугацаанд дараах этгээдтэй хамтран ажилласнаар танилын аюул занал үүсэж болзошгүй:
- (а) Аудитын үйлчлүүлэгч ба түүний үйл ажиллагаа;
 - (б) Аудитын үйлчлүүлэгчийн ахлах түвшний удирдлага; эсвэл
 - (в) Аудитын компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан бэлтгэх үндэс суурийг бүрдүүлэгч эсвэл санхүүгийн мэдээлэл.
- 540.3 A2 Урт хугацаанд хамтарч байгаа үйлчлүүлэгчээ алдах бий гэсэн болгоомжлол, эсвэл ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй этгээдтэй тогтоосон хувийн дотно харилцаагаа хадгалж үлдэх сонирхлын үр дүнд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болно. Ийм аюул занал нь тухайн хувь хүний шүүн тунгаалтад зүй бусаар нөлөөлөх боломжтой.
- 540.3 A3 Танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна:
- (а) Тухайн хүний хувьд:
 - Аудитын үйлчлүүлэгчтэй тухайн хувь хүний тогтоосон харилцаа холбооны үргэлжилсэн хугацаа, үүнд тухайн хүн өмнөх аудитын компанид байх үед ийм харилцаа мөн байсан эсэх.
 - Тухайн хувь хүн аудитын гэрээт ажлын багийн гишүүнээр хэр удаан хугацаанд ажилласан болон гүйцэтгэж байсан үүрэг.
 - Тухайн хувь хүний ажлыг илүү дээгүүр түвшний ажилтан чиглүүлж, хянан шалгаж, дүгнэж байсан цар хүрээ.
 - Тухайн хүн өөрийн албан тушаалын зэрэг зиндаанд дулдуйдан, гол шийдвэр гаргах, эсвэл бусад гэрээт ажлын багийн гишүүдийн ажлыг чиглүүлэх зэргээр аудитын үр дүнд нөлөөлөх боломжийн цар хүрээ.
 - Ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрх мэдэл бүхий этгээдтэй хувь хүний тогтоосон харилцаа нь хэр ойр дотно болох.
 - Тухайн хувь хүн ба ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрх мэдэл бүхий этгээдийн хоорондох харилцан хамаарлын мөн чанар, давтамж, далайц.
 - (б) Аудитын үйлчлүүлэгчийн хувьд:
 - Үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын асуудлын шинж чанар, нарийн төвөгтэй байдал.
 - Сүүлийн үед, ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд өөрчлөгдсөн эсэх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Тухайн хувь хүн ба ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрх мэдэл бүхий этгээдийн хооронд байж болох харилцан үйлчлэлийн мөн чанар, давтамж, далайцад нөлөөлдөг бүтцийн өөрчлөлт уг үйлчлүүлэгчийн байгууллагад гарсан эсэх.

540.3 А4 Хоёр буюу хэд хэдэн хүчин зүйлс нийлж гарснаар аюул заналын түвшин нэмэгдэх эсвэл буурах боломжтой. Жишээлбэл, хувь хүн ба үйлчлүүлэгчийн ахлах түвшний удирдлагын хоорондох удаан хугацааны ойр дотно харилцаагаар үүссэн танилын аюул заналыг үйлчлүүлэгчийн уг ахлах түвшний удирдлагыг ажлаас чөлөөлснөөр бууруулж болно.

540.3 А5 Тухайн нэг хүн удаан хугацааны турш аудитын гэрээт ажилд оролцсоны улмаас үүссэн танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол тухайн хүнийг аудитын гэрээт ажлаас эргэцийн дагуу сэлгэн ажиллуулах явдал юм.

540.3 А6 Танилын болон хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Аудитын баг дахь тухайн хувь хүний үүрэг эсвэл уг хүний гүйцэтгэдэг ажил үүргийн мөн чанар, далайцыг өөрчлөх.
- Аудитын багийн гишүүн бус өөр тохирох хянан шалгагчаар уг хүний ажлыг хянан шалгуулах.
- Гэрээт ажлын чанарыг хараат бус гадаад болон дотоод шалгалтаар тогтмол хянан нягтлах.

Ш540.4 Зөвхөн аудитын багийн гишүүдийг сэлгэн ажиллуулснаар үүссэн аюул заналыг тодорхойлох боломжтой хэмээн компани шийдсэн бол, тэрээр ямар хугацаанд тухайн хүнийг дараах үйлдлээс хориглохыг тодорхойлох ёстой. Үүнд:

- (a) Аудитын гэрээт ажлын багийн гишүүн байх;
- (б) Аудитын гэрээт ажилд чанарын хяналт тавих; эсвэл
- (в) Аудитын гэрээт ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлэх.

Дээрх хугацаа нь танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлоход хангалттай байх ёстой. Нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгжийн хувьд, Ш540.5-Ш540.20-р параграфыг мөн дагаж мөрдөнө.

Аудитын Үйлчлүүлэгч нь Нийтийн Ашиг Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж байх

Ш540.5 Нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгжийн аудитын хувьд, Ш540.7-Ш540.9-р параграфын дагуу, аливаа хувь хүн нь доор дурдсан үүргүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдийг нийтдээ 7 жилээс дээш хугацаанд гүйцэтгэх ёсгүй ("байх хугацаа" / time-on period):

- (a) Гэрээт ажлын партнер;
- (б) Гэрээт ажлын чанарын хянан шалгагчаар томилогдсон хувь хүн;
- (в) Бусад аудитын гол партнерийн хувьд гүйцэтгэдэг үүрэг.

Цагтаа байх хугацаа өнгөрсөний дараа, тухайн хувь хүн нь Ш540.11-Ш540.19-р параграфт заасан нөхцлийн дагуу "түр завсарлах" хугацааг хэрэгжүүлэх ёстой.

Ш540.6 Байх хугацааг тооцохдоо, тухайн хувь хүн нь Ш540.5(а)-(в)-д заасан үүргүүдийн аль нэгийг хамгийн бага хугацаанд гүйцэтгэхээ зогсоосноос бусад тохиолдолд, жилүүдийн тооллыг дахин эхлүүлж болохгүй. Энд дурдсан хамгийн бага хугацаа гэдэг нь дор хаяж Ш540.11-Ш540.13-р параграфын дагуу тодорхойлсон Завсарлах хугацаатай тэнцүү байх дараалсан хугацаа бөгөөд үүнийг тухайн хувь хүн нь дээр дурдсан ажил үүрэг дэх оролцоогоо зогсоохын яг өмнөх жилд гүйцэтгэж байсан ажил үүрэгт хамааруулж ойлгоно.

540.6 А1 Жишээлбэл, гэрээт ажлын багт гурван жил ажилласны дараа гэрээт ажлын партнерээр дөрвөн жил ажилласан хүн зөвхөн эдгээр хугацааны дараа яг ижил аудитын гэрээт ажлын гол партнерээр дараачийн гурван жилд ажиллах боломжтой (нийтдээ долоон жил). Үүний дараа, тухайн хувь хүн ийм үүргээс Ш540.14-ийн дагуу, Завсарлах хугацааг хэрэгжүүлэх ёстой.

Ш540.7 Ш540.5-р параграфыг мөрдөхгүй байх тохиолдлын жишээнд, хэрэв гэрээт ажлын гол партнерийг үргэлжлүүлэн ажиллуулах нь аудитын чанарт, ялангуяа компанийн хяналтаас гадуурх урьдчилан тооцоолоогүй нөхцөл үүсэх ховор тохиолдолд маш чухал ач холбогдолтой байвал, засаглах эрхтэй удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр, хараат бус байдлын аюул заналыг зөвшөөрөгдөх

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

түвшин хүртэл арилгаж чадах хэмжээнд, дахин нэг жил аудитын гол партнерийн үүрэг гүйцэтгэхийг зөвшөөрдөг.

540.7 А1 Жишээлбэл, төлөвлөж байсан гэрээт ажлын партнер ноцтой өвдөх гэх мэт урьдчилан тооцоолоогүй нөхцөлийн улмаас партнерийн сэлгээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд, аудитын гол партнерийг дахин нэг жил хүртэл хугацаагаар үлдээж болох юм. Энэ тохиолдолд, төлөвлөсөн эргэцийг хэрэгжүүлж чадаагүй шалтгаан, үүссэн аюул заналыг бууруулах хамгаалалтын арга хэмжээ авах хэрэгцээ зэрэг асуудлаар засаглах эрхтэй удирдлагатай ярилцана.

Ш540.8 Хэрэв аудитын үйлчлүүлэгч нь нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болбол, эргэцийн хугацааг тодорхойлохдоо, уг үйлчлүүлэгч нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болохоос өмнө гол партнерээр тухайн хүн ямар хугацаанд ажиллаж байсныг харгалзан үзэх ёстой. Хэрэв үйлчлүүлэгчийг нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох үед тухайн хувь хүн нийт тав эсвэл түүнээс цөөн жил түүний гол партнер байсан бол, гэрээт ажлын эргэц хийхийн өмнө яг ийм үүргээр үйлчлүүлэгчтэй үргэлжлүүлэн ажиллах тухайн хувь хүний жил нь долоон жилээс өмнө нь ажилласан жилүүдийг хассан жилийн тоотой тэнцүү байна. Хэрэв үйлчлүүлэгчийг нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох үед тухайн хувь хүн нь нийтдээ зургаа эсвэл түүнээс дээш жил гол партнерээр ажиллаж байгаа бол, засаглах эрхтэй удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр, гэрээт ажлын сэлгээ хийхээс өмнө дахин хоёр жил аудитын гол партнерийн үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд Ш540.5-р параграфын шаардлагыг мөрдөхгүй гэсэн үг.

Ш540.9 Хэрэв компанид, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгжийн аудитад гол партнерээр ажиллахад шаардлагатай мэдлэг, туршлага бүхий хүн цөөн байвал, аудитын гол партнеруудад сэлгээ хийх боломжгүй. Ш540.5-р параграфын шаардлагыг мөрдөхгүй байх жишээнд, хэрэв хамаарах хууль эрх зүйн орчин дахь хараат бус зохицуулагч байгууллага нь ийм тохиолдолд партнеровын сэлгээ хийх шаардлагаас чөлөөлөгдөх нөхцөлийг зөвшөөрдөг бол, үүний дагуу тухайн хувь хүн нь долоон жилээс дээш хугацаанд аудитын гол партнер хэвээр үлдэж болох юм. Энэ тохиолдолд, хараат бус зохицуулагч байгууллага нь бусад мөргөл зохих шаардлагууд, жишээлбэл, аудитын гол партнерийг сэлгээнээс чөлөөлж болох хугацааны урт, эсвэл хараат бус гадаад чанарын хяналтыг тогтмол хийх зэрэг шаардлагуудыг заавал тодорхойлно.

Ажиллаж Байх Хугацаатай Холбоотой Бусад Асуудал

Ш540.10 Тухайн хувь хүн аудитын гэрээт ажилд урт удаан хугацаанд холбоотой байснаар үүссэн аюул заналыг үнэлэхдээ компани, тухайн хувь хүнийг аудитын гол партнер болохоос өмнө гэрээт ажилд гүйцэтгэдэг үүрэг болон хугацааны үргэлжлэлийг онцгой анхаарах ёстой.

540.10 А1 Онолын үзэл баримтлалыг ашиглахдаа, аудитын гол партнерээр ажиллаж байгаа тухайн хувь хүний өмнөх аудитын гол партнерээр ажиллаж байсан хугацааны үргэлжлэл нь долоон жилээс бага байсан ч гэсэн энэ үүргээрээ дахин ажиллах нь зохимжгүй хэмээн дүгнэх тохиолдол компанид гарч болзошгүй.

Түр Завсарлах Хугацаа

Ш540.11 Хэрэв тухайн хувь хүн нийт долоон жилийн хугацаанд аудитын гол партнеровын үүрэг гүйцэтгэсэн бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан таван жил байх ёстой.

Ш540.12 Хэрэв тухайн хувь хүнийг гэрээт ажлын чанарыг хянан нягтлах үүрэгт томилж, тэрээр нийт долоон жил энэ үүргийн дагуу ажилласан бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан гурван жил байна.

Ш540.13 Хэрэв тухайн хувь хүн Ш540.11, Ш540.12-т заасан үүргээс бусад ажил үүрэгт аудитын гол партнерээр нийт долоон жил ажилласан бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан хоёр жил байна.

Аудитын Гол Партнерийн Үүргийг Хослуулан Гүйцэтгэх

Ш540.14 Хэрэв тухайн хувь хүн аудитын гол партнер ба гэрээт ажлын партнерийн үүргийг дөрөв ба түүнээс дээш жилийн хугацаанд хослуулан гүйцэтгэсэн бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан таван жил байна.

Ш540.15 Ш540.16(а)-д заасны дагуу, хэрэв аудитын гол партнер ба гэрээт ажлын партнерийн үүргийг хослуулан гүйцэтгэсэн хувь хүн гэрээт ажлын чанарыг хянан нягтлах үүргийг дөрөв ба түүнээс дээш жил хариуцан ажилласан бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан гурван жил байна.

Ш540.16 Хэрэв тухайн хувь хүн нь ажиллаж байх хугацаандаа гэрээт ажлын партнер ба гэрээт ажлын чанарыг хянан нягтлах үүргийг хослуулан дөрөв ба түүнээс дээш жил ажилласан бол “түр завсарлах” хугацааг дараах байдлаар тодорхойлох ёстой:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (а) Ш540.15-д зааснаас бусад тохиолдолд, тухайн хувь хүн нь гурав ба түүнээс дээш жил гэрээт ажлын партнер байсан бол, дараалсан таван жил байх;
- (б) Бусад аливаа үүргийг хослуулан гүйцэтгэсэн бол, дараалсан гурван жил байх.

Ш540.17 Хэрэв тухайн хувь хүн Ш540.14-Ш540.16-д зааснаас бусад ажил үүрэгт, аудитын гол партерийн үүргийг хослуулан ажилласан бол “түр завсарлах” хугацаа нь дараалсан хоёр жил байна.

Өмнөх Компанид Үзүүлж Байсан Үйлчилгээ

Ш540.18 Ш540.5-д заасан аудитын гол партнерээр ажиллаж байгаа хувь хүний жилийн тоог тодорхойлохдоо, тухайн харилцааны үргэлжлэх хугацаанд хамааралтай байвал өмнөх компанид уг аудитын гэрээт ажилд аудитын гол партнерээр ажиллаж байсан хугацааг нь оруулах ёстой.

Хууль, Тогтоомжид Заасан Илүү Богино Хугацааны “Түр Завсарлагаа”

Ш540.19 Хууль тогтоох эсвэл зохицуулах байгууллага (эсвэл хууль тогтоох, зохицуулах байгууллагаас зохих эрх мэдэл өгсөн эсвэл хүлээн зөвшөөрсөн байгууллага)-ын зүгээс гэрээт ажлын партнерийн “түр завсарлах” хугацааг таваас доошгүй дараалсан жил байхаар тогтоосон бол, энэ хугацаа эсвэл гурван жилийн аль их хугацаагаар Ш540.11, Ш540.14, Ш540.16(а) дахь дараалсан таван жилийн “түр завсарлах” хугацааг орлуулж болох бөгөөд мөрдөх боломжтой байх хугацаа нь долоон жилээс хэтрээгүй байх ёстой.

“Завсарлах” Хугацааны Үйл Ажиллагаанд Тавих Хязгаарлалт

Ш540.20 “Түр завсарлах” хугацаанд, тухайн хүн дараах үйл ажиллагааг эрхэлж болохгүй:

- (а) Гэрээт ажлын гишүүн байх эсвэл аудитын ажилд чанарын хяналт тавих;
- (б) Аудитын ажилд нөлөөлөхүйц техникийн эсвэл салбарын онцлог асуудлууд, ажил гүйлгээ, үйл явдлын талаар гэрээт ажлын баг эсвэл үйлчлүүлэгчтэй зөвлөлдөх (тухайн хувь хүний цагтаа байх хугацааны хамгийн сүүлийн жилд хийсэн ажил, гаргасан дүгнэлтээр хязгаарласан гэрээт ажлын багтай хийсэн ярилцлага, энэ нь аудиттай холбоотой хэвээр байгаагаас бусад тохиолдол);
- (в) Компани, сүлжээ компаниас аудитын үйлчлүүлэгчдэд үзүүлдэг мэргэжлийн үйлчилгээг удирдах, зохицуулах, эсвэл компани, сүлжээ компаниас аудитын үйлчлүүлэгчтэй харьцдаг харилцаанд хяналт тавих ажлыг хариуцах;
- (г) Аудитын үйлчлүүлэгчтэй хамааралтай, дээр дурдсанаас бусад үүрэг, үйл ажиллагаа, үүний дотор тухайн хувь хүнийг дараах байр суурьт хүргэж болзошгүй баталгаажуулах бус үйлчилгээ үзүүлэх:
 - (i) Ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай мэдэгдэхүйц бөгөөд байнгын харилцаатай болох;
 - (ii) Аудитын гэрээт ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлэх.

540.20 A1 Дээрх Ш540.20-р параграфт дурдсан нөхцөл нь тухайн хүнийг компани, сүлжээ компанид Ахлах эсвэл Удирдах партнер (гүйцэтгэх захирал буюу түүнтэй адилтгах) зэрэг удирдах албан тушаал эрхлэхийг хориглох зорилгогүй болно.

ХЭСЭГ 600

АУДИТЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД БАТАЛГААЖУУЛАЛТЫН БУС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

Танилцуулга

- 600.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөхийг компаниудаас шаарддаг.
- 600.2 Компани, сүлжээ компаниуд нь өөрийн ур чадвар, туршлагад нийцсэн баталгаажуулалтын бус олон төрлийн үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлдэг. Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх нь суурь зарчмын нийцэл болон хараат бус байдалд аюул занал учруулж болзошгүй.
- 600.3 Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх үед хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчмыг хэрхэн мөрдөх шаардлага, ашиглах материалыг энэ хэсэгт тодорхойлсон болно. Дэд хэсгүүдэд, аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус зарим үйлчилгээ үзүүлдэг компани, сүлжээ компанид хамааралтай шаардлага, ашиглах материалыг энэ хэсэгт тодорхойлж, үүний үр дүнд үүсэж болзошгүй аюул заналын төрлийг харуулсан болно. Зарим дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд аудитын үйлчлүүлэгчид зарим нэг үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг тодорхой оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- Ш600.4** Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх тухай гэрээт ажлыг зөвшөөрөхийн өмнө компани, сүлжээ компани нь ийм үйлчилгээ үзүүлснээр хараат бус байдалд аюул занал учирч болох эсэхийг тодорхойлох ёстой.
- 600.4A1 Энэ хэсэгт багтсан шаардлага ба ашиглах материал нь аудитын үйлчлүүлэгчид үзүүлэх баталгаажуулалтын бус зарим үйлчилгээний төрөл, хэрэв компани, сүлжээ компани нь баталгаажуулалтын бус үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлбэл үүсэж болзошгүй аюул заналыг задлан шинжлэхэд компани, сүлжээ компанид тусалдаг.
- 600.4A2 Бизнесийн шинэ практик, санхүүгийн зах зээлийн хувьсал, мэдээллийн технологийн өөрчлөлт зэрэг нь аудитын үйлчлүүлэгчид үзүүлж болох баталгаажуулалтын бус үйлчилгээний бүх төрлийг багтаасан жагсаалтыг нэг мөр гаргах боломжгүйд хүргэж байна. Үүний улмаас, уг Дүрэмд аудитын үйлчлүүлэгчид үзүүлэх боломжтой баталгаажуулалтын бус үйлчилгээний төрлийн бүрэн жагсаалтыг тусгаагүй болно.

Аюул Заналыг Үнэлэх

- 600.5A1 Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр бий болсон аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:
- Үйлчилгээний шинж чанар, цар хүрээ, зорилго.
 - Аудитын хэсэг болох уг үйлчилгээний үр дүнд тулгуурлах түвшин.
 - Үйлчилгээ үзүүлдэг хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин.
 - Үйлчилгээний үр дүн нь компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд тусгагдсан зүйлд нөлөөлөх эсэх, хэрэв тийм бол:
 - o Үйлчилгээний үр дүн нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх далайц.
 - o Санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр зүйлсийн хувьд, зохих дүн эсвэл аргыг тодорхойлохдоо авч үзсэн субъектив байдлын түвшин.
 - Үзүүлсэн үйлчилгээний төрлөөр, тухайн үйлчлүүлэгчийн удирдлага, ажилтнуудын эзэмшсэн мэргэжлийн түвшин.
 - Томоохон шүүн тунгаалт шаардсан асуудлыг тодорхойлоход үйлчлүүлэгчийн оролцсон байдал.
 - Үйлчлүүлэгчийн дараах асуудлын томоохон хэсгийг бүрдүүлдэг мэдээлэл боловсруулалтын системд

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

үзүүлж байгаа үйлчилгээний нөлөөллийн мөн чанар ба далайц:

- o Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа нягтлан бодох бүртгэл хөтлөлт буюу санхүүгийн тайлан.
- o Санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт.
- Үйлчлүүлэгч нь нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж мөн эсэх. Жишээлбэл, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх нь аюул заналыг өндөр түвшинд хүргэж болзошгүй хэмээн үзэж болох юм.

600.5A2 Дэд хэсэг 601-610-т, эдгээр дэд хэсэгт тодорхойлсон баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр бий болсон аюул заналын түвшинг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийг нэмэлт жишээгээр харуулсан болно.

Санхүүгийн Тайлантай Холбоотой Материаллаг Байдал

600.5A3 Дэд хэсэг 601-610 нь аудитын үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангийн материаллаг байдалд хамааралтай юм. Аудиттай холбоотой материаллаг байдлын тухай ойлголтыг АОУС 320, *Аудитын төлөвлөлт ба гүйцэтгэлийн материаллаг байдал*, нягтлах ажилтай холбоотой материаллаг байдлын тухай ойлголтыг НГАОУС 2400 (Хянан засварласан), *Түүхэн санхүүгийн тайланг нягтлах гэрээт ажил*-д тус тус авч үздэг. Материаллаг байдлыг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлдэг бөгөөд үүнд тоон ба чанарын хүчин зүйлс нөлөөлдөг. Мөн хэрэглэгчдийн санхүүгийн мэдээллийн эрэлт хэрэгцээний талаарх ойлголт нөлөөлдөг.

Нэг Аудитын Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Олон Төрлийн Үйлчилгээ Үзүүлэх

600.5A4 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Ийм тохиолдолд, эдгээр үйлчилгээг үзүүлснээр бий болсон аюул заналын нийлмэл үр нөлөөг авч үзэх нь компанийн хийх аюул заналын үнэлгээнд хамааралтай юм.

Аюул Заналыг Тодорхойлох

600.6A1 Дэд хэсэг 601-610-т, аюул заналын түвшин нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байхгүй үед, баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр бий болсон хараат бус байдалд учрах аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээг жишээгээр харуулсан болно. Эдгээр жишээ нь бүх тохиолдлыг хамарсан бүрэн жагсаалт биш юм.

600.6A2 Зарим дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд аудитын үйлчлүүлэгчид зарим нэг үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг тодорхой оруулсан байна.

600.6A3 Параграф 120.10A2-т хамгаалалтын арга хэмжээг тодорхойлсон байгаа. Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хамгаалалт бол, хараат бус байдалд учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулж чадах үр нөлөөтэй арга хэмжээг компани дангаар нь эсвэл хамтад нь авах арга хэмжээ юм. Зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр аюул занал учрах үед авах хамгаалалтын арга хэмжээ бэлэн биш байж болзошгүй. Ийм тохиолдолд, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлал нь, аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эсвэл цуцлахыг компаниас шаарддаг.

Удирдлагын Үүрэг Хариуцлага Хүлээхийг Хориглох

Ш600.7 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгч байгууллагад удирдлагын үүрэг хариуцлага хүлээх ёсгүй.

600.7A1 Удирдлагын үүрэг хариуцлагад хүний нөөцийн, санхүүгийн, технологийн, биет болон биет бус нөөцийг олж бэлтгэх, ашиглах, хянахтай холбоотой шийдвэр гаргах зэрэг аж ахуйн нэгж, байгууллагыг хянах, удирдах ба чиглүүлэх үүрэг багтдаг.

600.7A2 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх явцдаа удирдлагын хариуцлага хүлээдэг бол, өөрийгөө хянах болон хувийн ашиг сонирхлын аюул занал бий болгодог. Удирдлагын хариуцлага хүлээнснээр, компани, сүлжээ компани нь тухайн үйлчлүүлэгчийн удирдлагын үзэл бодол, ашиг сонирхолтой хэт зохицох буюу нэгддэг тул танилын аюул занал үүсгээд зогсохгүй өмгөөлөх аюул заналыг ч үүсгэж болзошгүй.

600.7A3 Аливаа үйл ажиллагааг удирдлагын үүрэг хариуцлага мөн эсэхийг тодорхойлох нь тухайн нөхцөл

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

байдлаас хамаарах бөгөөд мэргэжлийн шүүн тунгаалт ашиглахыг шаарддаг. Удирдлагын үүрэг хариуцлага хэмээн үзэж болох үйл ажиллагааны жишээнд дараахыг багтаана:

Бодлого, стратегийн чиглэлийг тогтоох.

- Ажилтнуудыг ажилд авах буюу халах.
- Тухайн аж ахуйн нэгжийн төлөө ажиллаж байгаа ажилтнуудын үйлдлийг чиглүүлэх ба хариуцах.
- Ажил гүйлгээ хийхийг зөвшөөрөх.
- Банкны данс эсвэл хөрөнгө оруулалтыг хянах буюу удирдах.
- Компани, сүлжээ компани, бусад гуравдагч талуудын өгсөн аль зөвлөмжийг хэрэгжүүлэхийг шийдэх.
- Удирдлагын өмнөөс засаглах эрхтэй удирдлагад тайлагнах.
- Дараах асуудлаар хариуцлага хүлээх:
 - o Мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн санхүүгийн тайлан бэлтгэх, үнэн зөв толилуулах.
 - o Дотоод хяналтыг зохиомжлох, хэрэгжүүлэх, хянан шинжлэх буюу сахин мөрдөх.

600.7A4 Үүрэг хариуцлага биелүүлэхэд нь тус дэм болох зөвлөгөө, зөвлөмжийг аудитын үйлчлүүлэгчдээ өгөх нь удирдлагын үүрэг хариуцлага хүлээж байгаа хэрэг биш юм (Лав: Пара. Ш600.7-600.7A3).

Ш600.8 Аудитын үйлчлүүлэгчид баталгаажуулах бус үйлчилгээ үзүүлэх үедээ үйлчлүүлэгчийн удирдлагын үүрэг хариуцлагыг өөртөө авахаас зайлсхийхийн тулд, удирдлагын гарцаагүй үүрэг хариуцлага болох чухал шүүн тунгаалт, шийдвэрийг үйлчлүүлэгчийн удирдлага гаргасан гэдэгт компани итгэлтэй байх ёстой. Үүнд үйлчлүүлэгчийн удирдлага дараах шийдвэр гаргасан гэх баталгаа багтдаг:

(a) Үйлчлүүлэгчийн гаргасан шийдвэрийг цаг хугацаанд нь хариуцахуйц ур чадвар, мэдлэг, туршлагыг эзэмшсэн хувь хүнийг томилж, үйлчилгээг хянуулна. Ийм хүнийг дээд түвшний удирдлагын хүрээнээс сонгох бөгөөд тэрээр дараах зүйлийг ойлгосон байна:

(i) Үйлчилгээний зорилго, шинж чанар, үр дүн;

(ii) Тухайн үйлчлүүлэгч болон компани, сүлжээ компанийн хүлээх хариуцлага.

Гэхдээ, тухайн хувь хүнээс үйлчилгээг гүйцэтгэх эсвэл дахин гүйцэтгэх туршлагатай байхыг шаарддаггүй.

(b) Үйлчилгээг хянах, үйлчлүүлэгчийн зорилгод нийцүүлэн гүйцэтгэсэн үйлчилгээний үр дүнг үнэлэх.

(в) Үйлчилгээний үр дүнд үндэслэн авах арга хэмжээний хариуцлагыг хүлээх.

Хожим нь Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж болсон Аудитын Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Үйлчилгээ Үзүүлэх

Ш600.9 Компани, сүлжээ компаниас аудитын үйлчлүүлэгчдээ одоо эсвэл өмнө нь үзүүлж байсан баталгаажуулалтын бус үйлчилгээ нь дараахаас бусад тохиолдолд, түүний хараат бус байдалд эрсдэл учруулдаг:

(a) Өмнөх баталгаажуулалтын бус үйлчилгээ нь нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж биш аудитын үйлчлүүлэгчид хамаарах энэ хэсгийн заалтуудад нийцэж байсан;

(b) Энэ хэсэгт зөвшөөрөөгүй баталгаажуулалтын бус үйлчилгээг нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид одоо үзүүлж байгаа бөгөөд энэ нь тухайн үйлчлүүлэгч нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болохын өмнө эсвэл дараа аль болох түргэн хугацаанд дуусгавар болдог;

(в) Үйлчилгээнээс үүсдэг аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах боломжгүй хэмээн компани тодорхойлдог.

Зарим Холбоотой Аж Ахуйн Нэгжүүдийг Харгалзаж Үзэх

Ш600.10 Энэ хэсэгт компани, сүлжээ компаниас аудитын үйлчлүүлэгчийн өмнөөс удирдлагын хариуцлага хүлээх

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

эсвэл баталгаажуулалтын бус зарим үйлчилгээ үзүүлэхийг хориглох шаардлагуудыг тусгасан болно. Тухайн үйлчлүүлэгчийн доор дурдсан холбоотой талуудын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийг хориглосноос бусад тохиолдолд, компани, сүлжээ компани нь эдгээр шаардлагыг мөрдөхгүй байх буюу удирдлагын хариуцлага хүлээж эсвэл баталгаажуулалтын бус зарим үйлчилгээ үзүүлж болох юм. Үүнд:

- (a) Үйлчлүүлэгчид шууд буюу шууд бус хяналт тавьдаг аж ахуйн нэгж;
- (б) Хэрэв уг аж ахуйн нэгж нь үйлчлүүлэгчид мэдэгдэхүйц нөлөөтэй бөгөөд үйлчлүүлэгчийн өмчлөл дэх түүний Ашиг Сонирхол нь уг аж ахуйн нэгжид материаллаг дүнтэй бол тухайн үйлчлүүлэгчтэй санхүүгийн шууд Ашиг Сонирхол бүхий аж ахуйн нэгж;
- (в) Дараах бүх нөхцөл хангагдах үед, үйлчлүүлэгчтэй нийтлэг нэг хяналтад байдаг аж ахуйн нэгж:
 - (i) Компани, сүлжээ компани нь уг холбоотой талын санхүүгийн тайланд дүгнэлт өгдөггүй;
 - (ii) Компани, сүлжээ компани нь санхүүгийн тайланд дүгнэлт өгөх гэж байгаа аж ахуйн нэгжийн төлөө шууд эсвэл шууд бусаар удирдлагын хариуцлага хүлээдэггүй;
 - (iii) Үр дүнг нь аудитын горимд хамруулдаггүй тийм үйлчилгээ нь өөрийгөө хянах аюул заналыг бий болгодоггүй;
 - (iv) Ийм үйлчилгээ үзүүлснээр үүсэх аюул заналын түвшинг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах боломжгүй бусад аюул занал байгааг компани олж тодорхойлсон.

ДЭД ХЭСЭГ 601 – НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ БА ДАНС ХӨТЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 601.1 Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах аюул занал үүсгэж болзошгүй.
- 601.2 Аудитын үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-III600.10 параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх зарим үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 601.3A1 Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ нь дараах өргөн хүрээний үйлчилгээнээс бүрддэг:
 - Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх.
 - Ажил гүйлгээ бүртгэх.
 - Цалин тооцоолох үйлчилгээ.
- 601.3A2 Мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайлан бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Ийм хариуцлагад дараахыг хамруулна:
 - Нягтлан бодох бүртгэл бодлого болон болон түүнд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлох;
 - Гүйлгээ гарсны нотолгоо болгон анхан шатны баримтууд буюу анхдагч тоон мэдээг цахим эсвэл өөр хэлбэрээр бэлтгэх эсвэл өөрчлөх. Үүний жишээнд дараахыг багтаана:
 - Худалдан авалтын захиалга.
 - Цалингийн цагийн бүртгэл.
 - Харилцагчийн захиалга.
 - Журналын анхны бичилт хийх, өөрчлөх
 - Ажил гүйлгээний дансны ангиллыг тодорхойлох, батлах.
- 601.3A3 Аудитын үйл явц дунд компани ба аудитын үйлчлүүлэгчийн удирдлагын хооронд дараах зүйлсийг

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

хөндсөн яриа хэлцэл зайлшгүй өрнөдөг бөгөөд үүнд дараах асуудлыг багтаах боломжтой:

- Нягтлан бодох бүртгэлийн стандарт, бодлого болон санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэх шаардлагуудыг мөрдөх;
- Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн хяналтын зохистой байдал, мөн хөрөнгө, өр төлбөрийн тогтоосон дүнг тодорхойлоход хэрэглэх аргагүйг үнэлэх;
- Журналын тохируулах бичилтүүдийг төлөвлөж танилцуулах.

Эдгээр үйл ажиллагаа нь аудитын үйл явцын хэвийн нэг хэсэг бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөлт ба санхүүгийн тайланг бэлтгэх бол үйлчлүүлэгчийн хариуцлага гэдэг талаасаа хараат бус байдалд ихэвчлэн аюул занал учруулдаггүй.

601.3A4 Үүний нэгэн адил, аудитын үйлчлүүлэгч нь дансны тохируулгын асуудлуудыг шийдвэрлэх, хууль тогтоомжийн дагуу тайлагнах мэдээллийг цуглуулж задлан шинжлэх гэх мэт асуудлаар техникийн туслалцаа авахыг компаниас хүсэх боломжтой. Мөн, санхүүгийн тайлагналын нэг үзэл баримтлалаас нөгөөд нийцүүлэн одоо байгаа санхүүгийн тайлангаа хөрвүүлэх гэх мэт нягтлан бодох бүртгэлийн асуудлаар аудитын үйлчлүүлэгч түүнээс техникийн зөвлөгөө авах боломжтой. Үүний жишээнд:

- Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлэх,
- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт зэрэг тайлагналын өөр үзэл баримтлал руу шилжих үйл явц.

Компани эсвэл сүлжээ компанийн аль нь ч үйлчлүүлэгчийн удирдлагын хариуцлага хүлээдэггүй бол, ийм үйлчилгээ үзүүлэх нь ерөнхийдөө хараат бус байдалд аюул занал учруулдаггүй.

Нягтлан Бодох Бүртгэл ба Данс Хөтлөх Хэвшмэл буюу Механик Шинжтэй Үйлчилгээ

601.4A1 Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх хэвшмэл буюу механик шинжтэй үйлчилгээ үзүүлэх нь мэргэжлийн шүүн тунгаалт шаардах асуудал биш юм. Ийм үйлчилгээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Үйлчлүүлэгчийн гаргасан тоон мэдээнд үндэслэн цалингийн тооцоолол буюу тайлан бэлтгэж, үйлчлүүлэгчээр батлан төлбөр хийхэд бэлэн болгох.
- Аудитын үйлчлүүлэгч нь дансны тохирох ангиллыг тодорхойлсон буюу зөвшөөрч баталсан ашиглалтын зардлын нэхэмжлэх гэх мэт анхан шатны баримт буюу анхдагч тоон мэдээнээс дүнг нь хялбар тодорхойлж болохуйц дахин давтагддаг ажил гүйлгээг бүртгэх.
- Үйлчлүүлэгч нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодорхойлон, ашиглалтын хугацаа ба үлдэх өртгийг тооцоолсон үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох.
- Үйлчлүүлэгчийн кодолсон ажил гүйлгээг ерөнхий дэвтэрт шилжүүлж бичих.
- Үйлчлүүлэгчийн зөвшөөрч баталсан бичилтүүдийг шалгах баланст шилжүүлж бичих;
- Үйлчлүүлэгчийн зөвшөөрч баталсан шалгах балансын мэдээлэлд үндэслэн санхүүгийн тайлан бэлтгэх, мөн үйлчлүүлэгчийн зөвшөөрч баталсан бичилтэд үндэслэн холбогдох тэмдэглэл бэлтгэх.

Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж биш Аудитын Үйлчлүүлэгчид

Ш601.5 Доор дурдсанаас бусад тохиолдолд, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж биш аудитын үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ, үүнд өөрийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайлан буюу түүнийг бэлтгэх үндэслэл болсон санхүүгийн мэдээлэл бэлтгэх үйлчилгээг компани, сүлжээ компани үзүүлж болохгүй. Үүнд:

- (а) Тухайн үйлчилгээ нь хэвшмэл буюу механик шинжтэй үйлчилгээ байх;
- (б) Ийм үйлчилгээ үзүүлснээр бий болсон аюул заналын түвшин нь зөвшөөрөгдөх хэмжээнд биш байна гэж компани тодорхойлох.

601.5A1 Нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх хэвшмэл буюу механик шинжтэй үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлснээр үүссэн өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараахыг оруулна:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй бөгөөд гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянадаг

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тохирох хянан шалгагчтай байх.

Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж Аудитын Үйлчлүүлэгчид

Ш601.6 Компани, сүлжээ компани нь Ш601.7-р параграфын дагуу, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээ, үүнд өөрийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайлан буюу түүнийг бэлтгэх үндэслэл болсон санхүүгийн мэдээлэл бэлтгэх үйлчилгээг компани, сүлжээ компани үзүүлж болохгүй.

Ш601.7 Параграф Ш601.6-д зааснаас бусад тохиолдолд, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчийн хэлтэс/ нэгж буюу холбоотой талуудад нягтлан бодох бүртгэл ба данс хөтлөх үйлчилгээг компани, сүлжээ компани үзүүлж болно, энэ тохиолдолд уг үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнууд нь аудитын багийн гишүүн биш бөгөөд:

- (а) Үйлчилгээ авч байгаа хэлтэс/ нэгж буюу холбоотой аж ахуйн нэгжүүд нь хамтдаа тухайн компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг биш байх;
- (б) Тухайн үйлчилгээ нь хэлтэс/ нэгж буюу холбоотой аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан дахь хамтдаа материаллаг бус зүйлсэд хамааралтай байх.

ДЭД ХЭСЭГ 602 – ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 602.1 Аудитын үйлчлүүлэгчдэд захиргааны үйлчилгээ үзүүлэх нь ихэвчлэн аюул занал үүсгэдэггүй.
- 602.2 Аудитын үйлчлүүлэгчид захиргааны үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10 параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 602.3A1 Захиргааны үйлчилгээ гэж үйлчлүүлэгчийн хэвийн үйл ажиллагааны хүрээнд, түүний хэвмшэл буюу механик ажил үүрэгт туслах үйлчилгээг хэлнэ. Ийм үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн шүүн тунгаалт бараг эсвэл огт шаардлагагүй бөгөөд бичиг хэргийн шинжтэй байдаг.
- 602.3A2 Захиргааны үйлчилгээний жишээнд дараахыг оруулна:
- Бичиг баримт боловсруулах үйлчилгээ.
 - Захиргааны эсвэл хуулиар шаардсан бичиг баримт бэлтгэж, үйлчлүүлэгчээр батлуулах.
 - Дээрх бичиг баримтуудыг үйлчлүүлэгчийн зааврын дагуу хүргүүлэх.
 - Хуулиар шаардсан баримт бичгүүдийн огноо, дэс дугаарт хяналт тавих, энэ талаар аудитын үйлчлүүлэгчид зөвлөх.

ДЭД ХЭСЭГ 603 – ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 603.1 Аудитын үйлчлүүлэгчид үнэлгээний үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөллийн аюул занал учруулж болзошгүй.
- 603.2 Аудитын үйлчлүүлэгчид үнэлгээний үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид зарим үнэлгээний үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 603.3A1 Үнэлгээ нь хөрөнгө, өр төлбөр болон нийт бизнесийн тодорхой үнэ цэнэ эсвэл үнэ цэнийн цар хүрээг тооцоолохын тулд, ирээдүйн хөгжил дэвшлийн талаарх таамаглал, тохиромжтой арга, техникийг ашиглах, мөн эдгээрийг хослуулан гүйцэтгэх ажиллагаанаас бүрдэнэ.
- 603.3A2 Хэрэв аудитын үйлчлүүлэгч нь татварын тайлагналын үүрэг эсвэл татвараа төлөвлөх зорилгодоо туслуулахын тулд үнэлгээ хийж өгөхийг компани, сүлжээ компаниас хүссэн бөгөөд ийм үнэлгээний үр дүн нь санхүүгийн тайланд шууд нөлөө үзүүлэхээргүй бол, уг үйлчилгээтэй холбоотой 604.9A1-604.9A5-р параграфыг мөрддөг.
- 603.3A3 Аудитын үйлчлүүлэгчид үнэлгээний үйлчилгээ үзүүлснээр бий болсон өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналын үнэлгээнд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Үнэлгээний тайлангийн хэрэглээ ба зорилго.
 - Үнэлгээний тайланг нийтэд мэдээлэх эсэх.
 - Үнэлгээний аргачлал болон бусад чухал асуудлыг тодорхойлох, батлахад үйлчлүүлэгчийн оролцооны хэр хэмжээ.
 - Стандарт буюу тогтоосон аргачлалыг хамруулан, үнэлгээ хийх зүйлд байнга тохиолддог субъектив байдлын түвшин.
 - Үнэлгээ нь санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх эсэх.
 - Санхүүгийн тайлангийн үнэлгээтэй холбоотой тодруулгын далайц ба тод томруун байдал.
 - Холбогдох үнийн дүнд мэдэгдэхүйц хэлбэлзэл үүсгэх шинжтэй ирээдүйн үйл явдлаас хамаарах түвшин.
- 603.3A4 Аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараахыг оруулна:
- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой.
 - Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах нь өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.

Нийтийн Сонирхолтой Аж Ахуйн Нэгж биш Аудитын Үйлчлүүлэгчид

- Ш603.4** Дараах тохиолдолд, компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид үнэлгээний үйлчилгээ үзүүлж болохгүй. Үүнд:
- (а) Үнэлгээ нь субъектив байдлын түвшин өндөртэй;
- (а) Үнэлгээ нь компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр байвал.
- 603.4A1 Зарим үнэлгээнд субъектив шинж чанар тун өчүүхэн байдаг. Үндсэн төсөөллийг хууль тогтоомжид заасан, эсвэл өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн бөгөөд ашиглахаар зэхсэн арга, техникийг нийтээр хүлээн зөвшөөрсөн стандарт эсвэл хууль тогтоомжид үндэслэсэн үед ийм тохиолдол үүсэх магадлалтай. Энэ тохиолдолд, хоёр ба түүнээс дээш талын гүйцэтгэсэн үнэлгээний үр дүн хоорондоо материаллаг дүнгээр зөрөх магадлал бага юм.

Нийтийн Сонирхолтой Аж Ахуйн Нэгж болох Үйлчлүүлэгчид

Ш603.5 Хэрэв үнэлгээний үйлчилгээ нь компанийн дүгнэлт гаргах санхүүгийн тайланд дангаараа эсвэл нийт дүнгээрээ материаллаг нөлөө үзүүлэхүйц байвал тэрээр ийм нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид үнэлгээний үйлчилгээ үзүүлэх ёсгүй.

ДЭД ХЭСЭГ 604 – ТАТВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

604.1 Аудитын үйлчлүүлэгчид татварын үйлчилгээг үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул занал учруулж болзошгүй.

604.2 Аудитын үйлчлүүлэгчид татварын үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид зарим үнэлгээний үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

604.3A1 Татварын үйлчилгээ нь өргөн хүрээний үйлчилгээ бөгөөд үүнд дараахыг багтаана:

- Татварын тайлан гаргах.
- Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийхийн тулд татварын тооцоолол хийх.
- Татварын төлөвлөлт болон татварын бусад зөвлөх үйлчилгээ.
- Үнэлгээг багтаасан татварын үйлчилгээ.
- Татварын маргааныг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх.

Энэ дэд хэсэгт, дээр дурдсан татварын үйлчилгээний төрөл тус бүрийг өөр өөр гарчгийн дагуу тусад нь авч үзсэн хэдий ч, практикт татварын үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа ихэвчлэн хоорондоо нягт холбоотой байдаг.

604.3A2 Аудитын үйлчлүүлэгчид татварын үйлчилгээ үзүүснээр бий болсон аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаадаг:

- Тухайн гэрээт ажлын онцлог шинж чанар.
- Үйлчлүүлэгчийн ажилтнууд нь татварын асуудлаар хэр мэргэшсэн.
- Татварын эрхтэй байгууллагууд үүсээд байгаа татварын асуудлыг үнэлж, удирдан чиглүүлдэг тогтолцоо болон тэрхүү үйл явцад компани, сүлжээ компанийн гүйцэтгэх үүрэг.
- Холбогдох татварын тогтолцооны нарийн төвөгтэй байдал, түүнийг мөрдөхөд шаардагдах мэргэжлийн шүүн тунгаалтын түвшин.

Татварын Тайлан Гаргах

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

604.4A1 Татварын тайланг бэлтгэж гаргах нь ихэвчлэн аюул занал үүсгэдэггүй.

604.4A2 Татварын тайлан бэлтгэхтэй холбоотой дараах үйлчилгээ байдаг:

- Татварын өглөгийн дүнг тооцох гэх мэтээр холбогдох татварын албанд тушаах ёстой мэдээллийг боловсруулах, гүйцээн бүрдүүлэх (ихэвчлэн стандарт маягтын дагуу) замаар татварын тайлагналын үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь үйлчлүүлэгчид туслах.
- Өнгөрсөн үеийн ажил гүйлгээг тайлагнах татварын тайлангийн арга хандлагын талаар зөвлөгөө өгөх, мөн аудитын үйлчлүүлэгчийн өмнөөс татварын байгууллагад нэмэлт мэдээлэл, шинжилгээ хийж өгөх (баримталсан арга хандлагыг тайлбарлах, техникийн дэмжлэг үзүүлэх).

604.4A3 Татварын тайлан бэлтгэх үйлчилгээ гол төлөв түүхэн мэдээлэлд үндэслэдэг бөгөөд үндсэндээ хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хууль, түүнчлэн өмнөх болон тогтсон практикийн дагуу ийм түүхэн мэдээллийг шинжилж толилуулдаг. Түүнээс гадна, татварын байгууллага зохистой гэж үзвэл татварын

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тайлангуудыг шалгах эсвэл батлах үйл явц бий.

Нягтлан Бодох Бүртгэлийн Бичилт Хийхийн Тулд Татварын Тооцоолол Хийх

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

604.5A1 Аудитын үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бичилтийг нь бэлтгэх зорилгоор тайлант үеийн болон хойшлогдсон татварын өр төлбөр (эсвэл хөрөнгө)-ийн тооцооллыг гүйцэтгэж, дараа нь түүндээ аудит хийх нь өөрийгөө хянах аюул заналыг компанид бий болгоно.

604.5 A2 Аудитын үйлчлүүлэгчид ийм тооцоо хийснээр үүссэн аюул заналын далайцыг үнэлэхэд 604.3A2-р параграфт заасан хүчин зүйлээс гадна хамаарах хүчин зүйл бол уг тооцоолол нь компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлж болох эсэх асуудал юм.

Нийтийн Сонирхолтой Аж Ахуйн Нэгж Биш Аудитын Үйлчлүүлэгчид

604.5A3 Аудитын үйлчлүүлэгч нь нийтийн сонирхолтой аж ахуйн нэгж биш байх үед өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг багтаадаг:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах.

Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж болох Аудитын Үйлчлүүлэгчид

Ш604.6 Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчийн хувьд, компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор тайлант үеийн болон хойшлогдсон татварын өр төлбөр (эсвэл хөрөнгө)-ийн тооцооллыг компани хийх ёсгүй.

604.6A1 Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллаг бус нөлөөтэй бөгөөд компанийн дүгнэлт гаргах гэж тайлант үеийн болон хойшлогдсон татварын өр төлбөр (эсвэл хөрөнгө)-ийг тооцоолоход 604.5A3-р параграфт заасан өөрийгөө хянах аюул заналыг арилгах үйл ажиллагааны жишээг ашиглана.

Татварын Төлөвлөлт болон Татварын Бусад Зөвлөх Үйлчилгээ

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

604.7A1 Татварын төлөвлөлт болон татварын бусад зөвлөх үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул занал учруулж болзошгүй юм.

604.7A2 Үйлчлүүлэгчид татварын төлөвлөлт ба бусад татварын зөвлөх үйлчилгээнд ажил хэргээ татварын хувьд үр ашигтайгаар хэрхэн зохион байгуулах, эсвэл татварын шинэ хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлэх талаар зөвлөх гэх мэт өргөн хүрээний үйлчилгээ багтдаг.

604.7A3 Аудитын үйлчлүүлэгчид татварын төлөвлөлт болон татварын бусад зөвлөх үйлчилгээ үзүүлснээр үүссэн өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналын далайцыг үнэлэхэд 604.3A2-р параграфт заасан хүчин зүйлээс гадна дараах хүчин зүйлс багтдаг:

- Санхүүгийн тайланд татварын зөвлөгөөг зохих ёсоор тусгах аргыг тодорхойлоход хамаарах субъектив байдлын түвшин.
- Санхүүгийн тайланг бэлтгэхээс өмнө, татварын арга хандлагыг тусдаа дүрмээр дэмжсэн эсвэл татварын эрхтэй байгууллагаас тодруулж өгсөн эсэх.
Жишээлбэл, татварын төлөвлөлт болон бусад татварын зөвлөх үйлчилгээний үр дүнд өгсөн зөвлөгөө нь:
 - Татварын эрхтэй байгууллага эсвэл өмнөх байгууллагаар илт дэмжигдсэн эсэх.
 - Тогтсон практик мөн эсэх.
 - Давамгайлах хандлагатай байх магадлал бүхий татварын хуульд үндэслэсэн эсэх.
- Санхүүгийн тайланд татварын зөвлөгөөний үр дүнгийн үзүүлэх материаллаг нөлөөний далайц.
- Татварын зөвлөгөөний үр өгөөж нь нягтлан бодох бүртгэлийн арга хандлага болон санхүүгийн тайлан

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

дахь толилуулгаас хамаарч байгаа эсэх, уг нягтлан бодох бүртгэлийн арга болон толилуулга нь холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцэж буй эсэхэд эргэлзээ байгаа эсэх.

604.7A4 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараах жишээг оруулна:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах нь өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.
- Татварын байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.

Татварын Зөвлөгөөний Үр Дүн нь Нягтлан Бодох Бүртгэлийн Тодорхой Арга Хандлага эсвэл Толилуулгаас Хамааралтай Байх Тохиолдол

Ш604.8 Татварын зөвлөгөөний үр дүн нь нягтлан бодох бүртгэлийн тодорхой арга хандлага эсвэл санхүүгийн тайлангийн толилуулгаас хамаардаг бөгөөд дараах шинж илэрч байвал, компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид татварын зөвлөгөө үзүүлэх ёсгүй. Үүнд:

- (а) Холбогдох нягтлан бодох бүртгэлийн арга хандлагын зохистой эсэх болон толилуулга нь хамаарах санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцэж буй эсэх талаар аудитын баг нь ул үндэслэлтэй эргэлзэж байгаа эсэх.
- (б) Татварын зөвлөгөөний үр дүн эсвэл үр дагавар нь компанийн дүгнэлтээ гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй байх эсэх.

Үнэлгээг Багтаасан Татварын Үйлчилгээ

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

604.9A1 Аудитын үйлчлүүлэгчид татварын үнэлгээний үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул занал учруулж болзошгүй.

604.9A2 Үнэлгээг зөвхөн татварын зорилгоор гүйцэтгэж байгаа бөгөөд үнэлгээний үр дүн нь санхүүгийн тайланд шууд нөлөөлөхгүй (өөрөөр хэлбэл, зөвхөн татвартай холбоотой бүртгэлийн бичилтүүд л санхүүгийн тайланд нөлөөлнө) байх үед компани, сүлжээ компани нь үнэлгээний үйлчилгээ гүйцэтгэх боломжтой. Хэрэв ийм үнэлгээний санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө материаллаг бус эсвэл түүнийг татварын эрхтэй байгуулага эсвэл үүнтэй ижил төстэй эрхтэй байгууллагаас хөндлөнгийн хяналт хийдэг бол ихэвчлэн аюул занал үүсдэггүй.

604.9A3 Татварын зорилгоор гүйцэтгэсэн үнэлгээг гадны этгээдээр шалгуулдаггүй бөгөөд нөлөө нь санхүүгийн тайлангийн хувьд материаллаг бол, 604.3A2-р параграфт зааснаас гадна, эдгээр үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үүссэн өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлс дараах байна:

- Үнэлгээний аргачлал нь татварын хууль тогтоомж, бусад өмнөх эсвэл одоогийн практикаар дэмжигдэж буй далайц.
- Үнэлгээнд заавал байдаг субъектив байдлын түвшин.
- Суурь тоон мэдээний найдвартай байдал ба далайц.

604.9A4 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараах жишээг оруулна:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах нь өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.
- Татварын эрхтэй байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлж болох юм.

604.9A5 Татварын тайлагналын үүрэг эсвэл татвараа төлөвлөх аудитын үйлчлүүлэгчийнхээ зорилгод нь туслахын тулд компани, сүлжээ компани татварын үнэлгээг хийж өгөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд үнэлгээний үр дүн нь санхүүгийн тайланд шууд нөлөө үзүүлнэ. Энэ тохиолдолд, үнэлгээний үйлчилгээтэй

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

холбоотой Дэд хэсэг 603-д дурдсан шаардлага, ашиглах материалыг мөрддөг.

Татварын Маргааныг Шийдвэрлэхэд Туслалцаа Үзүүлэх

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 604.10A1 Аудитын үйлчлүүлэгчид татварын маргаан шийдвэрлэхэд нь тусалбал өөрийгөө хянах болон өмгөөлөх аюул занал үүсэх боломжтой.
- 604.10A2 Татварын эрхтэй байгууллагаас, тодорхой асуудлаар үйлчлүүлэгчийн гаргасан үндэслэлийг хүлээж аваагүйгээ түүнд албан ёсоор мэдэгдсэн, мөн тухайн татварын эрхтэй байгууллага эсвэл тухайн үйлчлүүлэгчийн аль нэг тухайн асуудлыг албан ёсоор жишээлбэл, нийтийн индэр эсвэл шүүхээр шийдвэрлүүлэхээр хандсан байгаа тохиолдолд компанид татварын маргаан үүсэх боломжтой.
- 604.10A3 Параграф 604.3A2-оос гадна, татварын маргааныг шийдвэрлэхэд нь аудитын үйлчлүүлэгчид туслалцаа үзүүлснээр үүссэн өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналын дайлацыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:
- Татварын маргааныг шийдвэрлэхэд удирдлагын гүйцэтгэдэг үүрэг.
 - Маргааны үр дүн нь компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх далайц.
 - Компанийн өгсөн зөвлөгөө нь татварын маргаан үүсгэх эсэх.
 - Тухайн асуудал нь татварын хууль тогтоомж, өмнөх болон тогтсон практикаар дэмжигдэж байгаа эсэх.
 - Маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг олон нийтэд ил тод явуулдаг эсэх.
- 604.10A4 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараах жишээг оруулна:
- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулснаар өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой.
 - Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулснаар өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болно.

Татварын Асуудлыг Шийдвэрлүүлэхэд Өмгөөлөгчөөр Оролцох

- Ш604.11** Компани, сүлжээ компани нь дараах зүйлийг багтаасан татварын үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлэх ёсгүй. Үүнд:
- (a) Татварын асуудлыг шийдвэрлүүлэхээр нийтийн индэр эсвэл шүүхийн өмнө үйлчлүүлэгчийн өмгөөлөгчөөр оролцох;
 - (b) Компанийн дүгнэлтээ гаргах ёстой санхүүгийн тайлангийн хувьд уг дүн нь материаллаг бол.
- 604.10A1 Дээрх Ш604.11-р параграф нь нийтийн индэр эсвэл шүүхээр орохын өмнө хэлцэгдэж буй асуудлаар үйлчлүүлэгчид үргэлжлүүлэн, жишээлбэл дараах чиглэлээр зөвлөгөө өгөхийг компани, сүлжээ компанид хориглодоггүй:
- Мэдээллийн чанартай онцгой хүсэлтэд хариу өгөх,
 - Гүйцэтгэсэн ажлын нотолгоо болон бодит тайлангаар хангах
 - Тухайн зүйлд хамаарах татварын асуудлыг шинжлэхэд нь үйлчлүүлэгчид туслах.
- 604.11A2 “Олон нийтийн индэр буюу шүүх”-ийг юу бүрдүүлэх нь тодорхой нэг хууль эрхзүйн орчинд татварын хэргүүдийг хэрхэн хэлэлцэхээс хамаардаг ойлголт юм.

ДЭД ХЭСЭГ 605 – ДОТООД АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 605.1 Аудитын үйлчлүүлэгчид дотоод аудитын үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 605.2 Аудитын үйлчлүүлэгчид дотоод аудитын үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид дотоод аудитын зарим үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 605.3A1 Дотоод аудитын үйлчилгээнд, аудитын үйлчлүүлэгчийн дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлд туслах ажил багтдаг. Дотоод аудитын үйл ажиллагаанд дараахыг хамруулдаг:
- Дотоод хяналтын мониторинг - хяналтыг нягтлах, тэдгээрийн үйл ажиллагааг ажиглан хянаж, сайжруулах зөвлөмж өгөх;
 - Дараах байдлаар санхүүгийн болон ажиллагааны мэдээллийг шалгах:
 - Санхүүгийн болон ажиллагааны мэдээллийг тодорхойлж, хэмжиж, ангилан тайлагнах арга барилыг нягтлах,
 - Ажил гүйлгээ, үлдэгдэл болон горимуудыг нарийвчлан тестлэх үйл явц гэх мэт тухайлсан зүйлсийг онцгойлон шалгах;
 - Байгууллагын үйл ажиллагаа, үүний дотор санхүүгийн бус үйл ажиллагааны ариг гамтай, үр ашигтай ба бүтээмжтэй ашиглалтыг нягтлах;
 - Дараах зүйлд нийцсэн байдлыг нягтлах:
 - Хууль, журам болон бусад гадны шаардлагууд,
 - Удирдлагын бодлого ба чиглэл, бусад дотоодын шаардлага.
- 605.3A2 Дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, зорилтууд нь харилцан адилгүй бөгөөд аж ахуйн нэгжийн хэмжээ, бүтэц, гүйцэтгэх ба засаглах эрхтэй удирдлагын шаардлагаас хамааралтай юм.
- Ш605.4 Аудитын үйлчлүүлэгчид дотоод аудитын үйлчилгээ үзүүлэхдээ компани дараах зүйлийн талаар сэтгэл хангалуун байх ёстой:
- (a) Үйлчлүүлэгч нь дараах үүргийг хүлээж ажиллах чадварлаг бөгөөд зохих хүний нөөцийг, болж өгвөл ахлах удирдлага дотроос олж томилох:
 - (i) Дотоод аудитын ажиллагааг байнга хариуцах;
 - (ii) Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянан шинжлэх, сахин мөрдүүлэх үүрэг хариуцлага хүлээх.
 - (b) Үйлчлүүлэгчийн удирдлага эсвэл засаглах эрхтэй этгээдүүд дотоод аудитын үйлчилгээний хамрах хүрээ, эрсдэл ба давтамжийг хянаж, үнэлж, баталдаг байх;
 - (v) Үйлчлүүлэгчийн удирдлага нь дотоод аудитын үйлчилгээний зохистой байдал болон эдгээр үйлчилгээг үзүүлснээр илрүүлсэн зүйлсийг үнэлдэг байх;
 - (г) Үйлчлүүлэгчийн удирдлага нь дотоод аудитын үйлчилгээний үр дүнгээр өгсөн аль зөвлөмжийг хэрэгжүүлбэл зохихыг үнэлж тодорхойлж, мөн хэрэгжүүлэх үйл явцыг удирддаг;
 - (д) Үйлчлүүлэгчийн удирдлага нь дотоод аудитын үйлчилгээгээр олж илрүүлсэн чухал зүйлс болон зөвлөмжийн талаар засаглах эрхтэй этгээдүүдэд тайлагнадаг.
- 605.4 A1 Параграф Ш600.7 нь удирдлагын хариуцлага хүлээхийг компани, сүлжээ компанид хориглодог. Тухайн үйлчлүүлэгчийн дотоод аудитын ажлын томоохон хэсгийг гүйцэтгэснээр дотоод аудитын үйлчилгээ

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

үзүүлж буй компанийн ажилтнууд нь үйлчлүүлэгчийн удирдлагын зарим хариуцлагыг өөртөө хүлээхэд хүргэнэ.

- 605.4A2 Удирдлагын үүрэг хариуцлагыг агуулсан дотоод аудитын үйлчилгээний жишээнд дараахыг оруулна:
- Дотоод аудитын бодлого, эсвэл дотоод аудитын үйл ажиллагааны стратеги чиглэлийг тогтоох.
 - Аж ахуйн нэгжийн дотоод аудитын ажилтнуудын үйл ажиллагааг чиглүүлж, хариуцлагыг нь хүлээх.
 - Дотоод аудитын ажлын үйл ажиллагааны үр дүнд өгсөн зөвлөмжөөс алийг нь хэрэгжүүлэхийг шийдэх.
 - Удирдлагын өмнөөс, дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнг засаглах эрхтэй этгээдүүдэд тайлагнах.
 - Ажилтнуудын талаарх тоон мэдээнд хандах эрхийг хянах, өөрчлөлтийг нь батлах гэх мэт дотоод аудитыг бүрдүүлдэг горимыг гүйцэтгэх.
 - Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянан шинжлэх, сахин мөрдүүлэх үүрэг хариуцлага хүлээх.
 - Дотоод аудитын үүргийг хэсэгчлэн эсвэл бүгдийг гүйцэтгүүлэхээр гаднаас дотоод аудитын үйлчилгээ авах, үүнд компани, сүлжээ компани нь дотоод аудитын ажлын хамрах хүрээг тодорхойлох үүрэгтэй; мөн дээр дурдсан үүрэг хариуцлагаас нэг ба түүнээс олныг хариуцаж болно.
- 605.4A3 Компани нь аудитын гэрээт ажилдаа дотоод аудитын чиг үүргийг ашиглаж байвал, энэ ажлын зүй зохистой эсэхийг үнэлэх горимуудыг гүйцэтгэхийг АОУС-д шаарддаг. Үүний нэгэн адил, аудитын үйлчлүүлэгчид дотоод аудитын үйлчилгээ үзүүлэх ажлыг компани гүйцэтгэхээр хүлээн авах үед, энэ үйлчилгээний үр дүнг гадаад аудит хийхэд ашиглаж болно. Аудитын ажлын баг дотоод аудитын үйлчилгээний үр дүнг ашиглах боломжтой учраас, хэрэв дараах арга хэмжээг авахгүй бол, өөрийгөө хянах аюул занал үүснэ:
- (а) Тэдгээр үр дүнг зохих ёсоор үнэлэх;
 - (б) Дотоод аудитын ажлыг компанийн гишүүн бус этгээд гүйцэтгэсэн тохиолдолд хэрэгжүүлж болох байсан түвшинд мэргэжлийн үл итгэх байдлыг хэрэгжүүлэх.
- 605.4A4 Өөрийгөө хянах аюул заналын далайцыг үнэлэхэд хамаарах хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Холбогдох санхүүгийн тайлангийн дүнгүүдийн материаллаг байдал;
 - Тэдгээр санхүүгийн тайлангийн дүнгүүдэд хамааралтай батламж мэдэгдлийг буруугаар илэрхийлэх эрсдэл;
 - Гадаад аудитын явцад, аудитын багийн гишүүн уг дотоод аудитын үйлчилгээнд найдаж болох түвшин.
- 605.4A5 Өөрийгөө хянах аюул заналын далайцыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн гишүүн бус мэргэжилтнээр уг үйлчилгээг гүйцэтгүүлэх явдал юм.

Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж болох Аудитын Үйлчлүүлэгчид

- Ш605.5** Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид дараах зүйлд хамаарах дотоод аудитын үйлчилгээг компани, сүлжээ компани үзүүлж болохгүй:
- (а) Санхүүгийн тайлагналтай холбоотой дотоод хяналтын үлэмж хэсэг;
 - (б) Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд болон санхүүгийн тайланд дангаараа, эсвэл хамтдаа материаллаг ач холбогдол бүхий мэдээллийг боловсруулж буй санхүүгийн бүртгэлийн систем;
 - (в) Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг ач холбогдол бүхий дүнгүүд, эсвэл тодруулгууд.

ДЭД ХЭСЭГ 606 – МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 606.1. Аудитын үйлчлүүлэгчид мэдээллийн технологи (МТ)-ийн системийн үйлчилгээг үзүүлэх нь өөрийгөө хянах аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 606.2 Аудитын үйлчлүүлэгчид мэдээллийн технологийн системийн үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид зарим мэдээллийн технологийн системийн үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

606.3A1 Мэдээллийн технологийн системтэй холбоотой үйлчилгээний жишээнд техник хангамж ба программ хангамжийн системүүдийг зохиомжлох, эсвэл хэрэгжүүлэх үйлчилгээ багтдаг. Мэдээллийн технологийн системүүд нь дараах чиг үүргийг гүйцэтгэх боломжтой:

- (а) Анхдагч тоон мэдээг нэгтгэх;
- (б) Санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын нэг хэсгийг бүрдүүлэх;
- (в) Бүртгэлийн бичилтүүд, санхүүгийн тайлан, холбогдох тодруулгад нөлөөлдөг мэдээллийг боловсруулах.

Гэхдээ, МТ-ийн системд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд эсвэл санхүүгийн тайлагнал буюу санхүүгийн тайланд тавих дотоод хяналтад хамааралгүй зүйлсийг багтаасан байх боломжтой.

606.3A2 Параграф Ш600.7-д, удирдлагын хариуцлагыг хүлээхийг компани, сүлжээ компанид хориглосон байдаг. Компани, сүлжээ компанийн ажилтнууд удирдлагын хариуцлага хүлээдэггүй учраас аудитын үйлчлүүлэгчид дараах МТ-ийн системийн үйлчилгээ үзүүлэх нь ихэвчлэн аюул занал үүсгэдэггүй:

- (а) Санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналттай холбоогүй МТ-ийн системийг зохиомжлох эсвэл хэрэгжүүлэх;
- (б) Бүртгэлийн бичилтүүд, санхүүгийн тайлангуудын чухал хэсгийг бүрдүүлж буй мэдээллийг боловсруулах МТ-ийн системийг зохиомжлох эсвэл хэрэгжүүлэх;
- (в) Хэрэв үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлэн хийх тохиргоо нь төдийлөн их биш бол компани, сүлжээ компанийн боловсруулаагүй бөгөөд “бэлэн байгаа” нягтлан бодох бүртгэл эсвэл санхүүгийн мэдээллийг тайлагнах программ хангамжийг хэрэгжүүлэх;
- (г) Өөр нэг үйлчилгээ үзүүлэгч, эсвэл үйлчлүүлэгчийн өөрөө зохиомжилсон, хэрэгжүүлсэн эсвэл ажиллуулсан МТ-ийн системийг үнэлж, зөвлөгөө өгөх.

Ш606.4 Аудитын үйлчлүүлэгчид МТ-ийн системийн үйлчилгээ үзүүлж байхдаа компани, сүлжээ компани нь дараах зүйлийн талаар итгэлтэй байх ёстой:

- (а) Үйлчлүүлэгч нь дотоод хяналтын системийг бий болгож, хянах хариуцлагаа ойлгож, зөвшөөрдөг;
- (б) Үйлчлүүлэгч нь техник хангамж болон программ хангамжийн системүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхтэй холбоотой удирдлагын бүх шийдвэрийг гаргах хариуцлагыг болж өгвөл ахлах удирдлагын дундаас шаардлага хангасан ажилтанд даалгадаг;
- (в) Үйлчлүүлэгч нь зохиомж болон хэрэгжүүлэлтийн үйл явцад хамаарах бүх удирдлагын шийдвэрийг гаргадаг;
- (г) Үйлчлүүлэгч нь системийн зохиомж болон хэрэгжүүлэлтийн үр дүн ба чадавхийг үнэлдэг;
- (д) Үйлчлүүлэгч нь үйлдлийн систем (программ хангамж эсвэл техник хангамж) болон түүгээр боловсруулж, ашигладаг тоон мэдээний төлөө хариуцлага хүлээдэг.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

606.4A1 Аудитын үйлчлүүлэгчид МТ-ийн системийн үйлчилгээ үзүүлснээр бий болсон өөрийгөө хянах аюул заналыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:

- Үйлчилгээний мөн чанар.
- МТ-ийн системийн шинж чанар ба тэдгээр нь үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангуудад нөлөөлдөг далайц.
- Аудитын нэг хэсэг болох МТ-ийн тодорхой системд найдаж болох түвшин.

606.4A2 Өөрийгөө хянах аюул заналын далайцыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол аудитын багийн гишүүн бус мэргэжилтнээр уг үйлчилгээг гүйцэтгүүлэх явдал юм.

Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид

Ш606.5 Компани, сүлжээ компани нь дараах шинж чанар бүхий МТ-ийн системийн үйлчилгээг, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж болох аудитын үйлчлүүлэгчид үзүүлж болохгүй:

- (a) Санхүүгийн тайлагналтай холбоотой дотоод хяналтын үлэмж хэсгийг бүрдүүлдэг;
- (b) Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд болон санхүүгийн тайланд үлэмж ач холбогдол бүхий мэдээллийг боловсруулдаг.

ДЭД ХЭСЭГ 607 – ЗАРГА ШИЙДВЭРЛЭХЭД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 607.1 Аудитын үйлчлүүлэгчид шүүхийн тодорхой зарим заргыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлж буй үйлчилгээ нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 607.2 Аудитын үйлчлүүлэгчид шүүхийн заргыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид шүүхийн заргыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 607.3A1 Зарга шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд дараах үйл ажиллагаа багтаж болно:
- Баримт бичгийг цэгцлэх болон гаргуулах
 - Шинжээч гэрчийн үүрэг гүйцэтгэх,
 - Учирсан хохирол болон зарга эсвэл хуулийн бусад маргааны үр дүнд авлага эсвэл өглөг болж магадгүй бусад мөнгөн дүнгийн хэмжээг тооцоолох.
- 607.3A2 Зарга шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлснээр үүссэн өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:
- Үйлчилгээ үзүүлдэг хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин, тухайлбал, шинжээч гэрчийг сонгосон бөгөөд шүүхээс томилсон эсэх.
 - Үйлчилгээний шинж чанар, шинж чанар.
 - Зарга шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний үр дүн нь компанийн дүгнэлт гаргах гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх далайц.
- 607.3A3 Өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний нэг жишээ бол ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах явдал юм.
- 607.3A4 Хэрэв компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид шүүхийн заргыг шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд уг үйлчилгээнд компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц учирсан хохирол болон бусад мөнгөн дүнгийн хэмжээг тооцоолох үйлчилгээ багтсан бол, Дэд хэсэг 603-г заасан үнэлгээний үйлчилгээтэй холбоотой шаардлага ба ашиглах материалыг мөрдөнө.

ДЭД ХЭСЭГ 608 – ХУУЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

- 608.1 Аудитын үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул занал учруулж болзошгүй.
- 608.2 Аудитын үйлчлүүлэгчид хуулийн үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай байна. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, аудитын үйлчлүүлэгчид хуулийн зарим үйлчилгээ үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

- 608.3A1 Хуулийн үйлчилгээ гэж дараах шаардлагыг заавал хангасан хувь хүний үзүүлдэг үйлчилгээг хэлнэ:
- (a) Хуулийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хуулийн боловсролыг эзэмшсэн байх;
 - (b) Үйлчилгээ үзүүлэх гэж байгаа хууль эрхзүйн орчны шүүхийн өмнө хуулийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан байх.

Хуулийн Зөвлөхийн Үүрэг Гүйцэтгэх

- 608.4A1 Ийм хуулийн үйлчилгээнд, хууль эрхзүйн ямар орчинд харъяалагдахаас хамааран өргөн хүрээтэй, олон төрөл чиглэлийг хамруулах боломжтой бөгөөд аудитын үйлчлүүлэгчид үзүүлдэг үйлдвэрлэлийн болон арилжааны шинжтэй дараах үйлчилгээ багтдаг:

- Гэрээнд дэмжлэг үзүүлэх.
- Ажил гүйлгээ хийхэд нь аудитын үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх.
- Нэгдэж нийлэх ба худалдан авах.
- Аудитын үйлчлүүлэгчийн дотоод хуулийн хэлтэст туслалцаа үзүүлэх
- Хуулийн хянамгай байдал/ хязгаарлагдмал шалгалт хийх, бүтцийн өөрчөлт хийх.

- 608.4A2 Аудитын үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлснээр бий болсон өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:

- Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангай холбоотойгоор тусгайлсан асуудлын материаллаг байдлын түвшин.
- Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хууль зүйн асуудлын нарийн төвөгтэй байдал болон шүүн тунгаалтын хэмжээ.

- 608.4A3 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг багтаана:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах нь өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.

Хуулийн Ерөнхий Зөвлөхөөр Ажиллах

- Ш608.5** Компани, сүлжээ компанийн партнер эсвэл ажилтан нь аудитын үйлчлүүлэгчийн хуулийн ерөнхий зөвлөхөөр ажиллаж болохгүй.

- 608.5A1 Хуулийн ерөнхий зөвлөхийн албан тушаал бол ихэвчлэн компанийн хуулийн асуудлыг өргөн хүрээнд хариуцдаг, удирдлагын ахлах түвшний албан тушаал байдаг.

Өмгөөлөгчөөр Ажиллах

- Ш608.6 Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө бүхий дүнтэй зарга эсвэл маргааныг шийдвэрлэхэд аудитын үйлчлүүлэгчийн өмгөөлөгчийн үүргийг компани, сүлжээ компани гүйцэтгэж болохгүй.

608.6 А1 Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй дүн бүхий зарга эсвэл маргааныг шийдвэрлэхэд аудитын үйлчлүүлэгчийн өмгөөлөгчийн үүргийг гүйцэтгэж байх үед үүссэн өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээ байж болох жишээнд дараахыг багаана:

- Ийм үйлчилгээ гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах.

ДЭД ХЭСЭГ 609 – АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

609.1 Аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлэх нь хувийн сонирхол, танил талын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй.

609.2 Аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай юм. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

609.3A1 Ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээнд дараах үйл ажиллагааг хамруулах боломжтой:

- Ажлын байрны тодорхойлолт боловсруулах.
- Боломжит нэр дэвшигчдийг тодорхойлох, сонгох үйл явцыг боловсруулах.
- Нэр дэвшигчийг эрж хайх буюу олох.
- Аажил үүрэгт тохирох боломжит нэр дэвшигчдийг дараах байдлаар шүүн сонгох:
 - o Өргөдөл гаргагчдын мэргэшил, ур чадварыг үнэлж, зарласан ажлын байрны шаардлагад тэдгээрийн тохирох эсэхийг тодорхойлох.
 - o Боломжит нэр дэвшигчдийг лавлагаагаар шалгах.
 - o Тохирох нэр дэвшигчидтэй ярилцлага хийх ба сонгох, тэдний ур чадварын талаар зөвлөгөө өгөх.
- Хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг тодорхойлох, цалин хөлс, цаг, бусад нөхөн олговор зэрэг тодорхой асуудлуудаар хэлэлцэж тохиролцох.

609.3 A2 Параграф Ш600.7-д, удирдлагын хариуцлагыг хүлээхийг компани, сүлжээ компанид хориглосон байдаг. Компани, сүлжээ компанийн ажилтнууд удирдлагын хариуцлага хүлээдэггүй учраас аудитын үйлчлүүлэгчид дараах үйлчилгээ үзүүлэх нь ихэвчлэн аюул занал үүсгэдэггүй:

- Өргөдөл гаргасан хүмүүсийн мэргэжлийн чадварыг үнэлэх, зарласан албан тушаалд тухайн өргөдөл гаргагч тохирох эсэх талаар зөвлөх.
- Санхүүгийн нягтлан бодох бүртгэл, захиргааны эсвэл хяналтын албан тушаалд нэр дэвшигчидтэй ярилцлага хийх, тэдний ур чадварын талаар зөвлөгөө өгөх.

Ш609.4 Аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлж байхдаа компани, сүлжээ компани нь дараах зүйлийн талаар итгэлтэй байх ёстой:

- (а) Үйлчлүүлэгч нь зарласан албан тушаалд ажилтан авахтай холбоотой удирдлагын бүх шийдвэр гаргах хариуцлагыг болж өгвөл ахлах удирдлагын дундаас шаардлага хангасан ажилтанд даалгадаг;
- (в) Үйлчлүүлэгч нь ажилтан ажилд авах үйл явцад хамаарах бүх удирдлагын шийдвэрийг гаргадаг бөгөөд үүнд дараах хамаарна:
 - Боломжит өргөдөл гаргагчдын тохирох эсэхийг тодорхойлж, тухайн албан тушаалд тохирох хүнийг сонгох.
 - Хөдөлмөр эрхлэлтийн нөхцлийг тодорхойлох, цалин хөлс, цаг, бусад нөхөн олговор зэрэг

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тодорхой асуудлаар хэлэлцэж тохиролцох.

609.5A1 Аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлснээр бий болсон хувийн ашиг сонирхол, танил тал, айлган сүрдүүлэх аюул заналыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:

- Хүсэлт тавьсан тусламжийн мөн чанар.
- Ажилд авах гэж байгаа хувь хүний гүйцэтгэх үүрэг.
- Өргөдөл гаргагч ба зөвлөгөө эсвэл үйлчилгээ үзүүлсэн компанийн хоорондох ашиг сонирхлын зөрчил эсвэл харилцаа холбоо.

609.5A2 Хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах явдал юм.

Ажилд Авах Үйлчилгээнд Хориглодог Үйл Ажиллагаа

Ш609.6 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн өмнөөс тохиролцогч талын үүрэг гүйцэтгэж болохгүй.

Ш609.7 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчид ажилтан сонгон шалгаруулах үйлчилгээ үзүүлэхдээ:

- (a) Нэр дэвшигчийг эрж хайх буюу олох;
- (b) Дараах албан тушаалтай холбогдуулан боломжит нэр дэвшигчдийг лавлагаагаар шалгах:
 - (i) Үйлчлүүлэгч аж ахуйн нэгжийн захирал буюу ажилтан;
 - (ii) Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд эсвэл санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд үлэмж нөлөө үзүүлэхүйц ахлах түвшний удирдлагын гишүүн.

ДЭД ХЭСЭГ 610 – КОРПОРАЦИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Танилцуулга

610.1 Корпорацийн санхүүгийн үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлэх нь өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул занал үүсгэж болзошгүй.

610.2 Аудитын үйлчлүүлэгчид корпорацийн санхүүгийн үйлчилгээ үзүүлж байх үед, энэ дэд хэсгийн тусгай шаардлага ба ашиглах материалаас гадна, 600.1-Ш600.10-р параграф дахь шаардлага ба ашиглах материал нь онолын үзэл баримтлалыг дээрх тохиолдолд хэрхэн мөрдөхөд хамааралтай юм. Энэ дэд хэсэгт, учирсан аюул заналыг хамгаалалтын арга хэмжээ аван шийдвэрлэж үл чадах зарим нөхцөлд, корпорацийн санхүүгийн зарим үйлчилгээг аудитын үйлчлүүлэгчид үзүүлэхийг компани, сүлжээ компанид хориглодог шаардлагыг оруулсан байна.

Шаардлага ба Ашиглах Материал

Аудитын Бүх Үйлчлүүлэгч

610.3A1 Өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх болон аюул заналыг үүсгэх боломжтой корпорацийн санхүүгийн үйлчилгээнд дараахыг дурдаж болно:

- Үйлчлүүлэгчид корпорацийн стратегийг боловсруулахад туслах.
- Аудитын үйлчлүүлэгчийн худалдан авч эзэмших боломжтой, зорилтот объектыг олж тогтоох.
- Зарж борлуулах гүйлгээний талаар зөвлөх.
- Санхүүжилт босгох ажил гүйлгээний талаар зөвлөх.
- Компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд тусгагдах дүнд шууд нөлөөлөх корпорацийн санхүүгийн гүйлгээг бүтэцчилэх эсвэл санхүүгийн тохиролцоо хийх талаар зөвлөх.

610.3A2 Аудитын үйлчлүүлэгчид корпорацийн санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр бий болсон аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:

- Санхүүгийн тайланд өгсөн корпорацийн санхүүгийн зөвлөгөөний үр дүн буюу үр дагаврын хувьд

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

зохистой арга хандлагыг тодорхойлохдоо авч үзсэн субъектив байдлын түвшин.

- Дараах зүйлийн далайц:
 - Корпорацийн санхүүгийн зөвлөгөөний үр дүн нь санхүүгийн тайланд тусгагдсан дүнд шууд нөлөөлөх.
 - Тухайн дүнгүүд нь санхүүгийн тайланд хэр материаллаг байх.
- Корпорацийн санхүүгийн зөвлөгөө хэр үр өгөөжтэй байх нь нягтлан бодох бүртгэлийн тухайлсан арга хандлага, эсвэл санхүүгийн тайлангийн толилуулгаас хамаардаг бөгөөд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал дагуу холбогдох нягтлан бодох бүртгэлийн хандлага эсвэл толилуулга нийцтэй эсэх талаар эргэлзээ гардаг.

610.3A3 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг багтаана:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ аудитын ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулснаар өөрийгөө хянах эсвэл өмгөөлөх аюул заналыг тодорхойлох боломжтой.
- Ийм үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй тохирох хянан шалгагчаар гүйцэтгэсэн аудитын ажил буюу үйлчилгээг хянуулах нь өөрийгөө хянах аюул заналыг тодорхойлох боломжтой болгоно.

Үзүүлэхийг Хориглосон Корпорацийн Санхүүгийн Үйлчилгээ

Ш610.4 Компани, сүлжээ компани нь аудитын үйлчлүүлэгчийн хувьцааг сурталчлах, арилжих буюу түүнд баталгаа өгөх зэрэг корпорацийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ёсгүй.

Ш610.5 Хэрэв корпорацийн санхүүгийн зөвлөгөөний үр ашиг нь нягтлан бодох бүртгэлийн тодорхой хандлага эсвэл компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайлан дахь толилуулгаас хамаарах бөгөөд мөн:

- (a) Холбогдох нягтлан бодох бүртгэлийн хандлага эсвэл толилуулга нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу тохиромжтой эсэх талаар аудитын багт ул үндэслэлтэй эргэлзээ төрж байвал;
- (б) Корпорацийн санхүүгийн зөвлөгөөний үр дүн эсвэл үр дагавар нь компанийн дүгнэлт өгөх гэж байгаа санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр байвал ийм үйлчлүүлэгчид тэрээр корпорацийн санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ёсгүй.

ХЭСЭГ 800

АШИГЛАХ БА ТҮГЭЭХ НӨХЦӨЛД НЬ ХЯЗГААРЛАЛТ ТАВЬСАН, ТУСГАЙ ЗОРИЛГОТой САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТАЙЛАН (АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖИЛ)

Танилцуулга

- 800.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 800.2 Энэ хэсэгт, Бүлэг 4А-д тусгай зорилготой санхүүгийн тайланд аудит хийх гэрээт ажлын тайланг ашиглах ба нийтэд түгээхийг тодорхой тохиолдолд зөвшөөрсөн зарим өөрчлөлтийг тусгасан болно. Энэ хэсэгт, Ш800.3-р параграфт заасан нөхцөлийн дагуу, ашиглах ба нийтэд түгээх хязгаарлалт бүхий тайлан гаргах гэрээт ажлыг “зохистой аудитын гэрээт ажил” гэж үзнэ.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

Ш800.3 Тусгай зорилготой санхүүгийн тайланд аудит хийх гэрээт ажлын талаар компани нь ашиглах ба нийтэд түгээх хязгаарлалт бүхий тайлан гаргахаар төлөвлөж байвал, энэ хэсэгт зөвшөөрсөн өөрчлөлтийн хувьд, Бүлэг 4А-ийн хараат бус байдлын шаардлагыг зөвхөн дараах тохиолдолд мөрдөх боломжтой хэмээн үзэх ёстой:

- (а) Компани тухайн үйлчилгээг үзүүлэхдээ мөрдвөл зохих хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлагын талаар тайлангийн зорилтот хэрэглэгчидтэй харилцаж, мэдээлдэг бол;
- (б) Тайлангийн зорилтот хэрэглэгчид нь тайлангийн зорилго, баталгаажуулах асуудлын мэдээлэл болон хязгаарлалтын талаар ойлголттой бөгөөд уг өөрчлөлтийг дагаж мөрдөхийг илэрхий зөвшөөрч байвал.

800.3А1 Тайлангийн зорилтот хэрэглэгчид нь гэрээт ажлын мөн чанар, цар хүрээг тогтооход шууд эсвэл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхтэй удирдлага буюу төлөөлөгчөөр дамжуулан шууд бусаар оролцох замаар тайлангийн зорилго ба хязгаарлалтын талаар ойлголт авах боломжтой. Аль ч тохиолдолд, дээрх оролцоо нь хараат бус байдал, үүнд онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхтэй холбоотой нөхцөлийн талаар компанийн зүгээс зорилтот хэрэглэгчидтэй ярилцаж, харилцахад тус дэмж болдог. Түүнчлэн, хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлагыг зорилтот хэрэглэгчдэд ойлгуулж, тэднээс зөвшөөрөл авах боломжийг компани олгодог.

Ш800.4 Гэрээт ажлын нөхцөлийг тогтоож байх үед зорилтот хэрэглэгчдийг нэрээр нь тусгайлан тодорхойлох боломжгүй бүлэг байх тохиолдолд компани, хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлага бол тэдгээр хэрэглэгчдийн удирдлагатай зөвшилцсөн шаардлага юм гэдгийг цаашид ойлгуулах нь зүйтэй.

800.4А1 Жишээлбэл, зорилтот хэрэглэгчид нь зээлийн нэгдсэн хэлцэл дэх зээлдүүлэгчид гэх мэт ангилалд багтаж байвал тухайн зээлдүүлэгчдийн удирдлагад илгээх гэрээт ажлын захидалдаа энэхүү өөрчлөгдсөн хараат бус байдлын шаардлагыг компани тодорхойлж бичих боломжтой. Удирдлага нь компаниас хүлээн авсан удирдлагад илгээх захидлыг зээлдүүлэгчдийн бүлгийн гишүүдэд мэдээлж, ингэснээр хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлага бол тэдгээр хэрэглэгчдийн удирдлагатай зөвшилцсөн шаардлага юм гэдгийг хэрэглэгчдэд ойлгуулах шаардлагыг компани хангах юм.

Ш800.5 Зохистой аудитын гэрээт ажлыг компани гүйцэтгэж байх үед, Бүлэг 4А-д ямар нэг өөрчлөлт оруулахдаа, Ш800.7-Ш800.14-р параграфт заасан өөрчлөлтөөр хязгаарлах ёстой. Санхүүгийн тайланд аудит хийхийг хууль тогтоомжид шаардсан үед компани эдгээр өөрчлөлтийг дагаж мөрдөхгүй.

Ш800.6 Хэрэв компани аудитын гэрээт ажлын тайлан гаргахдаа, нэг ижил үйлчлүүлэгч түүнийг ашиглах ба түгээхэд нь хязгаарлалт тавьдаггүй бол тэрээр уг аудитын гэрээт ажилд Бүлэг 4А-г дагаж мөрдөх ёстой.

Нийтийн Сонирхол бүхий Аж Ахуйн Нэгж

Ш800.7 Компани нь зохистой аудитын гэрээт ажлыг гүйцэтгэж байх үед, зөвхөн нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгжид хийх аудитын гэрээт ажилд хамааралтай Бүлэг 4А-д заасан хараат бус байдлын шаардлагыг мөрдөх албагүй юм.

Холбоотой Аж Ахуйн Нэгжүүд

Ш800.8 Компани нь зохистой аудитын гэрээт ажлыг гүйцэтгэж байх үед, Бүлэг 4А дахь “аудитын үйлчлүүлэгч” гэдэг ойлголтод түүний холбоотой аж ахуйн нэгжүүдийг оруулах шаардлагагүй. Гэхдээ, тухайн үйлчлүүлэгчийн холбоотой нэг аж ахуйн нэгжийг багтаасан харилцаа холбоо, нөхцөл байдал нь компанийн уг үйлчлүүлэгчээс хэр зэрэг хараат бус байх үнэлгээнд хамаатай гэдгийг аудитын баг мэдсэн эсвэл ийнхүү итгэх шалтгаан байвал тэрээр хараат бус байдлын аюул заналыг тогтоох, үнэлэх, тодорхойлох үедээ холбоотой аж ахуйн нэгжийг оруулж тооцдог.

Сүлжээ ба Сүлжээний Компаниуд

Ш800.9 Компани нь зохистой аудитын гэрээт ажлыг гүйцэтгэж байх үед, Бүлэг 4А-д тодорхойлсон сүлжээ компанитай холбоотой тусгай шаардлагуудыг мөрдөх албагүй. Гэхдээ, сүлжээ компанийн ашиг сонирхол, харилцаа холбооны улмаас хараат бус байдалд аюул занал үүсдэгийг компани мэддэг эсвэл ийнхүү итгэх шалтгаан түүнд байвал, тэрээр ийм аюул заналыг үнэлж, тодорхойлох ёстой.

Санхүүгийн Ашиг Сонирхол, Зээл ба Баталгаа, Бизнесийн, Гэр Бүлийн болон Хувийн Ойр Дотно Харилцаа Холбоо

Ш800.10 Компани нь зохистой аудитын гэрээт ажил гүйцэтгэж байх үедээ:

- (а) Хэсэг 510, 511, 520, 521, 522, 524, 525-д заасан нөхцөлүүдээс холбогдох нөхцөлийг зөвхөн гэрээт ажлын багийн гишүүд, тэдний ам бүл, хамааралтай гэж үзвэл гэр бүлийн ойрын гишүүд дагаж мөрдөх хэрэгтэй;
- (б) Компани нь аудитын гэрээт ажлын үйлчлүүлэгч ба аудитын багийн дараах гишүүдийн хоорондох, Хэсэг 510, 511, 520, 521, 522, 524, 525-д заасан ашиг сонирхол, харилцааны үр дүнд хараат бус байдалд учирсан аливаа аюул заналыг олж тогтоон, үнэлж, тодорхойлох ёстой;
 - (i) Техникийн эсвэл салбарын онцлог асуудлууд, ажил гүйлгээ, үйл явдалд зөвлөгөө өгдөг хүмүүс;
 - (ii) Гэрээт ажилд чанарын хяналт тавих хүмүүс, үүнд гэрээт ажлын чанарын хяналт шалгалт гүйцэтгэдэг хүмүүс орно;
- (в) Аудитын гэрээт ажлын үйлчлүүлэгч ба аудитын ажлын үр дүнд шууд нөлөөлж чадахуйц компани доторх бусад хүмүүсийн хоорондох ашиг сонирхол ба харилцаа холбооны үр дүнд аюул занал үүссэн хэмээн итгэх шалтгаан гэрээт ажлын багт байвал компани ийм аюул заналын далайцыг үнэлж, тодорхойлох хэрэгтэй.

800.10A1 Аудитын ажлын үр дүнд шууд нөлөөлж чадахуйц компани доторх бусад хүмүүс гэдэгт, нөхөн олговорын талаар зөвлөдөг эсвэл аудитын ажлын гүйцэтгэлийг шууд хянадаг, удирддаг эсвэл хөндлөнгөөс хянадаг аудитын гэрээт ажлын партнер, үүнд компанийн Ахлах эсвэл Удирдах партнер (гүйцэтгэх захирал буюу түүнтэй адилтгах) зэрэг партнерээс дээгүүр түвшний удирдах албан тушаалтныг багтаан авч үздэг.

Ш800.11 Компани нь зохистой аудитын гэрээт ажил гүйцэтгэж байх үед, Ш510.4(в) ба (г), Ш510.5, Ш510.7, Ш510.10A5, Ш510.10A9-д заасан хувь хүмүүсийн эзэмшиж байгаа аудитын үйлчлүүлэгч дэх санхүүгийн Ашиг Сонирхол нь хараат бус байдалд аюул занал учруулна хэмээн итгэх шалтгаан гэрээт ажлын багт байвал тэрээр ийм аюул заналыг заавал үнэлж, тогтоох ёстой.

Ш800.12 Зохистой аудитын ажил гүйцэтгэж байгаа бөгөөд Ш510.4 (а), Ш510.6, Ш510.7-р параграфыг хамаарах ашиг сонирхолд дагаж мөрддөг компани нь аудитын үйлчлүүлэгчид материаллаг хэмжээний шууд эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцоо эзэмшиж үл болно.

Аудитын Үйлчлүүлэгч Байгууллагад Ажил Эрхлэх

Ш800.13 Зохистой аудитын гэрээт ажил гүйцэтгэж байгаа компани нь 524.3A1-524.5A3-р параграфт заасны дагуу, ажил эрхлэх харилцаанаас үүссэн аюул заналыг үнэлж, тодорхойлох ёстой.

Баталгаажуулалтын бус Үйлчилгээ Үзүүлэх

Ш800.14 Хэрэв компани нь аудитын үйлчлүүлэгчид зохистой аудитын ажил гүйцэтгэж, мөн баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлж байвал, тэрээр Ш800.7-Ш800.9-р параграфт нийцүүлэн, Хэсэг 410-430, Хэсэг 600-г дэд хэсгүүдийн хамт мөрдөх ёстой.

**БҮЛЭГ 4Б – АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ХАРААТ
БУС БАЙДАЛ**

		Хуудас
Хэсэг 900	Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажлын Хараат бус Байдалд Онолын Үзэл Баримтлалыг Мөрдөх нь	177
Хэсэг 905	Төлбөр	184
Хэсэг 906	Бэлэг, Дайллага	186
Хэсэг 907	Бодит эсвэл Болзошгүй Зарга Маргаан	187
Хэсэг 910	Санхүүгийн Ашиг Сонирхол	188
Хэсэг 911	Зээл ба Баталгаа	191
Хэсэг 920	Бизнесийн Харилцаа Холбоо	193
Хэсэг 921	Гэр Бүлийн болон Хувийн Харилцаа Холбоо	194
Хэсэг 922	Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчид Сүүлийн Үед Алба Хашсан Байдал	197
Хэсэг 923	Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчид Захирал, Албан Тушаалтнаар Ажилласан Байдал	198
Хэсэг 924	Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчид Ажил Эрхлэх	199
Хэсэг 940	Ажилтнууд ба Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчийн Хоорондох Удаан Хугацааны Харилцаа	201
Хэсэг 950	Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Үйлчилгээ Үзүүлэх	203
Хэсэг 990	Ашиглах ба Түгээх Нөхцөлд нь Хязгаарлалт Тавьсан Тайлан (Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажил)	206

БҮЛЭГ 4Б – АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛ

ХЭСЭГ 900 АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ХАРААТ БУС БАЙДАЛД ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ МӨРДӨХ

Танилцуулга

Ерөнхий зүйл

- 900.1 Энэ хэсгийг аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах ажилд мөрдөнө (энэ Бүлэг дэх “баталгаажуулах гэрээт ажил”-д хамаарна). Ийм гэрээт ажлын жишээнд дараах багтана:
- Тусгай элемент, санхүүгийн тайлангийн данс буюу зүйлүүдийн аудит.
 - Компанийн гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдэд хийсэн гүйцэтгэлийн баталгаажуулалт.
- 900.2 Энэ Бүлэг дэх “мэргэжлийн нягтлан бодогч” гэсэн нэр томъёо нь олон нийтэд зориулсан үйл ажиллагаа явуулдаг эсвэл ийм компанид ажилладаг мэргэжлийн нягтлан бодогч хувь хүмүүст хамааралтай.
- 900.3 Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт 1-д, компани ба түүний ажилтнууд, хамааралтай гэж үзвэл хараат бус шаардлагыг биелүүлбэл зохих бусад этгээдийг холбогдох ёс зүйн шаардлагын дагуу хараат бус байдлаа хадгална гэсэн ул үндэслэлтэй баталгаагаар хангахуйц бодлого, горимыг боловсруулан мөрдүүлэхийг компаниас шаарддаг. АОУС ба НАОУС-д гэрээт ажлын түвшинд партнер болон багийн хувьд хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон болно. Компани дотор үүрэг хариуцлагыг хэрхэн хуваарилах нь тухайн байгууллагын хэмжээ, бүтэц, зохион байгуулалтаас хамаардаг. Бүлэг 4Б-ийн ихэнх заалтаар, хараат бус байдалд хамаарах үйлдлийн төлөө компани доторх хүмүүсийн тус тусын онцлог үүрэг хариуцлагыг тодорхойлоогүй бөгөөд харин үүний оронд “компани” гэдэг үгээр арай хялбаршуулан илэрхийлсэн байгаа. Компаниуд ЧХОУС 1-д нийцүүлэн тодорхой үйлдлийн төлөө хүлээх хариуцлагыг хувь хүн эсвэл бүлэг (аудитын баг)-г хуваарилан ноогдуулдаг. Түүнээс гадна, мэргэжлийн нягтлан бодогч хувь хүнд өөрийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбоонд мөрдвөл зохих аливаа заалтад нийцүүлэн ажиллах хариуцлага хэвээр хадгалагдана.
- 900.4 Хараат бус байдал нь бодитой хандлага ба шударга байдлын суурь зарчимтай холбоотой юм. Хараат бус байдал нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (а) Сэтгэл санааны хараат бус байдал - мэргэжлийн шүүн тунгаалтын үнэ цэнийг алдагдуулах нөлөөнд үл автуулах, тэгснээрээ шударга, бодитой, мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандан дүгнэлт илэрхийлэх боломж олгохуйц сэтгэл санааны байдал.
 - (б) Гадна төрхийн хараат бус байдал – ухаалаг бөгөөд мэдлэгтэй гуравдагч этгээд нь компанийн эсвэл аудит, эсвэл баталгаажуулах багийн гишүүний шударга ёс, бодитой хандлага, мэргэжлийн үл итгэх үзэл алдагдсан гэж үндэслэлтэйгээр дүгнэж болохуйц бодит баримт, нөхцөл байдлаас зайлсхийх явдал.
- Энэ Хэсэгт, хэн нэг хувь хүн эсвэл компани “хараат бус байх”-ыг тухайн хувь хүн эсвэл компани энэ Хэсгийн заалтуудыг сахин мөрдсөн гэсэн утгаар авч үзсэн болно.
- 900.5 Баталгаажуулах гэрээт ажил гүйцэтгэхдээ суурь зарчмуудад нийцүүлж, хараат бус байхыг компаниас шаарддаг. Ийм гэрээт ажил гүйцэтгэхдээ хараат бус байдлаа хадгалахын тулд онолын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах материал ба тусгай шаардлагыг энэ Хэсэгт тодорхойлсон байна. Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг Хэсэг 110-д заасан суурь зарчмуудыг мөрддөгийн нэгэн адил хараат бус байдалд дагаж мөрдөнө.
- 900.6 Энэ хэсэгт дараах зүйлийг тайлбарласан болно:
- (а) Хараат бус байдалд аюул занал учруулдаг эсвэл учруулж болзошгүй мэргэжлийн үйл ажиллагаа, ашиг сонирхол, харилцаа холбооны талаарх бодит баримт ба нөхцөл байдал;
 - (б) Ийм аюул заналыг тодруулахад тохиромжтой байж болох арга хэмжээ, үүний дотор хамгаалалтын арга хэмжээ;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (в) Тухайн аюул заналыг арилгаж чадахааргүй эсвэл зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах хамгаалалтын арга хэмжээ авч болох зарим нөхцөл байдал.

Бусад Баталгаажуулах Ажлын Тодорхойлолт

- 900.7 Баталгаажуулах гэрээт ажил нь шалгах асуудлын үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүнгийн баталгаатай байдлыг тогтоосон шалтгууртай харьцуулан, зорилтот хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготой юм. Баталгаажуулах гэрээт ажлын хувьд, компани нь шалгах асуудлын үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүнгийн баталгаатай байдлыг тогтоосон шалтгууртай харьцуулан, зорилтот хэрэглэгч (хариуцсан талаас бусад)-ийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготой дүгнэлт гаргадаг. Баталгаажуулах ажлын үзэл баримтлалд баталгаажуулах гэрээт ажлын элемент ба зорилтыг тодорхойлдог бөгөөд үүнд БАОУС-ыг мөрддөг. Баталгаажуулах гэрээт ажлын элемент ба зорилтыг хэрхэн тодорхойлсныг Баталгаажуулах ажлын үзэл баримтлалаас харна уу.
- 900.8 Тухайн баталгаажуулах асуудлын үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүн нь тухайн баталгаажуулах асуудалд тогтоосон тохирох шалгуурыг хэрэглэсний үр дүнд бий болсон мэдээлэл юм. “Шалгах асуудлын мэдээлэл” гэдэг нэр томъёог тухайн баталгаажуулах асуудлын үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүнг илэрхийлэхэд ашигладаг. Тухайлбал, Баталгаажуулах ажлын үзэл баримтлалд, дотоод хяналт (баталгаажуулах асуудлын мэдээлэл)-ын үр дүнтэй байдлын талаарх батламж мэдэгдэл нь дотоод хяналтын үр дүнтэй байдлыг үнэлэхэд зориулсан ИТБХ эсвэл КХШИМНБ (шалгуур), үйл явц (баталгаажуулах асуудал)-д дагаж мөрдсөнөөр үүсдэг.
- 900.9 Баталгаажуулах ажил нь батламж мэдэгдэлд суурилсан эсвэл шууд тайлагнах ажил байх боломжтой. Аль нь ч байсан гэсэн, энд нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч, хариуцагч тал, зорилтот хэрэглэгч гэсэн гурван бие даасан тал оролцдог.
- 900.10 Батламж мэдэгдэлд суурилсан баталгаажуулах ажилд тухайн баталгаажуулах асуудлын үнэлгээ буюу хэмжилтийг хариуцагч тал нь гүйцэтгэдэг. Тухайн баталгаажуулах асуудлын мэдээллийг хариуцагч тал батдамж мэдэгдэл хэлбэрээр гаргаж, зорилтот хэрэглэгчдэд зориулан бэлэн болгодог.
- 900.11 Шууд тайлагнах баталгаажуулах ажлыг гүйцэтгэхдээ компани:
- (а) Баталгаажуулах асуудлын үнэлгээ буюу хэмжилтийг шууд гүйцэтгэдэг; эсвэл
 - (б) Зорилтот хэрэглэгчдэд бэлэн байхгүй үнэлгээ буюу хэмжилтийг гүйцэтгэсэн хариуцагч талаас төлөөлсөн мэдээллийг олж авдаг. Тухайн баталгаажуулах асуудлын мэдээллийг баталгаажуулах тайланд тусган зорилтот хэрэглэгчдэд хүргүүлдэг.

Ашиглах ба Түгээхэд Хязгаарлалт Тавьсан Тайлан

- 900.12 Баталгаажуулах ажлын тайланд ашиглах ба түгээн илчлэхийг хязгаарласан нөхцөлийг оруулах боломжтой. Хэрэв ийм хязгаарлалт байгаа бөгөөд энэ нь Хэсэг 990-д заасан нөхцлийг хангаж байвал энэ Бүлэг дэх хараат бус байх шаардлагыг Хэсэг 990-д заасны дагуу өөрчилж болох юм.

Аудит ба Нягтлах Гэрээт Ажил

- 900.13 Аудит ба нягтлах гэрээт ажилд баримтлах хараат бус байдлын стандартыг Бүлэг 4А- *Аудит ба нягтлах гэрээт ажлын хараат бус байдал*-д тусгасан болно. Хэрэв компани нь нэг ижил үйлчлүүлэгчид баталгаажуулах гэрээт ажил ба аудит эсвэл нягтлах гэрээт ажлын аль алийг гүйцэтгэсэн бол, Бүлэг 4А-д заасан шаардлагыг тухайн компани, сүлжээ компани болон аудит эсвэл нягтлах ажлын багийн гишүүд үргэлжлүүлэн мөрдөнө.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- Ш900.14** Баталгаажуулах ажил гүйцэтгэх компани хараат бусаар ажилллах ёстой.
- Ш900.15** Компани нь баталгаажуулах гэрээт ажилд хамаарах хараат бус байдалд учирч байгаа аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.

Сүлжээ Компани

- Ш900.16** Сүлжээ компанийн ашиг сонирхол ба харилцаа холбоо нь тухайн компанийн хараат бус байдалд аюул

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

занал учруулна хэмээн итгэх шалтгаан компанид байвал тэрээр ийм аюул заналыг заавал үнэлж, тогтоох ёстой.

900.16A1 Сүлжээ компанийн талаар 400.50A1- 400.54A1-р параграфт авч үзсэн болно.

Холбоотой Аж Ахуйн Нэгжүүд

Ш900.17 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн холбоотой аж ахуйн нэгжид хамаарах харилцаа холбоо, нөхцөл байдал нь тухайн компани уг үйлчлүүлэгчээс хэр зэрэг хараат бус байх үнэлгээтэй хамааралтай гэдгийг баталгаажуулах ажлын баг мэдсэн эсвэл ийнхүү итгэх шалтгаан байвал тэрээр хараат бус байдлын аюул заналыг тогтоох, үнэлэх, тодорхойлох үедээ уг холбоотой аж ахуйн нэгжийг оруулж тооцдог.

Баталгаажуулах Гэрээт Ажлын Төрөл

Батламж Мэдэгдэлд Суурилсан Баталгаажуулах Ажил

Ш900.18 Батламж мэдэгдэлд суурилсан баталгаажуулах ажил гүйцэтгэхдээ:

- (а) Энэ Бүлэгт заасны дагуу, баталгаажуулах ажлын багийн гишүүд болон компани нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч (баталгаажуулах асуудлын мэдээллийг хариуцахаас гадна баталгаажуулах асуудлыг хариуцдаг байж болох тал)-ээс хараат бус байх ёстой. Энэ Бүлэгт заасан хараат бус байдлын шаардлага нь баталгаажуулах ажлын багийн гишүүд болон (i) үйлчлүүлэгчийн захирал, албан тушаалтнууд, (ii) баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг албыг үйлчлүүлэгч аж ахуйн нэгжид хашдаг ажилтнуудын хооронд тодорхой зарим харилцаа холбоо тогтоохыг хориглодог;
- (б) Гэрээт ажлын баталгаажуулах асуудалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх алба хашдаг үйлчлүүлэгчийн ажилтантай тогтоосон харилцаа холбооны хувьд компани нь Хэсэг 120-д заасан онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой;
- (в) Сүлжээ компанийн ашиг сонирхол болон харилцаа холбооноос үүссэн хэмээн компани ул үндэслэлтэй итгэж байвал, тэрээр ийм аюул заналын далайцыг үнэлэх хэрэгтэй.

Ш900.19 Хариуцагч тал нь баталгаажуулах асуудал бус харин түүнийг мэдээлэх ажлыг хариуцдаг тохиолдолд, батламж мэдэгдэлд суурилсан баталгаажуулах ажил гүйцэтгэж байвал:

- (а) Баталгаажуулах ажлын багийн гишүүд ба компани нь баталгаажуулах асуудлыг мэдээлэх ажлыг хариуцдаг тал (баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч)-аас хараат бус байх ёстой;
- (б) Баталгаажуулах ажлын багийн гишүүн, компани, сүлжээ компани болон баталгаажуулах асуудлыг хариуцагч талуудын хоорондох ашиг сонирхол ба харилцаа холбооны үр дүнд аюул занал үүсдэг хэмээн итгэх шалтгаан компанид байвал тэрээр ийм аюул заналын далайцыг үнэлж, тодорхойлох хэрэгтэй.

900.19A1 Батламж мэдэгдэлд суурилсан ихэнх баталгаажуулах ажилд, хариуцагч тал нь баталгаажуулах асуудлын мэдээлэл ба баталгаажуулах асуудлын аль алийг хариуцдаг. Гэхдээ, зарим ажлын хувьд хариуцагч тал нь баталгаажуулах асуудлыг хариуцахгүй байж болно. Жишээлбэл, зорилтот хэрэглэгчдэд хүргэхээр байгаль орчны зөвлөхийн бэлтгэсэн компанийн тогтвортой байдлын практик үйл ажиллагааны тайланд хамаарах баталгаажуулах ажлыг гүйцэтгүүлэхээр компанитай гэрээ байгуулж болно. Энэ тохиолдолд, байгаль орчны зөвлөх нь баталгаажуулах асуудлын мэдээллийг хариуцагч тал, харин компани нь баталгаажуулах асуудал (тогтвортой байдлын практик үйл ажиллагаа)-ыг хариуцагч тал болно.

Шууд Тайлагналын Баталгаажуулах Ажил

Ш900.20 Шууд тайлагналын баталгаажуулах ажил гүйцэтгэж байвал:

- (а) Баталгаажуулах ажлын багийн гишүүд ба компани нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч (баталгаажуулах асуудлыг хариуцагч тал)-ээс хараат бус байх ёстой;
- (б) Сүлжээ компанийн ашиг сонирхол ба харилцаа холбооны үр дүнд аюул занал үүссэн хэмээн итгэх шалтгаан компанид байвал тэрээр хараат бус байдалд учрах ийм аюул заналыг үнэлж, тодорхойлох ёстой.

Хариуцлага Хүлээсэн Олон Талууд

900.21A1 Батламж мэдэгдэлд суурилсан эсвэл шууд тайлагналын зарим баталгаажуулах ажлын хувьд, хэдэ хэдэн хариуцагч талтай байж болно. Ийм гэрээт ажилд, энэ Бүлгийн заалтуудыг хариуцлага хүлээж буй бүх талуудын хувьд мөрдөх шаардлагатай эсэхийг тухайн компани тодорхойлохдоо тодорхой зүйлсийг анхаарах нь зүйтэй. Эдгээр зүйлд, тухайн компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүн болон хариуцлага хүлээж буй аль нэг талын хоорондох ашиг сонирхол эсвэл харилцаа холбооны улмаас тухайн баталгаажуулах асуудлын мэдээллийн хувьд ялимгүй биш бөгөөд ноцтой аюул занал хараат бус байдалд учрах эсэхийг тооцон үзэж болох юм. Үүнийг тооцохдоо, дараах хүчин зүйлсийг авч үзнэ:

- (а) Тодорхой нэг хариуцагч талын хариуцаж буй баталгаажуулах асуудлын мэдээлэл (эсвэл баталгаажуулах асуудал)-ийн материаллаг байдлын түвшин;
- (б) Гэрээт ажилтай холбоотой олон нийтийн ашиг сонирхлын түвшин.

Тодорхой нэг хариуцагч талтай тогтоосон харилцаа эсвэл ашиг сонирхлын улмаас үүссэн аюул занал нь ялимгүй бөгөөд ноцтой биш хэмээн компани тодорхойлсон бол, энэ хэсгийн бүх заалтыг тэрхүү хариуцлага хүлээж буй тал мөрдөх шаардлагагүй байж болно.

[900.22-900.29-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно.]

Хараат бус Байдал Шаардагдах Хугацаа

Ш900.30 Энэ Бүлэгт шаардсаны дагуу, хараат бус байдлыг дараах хоёр хугацааны аль алинд хадгалах ёстой:

- (а) Гэрээт ажлын хугацаа; болон
- (б) Баталгаажуулах асуудлын мэдээллийн хамарч буй хугацаа.

900.30A1 Баталгаажуулах ажлын баг тухайн ажилтай холбоотой баталгаажуулах үйлчилгээг гүйцэтгэж эхэлснээр гэрээт ажлын хугацаа эхэлнэ. Баталгаажуулах ажлын тайлан гарснаар ажлын хугацаа дуусгавар болно. Баталгаажуулах ажил нь давтагдах шинж чанартай ажил байвал, мэргэжлийн харилцаа дуусгавар болсоныг аль нэг тал мэдэгдсэн эсвэл баталгаажуулах ажлын эцсийн тайлан гарсан хугацаа хоёрын аль сүүлд байгаа хугацааг дуусгавар хугацаа гэж үзнэ.

Ш900.31 Хэрэв аж ахуйн нэгж нь компанийн дүгнэлт өгөх гэж байгаа баталгаажуулах асуудлын мэдээллийн хамрах хугацааны дундуур эсвэл дараа нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч болсон бол тэрээр дараах зүйлээс үүдэлтэй аюул занал хараат бус байдалд үүссэн эсэхийг тодорхойлох ёстой. Үүнд:

- (а) Баталгаажуулах асуудлын мэдээллийн хамрах хугацааны дундуур эсвэл дараа нь, гэхдээ баталгаажуулах ажлыг хүлээж авахаас өмнө баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй тогтоосон санхүүгийн болон бизнесийн харилцаа холбоо;
- (б) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид өмнө нь үзүүлсэн үйлчилгээ.

Ш900.32 Баталгаажуулах асуудлын мэдээллийн хамрах хугацааны дундуур эсвэл дараа нь, гэхдээ баталгаажуулах ажлын багаас баталгаажуулах ажлын үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө баталгаажуулах ажлын бус үйлчилгээг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлж байсан бөгөөд уг баталгаажуулах ажлын явцад тухайн үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөхгүй байж болно. Энэ тохиолдолд, уг үйлчилгээг үзүүлснээр хараат бус байдалд учирсан аливаа аюул заналыг компани үнэлэх ёстой. Хэрэв ийм аюул занал нь хүлээн зөвшөөрөгдөх түвшнээс хэтэрсэн байвал түүнийг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулсан үед л зөвхөн баталгаажуулах ажлыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

900.32A1 Ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг багтаана:

- Ийм үйлчилгээг гүйцэтгэхдээ баталгаажуулах ажлын багийн гишүүн бус мэргэжилтэн ажиллуулах.
- Баталгаажуулалтын болон баталгаажуулалтын бус үйлчилгээний аль зохистойг хянан шалгадаг тохирох хянан шалгагчийг ажиллуулах.

Ш900.33 Хэрэв гэрээт ажлын явцад үл зөвшөөрөх баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлж дуусаагүй бөгөөд баталгаажуулах ажилтай холбоотой мэргэжлийн үйлчилгээг эхлэхээс өмнө түүнийг гүйцэтгэж дуусгах буюу дуусгавар болгох бодит боломж байхгүй бол:

- (а) Компани зөвхөн дараах нөхцөл хангагдсан үед л баталгаажуулах ажлыг зөвшөөрөх ёстой:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (i) Баталгаажуулах бус үйлчилгээг богино хугацааны дотор гүйцэтгэж дуусгахаар байвал;
 - (ii) Үйлчлүүлэгч нь тухайн үйлчилгээг богино хугацааны дотор шилжүүлэхээр өөр компанитай тохиролцсон бол.
- (б) Үйлчилгээ үзүүлэх явцад шаардлагатай хамгаалалтын арга хэмжээ авах ёстой;
 - (в) Засаглах эрхтэй этгээдүүдтэй тухайн асуудлыг хэлэлцэх.

[900.34 -900.39-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно.]

Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас бусад Баталгаажуулах Ажлын Хараат Бус Байдлыг Ерөнхийд нь Баримтжуулах

Ш900.40 Компани нь энэ Бүлэгт заасан нийцлийн талаарх дүгнэлт болон эдгээр дүгнэлтийг дэмжин нотлохтой холбоотой хэлэлцүүлгийн гол агуулгыг заавал баримтжуулна. Ялангуяа:

- (a) Аюул заналыг тодорхойлохдоо хамгаалалтын арга хэмжээ ашигладаг бол компани уг аюул заналын мөн чанар ба ашиглахад бэлэн байгаа эсвэл ашигласан хамгаалалтын арга хэмжээг баримтжуулах ёстой;
- (б) Ямар нэг аюул заналд томоохон шинжилгээ хийх шаардлагатай бөгөөд компанийн дүгнэсэнээр тухайн аюул занал нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгаа бол компани аюул заналын мөн чанар ба ийнхүү дүгнэсэн үндэслэлээ баримтжуулах хэрэгтэй.

900.40A1 Баримтжуулалт нь энэ Бүлэгт заасан нийцлийн талаарх компанийн дүгнэлтийн нотолгоо болдог. Гэхдээ, баримтжуулалт дутуу дулимаг байх нь компани тодорхой асуудлыг тооцож үзсэн эсэх болон түүний хараат бус байгаа эсэхийг тодорхойлох хүчин зүйл болж чадахгүй.

[900.41-900.49-р параграфыг зориуд хоосон үлдээсэн болно.]

Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас Бусад Баталгаажуулах Ажилд Хараат Бус Байх Зарчмыг Зөрчих нь

Компани Шаардлагыг Зөрчсөнөө Олж Тогтоосон Бол

Ш900.50 Энэ Бүлгийн шаардлагыг зөрчсөнөө компани олж тогтоосон бол тэрээр дараах зүйлсийг тодорхойлох ёстой:

- (a) Ийнхүү зөрчихөд хүргэсэн ашиг сонирхол, харилцаа холбоогоо таслах, цуцлах, устгах;
- (б) Зөрчлийн ач холбогдол, компанийн бодит байдал ба баталгаажуулах ажлын тайлан гаргах боломжид түүний үзүүлэх нөлөөг үнэлэх;
- (в) Зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгаж чадахуйц арга хэмжээ авч чадах эсэхийг тодорхойлох.

Ийнхүү тодорхойлохдоо компани мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлэх бөгөөд ул суурьтай, мэдлэгтэй гуравдагч талын зүгээс компанийн бодитой байх зарчим алдагдаж, улмаар баталгаажуулах ажлын тайлан гаргах боломжгүй гэсэн дүгнэлт гаргаж болох магадлалыг харгалзах хэрэгтэй.

Ш900.51 Хэрэв компани зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгах арга хэмжээ авч чадахгүй хэмээн тодорхойлсон бол түүнийг хөлсөлсөн тал эсвэл түүний засаглах эрхтэй этгээдийн аль тохирох талд энэ тухай аль болох шуурхай мэдээлэх ёстой. Мөн баталгаажуулах ажлыг цуцлахтай холбоотой хуулийн эсвэл зохицуулах хүрээний шаардлагад нийцүүлэн, баталгаажуулах гэрээт ажлаа цуцлах алхмыг компани хийх хэрэгтэй.

Ш900.52 Хэрэв компани зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгах арга хэмжээ авч чадна хэмээн тодорхойлж байвал тэрээр зөрчил болон хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагаагааны тухай түүнийг хөлсөлсөн тал эсвэл түүний засаглах эрхтэй этгээдийн аль тохирох талтай ярилцах ёстой. Компани гэрээт ажил ба зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан, зөрчил ба төлөвлөсөн үйл ажиллагааны тухай цаг хугацаанд нь ярилцах хэрэгтэй.

Ш900.53 Аудитын компанийг хөлсөлсөн тал эсвэл түүний засаглах эрхтэй этгээдийн аль нэг нь төлөвлөсөн арга хэмжээний үр дүнд зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгана гэдэгтэй санал нийлэхгүй байвал компани хууль тогтоомжид хориглоогүй тохиолдолд, баталгаажуулах ажлыг цуцлахтай холбоотой хуулийн эсвэл зохицуулах хүрээний шаардлагад нийцүүлэн уг баталгаажуулах ажлыг цуцлах алхмыг хийх хэрэгтэй.

Баримтжуулалт

Ш900.54 Ш900.50-Ш900.53-р параграф дахь шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд компани дараах зүйлийг баримтжуулах нь зүйтэй:

- (a) Гарсан зөрчил;
- (б) Авсан арга хэмжээ;
- (в) Гаргасан гол шийдвэр;
- (г) Компанийг хөлсөлсөн тал эсвэл түүний засаглах эрхтэй этгээдтэй ярилцсан бүх асуудал.

Ш900.55 Хэрэв компани баталгаажуулах гэрээт ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэх бол тэрээр дараах зүйлсийг баримтжуулах ёстой. Үүнд:

- (a) Компани мэргэжлийн шүүн тунгаалтын хүрээнд, бодитой байдлаа алдаагүй гэсэн дүгнэлт;
- (б) Зөрчлийн үр дагаварыг хангалттай арилгаж, баталгаажуулах ажлын тайлан гаргах боломжтой болгоход тухайн арга хэмжээг яагаад хангалттай гэж үзсэн тухай.

ХЭСЭГ 905

ТӨЛБӨР

Танилцуулга

- 905.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 905.2 Төлбөр болон нөхөн олговрын бусад хэлбэрийн шинж чанар ба хэмжээ нь хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэх боломжтой. Дээр дурдсан тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Төлбөр- Харьцангуй Хэмжээ

- 905.3A1 Баталгаажуулах ажлын нэг үйлчлүүлэгчээс авсан нийт төлбөр нь уг баталгаажуулах ажлын дүгнэлт гаргаж буй компанийн хүлээн авч буй нийт төлбөрийн дийлэнх хувийг бүрдүүлж байгаа үед тухайн үйлчлүүлэгчээс хараат байх, мөн уг үйлчлүүлэгчийг алдаж болзошгүй гэсэн болгоомжлол нь хувийн ашиг сонирхлын, эсвэл айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэдэг.
- 905.3A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамаарах хүчин зүйлсэд дараахыг оруулж үздэг. Үүнд:
- Компанийн үйл ажиллагааны бүтэц;
 - Компанийн үйл ажиллагаа тогтворжсон эсвэл шинээр байгуулагдсан эсэх;
 - Тухайн үйлчлүүлэгч нь тоо хэмжээ болон чанарын хувьд компанид хэр чухал болох.
- 905.3A3 Хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс хараат байдлаа багасгахын тулд үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх аргыг дурдаж болно.
- 905.3A4 Баталгаажуулах ажлын нэг үйлчлүүлэгчээс авах нийт төлбөр нь нэг партнерийн үйлчлүүлэгчдээс олох орлогын дийлэнх хувийг бүрдүүлж байвал мөн хувийн ашиг сонирхлын, эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэж болно.
- 905.3A5 Хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Партнер эсвэл компанийн салбарын үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх замаар баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс хараат байх байдлыг бууруулна.
 - Тухайн баталгаажуулах гэрээт ажилд оролцоогүй хүнээр ажлыг нь хянуулах.

Төлбөр - Хугацаа Хэтэрсэн

- 905.4A1 Дараагийн жилийн баталгаажуулах ажлын тайлан гарахаас өмнө, үйлчлүүлэгчийн төлбөл зохих төлбөрийн томоохон хэсэг төлөгдөөгүй бол хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болзошгүй. Ерөнхийдөө, энэ тайлан гаргахын өмнө компани үйлчилгээний төлбөрөө төлөхийг үйлчлүүлэгчээс шаарддаг. Хэсэг 911-ийн зээл ба баталгаатай холбоотой шаардлага, ашиглах материалыг төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдэл байгаа тохиолдолд мөн дагаж мөрдөж болно.
- 905.4A2 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Хугацаа хэтэрсэн төлбөрийн зарим хэсгийг төлүүлэх.
 - Тухайн баталгаажуулах ажилд оролцоогүй ажлтнаар гүйцэтгэсэн ажлыг хянуулах.

Ш905.5 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс авах төлбөрийн үлэмж хэсэг удаан хугацаагаар төлөгдөөгүй бол, компани дараах зүйлийг тодорхойлох ёстой. Үүнд:

- (a) Хугацаа хэтэрсэн төлбөрийг үйлчлүүлэгчид өгсөн зээлтэй адилтган үзэж болох эсэх;
- (b) Уг компанийг баталгаажуулах ажил гүйцэтгүүлэхээр дахин томилох эсвэл үргэлжлүүлэхийн аль нь

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тохиромжтой байх.

Болзошгүй Төлбөр

- 905.6A1 Болзошгүй төлбөр гэдэг нь ажил гүйлгээний үр дүн, эсвэл гүйцэтгэсэн үйлчилгээний үр дүнтэй холбож урьдчилан тодорхойлсон сууриар тооцоолсон төлбөр юм. Зуучлагчаар дамжуулан нэхэмжилсэн болзошгүй төлбөр бол шууд бус болгошгүй төлбөрийн жишээ юм. Энэ хэсэгт, шүүх эсвэл төрийн бусад эрхтэй байгууллагаас тогтоосон төлбөрийг болзошгүй хэмээн үзэхгүй байхаар заасан болно.
- Ш905.7** Компани нь баталгаажуулах гэрээт ажлын төлөө болзошгүй төлбөрийг шууд эсвэл шууд бусаар ноогдуулж болохгүй.
- Ш905.8** Хэрэв баталгаажуулах бус үйлчилгээний үр дүн, улмаар төлбөрийн хэмжээ нь баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд материаллаг нөлөө бүхий зүйлтэй холбоотой ирээдүйн эсвэл одооны шүүн тунгаалтаас хамаарч байвал баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлсэн баталгаажуулалтын бус үйлчилгээний болзошгүй төлбөрийг шууд эсвэл шууд бусаар ноогдуулж болохгүй.
- 905.9A1 Болзошгүй төлбөрийн талаар баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй ямар нэг тохиролцоо хийхийг Ш905.7 болон Ш905.8-р параграфын дагуу компанид зөвшөөрдөггүй. Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлж байхад болзошгүй төлбөрийн тохиролцоо хийхийг хориглодоггүй байсан ч гэсэн хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэх боломж байсаар байна.
- 905.9A2 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийн жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Төлбөрийн боломжит дүнгийн хүрээ.
 - Холбогдох эрхтэй байгууллагаас үр нөлөөнөөс хамааралтай болзошгүй төлбөрийн хэмжээг тодорхойлсон эсэх.
 - Компанийн гүйцэтгэсэн ажлын зорилтот хэрэглэгчдэд зориулсан тодруулга ба цалин хөлс, урамшууллын суурь.
 - Тухайн үйлчилгээний шинж чанар.
 - Тухайн үйл явдал буюу ажил гүйлгээний санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө.
- 905.9A3 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхэд оролцоогүй хүнээр хамаарах баталгаажуулалтын ажлыг хянуулах.
 - Цалин хөлс, урамшууллын талаар үйлчлүүлэгчтэй урьдчилж бичгээр тохиролцох.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 906

БЭЛЭГ, ДАЙЛЛАГА, УРАМШУУЛАЛ

Танилцуулга

- 906.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 906.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс бэлэг, дайллага хүлээн авах нь хувийн ашиг сонирхлын, танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Шаардлага ба Ашиглах Материал

- Ш906.3** Компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүн хүн нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс үнэ цэнэ нь илт ялимгүй байхаас бусад тохиолдолд, ямар ч бэлэг авч, дайлуулж болохгүй.
- 906.3A1 Компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүн хүн нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авах тохиолдолд, Хэсэг 340-д дурдсан шаардлага ба ашиглах материалыг мөрдөх ба эдгээр шаардлагад үл нийцсэн үйлдэл хийвэл хараат бус байдалд аюул занал учирч болзошгүй.
- 906.3A2 Урамшуулал санал болгох эсвэл түүнийг хүлээн авахтай холбоотой Хэсэг 340-ийн шаардлагад, ялимгүй үнэ цэнэтэй ч зан төлөвт зүй бусаар нөлөөлөх зориготой тийм бэлэг, дайллагыг хүлээн авахыг компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүнд зөвшөөрдөггүй.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 907

БОДИТ ЭСВЭЛ БОЛЗОШГҮЙ ЗАРГА МАРГААН

Танилцуулга

- 907.1 Компани нь суурь зарчмын шаардлагуудыг мөрдөн, хараат бус байж, түүнд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөх ёстой.
- 907.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй холбоотой зарга үүссэн, эсвэл үүсэх магадлалтай бол, хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул занал учирч болзошгүй. Ийм тохиолдолд, онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхөд хамаарах тусгай шаардлага ба ашиглах материалыг энэ хэсэгт тайлбарласан болно.

Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 907.3A1 Үйлчлүүлэгчийн удирдлага ба баталгаажуулах ажлын багийн гишүүдийн хоорондох харилцаа нь үйлчлүүлэгч бизнесийн үйл ажиллагаагаа бүхэлд нь хэр ил тод, илэн далангүй илэрхийлж байгаагаар тодорхойлогдох ёстой. Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч ба компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүний хоорондох бодит эсвэл болзошгүй зарга маргааны улмаас тэдний дунд эсрэг тэсрэг буюу сөргөлдөгч байр суурь үүсэж болзошгүй. Ийм сөргөлдөгчийн байр суурь нь удирдлагын бүрэн тодруулга хийх хүсэл эрмэлзэлд сөргөөр нөлөөлж, хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэдэг.
- 907.3A2 Ийм аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсийн жишээнд дараахыг дурдаж болно. Үүнд:
- Зарга маргааны материаллаг байдлын түвшин.
 - Тухайн зарга маргаан нь өмнөх баталгаажуулах гэрээт ажилтай холбоотой эсэх.
- 907.3A3 Хэрэв зарга маргаанд баталгаажуулах ажлын багийн гишүүн оролцсон бол хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээ бол тухайн хүнийг баталгаажуулах ажлын багаас гаргах явдал юм.
- 907.3A4 Хувийн ашиг сонирхлын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд гүйцэтгэсэн ажлыг шалгадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 910

САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХОЛ

Танилцуулга

- 910.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 910.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй санхүүгийн сонирхлоор холбоотой байх нь хувийн сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 910.3A1 Санхүүгийн хувь оролцоог шууд эсвэл хамтын хөрөнгө оруулалтын хэрэглүүр, эд хөрөнгө, итгэмжлэл зэрэг зуучлалаар дамжуулан шууд бусаар эзэмших боломжтой. Ашиг хүртэх өмчлөгч нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэглүүрийг хянадаг, эсвэл хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх чадамжтай байвал ийм санхүүгийн сонирхлыг Ёс зүйн дүрэмд шууд сонирхол хэмээн тодорхойлсон болно. Эсрэгээр, ашиг хүртэх өмчлөгч нь тухайн хөрөнгө оруулалтын хэрэглүүрийг хянадаггүй, хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх чадамжгүй бол ийм санхүүгийн сонирхлыг шууд бус хэмээн энэ Дүрэмд тодорхойлсон байна.
- 910.3A2 Энэ хэсэгт санхүүгийн хувь оролцооны "материаллаг байдал"-ыг авч үзсэн болно. Хувь оролцоо нь тухайн хүний хувьд материаллаг эсэхийг тодорхойлохдоо, уг хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үзэж болно.
- 910.3A3 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй санхүүгийн хувь оролцоотой болсноор үүссэн хувийн сонирхлын аюул заналын түвшнийг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлүүдэд дараах орно:
- Санхүүгийн сонирхолтой этгээдийн үүрэг оролцоо.
 - Санхүүгийн сонирхол нь шууд ба шууд бусын алин болох.
 - Санхүүгийн сонирхлын материаллаг байдал.

Компани, Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүд болон Ам Бүлийн Гишүүдийн Эзэмшиж Байгаа Санхүүгийн Хувь Оролцоо

- Ш910.4** Дараах этгээд нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй шууд санхүүгийн хувь оролцоо эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцоо эзэмшиж болохгүй:
- (а) Компани; эсвэл
- (б) Баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл тэдгээрийн хэн нэгний ам бүл.

Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчийг Хянадаг Аж Ахуйн Нэгж дэх Санхүүгийн Хувь Оролцоо

- Ш910.5** Аж ахуйн нэгж нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид хяналтын хувь оролцоотой бөгөөд тухайн үйлчлүүлэгч нь уг аж ахуйн нэгжид материаллаг нөлөөтэй бол компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн, тухайн хүний ам бүлийн аль ч гишүүн тухайн аж ахуйн нэгжид шууд эсвэл материаллаг хэмжээний шууд бус санхүүгийн хувь оролцоотой байж болохгүй.

Итгэмжлэгчийн хувьд Эзэмшдэг Санхүүгийн Хувь Оролцоо

- Ш910.6** Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч нь итгэмжлэлийн сангийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд компани эсвэл тухайн хувь хүн нь уг санд итгэмжлэгчийн хувьд санхүүгийн хувь оролцоотой бол дараахаас бусад тохиолдолд дээрх Ш910.4-р параграфыг дагаж мөрдөх ёстой:
- (а) Итгэмжлэгч, баталгаажуулах багийн гишүүн эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн, эсвэл компанийн аль нь ч тухайн итгэмжлэлийн сангаас ашиг хүртэгч биш байх;
- (б) Итгэмжлэлийн сангаас хувь эзэмшдэг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн хувь хэмжээ нь тухайн

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

сангийн хувьд материаллаг бус байх;

- (в) Итгэмжлэлийн сан нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжгүй байх;
- (г) Итгэмжлэгч, баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн эсвэл компанийн аль нь ч баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч дэх санхүүгийн хувь оролцоог хөндсөн хөрөнгө оруулалтын шийдвэрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжгүй байх.

Санаандгүй Хүлээн Авсан Санхүүгийн Хувь Оролцоо

Ш910.7 Хэрэв компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл тухайн хувь хүний ам бүлийн гишүүн нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс санхүүгийн шууд хувь оролцоо, эсвэл санхүүгийн шууд бус материаллаг хувь оролцоог нэгдэлт эсвэл түүнтэй адилтгах нөхцлийн үр дүнд үүссэн өв залгамжлал, бэлгийн хэлбэрээр хүлээн авсан бөгөөд ийм хувь эзэмшихийг энэ бүлгийн дагуу хүлээн зөвшөөрөхөөргүй бол дараах алхмыг хийнэ:

- (а) Хэрэв компани ийм хувь оролцоог хүлээн авсан бол түүнийг нэн даруй зарж борлуулах эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцоог хангалттай материаллаг бус хэмжээгээр зарж борлуулах;
- (б) Хэрэв ийм хувь оролцоог баталгаажуулах багийн гишүүн эсвэл тухайн хүний ам бүлийн гишүүн хүлээн авсан бол ийм санхүүгийн хувь оролцоог аль болох ойрын хугацаанд зарж борлуулах эсвэл үлдэж байгаа хувь нь цаашид хангалттай материаллаг биш байхуйц хэмжээгээр зарж борлуулах;

Санхүүгийн Ашиг Сонирхол –Бусад Нөхцөл

Гэр Бүлийн Ойрын Гишүүн

910.8A1 Хэрэв баталгаажуулах ажлын багийн гишүүний гэр бүлийн ойрын гишүүн нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид шууд санхүүгийн хувь оролцоотой эсвэл материаллаг хэмжээний шууд бус санхүүгийн хувь оролцоотой гэдгийг мэдэж байвал өөрийгөө хянах аюул занал үүсэж болзошгүй.

910.8A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэх хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна. Үүнд:

- Баталгаажуулах ажлын багийн гишүүн ба түүний гэр бүлийн ойрын гишүүний хоорондын харилцаа холбооны шинж чанар;
- Санхүүгийн хувь оролцоо шууд эсвэл шууд бусын алин болох.
- Санхүүгийн хувь оролцоо нь гэр бүлийн ойрын гишүүний хувьд хэр материаллаг болох.

910.8A3 Ийм хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах боломжтой хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Гэр бүлийн ойрын гишүүн нь санхүүгийн хувь оролцоогоо бүгдийг эсвэл шууд бус санхүүгийн хувь оролцооны үлдэх хэсгийг цаашид материаллаг гэж үзэхгүй байх хэмжээгээр зарж борлуулах.
- Баталгаажуулах ажлын багаас тухайн хувь хүнийг чөлөөлөх.

910.8 A4 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлоход чиглэсэн арга хэмжээний жишээ бол баталгаажуулах ажлын багийн гишүүний ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

Бусад Хувь Хүмүүс

910.8A5 Хэрэв баталгаажуулах ажлын багийн гишүүн нь дараах хувь хүмүүс баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид санхүүгийн хувь эзэмшиж байгааг мэдвэл энэ нь хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй:

- Ш910.4-д дурдсан санхүүгийн хувь оролцоотой байхыг тусгайлан хориглосон хүмүүсээс тусад нь тодорхойлсон компанийн партнер, мэргэжлийн ажилтнууд эсвэл тэдний ам бүлийн гишүүд;
- Баталгаажуулах ажлын багийн гишүүнтэй хувийн дотно харилцаа холбоотой хувь хүмүүс.

910.8A6 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол баталгаажуулах ажлын багаас хувийн харилцаа холбоо бүхий гишүүнийг чөлөөлөх явдал юм.

910.8A7 Хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг оруулдаг:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Баталгаажуулах гэрээг ажлын талаар чухал шийдвэр гаргахдаа баталгаажуулах багийн тухайн гишүүнийг оролцуулахгүй байх.
- Баталгаажуулах ажлын багийн тухайн гишүүний ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 911

ЗЭЭЛ БА БАТАЛГАА

Танилцуулга

- 911.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 911.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй зээл эсвэл зээлийн баталгааны талаар холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 911.3A1 Энэ хэсэгт зээл ба зээлийн баталгааны "материаллаг байдал"-ыг авч үзсэн болно. Зээл ба зээлийн баталгаа нь хувь хүний хувьд материаллаг эсэхийг тодорхойлохдоо, тухайн хувь хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчтэй Хийсэн Зээл ба Баталгаа

Ш911.4 Зээл эсвэл зээлийн баталгаа нь дараах этгээдүүдэд материаллаг бус байхаас бусад тохиолдолд компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нь ч баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид зээл эсвэл зээлийн баталгаа гаргах ёсгүй.

(а) Зээл эсвэл зээлийн баталгаа гаргаж байгаа компани эсвэл хувь хүний аль тохирох;

(б) Үйлчлүүлэгч.

Банк, Түүнтэй Ижил Төстэй Байгууллага болох Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчтэй Холбоотой Зээл ба Зээлийн Баталгаа

Ш911.5 Банк ба түүнтэй ижил төстэй байгууллага болох баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь зээл авч эсвэл зээлийн баталгаа гаргуулж үл болно.

911.5A1 Зээлийн жишээнд, мөргөйж, банкны овердрафт, автомашины зээл ба зээлийн картын үлдэгдэл зэргийг оруулдаг.

911.5A2 Банк ба түүнтэй ижил төстэй байгууллага болох баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс компани нь зээл олгох ердийн горим, нөхцөл ба болзлын дагуу зээл авсан ч гэсэн ийм зээл нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч эсвэл зээл авч байгаа компанийн хувьд материаллаг ач холбогдолтой бол хувийн ашиг сонирхлын аюул занал учирч болзошгүй.

911.5A3 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол сүлжээ компаниас зээл хүлээн авагч бус, мөн баталгаажуулах ажлын багийн гишүүн биш хүнээр хийсэн ажлыг нь зохих ёсоор хянан шалгуулах явдал юм.

Хадгаламж эсвэл Брокерын Данс

Ш911.6 Банк, боркер ба түүнтэй ижил төстэй байгууллага болох баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь хадгаламж эсвэл дансыг арилжааны ердийн нөхцөлөөр эзэмшиж байхаас бусад тохиолдолд хадгаламж, эсвэл брокерын данстай байж болохгүй.

Банк, Түүнтэй Ижил Төстэй Байгууллага биш Аудитын Үйлчлүүлэгчтэй Холбоотой Зээл ба Зээлийн Баталгаа

Ш911.7 Зээл эсвэл зээлийн баталгаа нь дараах этгээдүүдэд материаллаг бус байхаас бусад тохиолдолд, банк ба түүнтэй ижил төстэй байгууллага биш баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээс компани, баталгаажуулах ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүний хэн нэг нь зээл авах эсвэл зээлийн баталгаа гаргуулж үл болно:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (a) Зээл эсвэл зээлийн баталгаа хүлээн авч байгаа компани эсвэл хувь хүний аль тохирох;
- (б) Үйлчлүүлэгч.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 920

БИЗНЕСИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО

Танилцуулга

- 920.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 920.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлагатай бизнесийн ойр дотно харилцаа холбоотой байх нь хувийн ашиг сонирхол болон айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 920.3A1 Энэ хэсэгт санхүүгийн хувь оролцооны "материаллаг байдал" ба бизнесийн харилцаа холбооны "ач холбогдол"-ыг авч үзсэн болно. Хувь оролцоо нь тухайн хүний хувьд материаллаг эсэхийг тодорхойлохдоо, уг хүн ба түүний ам бүлийн гишүүдийн нэгтгэсэн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг харгалзан үзэж болно.
- 920.3A2 Арилжааны харилцаа холбоо буюу санхүүгийн нийтлэг ашиг сонирхлоос үүсдэг бизнесийн ойр дотно харилцааны жишээнд дараахыг багтаана:
- Үйлчлүүлэгч эсвэл түүний хяналтын эрхтэй өмчлөгч, захирал, албан тушаалтан, тухайн үйлчлүүлэгчийн компанид дээд түвшний удирдах албан тушаал хашдаг бусад хувь хүнтэй хамт хамтарсан компанид санхүүгийн хувь эзэмшдэг;
 - Компанийн нэг буюу түүнээс дээш тооны үйлчилгээ эсвэл бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчийн нэг буюу түүнээс дээш тооны үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй нэгтгэж, багцлан хоёр талын нэр дээр зах зээлд гаргахаар тохиролцох;
 - Компани нь үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх буюу зах зээлд гаргах, эсвэл үйлчлүүлэгч нь компанийн бүтээгдэхүүн үйлчилгээг түгээх буюу зах зээлд гаргахаар тохиролцох.

Компани, Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүн эсвэл Ам Бүлийн Гишүүдийн Бизнесийн Харилцаа Холбоо

- Ш920.4** Санхүүгийн ашиг сонирхол нь материаллаг бус бөгөөд тухайн бизнесийн харилцаа холбоо нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлага болон компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүнд чухал ач холбогдолтой байхаас бусад тохиолдолд, компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүний хэнд нь ч баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй бизнесийн ойр дотно харилцаа холбоо тогтоохыг хориглох ёстой.
- 920.4A1 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч эсвэл түүний удирдлага болон баталгаажуулах ажлын багийн гишүүний ам бүлийн хооронд бизнесийн ойр дотно харилцаа холбоо байх нь хувийн ашиг сонирхол эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй.

Бараа, Үйлчилгээ Худалдан Авах

- 920.5A1 Компани эсвэл баталгаажуулах ажлын багийн гишүүн, түүний ам бүлийн гишүүдийн хэн нэгнээс бараа, үйлчилгээ худалдаж авах ажил гүйлгээ нь бизнесийн ердийн нөхцлөөр хийгдсэн бөгөөд холбоогүй талуудынх байвал ерөнхийдөө хараат бус байдалд аюул занал учруулдаггүй. Гэхдээ ийм ажил гүйлгээ нь хувийн ашиг сонирхлын аюул заналыг үүсгэхүйц шинж чанар, далайцтай байх боломжтой.
- 920.5A2 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг арилгах арга хэмжээний жишээнд дараахыг оруулж болно:
- Тухайн ажил гүйлгээг зогсоох эсвэл түүний цар хэмжээг багасгах;
 - Тухайн хувь хүнийг баталгаажуулах ажлын багаас чөлөөлөх

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 921

ГЭР БҮЛИЙН БОЛОН ХУВИЙН ХАРИЛЦАА ХОЛБОО

Танилцуулга

- 921.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 921.2 Үйлчлүүлэгчийн ажилтнуудтай тогтоосон гэр бүлийн эсвэл хувийн харилцаа холбоо нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 921.3A1 Баталгаажуулах ажлын багийн гишүүн ба баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн захирал, эсвэл гүйцэтгэх үүргээс хамааран зарим албан тушаалтан, ажилтнуудын хооронд гэр бүлийн ба хувийн харилцаа холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэж болзошгүй.
- 921.3A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:
- Баталгаажуулах ажлын багт тухайн хувь хүний хариуцаж буй ажил үүрэг.
 - Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид гэр бүлийн гишүүн ба бусад хувь хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, уг харилцаа холбоо хэр ойр дотно байх.

Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүний Ам Бүл

- 921.4A1 Баталгаажуулах ажлын багийн гишүүний ам бүлийн гишүүн нь гэрээт ажлын баталгаажуулах асуудалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх түвшний албан тушаал эрхэлдэг бол хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүсдэг.
- 921.4A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:
- Ам бүлийн гишүүний хашиж байгаа албан тушаал.
 - Баталгаажуулах ажлын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.
- 921.4 A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний жишээ бол тухайн хувь хүнийг баталгаажуулах ажлын багаас чөлөөлөх явдал юм.
- 921.4A4 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол баталгаажуулах ажлын багийн тухайн гишүүн нь өөрийн ам бүлийн гишүүний үүрэг хариуцлагад хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар баталгаажуулах ажлын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.

- Ш921.5** Тухайн хувь хүний ам бүлийн хүн дараах алба тушаал хашдаг бол баталгаажуулах ажлын багийн гишүүнээр ажилд оролцох ёсгүй:
- (а) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан;
 - (б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.
 - (в) Гэрээт ажил эсвэл баталгаажуулах асуудлын мэдээлэлд хамрагдсан хугацаанд дээр дурдсан албан тушаал хашиж байсан бол.

Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүний Ойрын Гэр Бүл

- 921.6A1 Баталгаажуулах ажлын багийн гишүүний гэр бүлийн ойрын гишүүн нь дараах тохиолдолд хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг үүсгэнэ:
- (а) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн захирал буюу ажилтан;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

(б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.

921.6A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:

- Баталгаажуулах ажлын багийн гишүүн ба түүний гэр бүлийн ойрын гишүүний хоорондох харилцаа холбооны шинж чанар.
- Гэр бүлийн ойрын гишүүний хашдаг албан тушаал.
- Баталгаажуулах ажлын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.

921.6A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол баталгаажуулах ажлын багаас тухайн гишүүнийг чөлөөлөх явдал юм.

921.6A4 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол баталгаажуулах ажлын багийн тухайн гишүүн нь гэр бүлийн ойрын гишүүний үүрэгт хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар баталгаажуулах ажлын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.

Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүний бусад Ойр Дотнын Харилцаа Холбоо

Ш921.7 Хэрэв баталгаажуулах ажлын багийн гишүүн нь түүний ам бүлийн гишүүн эсвэл гэр бүлийн ойрын гишүүн биш боловч дараах албан тушаал хашдаг этгээдтэй ойр дотнын харилцаа холбоотой бол тэрээр өөрийн компанийн бодлого, горим журамд нийцүүлэн үүнийг авч үзэх хэрэгтэй:

- (а) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан;
- (б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.

921.7A1 Ийм харилцаа холбооны үр дүнд үүссэн хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:

- Тухайн хувь хүн ба баталгаажуулах ажлын багийн гишүүний хоорондох харилцаа холбооны шинж чанар.
- Аудитын үйлчлүүлэгчид тухайн хувь хүний хашдаг албан тушаал.
- Баталгаажуулах ажлын багийн гишүүний гүйцэтгэдэг үүрэг.

921.7A2 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг арилгах боломжтой арга хэмжээний нэг жишээ бол баталгаажуулах ажлын багаас тухайн гишүүнийг чөлөөлөх явдал юм.

921.7A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол баталгаажуулах ажлын багийн тухайн гишүүн нь өөрийн ойр дотнын харилцаа холбоо бүхий хувь хүний үүрэг хариуцлагад хамаарах асуудлыг хариуцахгүй байхаар баталгаажуулах ажлын багийн ажил үүргийг хуваарилах явдал юм.

Компанийн Партнер ба Ажилтнуудын Харилцаа Холбоо

921.8A1 Дараах хүмүүсийн хоорондох хувийн эсвэл гэр бүлийн харилцааны улмаас хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүсэж болно:

- (а) Баталгаажуулах ажлын багийн гишүүн биш хүн биш боловч тухайн компанийн партнер эсвэл ажилтан;
- (б) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн захирал эсвэл албан тушаалтан, баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байгаа ажилтан.

921.8A2 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаадаг:

- Компанийн партнер эсвэл ажилтан ба үйлчлүүлэгчийн захирал, албан тушаалтан эсвэл ажилтны хоорондох харилцаа холбооны шинж чанар.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- Компанийн партнер эсвэл ажилтаны баталгаажуулах ажлын багтай харилцан хамтрах түвшин.
- Партнер эсвэл ажилтны тухайн компанид хашиж буй албан тушаал.
- Үйлчлүүлэгчийн дотор хашиж байгаа тухайн хувь хүний албан тушаал.

921.8A3 Хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээнд дараахыг оруулна:

- Баталгаажуулах гэрээт ажилд нөлөөлөх аливаа боломжийг багасгахын тулд партнер эсвэл ажилтны ажил үүргийг хуваарилах.
- Гүйцэтгэсэн баталгаажуулах ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 922

БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД СҮҮЛИЙН ҮЕД АЛБА ХАШСАН БАЙДАЛ

Танилцуулга

- 922.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 922.2 Хэрэв баталгаажуулах ажлын багийн гишүүн нь сүүлийн үед баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагад захирал эсвэл албан ташуултан эсвэл түүний ажилтнаар ажиллаж байсан бол хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Баталгаажуулах Ажлын Тайланд Хамрагдсан Хугацаанд Алба Хашсан Байдал

- Ш922.3** Баталгаажуулах ажлын багт, баталгаажуулах ажлын тайланд хамрагдсан хугацааны туршид дараах үйлчилгээ үзүүлж байсан хүмүүсийг оруулах ёсгүй. Үүнд:
- (а) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл өөр албан тушаал эрхэлж байсан;
 - (б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байсан ажилтан.

Аудитын Тайланд Хамрагдсан Хугацаанаас Өмнө Алба Хашсан Байдал

- 922.4A1 Хэрэв баталгаажуулах ажлын тайланд хамрагдсан хугацаанаас өмнө баталгаажуулах ажлын гишүүн дараах алба хашиж байсан бол хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул занал үүсэж болзошгүй. Үүнд:
- (а) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл өөр албан тушаал эрхэлж байсан;
 - (б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байсан ажилтан.
- Жишээлбэл, хэрэв дурдаж байгаа өмнөх хугацаанд баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагад ажиллаж байхдаа тухайн хувь хүний гаргасан шийдвэр эсвэл гүйцэтгэсэн ажлыг тайлант үеийн баталгаажуулах гэрээт ажлын нэг хэсэг болгож одоо үнэлэх гэж байгаа бол энэ нь дээрх аюул заналыг үүсгэнэ.
- 922.4A2 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг багтаана:
- Үйлчлүүлэгч байгууллагад тухайн хүний хашиж байсан албан тушаал;
 - Тухайн хувь хүн үйлчлүүлэгч байгууллагад ажиллахаа больсноос хойш өнгөрсөн хугацаа;
 - Баталгаажуулах ажлын багт тухайн хувь хүний гүйцэтгэдэг үүрэг.
- 922.4A3 Хувийн ашиг сонирхол, өөрийгөө хянах болон танилын аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээ бол баталгаажуулах ажлын багийн гишүүний гүйцэтгэсэн ажлыг хянадаг тохирох хянан шалгагчтай байх явдал юм.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

ХЭСЭГ 923

БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ЗАХИРАЛ, АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН БАЙДАЛ

Танилцуулга

- 923.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 923.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагад захирал эсвэл албан тушаалтнаар ажилласан байх нь өөрийгөө хянах болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг бий болгодог. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Захирал эсвэл Албан Тушаалтнаар Ажилладаг Байх

- Ш923.3** Компанийн партнер эсвэл ажилтан нь уг компанийн баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл албан тушаалтнаар ажиллаж болохгүй.

Компанийн Нарийн Бичгийн Даргын Алба Хаших

- Ш923.4** Дараахаас бусад тохиолдолд, компанийн партнер эсвэл ажилтан нь уг компанийн баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагын нарийн бичгийн даргын албыг хаших ёсгүй:

- (а) Ийм практикийг дотоодын хууль тогтоомж, мэргэжлийн дүрэм журам, эсвэл үйл ажиллагааны практикт тусгайлан зөвшөөрсөн;
- (б) Удирдлага нь холбогдох бүх шийдвэрийг гаргадаг;
- (в) Гүйцэтгэдэг албан үүрэг ба үйл ажиллагаа нь ярианы тэмдэглэл бэлтгэх, албан бичиг хөтлөлт хийх зэрэг байнга давтагддаг бөгөөд захиргааны шинжтэй үүргээр хязгаарлагддаг бол.

- 923.4 А1 Компанийн нарийн бичгийн даргын албан тушаал нь хууль эрх зүйн янз бүрийн орчинд мөн өөр өөр шинжтэй байдаг. Энэ ажил үүрэг нь хүний нөөцийг удирдах ба компанийн бичиг баримтын бүртгэл хөтлөх зэрэг захиргааны үүргээс эхлээд компанид хууль тогтоомжийг мөрдөн сахиулах буюу компанийн засаглалын асуудлаар зөвлөгөө өгөх хүртэлх олон талтай үүрэг байж болно. Энэ албан тушаал ихэвчлэн тухайн байгууллагын үйл ажиллагаатай илүү нягт уялдаатай байдлыг илэрхийлдэг. Тиймээс, компанийн партнер эсвэл ажилтан нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн компанийн нарийн бичгийн даргаар ажилладаг бол аюул занал үүснэ. (Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээг үзүүлэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хэсэг 950, *Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээг үзүүлэх*-д тодорхойлсон болно.)

ХЭСЭГ 924

БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД АЖИЛ ЭРХЛЭХ

Танилцуулга

- 924.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 924.2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй ажил эрхлэлтийн талаар холбоотой байх нь хувийн ашиг сонирхлын, танилын болон айлган сүрдүүлэх аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 924.3A1 Доор дурдсан этгээдийн хэн нэг нь баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл компанийн партнер бол танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэж болзошгүй:
- Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагын захирал эсвэл албан тушаалтан.
 - Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаал эрхэлж байсан ажилтан.

Өмнөх Партнер эсвэл Баталгаажуулах Ажлын Багийн Гишүүнд Тавих Хязгаарлалт

- Ш924.4** Хэрэв өмнөх партнер нь компанийн баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид эсвэл өмнөх баталгаажуулах ажлын багийн гишүүн нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид дараах алба хашихаар болсон бол тухайн хувь хүнийг компанийн бизнес буюу мэргэжлийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцуулж болохгүй:
- (а) Захирал эсвэл албан тушаалтан;
- (б) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх албан тушаалтан.
- 924.4A1 Хэрэв Ш924.4-р параграфт заасан хувь хүмүүсээс хэн нэг нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид дээрх албан тушаалын аль нэгийг хашиж, улмаар компанийн бизнес буюу мэргэжлийн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцохгүй байсан ч гэсэн танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэх боломжтой хэвээр байна.
- 924.4A2 Хэрэв компанийн өмнөх партнер нь 924.3A1 параграфт заасан албан тушаалын аль нэгийг хашиж, үүний дараа тухайн аж ахуйн нэгж нь компанийн баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч болсон бол мөн л танилын эсвэл айлган сүрдүүлэх аюул занал үүсэх боломжтой.
- 924.4A3 Ийм аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараах багтана:
- Үйлчлүүлэгч байгууллагын хувьд тухайн хувь хүний хашиж байгаа албан тушаал.
 - Тухайн хувь хүний зүгээс баталгаажуулах багийн ажилд оролцох байдал.
 - Тухайн хувь хүн баталгаажуулах ажлын багийн гишүүн эсвэл компанийн партнер байснаас хойш өнгөрсөн хугацаа.
 - Баталгаажуулах ажлын баг эсвэл компанид тухайн хувь хүний хашиж байсан хуучин албан тушаал. Жишээлбэл, тухайн хувь хүний ажил үүрэгт үйлчлүүлэгчийн удирдлага эсвэл засаглах эрхтэй удирдлагатай тогтмол холбоотой байх хэрэгцээ шаардлага байсан эсэх.
- 924.4A4 Танилын эсвэл айлган сүрдүүлэх ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:
- Урьдчилан тодорхойлсон тохиролцооны дагуу хийгдээгүй аливаа ашиг, урамшуулал, төлбөрийг тухайн хувь хүн компаниас авах эрхгүй байх тохиролцоо;
 - Тухайн хувь хүнд өгөх ёстой төлбөрийн дүн нь компанид материаллаг бус байхаар хийсэн тохиролцоо;
 - Баталгаажуулах ажлын төлөвлөгөөг өөрчлөх.
 - Үйлчлүүлэгч байгууллагад ажилд орсон хувь хүнтэй харьцуулахад хангалттай туршлага бүхий

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

хүмүүсийг баталгаажуулах ажлын багт томилох.

- Баталгаажуулах ажлын багийн өмнөх гишүүний гүйцэтгэсэн ажлыг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх.

Үйлчлүүлэгч Байгууллагад Ажил Эрхлэхээр Тохиролцсон Баталгаажуулах Багийн Гишүүд

- Ш924.5** Компанийн баталгаажуулах ажлын багийн гишүүд нь ажил эрхлэлтийн талаар баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчидтэй тохиролцохдоо компанидаа энэ тухай мэдэгдэхийг шаарддаг бодлого, горимтой байна.
- 924.5A1 Баталгаажуулах ажлын багийн гишүүн нь ирээдүйд үйлчлүүлэгч байгууллагад ажилд орох эсвэл орж болзошгүй талаар мэдэж байх үедээ уг баталгаажуулах ажилд багийн гишүүнээр оролцож байгаа тохиолдолд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсдэг.
- 924.5A2 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг арилгах арга хэмжээний нэг жишээ бол тухайн хувь хүнийг баталгаажуулах ажлын багаас чөлөөлөх явдал юм.
- 924.5A3 Хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний нэг жишээ бол, баталгаажуулах багийн гишүүн нь тухайн багт ажиллаж байхдаа гаргасан нөлөө бүхий шийдвэрийг хянаж үзэх зохих ёсны хянан шалгагчтай байх явдал юм.

ХЭСЭГ 940

АЖИЛТНУУД БА БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХООРОНДОХ УДААН ХУГАЦААНЫ ХАРИЛЦАА

Танилцуулга

- 940.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 940.2 Баталгаажуулах гэрээт ажилд оролцдог аливаа хувь хүн удаан хугацааны турш ийнхүү дахин ажиллах нь танилын болон хувийн ашиг сонирхлын аюул занал үүсгэж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- 940.3A1 Тухайн хувь хүн урт хугацаанд дараах этгээдтэй хамтран ажилласнаар танилын аюул занал үүсэж болзошгүй:
- (a) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч;
 - (b) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн ахлах түвшний удирдлага; эсвэл
 - (в) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудал болон баталгаажуулах асуудлын мэдээлэл.
- 940.3A2 Урт хугацаанд хамтарч байгаа баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчээ алдах бий гэсэн болгоомжлол, эсвэл ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрхтэй этгээдтэй тогтоосон хувийн дотно харилцаагаа хадгалж үлдэх сонирхлын үр дүнд хувийн ашиг сонирхлын аюул занал үүсэж болно. Ийм аюул занал нь тухайн хувь хүний шүүн тунгаалтад зүй бусаар нөлөөлөх боломжтой.
- 940.3A3 Танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлсэд дараахыг оруулна:
- Баталгаажуулах гэрээт ажлын мөн чанар
 - Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчтэй тухайн хувь хүний тогтоосон харилцаа холбооны үргэлжилсэн хугацаа, тухайн хувь хүнийн гэрээт ажлын баг дахь албан тушаалын зэрэглэл, гүйцэтгэсэн ажил үүргийн мөн чанар, үүнд тухайн хүн өмнөх аудитын компанид байх үед ийм харилцаа байсан эсэх.
 - Тухайн хувь хүний ажлыг илүү дээгүүр түвшний ажилтан чиглүүлж, хянан шалгаж, дүгнэж байсан цар хүрээ.
 - Тухайн хувь хүн хашиж байсан албан тушаалын зэрэг зиндаандаа дулдуйдан, баталгаажуулах ажлын үр дүн, жишээлбэл, гол шийдвэр гаргах, эсвэл бусад гэрээт ажлын багийн гишүүдийн ажлыг чиглүүлэх зэрэгт нөлөөлөх боломжийн цар хүрээ.
 - Ахлах түвшний удирдлага эсвэл засаглах эрх бүхий этгээдтэй хувь хүний тогтоосон харилцаа нь хэр ойр дотно болох.
 - Тухайн хувь хүн ба баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн хоорондох харилцан хамаарлын мөн чанар, давтамж, далайц.
 - Баталгаажуулах асуудал ба баталгаажуулах асуудлын мэдээллийн шинж чанар, нарийн төвөгтэй байдал өөрчлөгдсөн эсэх.
 - Хариуцагч тал болох нэг эсвэл хэд хэдэн хүн эсвэл хамааралтай гэж үзвэл ахлах түвшний удирдлага нь сүүлийн үед өөрчлөгдсөн эсэх.
- 940.3A4 Хоёр буюу хэд хэдэн хүчин зүйлс нийлж гарснаар аюул заналын түвшин нэмэгдэх эсвэл буурах боломжтой. Жишээлбэл, хувь хүн ба баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн хоорондох удаан хугацааны ойр дотно харилцаагаар үүссэн танилын аюул заналыг хариуцагч тал болох тухайн хувь хүнийг чөлөөлснөөр бууруулж болно.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

940.3A5 Тусгай гэрээт ажилтай холбоотой танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг арилгах арга хэмжээний нэг жишээ бол баталгаажуулах ажлын багаас тухайн хувь хүнийг эргэцийн дагуу чөлөөлөх явдал юм.

940.3A6 Танилын болон хувийн ашиг сонирхлын ийм аюул заналыг тодорхойлох хамгаалалтын арга хэмжээний жишээнд дараахыг дурдаж болно:

- Баталгаажуулах ажлын баг дахь тухайн хувь хүний үүрэг эсвэл түүний гүйцэтгэдэг ажил үүргийн мөн чанар, далайцыг өөрчлөх.
- Баталгаажуулах ажлын багийн гишүүн бус өөр зохих ёсны хянан шалгагчаар уг хүний ажлыг хянан шалгуулах.
- Гэрээт ажлын чанарыг хараат бус гадаад болон дотоод шалгалтаар тогтмол хянан нягтлах.

Ш940.4 Зөвхөн баталгаажуулах ажлын багийн гишүүдийг сэлгэн ажиллуулснаар үүссэн аюул заналыг тодорхойлох боломжтой хэмээн компани шийдсэн бол, тэрээр ямар хугацаанд тухайн хүнийг дараах үйлдлээс хориглохыг тодорхойлох ёстой. Үүнд:

- (a) Баталгаажуулах гэрээт ажлын хувьд, гэрээт ажлын багийн гишүүн байх;
- (б) Баталгаажуулах гэрээт ажилд чанарын хяналт тавих; эсвэл
- (в) Баталгаажуулах гэрээт ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлэх.

Дээрх хугацаа нь танилын болон хувийн ашиг сонирхлын аюул заналыг тодорхойлоход хангалттай байх ёстой.

ХЭСЭГ 950

АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ АЖЛЫН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД БАТАЛГААЖУУЛАЛТЫН БУС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

Танилцуулга

- 950.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөхийг компаниудаас шаарддаг.
- 950.2 Компаниуд нь өөрийн ур чадвар, туршлагад нийцсэн баталгаажуулалтын бус олон төрлийн үйлчилгээг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлэх боломжтой. Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх нь суурь зарчмын нийцэл болон хараат бус байдалд аюул занал учруулж болзошгүй. Энэ хэсэгт, онолын үзэл баримтлалыг ийм тохиолдолд хэрхэн мөрдөх шаардлага болон ашиглах материалыг тодорхойлсон болно.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- Ш950.3** Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх тухай гэрээт ажлыг зөвшөөрөхийн өмнө компани нь ийм үйлчилгээ үзүүлснээр хараат бус байдалд аюул занал учирч болох эсэхийг тодорхойлох ёстой.
- 950.3A1 Энэ хэсэгт багтсан шаардлага ба ашиглах материал нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлэх баталгаажуулалтын бус зарим үйлчилгээний төрөл, хэрэв компани нь баталгаажуулалтын бус үйлчилгээг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлбэл үүсэж болзошгүй аюул заналыг задлан шинжлэхэд компанид тусалдаг.
- 950.3A2 Бизнесийн шинэ практик, санхүүгийн зах зээлийн хувьсал, мэдээллийн технологийн өөрчлөлт зэрэг нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлж болох баталгаажуулалтын бус үйлчилгээний бүх төрлийг багтаасан жагсаалтыг нэг мөр гаргах боломжгүйд хүргэж байна. Үүний улмаас, уг Дүрэмд баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлэх боломжтой баталгаажуулалтын бус үйлчилгээний бүх төрлийг бүрэн тусгаагүй болно.

Аюул Заналыг Үнэлэх

- 950.4A1 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр бий болсон аюул заналын далайцыг үнэлэхэд хамааралтай хүчин зүйлд дараахыг багтаана:
- Үйлчилгээний шинж чанар, цар хүрээ, зорилго.
 - Баталгаажуулах ажлын хэсэг болох уг үйлчилгээний үр дүнд тулгуурлах түвшин.
 - Үйлчилгээ үзүүлдэг хууль эрх зүйн болон зохицуулалтын орчин.
 - Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудал эсвэл баталгаажуулах асуудлын мэдээлэлд тусгагдсан асуудалд тухайн үйлчилгээний үр дүн нөлөөлөх эсэх, хэрэв тийм бол:
 - o Үйлчилгээний үр дүн нь баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудалд материаллаг буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх далайц.
 - o Томоохон шүүн тунгаалт шаардсан асуудлыг тодорхойлоход баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч хэр оролцсон.
 - Үзүүлсэн үйлчилгээний төрөлд, үйлчлүүлэгчийн удирдлага болон ажилтнуудын мэргэшсэн түвшин.

Баталгаажуулах Ажлын Үйлчлүүлэгчийн Мэдээлэлтэй Холбоотой Материаллаг Байдал

- 950.4A2 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй холбоотой материаллаг байдлын тухай ойлголтыг *Түүхэн санхүүгийн тайлангийн аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах гэрээт ажил*, АОУС 300 (Хянан засварласан)-д авч үздэг. Материаллаг байдлыг тодорхойлохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хэрэгжүүлдэг бөгөөд үүнд тоон ба чанарын хүчин зүйлс нөлөөлдөг. Мөн хэрэглэгчдийн

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

санхүүгийн мэдээллийн эрэлт хэрэгцээний талаарх ойлголт нөлөөлдөг.

Баталгаажуулах Ажлын Нэг Үйлчлүүлэгчид Баталгаажуулалтын бус Олон Төрлийн Үйлчилгээ Үзүүлэх

950.4A3 Компани нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Ийм тохиолдолд, эдгээр үйлчилгээг үзүүлснээр бий болсон аюул заналын нийлмэл үр нөлөөг авч үзэх нь компанийн хийх аюул заналын үнэлгээнд хамааралтай юм.

Аюул заналыг тодорхойлох

950.5A1 Параграф 120.10A2-т хамгаалалтын арга хэмжээг тодорхойлсон байгаа. Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хамгаалалт бол, хараат бус байдалд учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулж чадах үр нөлөөтэй арга хэмжээг компани дангаар нь эсвэл хамтад нь авах арга хэмжээ юм. Зарим нөхцөлд, баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлснээр аюул занал учрах үед авах хамгаалалтын бэлэн арга хэмжээ байхгүй байж болно. Ийм тохиолдолд, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлал нь, баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эсвэл цуцлахыг компаниас шаарддаг.

Удирдлагын Үүрэг Хариуцлага Хүлээхийг Хориглох

Ш950.6 Компани нь баталгаажуулах асуудал эсвэл баталгаажуулах асуудлын мэдээлэлтэй холбоотой удирдлагын үүрэг хариуцлагыг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч байгууллагад хүлээх ёсгүй. Хэрэв компани нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид үзүүлсэн бусад үйлчилгээний нэг хэсэг болгон удирдлагын хариуцлага хүлээдэг байвал тэрээр уг хариуцлага нь өөрийн компанийн үзүүлсэн баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудал эсвэл баталгаажуулах асуудлын мэдээлэлтэй холбоотой хариуцлага биш гэдэгт итгэлтэй байх ёстой.

950.6A1 Удирдлагын үүрэг хариуцлагад хүний нөөцийн, санхүүгийн, технологийн, биет болон биет бус нөөцийг олж бэлтгэх, ашиглах, хянахтай холбоотой шийдвэр гаргах зэрэг аж ахуйн нэгж, байгууллагыг хянах, удирдах ба чиглүүлэх үүрэг багтдаг.

950.6A2 Компани нь баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид баталгаажуулалтын бус үйлчилгээ үзүүлэх явцдаа удирдлагын хариуцлага хүлээдэг бол, өөрийгөө хянах болон хувийн ашиг сонирхлын аюул занал бий болгодог. Компанийн үзүүлсэн баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудал эсвэл баталгаажуулах асуудлын мэдээлэлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэхдээ удирдлагын хариуцлага хүлээж байвал энэ нь танилын аюул заналаас гадна тухайн компани өөрийн үйлчлүүлэгчийн удирдлагын үзэл бодол, ашиг сонирхолтой хэт зохицох буюу нэгддэг тул өмгөөлөх аюул заналыг ч үүсгэж болзошгүй.

950.6A3 Аливаа үйл ажиллагааг удирдлагын үүрэг хариуцлага мөн эсэхийг тодорхойлох нь тухайн нөхцөл байдлаас хамаарах бөгөөд мэргэжлийн шүүн тунгаалт ашиглахыг шаарддаг. Удирдлагын үүрэг хариуцлага хэмээн үзэж болох үйл ажиллагааны жишээнд дараахыг багтаана:

- Бодлого, стратегийн чиглэлийг тогтоох.
- Ажилтнуудыг ажилд авах буюу халах.
- Тухайн аж ахуйн нэгжийн төлөө ажиллаж байгаа ажилтнуудын үйлдлийг чиглүүлэх ба хариуцах.
- Ажил гүйлгээ хийхийг зөвшөөрөх.
- Банкны данс эсвэл хөрөнгө оруулалтыг хянах буюу удирдах.
- Компани, бусад гуравдагч талуудын өгсөн аль зөвлөмжийг хэрэгжүүлэхийг шийдэх.
- Удирдлагын өмнөөс засаглах эрхтэй удирдлагад тайлагнах.
- Дотоод хяналтыг зохиомжлох, хэрэгжүүлэх, хянан шинжлэх буюу сахин мөрдөх.

950.6A4 Үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь тус дэм болох зөвлөгөө, зөвлөмжийг баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчдээ өгөх нь удирдлагын үүрэг хариуцлага хүлээж байгаа хэрэг биш юм (Лав: Пара. Ш950.6-950.6A3).

Ш950.7 Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид, баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудал эсвэл

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

баталгаажуулах асуудлын мэдээлэлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх үедээ үйлчлүүлэгчийн удирдлагын үүрэг хариуцлагыг өөртөө авахаас зайлсхийхийн тулд, удирдлагын гарцаагүй үүрэг хариуцлага болох чухал шүүн тунгаалт, шийдвэрийг үйлчлүүлэгчийн удирдлага гаргасан гэдэгт компани итгэлтэй байх ёстой. Үүнд үйлчлүүлэгчийн удирдлага дараах шийдвэр гаргасан гэх баталгаа багтдаг:

(a) Үйлчлүүлэгчийн гаргасан шийдвэрийг цаг хугацаанд нь хариуцахуйц ур чадвар, мэдлэг, туршлагыг эзэмшсэн хувь хүнийг томилж, үйлчилгээг хянуулна. Ийм хүнийг дээд түвшний удирдлагын хүрээнээс сонгох бөгөөд тэрээр дараах зүйлийг ойлгосон байна:

(i) Үйлчилгээний зорилго, шинж чанар, үр дүн;

(ii) Тухайн үйлчлүүлэгч ба компанийн хүлээх хариуцлага.

Гэхдээ, тухайн хувь хүнээс үйлчилгээг гүйцэтгэх эсвэл дахин гүйцэтгэх туршлагатай байхыг шаарддаггүй.

(b) Үйлчилгээг хянах, үйлчлүүлэгчийн зорилгод нийцүүлэн гүйцэтгэсэн үйлчилгээний үр дүнг үнэлэх.

(в) Үйлчилгээний үр дүнд үндэслэн авах арга хэмжээний хариуцлагыг хүлээх.

Баталгаажуулалтын бус Онцгой Үйлчилгээ Үзүүлэхтэй Холбогдуулан Анхаарах бусад Асуудал

950.8A1 Хэрэв компани баталгаажуулах асуудлын мэдээлэл бэлтгэхэд оролцсон бөгөөд энэ нь яваандаа баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэл болсон бол өөрийгөө хянах аюул занал үүсэж болзошгүй. Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээлэлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх үед үүсэж болзошгүй баталгаажуулалтын бус үйлчилгээний жишээнд дараахыг багтаана:

(a) Хэтийн мэдээлэл боловсруулах ба бэлтгэх, дараа нь эдгээр мэдээллийг баталгаажуулах үйлчилгээ үзүүлэх.

(b) Баталгаажуулах гэрээт ажлын баталгаажуулах асуудлын мэдээллийн нэг хэсгийг бүрдүүлдэг үнэлгээний ажил гүйцэтгэх.

ХЭСЭГ 990

АШИГЛАХ БА ТҮГЭЭХ НӨХЦӨЛД НЬ ХЯЗГААРЛАЛТ ТАВЬСАН ТАЙЛАН (АУДИТ БА НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛААС БУСАД БАТАЛГААЖУУЛАХ АЖИЛ)

Танилцуулга

- 990.1 Хараат бус байдалд учрах аюул заналыг олж тогтоох, үнэлэх, шийдвэрлэхдээ онолын суурь зарчимд нийцүүлэн хараат бус байж, Хэсэг 120-д тодорхойлсон онолын үзэл баримтлалыг мөрдөх ёстой.
- 990.2 Энэ хэсэгт, Бүлэг 4Б-д баталгаажуулах гэрээт ажлын тайланг ашиглах ба нийтэд түгээхийг тодорхой тохиолдолд зөвшөөрсөн зарим өөрчлөлтийг тусгасан болно. Энэ хэсэгт, Ш990.3-р параграфт заасан нөхцөлийн дагуу, ашиглах ба нийтэд түгээх хязгаарлалт бүхий тайлан гаргах гэрээт ажлыг зохистой баталгаажуулах гэрээт ажил” гэж үзнэ.

Шаардлага ба Ашиглах Материал

Ерөнхий Зүйл

- Ш990.3** Баталгаажуулах гэрээт ажлын талаар компани нь ашиглах ба нийтэд түгээх хязгаарлалт бүхий тайлан гаргахаар төлөвлөж байвал, энэ хэсэгт зөвшөөрсөн өөрчлөлтийн хувьд, Бүлэг 4Б-ийн хараат бус байдлын шаардлагыг зөвхөн дараах тохиолдолд мөрдөх боломжтой хэмээн үзэх ёстой:
- (а) Компани тухайн үйлчилгээг үзүүлэхдээ мөрдвөл зохих хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлагын талаар тайлангийн зорилтот хэрэглэгчидтэй харилцаж, мэдээлдэг бол;
 - (б) Тайлангийн зорилтот хэрэглэгчид нь тайлангийн зорилго, баталгаажуулах асуудлын мэдээлэл болон хязгаарлалтын талаар ойлголттой бөгөөд уг өөрчлөлтийг дагаж мөрдөхийг илэрхий зөвшөөрч байвал.
- 990.3A1 Тайлангийн зорилтот хэрэглэгчид нь гэрээт ажлын мөн чанар, цар хүрээг тогтооход шууд эсвэл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхтэй удирдлага буюу төлөөлөгчөөр дамжуулан шууд бусаар оролцох замаар тайлангийн зорилго, баталгаажуулах асуудлын мэдээлэл болон хязгаарлалтыг ойлгож авах боломжтой. Аль ч тохиолдолд, дээрх оролцоо нь хараат бус байдал, үүнд онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөхтэй холбоотой нөхцөлийн талаар компанийн зүгээс зорилтот хэрэглэгчидтэй ярилцаж, харилцахад тус дэм болдог. Түүнчлэн, хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлагыг зорилтот хэрэглэгчдэд ойлгуулж, тэднээс зөвшөөрөл авах боломжийг компанид олгодог.
- Ш990.4** Гэрээт ажлын нөхцөлийг тогтоож байх үед зорилтот хэрэглэгчдийг нэрээр нь тусгайлан тодорхойлох боломжгүй бүлэг байх тохиолдолд компани, хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлага бол тэдгээр хэрэглэгчдийн удирдлагатай зөвшилцсөн шаардлага юм гэдгийг цаашид ойлгуулах нь зүйтэй.
- 990.4A1 Жишээлбэл, зорилтот хэрэглэгчид нь зээлийн нэгдсэн хэлцэл дэх зээлдүүлэгчид гэх мэт ангилалд багтаж байвал тухайн зээлдүүлэгчдийн удирдлагад илгээх гэрээт ажлын захидалдаа энэхүү өөрчлөгдсөн хараат бус байдлын шаардлагыг компани тодорхойлж бичих боломжтой. Удирдлага нь компаниас хүлээн авсан удирдлагад илгээх захидлыг зээлдүүлэгчдийн бүлгийн гишүүдэд мэдээлж, ингэснээр хараат бус байдлын өөрчлөлт орсон шаардлага бол тэдгээр хэрэглэгчдийн удирдлагатай зөвшилцсөн шаардлага юм гэдгийг хэрэглэгчдэд ойлгуулах шаардлагыг компани хангах юм.
- Ш990.5** Зохистой баталгаажуулах гэрээт ажлыг компани гүйцэтгэж байх үед, Бүлэг 4Б-д ямар нэг өөрчлөлт оруулахдаа, Ш990.7, Ш990.8-р параграфт заасан өөрчлөлтөөр хязгаарлах ёстой.
- Ш990.6** Хэрэв компани баталгаажуулах гэрээт ажлын тайлан гаргахдаа, нэг ижил үйлчлүүлэгч түүнийг ашиглах ба түгээхэд нь хязгаарлалт тавьдаггүй бол тэрээр уг баталгаажуулах гэрээт ажилд Бүлэг 4Б-г дагаж мөрдөх ёстой.

Санхүүгийн Ашиг Сонирхол, Зээл ба Баталгаа, Бизнесийн, Гэр Бүлийн болон Хувийн Ойр Дотно Харилцаа Холбоо

- Ш990.7** Компани нь зохистой баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэж байх үедээ:

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- (a) Хэсэг 910, 911, 920, 921, 922, 924-д заасан нөхцөлүүдээс холбогдох нөхцөлийг зөвхөн баталгаажуулах гэрээт ажлын багийн гишүүд, тэдний ам бүлийн гишүүн ба гэр бүлийн ойрын гишүүд дагаж мөрдөх хэрэгтэй;
- (б) Компани нь баталгаажуулах гэрээт ажлын үйлчлүүлэгч ба баталгаажуулах ажлын багийн дараах гишүүдийн хоорондох, Хэсэг 910, 911, 920, 921, 922, 924-д заасан ашиг сонирхол, харилцааны үр дүнд хараат бус байдалд учирсан аливаа аюул заналыг олж тогтоон, үнэлж, тодорхойлох ёстой;
 - (i) Техникийн эсвэл салбарын онцлог асуудлууд, ажил гүйлгээ, үйл явдалд зөвлөгөө өгдөг хүмүүс;
 - (ii) Гэрээт ажилд чанарын хяналт тавих хүмүүс, үүнд гэрээт ажлын чанарын хяналт шалгалт гүйцэтгэдэг хүмүүс орно;
- (в) Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч ба баталгаажуулах гэрээт ажлын үр дүнд шууд нөлөөлж чадахуйц компани доторх бусад хүмүүсийн хоорондох, Хэсэг 910, 911, 920, 921, 922, 924-д заасан ашиг сонирхол ба харилцаа холбооны үр дүнд аюул занал үүссэн хэмээн итгэх шалтгаан гэрээт ажлын багт байвал компани ийм аюул заналын далайцыг үнэлж, тодорхойлох хэрэгтэй.

990.7A1 Баталгаажуулах гэрээт ажлын үр дүнд шууд нөлөөлж чадахуйц компани доторх бусад хүмүүс гэдэгт, нөхөн олговрын талаар зөвлөмж өгдөг эсвэл баталгаажуулах гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор шууд хяналт тавьдаг, шууд удирддаг эсвэл хөндлөнгөөс хянадаг баталгаажуулах гэрээт ажлын партнерийг оруулдаг.

Ш990.8 Компани нь зохистой баталгаажуулах гэрээт ажлыг гүйцэтгэхдээ, баталгаажуулах ажлын үйлчлүүлэгчид материаллаг хэмжээний шууд эсвэл шууд бус санхүүгийн хувь эзэмшиж үл болно.

НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР БОЛОН ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан)-д ганц тоон дээрх нэр үгийг олон тоо, эсвэл эсрэгээр нь ойлгож болох бөгөөд дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

Энэхүү Нэр томьёоны тайлбарт, энгийн нэр томьёоны тодорхойлолтыг ердийн үсгийн хэвээр; Ёс зүйн аль нэг хэсэгт онцгой утгатай орсон нэр томьёо, эсвэл нэр томьёоны нэмэлт тодорхойлолтыг ташуу үсгийн хэвээр тус тус илэрхийлэн тайлбарласан болно. Ёс зүйн дүрэмд тодорхойлсон нэр томьёонд хамаарах лавлагааг мөн харуулсан болно.

Хүлээн зөвшөөрөгдөх түвшин (Acceptable level)	Ул үндэслэлтэй бөгөөд мэдээлэлтэй гуравдагч талын тестийг ашиглаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч нь өөрийгөө суурь зарчмуудтай нийцэж байна гэж дүгнэх магадлалын түвшин.
Зар сурталчилгаа (Advertising)	Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид нь мэргэжлийн бизнес ажил олж авахын тулд өөрсдийн үзүүлдэг үйлчилгээ, ур чадварын талаарх мэдээллийг нийтэд түгээх үйл ажиллагаа.
Тохирох хянан шалгагч (Appropriate reviewer)	<i>Гүйцэтгэсэн ажил буюу үзүүлсэн үйлчилгээг бодитоор хянан шалгахад хэрэгтэй мэдлэг, ур чадвар, туршлага, эрх мэдэлтэй мэргэжилтнийг тохирох хянан шалгагч гэнэ. Ийм хүн нь мэргэжлийн нягтлан бодогч байж болно.</i> <i>Энэ нэр томьёог 300.8A4 параграфт тодорхойлсон болно.</i>
Баталгаажуулах ажлын үйлчлүүлэгч (Assurance client)	Дараах хариуцлагыг хүлээдэг тал буюу хувь хүн (хүмүүс)-ийг хэлнэ: (а) Шууд тайлагнах гэрээт ажлын хувьд, тухайн шалгах асуудлыг хариуцдаг хүн; (б) Батламж мэдэгдэлд суурилсан гэрээт ажлын хувьд, тухайн шалгах асуудлын мэдээллийг хариуцдаг бөгөөд шалгах асуудлыг ч мөн хариуцах боломжтой хүн.
Баталгаажуулах ажил (Assurance engagement)	Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч нь хариуцлага хүлээдэг талуудаас бусад зорилтот хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор, шалгууртай харьцуулж гаргасан шалгах асуудлын үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүнгийн таларх дүгнэлтээ илэрхийлдэг гэрээт ажил. (Аудит болон Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан <i>Баталгаажуулах Ажлын Олон Улсын Үзэл Баримтлалаас</i> баталгаажуулах ажлын тухай удирдамжийг үзнэ үү. <i>Баталгаажуулах Ажлын Олон Улсын Үзэл Баримтлалд</i> баталгаажуулах ажлын элементүүд ба зорилгуудыг тодорхойлж, <i>Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)</i> , <i>Нягтлах Ажлын Олон Улсын Стандарт (НАОУС)</i> , <i>Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандартууд (БАОУС)</i> -ыг дагаж мөрдөх ёстой ажлуудыг нарийвчлан тогтоодог.)
Баталгаажуулах ажлын баг (Assurance team)	(а) Баталгаажуулах ажлын багийн бүх гишүүн; (б) Баталгаажуулах ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлж чадах тухайн компанийн бусад ажилтан. Эдгээрт: (i) Баталгаажуулах ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан тухайн баталгаажуулах ажлын партнерт олгох урамшууллын талаар зөвлөмж өгдөг эсвэл түүнийг шууд хянан шалгадаг, удирдлага эсвэл бусад хэлбэрээр хяналт тавьдаг хүмүүс; (ii) Баталгаажуулах ажлын хувьд, техникийн эсвэл салбарын онцлог асуудал, ажил гүйлгээ, үйл явдлын талаар зөвлөдөг хүмүүс;

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Аудит (Audit)	(iii) Баталгаажуулах ажилд чанарын хяналт тавьдаг хүмүүс, үүнд баталгаажуулах ажлын чанарын хяналт шалгалт гүйцэтгэдэг хүмүүс. <i>Бүлэг 4А-д “аудит” гэдэг нэр томъёог “нягтлах ажил”-тай адил утгаар ашигласан болно.</i>
Аудитын үйлчлүүлэгч (Audit client)	Аудитын гэрээт ажил гүйцэтгэдэг, компанийн хэлбэртэй аж ахуйн нэгж. Аудитын үйлчлүүлэгч нь хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж байвал уг үйлчлүүлэгч холбоотой аж ахуйн нэгжүүдээ багтаана. Хэрэв аудитын үйлчлүүлэгч нь хөрөнгийн биржид бүртгэлгүй аж ахуйн нэгж бол тэрээр өөрийн шууд эсвэл шууд бус хяналтад байдаг холбоотой аж ахуйн нэгжүүдийг оруулна. <i>(Ш400.20 параграфыг харна уу.)</i> <i>Бүлэг 4А-д “аудитын үйлчлүүлэгч” гэдэг нэр томъёог “нягтлах ажлын үйлчлүүлэгч”-тэй адил утгаар ашигласан болно.</i>
Аудитын гэрээт ажил (Audit engagement)	Санхүүгийн тайлангуудыг бүх материаллаг зүйлсийн хувьд мөрдвөл зохих санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу (буюу үнэн зөв илэрхийлсэн эсвэл үнэн зөв толилуулсан) бэлтгэсэн эсэх талаар нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч дүгнэлтээ илэрхийлдэг ул үндэслэлтэй баталгаажуулах гэрээт ажил, тухайлбал, <i>Аудитын Олон Улсын Стандартад</i> нийцүүлэн хийсэн гэрээт ажил. Үүнд, хууль тогтоомж эсвэл бусад дүрэм журамд шаарддаг Заавал Гүйцэтгэх Аудитыг оруулна. <i>Бүлэг 4А-д, “аудитын гэрээт ажил” гэдэг нэр томъёог “нягтлах гэрээт ажил”-тай адил утгаар ашигласан болно.</i>
Аудитын тайлан (Audit report)	<i>Бүлэг 4А-д “аудитын тайлан” гэдэг нэр томъёог “нягтлах гэрээт ажлын тайлан”-тай адил утгаар ашигласан болно.</i>
Аудитын баг (Audit team)	(a) Аудитын гэрээт ажил хийхээр томилогдсон ажлын багийн бүх гишүүн; (б) Аудитын ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлж чадах тухайн компанийн бусад ажилтан. Эдгээрт: (i) Аудитын ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан тухайн аудитын ажлын партнерт олгох урамшууллын талаар зөвлөмж өгдөг эсвэл түүнийг шууд хянан шалгадаг, удирдлага эсвэл бусад хэлбэрээр хяналт тавьдаг хүмүүс бөгөөд эдгээрт тухайн аудитын партнерийн түвшнээс дээгүүрх бүх түвшний ажилтнаас эхлээд компанийн Ахлах эсвэл Удирдах Партнер (Гүйцэтгэх захирал эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан) хүртэлх ажилтнуудыг оруулна; (i) Гэрээт ажлын хувьд, техникийн эсвэл салбарын онцлог асуудал, ажил гүйлгээ, үйл явдлын талаар зөвлөдөг хүмүүс; (iii) Аудитын ажилд чанарын хяналт тавьдаг хүмүүс, үүнд гэрээт ажлын чанарын хяналт шалгалт гүйцэтгэдэг хүмүүс.
Гэр бүлийн ойрын гишүүн (Close family)	Сүлжээ компанийн хэмжээнд аудит ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлж чадах бүх ажилтан. <i>Бүлэг 4А-д “аудитын баг” гэдэг нэр томъёог “нягтлах ажлын баг”-тай адил утгаар ашигласан болно.</i> Ам бүлийн гишүүн бус эцэг, эх, хүүхэд эсвэл төрсөн ах, эгч

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Онолын үзэл баримтлал (Conceptual framework)	<i>Энэ нэр томъёог Хэсэг 120-д тодорхойлсон болно.</i>
Болзошгүй төлбөр (Contingent fee)	Компанийн гүйцэтгэсэн үйлчилгээний үр дүн ба ажил гүйлгээний үр дагавартай холбоотойгоор урьдчилж тодорхойлсон сууриар тооцоолсон төлбөр хураамж. Шүүхээр эсвэл бусад эрх бүхий төрийн байгууллагын тогтоосон төлбөрийг болзошгүй төлбөр хураамж гэж үзэхгүй.
Түр завсарлах хугацаа (Cooling-off period)	<i>Ш540.11-Ш540.19-р параграфын зорилгоор энэ нэр томъёог Ш540.5-д тодорхойлсон болно.</i>
Санхүүгийн шууд хувь оролцоо (Direct financial interest)	Дараах санхүүгийн хувь оролцоо: (а) Хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн шууд эзэмшдэг болон тэдгээрийн хяналтад байдаг (үүнд, удирдлагын үзэмжээр зарцуулдаг хувийг оруулна); эсвэл (б) Тухайн хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн хянадаг, мөн хөрөнгө оруулалтын шийдвэрт нь нөлөөлж чаддаг тийм хамтын хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, итгэмжит сан эсвэл бусад зуучлагчаар дамжуулан ашиг олох зорилготой эзэмшдэг санхүүгийн хувь.
Захирал эсвэл албан тушаалтан (Director or officer)	Албан тушаалыг үл харгалзан, аж ахуйн нэгжийн засаглах эрхтэй удирдлага эсвэл түүнтэй адилтгах эрх мэдлийн хүрээнд ажилладаг хүмүүс бөгөөд хууль эрх зүйн өөр өөр орчинд ялгаатай нэрлэж болох юм.
Зохистой аудитын гэрээт ажил (Eligible audit engagement)	<i>Хэсэг 800-ийн зорилгоор энэхүү нэр томъёог 800.2-р параграфт тодорхойлсон болно.</i>
Зохистой баталгаажуулах гэрээт ажил (Eligible assurance engagement)	<i>Хэсэг 990-ийн зорилгоор энэхүү нэр томъёог 990.2-р параграфт тодорхойлсон болно.</i>
Гэрээт ажлын партнер (Engagement partner)	Гэрээт ажил ба түүний гүйцэтгэл болон аудитын компанийн өмнөөс гаргасан тайлангийн төлөө хариуцлага хүлээдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд, мэргэжлийн, хуулийн эсвэл зохицуулах байгууллагаас олгодог зохих эрх мэдэлтэй партнер эсвэл аудитын компани дахь бусад этгээд.
Гэрээт ажлын хугацаа (Аудит ба нягтлах гэрээт ажил) (Engagement period) (Audit and Review Engagements)	Аудитын баг аудитыг гүйцэтгэж эхэлмэгц гэрээт ажлын хугацаа эхэлсэнд тооцно. Аудитын тайлан гаргах үед гэрээт ажлын хугацаа дуусна. Хэрэв гэрээт ажлыг давтан гүйцэтгэж байгаа бол аль нэг талаас мэргэжлийн харилцаа дуусгавар болсон тухай эсвэл аудитын эцсийн тайлан гарсан тухай мэдэгдсэн хугацааны аль сүүлд байгаа хугацааг дуусгавар хугацаа гэж үзнэ.
Гэрээт ажлын хугацаа (Аудит ба нягтлах гэрээт ажлаас бусад баталгаажуулах ажил) (Engagement period) (Assurance Engagements Other than Audit and Review Engagements)	Баталгаажуулах ажлын баг нь тухайн ажилтай холбоотой баталгаажуулах үйлчилгээг гүйцэтгэж эхэлснээр гэрээт ажлын хугацаа эхэлнэ. Баталгаажуулах ажлын тайлан гарснаар ажлын хугацаа дуусгавар болно. Баталгаажуулах ажил нь давтагдах шинж чанартай ажил байвал, аль нэг талаас мэргэжлийн харилцаа дуусгавар болсон тухай эсвэл баталгаажуулах ажлын эцсийн тайлан гарсан тухай мэдэгдсэн хугацааны аль сүүлд байгаа хугацааг дуусгавар хугацаа гэж үзнэ.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Гэрээт ажлын чанарын хяналтыг нягтлах ажил (Engagement quality control review)	Тайлан гаргах өдөр эсвэл түүнээс өмнө гэрээт ажлын багийн гаргасан чухал шүүн тунгаалт болон тайлан боловсруулж байхдаа төлөвлөсөн дүгнэлтэд бодитой үнэлгээ өгөх зорилгоор гүйцэтгэсэн үйл явц.
Гэрээт ажлын баг (Engagement team)	<p>Гэрээт ажил гүйцэтгэж буй бүх партнер болон албан хаагчид бөгөөд гэрээт ажлын горимыг хэрэгжүүлж байгаа аудитын компани эсвэл сүлжээ компанийн хөлсөлсөн хүн. Тухайн компани, эсвэл сүлжээ компанийн хөлсөлсөн хөндлөнгийн шинжээч үүнд багтахгүй.</p> <p>Түүнчлэн, хөндлөнгийн аудитор нь АОУС 610 (2013 онд шинэчлэн найруулсан), “Дотоод Аудиторуудын Ажлыг Ашиглах”-ын шаардлагыг мөрддөг бол, үйлчлүүлэгчийн дотоод аудитын үүрэг гүйцэтгэж, аудитын гэрээт ажилд шууд туслалцаа үзүүлдэг хүнийг “гэрээт ажлын баг” гэдэг нэр томъёонд оруулахгүй.</p>
Одоогийн нягтлан бодогч (Existing accountant)	Тайлант үед аудитын ажилд томилогдон ажиллаж байгаа эсвэл үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл, татварын тооцоолол, зөвлөгөө болон эдгээртэй адил төстэй үйлчилгээ үзүүлж буй нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч.
Хөндлөнгийн шинжээч (External expert)	Энэ нь нягтлан бодох бүртгэл ба аудитаас өөр салбарын мэдлэг, ур чадвар, туршлагыг эзэмшсэн бөгөөд энэ талбар дахь ажил нь хангалттай, зохистой нотлох баримт олж авахад тухайн мэргэжлийн нягтлан бодогчид тус болох хувь хүн буюу байгууллага (тухайн компани болон сүлжээ компанийн партнер эсвэл мэргэжлийн албан хаагч биш, мөн түр албан хаагч биш хүн).
Санхүүгийн хувь оролцоо (Financial interest)	Аж ахуйн нэгжийн хөрөнгө эсвэл бусад үнэт цаас, өрийн бичиг, зээл эсвэл өрийн бусад хэрэглүүр дэх хувь оролцоо, үүний дотор хувь оролцоо болон түүнд шууд хамаарах үүсмэл хэрэглүүрийг олж авах эрх, үүрэг.
Санхүүгийн тайлан (Financial statements)	Тухайлсан нэг өдрөөрх аж ахуйн нэгжийн эдийн засгийн нөөц, өр төлбөрийг эсвэл тодорхой хугацааны туршид тэдгээрт гарсан өөрчлөлтүүдийг санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу мэдээлэх зорилготой санхүүгийн түүхэн мэдээллийг холбогдох тэмдэглэлийн хамт бүтэцчилэн илэрхийлсэнийг хэлнэ. Холбогдох тэмдэглэлд ерөнхийдөө нягтлан бодох бүртгэлийн чухал бодлого, бусад тайлбар мэдээллийн хураангуйг багтаадаг. Энэ нэр томъёонд санхүүгийн тайлангийн багцыг хамруулж болох авч баланс, орлого ба зардлын тайлан, холбогдох тайлбар тэмдэглэл гэх мэт салангид тайланг ч авч үзэж болно.
Компанийн дүгнэлт өгөх санхүүгийн тайлан (Financial statements on which the firm will express an opinion) Компани (Firm)	<p>Бие даасан аж ахуйн нэгжийн хувьд тухайн аж ахуйн нэгжийн гаргасан санхүүгийн тайлангууд байна. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд мөн гурпнийн санхүүгийн тайлан буюу нэгтгэсэн санхүүгийн тайланг хамруулна.</p> <p>(а) Ганцаараа ажилладаг эсвэл нөхөрлөл эсвэл корпораци хэлбэрээр ажилладаг мэргэжлийн нягтлан бодогчид;</p> <p>(б) Өмчлөл, удирдлага эсвэл бусад арга хэлбэрээр дээрх талуудыг хянадаг аж ахуйн нэгж;</p> <p>(в) Өмчлөл, удирдлага эсвэл бусад арга хэлбэрээр дээрх талуудын хяналтад байдаг аж ахуйн нэгж.</p> <p><i>Бүлэг 4А ба 4Б-ийн аль алины шаардлагад нийцүүлэхэд мэргэжлийн нягтлан бодогчид, компаниудын хүлээх хариуцлагыг тодорхойлохын тулд “компани” гэдэг үгийг хэрхэн ашиглахыг 400.4 болон 900.3-р параграфт</i></p>

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

тайлбарласан болно.

Суурь зарчим (Fundamental principles)	<p><i>Энэ нэр томъёог 110.1A1-р параграфт тодорхойлсон. Суурь зарчим тус бүрийг дараах параграфт тайлбарласан:</i></p> <p><i>Шударга байдал Ш 111.1</i></p> <p><i>Бодитой хандлага Ш 112.1</i></p> <p><i>Мэргэжлийн ур чадвар ба хянамгай байдал Ш 113.1</i></p> <p><i>Нууцыг хадгалах Ш 114.1</i></p> <p><i>Мэргэжлийн үйл хөдлөл/ зан төлөв Ш 115.1</i></p>
Санхүүгийн түүхэн мэдээлэл (Historical financial information)	<p>Тодорхой нэг аж ахуйн нэгжтэй холбоотой өнгөрсөн хугацаанд тохиолдсон үйл явдал эсвэл өнгөрсөн тодорхой хугацаан дахь эдийн засгийн үйл явдал буюу нөхцөл байдлын талаарх санхүүгийн нэр томъёогоор илэрхийлэгдсэн мэдээлэл бөгөөд үүнийг юуны өмнө уг аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн системээс татаж гаргадаг.</p>
Ам бүл (Immediate family)	<p>Эхнэр, нөхөр (эсвэл тэдгээртэй адилтгах хүмүүс) эсвэл тэдний асран хамгаалуулагч.</p>
Хараат бус байдал (Independence)	<p>Хараат бус байдал нь дараах зүйлсээс бүрдэнэ:</p> <p>(а) Сэтгэл санааны хараат бус байдал - мэргэжлийн шүүн тунгаалтын үнэ цэнийг алдагдуулах нөлөөнд үл автуулах, тэгснээрээ шударга, бодитой, мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандан дүгнэлт илэрхийлэх боломж олгохуйц сэтгэл санааны байдал.</p> <p>(б) Гадна төрхийн хараат бус байдал – ухаалаг бөгөөд мэдлэгтэй гуравдагч этгээд нь компанийн эсвэл аудит, эсвэл баталгаажуулах багийн гишүүний шударга ёс, бодитой хандлага, мэргэжлийн үл итгэх үзэл алдагдсан гэж үндэслэлтэйгээр дүгнэж болохуйц бодит баримт, нөхцөл байдлаас зайлсхийх явдал.</p> <p><i>Хувь хүн эсвэл компани “хараат бус” байна гэдэг нь тухайн хүн эсвэл компани Бүлэг 4А ба 4Б-ийн аль хамаарах шаардлагуудыг дагаж мөрдөж байгаа гэсэн үг болохыг 400.5болон 900.4-р параграфт дурдсан байна.</i></p>
Шууд бус санхүүгийн хувь оролцоо (Indirect financial interest)	<p>Тухайн хувь хүн эсвэл аж ахуйн нэгжийн хянадаггүй, мөн хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлж чаддаггүй тийм хамтын хөрөнгө оруулалтын арга хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, итгэмжит сан эсвэл бусад зуучлагчаар дамжуулан ашиг олох зорилготой эзэмшдэг санхүүгийн хувь оролцоо.</p>
Урамшуулал (Inducement)	<p>Урамшуулал гэдэг нь хувь хүний зан төлөвт нөлөөлөх арга зам болгон ашигладаг объект, нөхцөл, эсвэл үйлдлийг хэлэх бөгөөд энэ нь тухайн хүний зан төлөвт заавал санаатайгаар зүй бус нөлөөлөх асуудал биш.</p> <p><i>Урамшуулал нь бизнесийн нөхөд/ хамт олны дунд дайллага хийх гэх мэт жижиг үйлдлээс хууль тогтоомжид үл нийцэх байдалд хүргэж болох үйлдэл гэх мэт өргөн хүрээтэй байж болно. Урамшууллын янз бүрийн хэлбэр байдгийг дараах жишээгээр харуулж болно. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none">• <i>Бэлэг.</i>• <i>Дайллага.</i>• <i>Зугаа цэнгэл.</i>• <i>Улс төрийн эсвэл буяны хандив.</i>• <i>Нөхөрлөл ба үнэнч байдлын төлөөх гуйлт.</i>• <i>Ажил олгох эсвэл бусад арилжааны боломж олгох.</i>

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

- *Хөнгөлөлттэй үйлчилгээ, эрх буюу давуу эрх олгох.*

Аудитын гол партнер
(Key audit partner)

Гэрээт ажлын чанарын хяналтын шалгалтыг хариуцдаг хувь хүн, мөн компани дүгнэлтээ гаргах ёстой санхүүгийн тайлангуудын аудиттай холбогдох чухал шийдвэр гаргадаг аудитын бусад партнер. Тухайн нөхцөл байдал болон аудитад оролцож буй хувь хүмүүсийн үүргээс хамааран аудитын бусад партнер гэдэгт жишээлбэл, томоохон охин компани, салбар хариуцсан аудитын партнерийг оруулах боломжтой.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй
аж ахуйн нэгж
(Listed entity)

Хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн бирж дээр хувьцаа, үнэт цаас, өрийн бичиг нь бүртгэгдсэн буюу арилжаалагдахаар зарлагдсан эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн бирж буюу түүнтэй адилтгах бусад байгууллагын журмын дагуу арилжаалагддаг аж ахуйн нэгж.

...-ж/ч болох; ...-ж/ч болох юм"
(May)

Дүрэмд энэ үгийг хэрэглэхдээ, тодорхой нөхцөл байдал үүсэх үед дүрмийн шаардлагад зааснаас бусад ямар нэг үйлдэл хийхийг зөвшөөрч байгааг илэрхийлсэн. Харин боломжтой гэдэг утгыг энэ үгээр илэрхийлэхгүй.

...-ж болзошгүй; "...-х боломжтой"
(Might)

Асуудал үүсэх, үйл явдал тохиолдох эсвэл арга хэмжээ авах боломжтой гэсэн утгыг Дүрэмд илэрхийлэхдээ энэ үгийг ашигласан. Энэ нэр томъёог аюул заналтай холбогдуулан ашиглаж байвал, боломж эсвэл магадлалын тодорхой түвшнийг илэрхийлдэггүй, учир нь аюул заналын түвшин бол тодорхой асуудал, үйл явдал эсвэл арга хэмжээ авах бодит байдал, орчин нөхцөлөөс шалтгаалдаг.

Сүлжээ
(Network)

Дараах шинж бүхий томоохон бүтцийг хэлнэ :

- (а) Хамтын ажиллагаанд чиглэсэн;
- (б) Ашиг болон зардлаа хуваалцахыг илэрхий зорьдог, эсвэл нэгдсэн өмчлөл, хяналт буюу удирдлага, чанарын хяналтын нэгдсэн бодлого, горим, бизнесийн нийтлэг стратеги, нийтлэг нэг бренд нэр эсвэл мэргэжлийн нөөцийн үлэмж хэсгийг хуваалцдаг.

Сүлжээ компани
(Network firm)

Аль нэг сүлжээ компанид харьяалагддаг компани эсвэл аж ахуйн нэгж.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол 400.50A1-400.54A1 хуртэлх параграфыг харна уу.

Хууль тогтоомжийн үл нийцэл
(*Бизнес дэх мэргэжлийн
нягтлан бодогч*)

Хууль тогтоомжийн үл нийцэл ("үл нийцэл") нь зонхилох хууль тогтоомжийн эсрэг дараах талуудын үйлдсэн санаатай болон санаандгүй орхигдуулах үйлдэл эсвэл захиалгаас бүрддэг. Үүнд:

(Non-compliance with laws and
regulations)
(*Professional Accountants in
Business*)

- (а) Мэргэжлийн нягтлан бодогчийн ажиллаж байгаа байгууллага;
- (б) Ажил олгогч байгууллагын засаглах эрхтэй удирдлага;
- (в) Ажил олгогч байгууллагын гүйцэтгэх удирдлага;
- (г) Ажил олгогч байгууллагын төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад этгээд.

Энэ нэр томъёог 260.5.A1-р параграфт тодорхойлсон болно.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Хууль тогтоомжийн үл нийцэл (Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч) (Non-compliance with laws and regulations) (Professional Accountants in Public Practice)	Хууль тогтоомжийн үл нийцэл (“үл нийцэл”) нь зонхилох хууль тогтоомжийн эсрэг дараах талуудын үйлдсэн санаатай болон санаандгүй орхигдуулах үйлдэл эсвэл захиалгаас бүрддэг. Үүнд: (а) Үйлчлүүлэгч; (б) Үйлчлүүлэгчийн засаглах эрхтэй удирдлага; (в) Үйлчлүүлэгчийн гүйцэтгэх удирдлага; (г) Үйлчлүүлэгчийн төлөө эсвэл түүний зааврын дагуу ажилладаг бусад этгээд. <i>Энэ нэр томъёог 360.5.A1-р параграфт тодорхойлсон болно.</i>
Албан газар (Office)	Газар зүйн байршил эсвэл үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдсан тусдаа ялгарах дэд бүлэг.
Өмнөх нягтлан бодогч (Predecessor accountant)	Одоо үйлчилгээ үзүүлж буй нягтлан бодогч байхгүй тохиолдолд, саяхны өмнөх хугацаанд аудитын ажилд томилогдон ажиллаж байсан эсвэл үйлчлүүлэгчид нягтлан бодох бүртгэл, татварын тооцоолол, зөвлөгөө болон эдгээртэй адил төстэй үйлчилгээ үзүүлж байсан нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч.
Мэргэжлийн нягтлан бодогч (Professional accountant)	Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны гишүүн байгууллагын гишүүн хувь хүн. <i>Бүлэг 1-д заасан “мэргэжлийн нягтлан бодогч” гэдэг нэр томъёог бизнесийн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогч хувь хүн болон нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид болон тэдний ажилладаг компанид хамааруулан ойлгоно.</i> <i>Бүлэг 2-т заасан “мэргэжлийн нягтлан бодогч” гэдэг нэр томъёог бизнесийн салбарт ажиллаж байгаа мэргэжлийн нягтлан бодогчид хамааруулан ойлгоно.</i> <i>Бүлэг 3, 4А болон 4Б-д заасан “мэргэжлийн нягтлан бодогч” гэдэг нэр томъёог нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчид болон тэдний ажилладаг компанид хамааруулан ойлгоно.</i>
Бизнес дэх мэргэжлийн нягтлан бодогч (Professional accountant in business)	Удирдах эсвэл энгийн үүрэгтэйгээр худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, улсын байгууллага, боловсролын болон ашгийн бус байгууллага, мэргэжлийн болон зохицуулагч байгууллагад ажилладаг эсвэл ийм байгууллагад гэрээгээр ажил гүйцэтгэдэг мэргэжлийн нягтлан бодогч байж болно.
Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч (Professional accountant in public practice)	Чиг үүргийн ангиллаас үл хамааран (жишээлбэл, аудит, татвар, зөвлөгөө гэх мэт) мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг компанийн мэргэжлийн нягтлан бодогчид. <i>“Нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч” гэдэг нэр томъёог нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогчдын компанид мөн хамааруулан ашигладаг.</i>
Мэргэжлийн үйл ажиллагаа (Professional activity)	Мэргэжлийн нягтлан бодогчдын гүйцэтгэдэг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа эсвэл холбогдох ур чадвар шаардсан аливаа үйлчилгээ, түүний дотор нягтлан бодох бүртгэл, аудит, татвар, удирдлагад зөвлөгөө өгөх болон санхүүгийн удирдлагын үйлчилгээ.
Мэргэжлийн үйлчилгээ (Professional services)	Үйлчлүүлэгчид зориулан гүйцэтгэж байгаа мэргэжлийн үйл ажиллагаа.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Дараагийн нягтлан бодогч (Proposed accountant)	Аудитын ажилд томилох томилгоо эсвэл ирээдүйн үйлчлүүлэгч (зарим тохиолдолд одоогийн үйлчлүүлэгч)-д нягтлан бодох бүртгэл, татварын тооцоолол, зөвлөгөө болон эдгээртэй адил төстэй үйлчилгээ үзүүлэх гэрээт ажлыг хүлээн зөвшөөрөхөөр зэхэж байгаа нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч.
Нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгж (Public interest entity)	(a) Биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж, (б) Дараах аж ахуйн нэгж: (i) Дүрэм журам эсвэл хууль тогтоомжид нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгж гэж тодорхойлсон байгууллага; эсвэл (ii) Хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжийн аудитад мөрддөг хараат бус байдлын шаардлагуудад мөн адил нийцүүлэн аудитыг нь гүйцэтгэхийг дүрэм журам эсвэл хууль тогтоомжид шаардсан байдаг аж ахуйн нэгж. Ийм дүрэм журмыг холбогдох ямар ч зохицуулагч, үүн дотор аудитын асуудал эрхэлдэг зохицуулдаг байгууллага гаргах боломжтой.
Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч тал Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч талын тест (Reasonable and informed third party) (Reasonable and informed third party test)	<i>400.8-р параграфт дурдсанчлан, нийтийн сонирхол бүхий байгууллагад бусад аж ахуйн нэгжийг мөн багтааж болох юм.</i> <i>Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч талын тест бол түүнтэй яг ижил дүгнэлтийг өөр нэг тал гаргаж болох магадлалыг мэргэжлийн нягтлан бодогч авч үзэхийг хэлнэ. Үүнийг дүгнэлт хийж байхдаа, нягтлан бодогчийн мэддэг эсвэл мэднэ гэж үндэслэлтэй хүлээж болох холбоотой бүх бодит баримт, нөхцөлийг үнэлж цэгнэдэг ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч талын хэтийн төлөв байдлаас хийдэг. Ухаалаг бөгөөд боловсролтой гуравдагч тал нь заавал нягтлан бодогч байх албагүй, гэхдээ ямар нэг алагчлах үзэлгүйгээр нягтлан бодогчийн хийсэн дүгнэлтийн зохистой эсэхийг ойлгож, дүгнэх хэмжээний мэдлэг, туршилагыг эзэмшсэн байх нь зүйтэй.</i> <i>Энэ нэр томъёог ШИ20.5А4-р параграфт тодорхойлсон болно.</i>
Холбоотой аж ахуйн нэгж (Related entity)	Үйлчлүүлэгчтэй дор дурдсан аль нэг хэлхээ холбоо бүхий байгууллага: (a) Үйлчлүүлэгчийг шууд буюу шууд бус хянадаг бөгөөд үйлчлүүлэгч нь өөрийнх нь хувьд материаллаг байх байгууллага; (б) Үйлчлүүлэгчид санхүүгийн шууд хувь оролцоотой, мөн үйлчлүүлэгчид үлэмж нөлөөтэй бөгөөд үйлчлүүлэгч дэх энэ хувь оролцоо өөрийнх нь хувьд материаллаг байх байгууллага; (в) Үйлчлүүлэгчийн шууд буюу шууд бус хяналтад байдаг байгууллага; (г) Үйлчлүүлэгч, эсвэл дээрх (в)-д дурдсан үйлчлүүлэгчтэй холбоо бүхий байгууллага нь санхүүгийн шууд хувь оролцоотой бөгөөд уг хувь нь тухайн байгууллагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжийг олгодог, мөн тус үйлчлүүлэгч болон (в)-д заасан уг холбоотой байгууллагын хувьд материаллаг байх байгууллага; (д) Үйлчлүүлэгчтэй нийтлэг нэг хяналтын дор байдаг байгууллага (цаашид “эгч дүү байгууллага” гэх), ингэхдээ эгч дүү байгууллага ба үйлчлүүлэгч нь хоёулаа уг хянадаг байгууллагын хувьд материаллаг байх байгууллага.
Нягтлах ажлын үйлчлүүлэгч (Review client)	Компанийн гүйцэтгэж буй нягтлах ажил хийгдэж байгаа байгууллага.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нягтлах ажил (Review engagement)	<p><i>Нягтлах Ажлын Олон Улсын Стандартууд</i> эсвэл адилтгах өөр бусад стандартын дагуу гүйцэтгэсэн бөгөөд нийтэд үйлчилдэг мэргэжлийн нягтлан бодогч аудитад шаардагдах бүх нотлох баримтыг үүсгэдэггүй горимууд дээр үндэслэн санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг асуудлаар харгалзах санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэгдэж чадаагүй байна гэж үзэхэд хүргэх ямарваа зүйл түүний анхааралд өртсөн эсэх талаар дүгнэлт гаргадаг баталгаажуулах ажил.</p>
Нягтлах ажлын баг (Review team)	<p>(a) Нягтлах ажлын багийн бүх гишүүн; (б) Нягтлах ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлж чадах тухайн компанийн бусад ажилтан, эдгээрт:</p> <ul style="list-style-type: none">(i) Нягтлах ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан тухайн ажлын партнерт олгох урамшууллын талаар зөвлөмж өгдөг эсвэл түүнийг шууд хянан шалгадаг, удирдлага эсвэл бусад хэлбэрээр хяналт тавьдаг хүмүүс бөгөөд эдгээрт тухайн ажлын партнерийн түвшнээс дээгүүрх бүх түвшний ажилтнаас эхлээд компанийн Ахлах эсвэл Удирдах Партнер (Гүйцэтгэх захирал эсвэл түүнтэй адилтгах албан тушаалтан) хүртэлх ажилтнуудыг оруулна;(ii) Гэрээт ажлын хувьд, техникийн эсвэл салбарын онцлог асуудал, ажил гүйлгээ, үйл явдлын талаар зөвлөдөг хүмүүс;(iii) Гэрээт ажилд чанарын хяналт тавьдаг хүмүүс, үүнд гэрээт ажлын чанарын хяналт шалгалт гүйцэтгэдэг хүмүүс.
Хамгаалалт (Safeguards)	<p>Сүлжээ компанийн хэмжээнд нягтлах ажлын үр дүнд шууд нөлөө үзүүлж чадах бүх ажилтан.</p> <p><i>Хамгаалалт гэдэг нь суурь зарчмын нийцэлд учрах аюул заналыг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулахад дангаараа эсвэл нийлмэл байдлаар үр дүнтэй гэж мэргэжлийн нягтлан бодогч үзэн, хэрэгжүүлдэг үйлдэл юм.</i></p> <p><i>Энэ нэр томъёог 120.10 А2-р параграфт тодорхойлсон болно.</i></p>
Ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогч (Senior professional accountant in business)	<p>Бизнес дэх ахлах түвшний мэргэжлийн нягтлан бодогчид бол ажил олгогч байгууллагын хүний нөөц, санхүү, технологи, биет болон биет бус нөөцийн худалдан авалт, байршуулалт, хяналтад нөлөөлөх болон шийдвэр гаргах эрхтэй захирал, албан тушаалтан эсвэл ахлах түвшний ажилтан байна.</p> <p><i>Энэ нэр томъёог 260.11 А1-р параграфт тодорхойлсон болно.</i></p>
Томоохон гарз хохирол (Substantial harm)	<p><i>Энэ нэр томъёог 260.5 А3 болон 360.5А3-р параграфт тодорхойлсон болно.</i></p>
Тусгай зорилготой санхүүгийн тайлан (Special purpose financial statements)	<p>Тухайлсан хэрэглэгчдийн санхүүгийн мэдээллийн хэрэгцээг хангах зорилгоор санхүүгийн тайлангийн үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангууд.</p>
Засаглах эрхтэй удирдлага (Those charged with governance)	<p>Аж ахуйн нэгж, байгууллагын стратегийн чиглэл, түүний хариуцлагатай байх үүрэгт хяналт тавих хариуцлагыг хүлээсэн хувь хүн (хүмүүс) эсвэл байгууллага (тухайлбал, корпорацийн итгэмжит төлөөлөл). Үүнд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэг орно. Хууль эрхзүйн зарим орчин дахь зарим байгууллагын хувьд, засаглах эрхтэй удирдлагын бүрэлдэхүүнд гүйцэтгэх удирдлагаас жишээлбэл, хувийн ба улсын секторын аж ахуйн нэгж, байгууллагын удирдах зөвлөлийн гишүүд, эсвэл өмчлөгч-менежер орох боломжтой.</p>

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Аюул занал
(Threats)

Энэ нэр томъёог 120.6 АЗ-р параграфт тодорхойлсон бөгөөд дараах байдлаар ангилдаг:

<i>Хувийн ашиг сонирхлын аюул занал</i>	<i>120.6 АЗ(а)</i>
<i>Өөрийгөө хянах аюул занал</i>	<i>120.6 АЗ(б)</i>
<i>Өмгөөлөх аюул занал</i>	<i>120.6 АЗ(в)</i>
<i>Танилын аюул занал</i>	<i>120.6 АЗ(г)</i>
<i>Айлган сүрдүүлэх аюул занал</i>	<i>120.6 АЗ(д)</i>

Ажиллаж байх хугацаа
(Time-on period)

Энэ нэр томъёог Ш540.5-р параграфт тодорхойлсон болно.

**ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ БА ЁС ЗҮЙН ДҮРЭМД
ХАМААРАХ СТАНДАРТЫН НЭРС**

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
Баталгаажуулах ажлын үзэл баримтлал	Баталгаажуулах Ажлын Олон Улсын Үзэл Баримтлал
ИТБХ	Ивээн Тэтгэгч Байгууллагуудын Хороо
КХШИМНБ	Канадын Хяналтын Шалгуурын Итгэмжлэгдсэн Мэргэжлийн Нягтлан Бодогчид
АБОУСЗ	Аудит Ба Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөл
НБЁЗОУСЗ	Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл
ДНБХ	Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БАОУС	Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандарт
ЧХОУС	Чанарын Хяналтын Олон Улсын Стандарт
НАОУС	Нягтлах Ажлын Олон Улсын Стандарт

ЁС ЗҮЙН ДҮРЭМД ХАМААРАХ СТАНДАРТЫН НЭРС

Стандарт	Бүтэн нэр
АОУС 320	Аудитыг Төлөвлөх ба Гүйцэтгэхэд Материаллаг Байдлыг Авч Үзэх
АОУС 610 (2013 онд Шинэчлэн найруулсан)	Дотоод Аудиторын Ажлыг Ашиглах нь
БАОУС 3000 (Шинэчлэн найруулсан)	Түүхэн Санхүүгийн Мэдээллийн Аудит ба Нягтлах Гэрээт Ажлаас Бусад Баталгаажуулах Ажил
ЧХОУС 1	Санхүүгийн Тайлангийн Аудит ба Нягтлах Ажил болон Бусад Баталгаажуулах ба Холбогдох Үйлчилгээ Үзүүлж Байгаа Компаниудын Чанарын Хяналт
НАОУС 2400 (Шинэчлэн найруулсан)	Түүхэн Санхүүгийн Мэдээллийг Нягтлах Гэрээт Ажил

ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ ХУГАЦАА

- Бүлэг 1, 2, 3-ыг 2019 оны 6-р сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөнө.
- Аудитын болон нягтлах гэрээт ажилд зориулсан хараат бус байдлын талаарх 4А хэсгийг 2019 оны 6-р сарын 15 буюу түүнээс хойш эхлэх тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудит ба нягтлах ажилд дагаж мөрдөнө.

Авч үзэх асуудлыг хамарсан хугацаатай холбоотой баталгаажуулах ажилд баримтлах хараат бус байдлыг тусгасан Бүлэг 4Б-г 2019 оны 6-р сарын 15 буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдэд мөрдөнө; өөрөөр хэлбэл энэ Бүлгийг 2019 оны 6-р сарын 15-аас эхлэн мөрдөх юм.

Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

НБЭЗОУСЗ-өөс өмнөх бүтэц ба төслийн тохиролцооны дагуу 2017 оны 1-р сард “байнгын баримт бичиг” болгон гаргасан урт хугацаанд хамтран ажиллахтай холбоотой Дүрмийн заалтын өөрчлөлтийн хүчинтэй мөрдөх хугацааны тухай мэдээллийг энэ баримт бичгийн 3-р хуудаснаас лавлаж харна уу.

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

The International Code of Ethics for Professional Accountants (including International Independence Standards), 2018 Edition of the International Ethics Standards Board for Accountants (IESBA) published by the International Federation of Accountants in July 2018 in the English language, has been translated into Mongolian by the Mongolian Institute of Certified Public Accountants in December 2019, and is reproduced with the permission of IFAC. The process for translating the *International Code of Ethics for Professional Accountants (including International Independence Standards), 2018 Edition* was considered by IFAC and the translation was conducted in accordance with “Policy Statement—Policy for Translating Publications of the International Federation of Accountants.” The approved text of all *International Code of Ethics for Professional Accountants (including International Independence Standards), 2018 Edition* is that published by IFAC in the English language. IFAC assumes no responsibility for the accuracy and completeness of the translation or for actions that may ensue as a result thereof.

English language text of *International Code of Ethics for Professional Accountants (including International Independence Standards)* © 2018 by IFAC. All rights reserved.

Mongolian language text of *Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрмийн Гарын Авлага (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан)* © 2019 by IFAC. All rights reserved.

Original title: *Handbook of the International Code of Ethics for Professional Accountants* © 2018 Edition: ISBN 978-1-60815-369-5

Contact Permissions@ifac.org for permission to reproduce, store or transmit, or to make other similar uses of this document.”

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

(ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭСЭН)

ЁС ЗҮЙН ДҮРЭМ



529, 5-р өргөн чөлөө, Нью-Йорк, Нью-Йорк 10017 Т
+1 (212) 286-9344 F + 1 (212) 286-9570
www.ifac.org
ISBN® 978-1-60815-369-5